

**БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**



Б.ЭНХБАЯР

2026 оны 03 дугаар сарын 27 ны өдөр

ШҮГЭЛ ҮЛЭЭГЧИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 58/4 дүгээр тогтоолоор баталсан “Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц”-д Монгол Улс 2005 онд нэгдэн орж, соёрхон баталсан. Тус конвенцын 33 дугаар зүйлд “Оролцогч улс бүр энэхүү конвенцын дагуу тогтоосон гэмт хэргийн талаарх аливаа баримт нотолгоог сайн санааны үүднээс, үндэслэлтэйгээр эрх бүхий байгууллагад мэдээлж буй аливаа этгээдийг шударга бус хандлагаас хамгаалах зохих арга хэмжээг дотоодын эрх зүйн тогтолцоонд нэвтрүүлэх асуудлыг авч үзнэ” гэж заасан.

Түүнчлэн, Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 4.1.3-т “Компанийн ёс зүйн дүрэм, журамд дотоод шүгэл үлээгчийг дэмжих, хамгаалах, урамшуулах зохицуулалтыг тусгах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлийг үл тэвчих, шүгэл үлээх соёлыг төлөвшүүлнэ” гэж, 5.1.8-д “Хулгайлагдсан хөрөнгийг илрүүлэх, цахим орчинд шинжилгээ хийх, санхүүгийн мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулах, гэрч, хохирогч, шүгэл үлээгч, мэдээлэгчийг хамгаалах болон аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий нэгжийг байгуулна” гэж, 6.4.3-т “Шүгэл үлээгчийг хамгаалах эрх зүйн орчныг бий болгох замаар шүгэл үлээх соёлыг төлөвшүүлнэ” гэж, 9.5.2-т “Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар олон нийтэд сурталчилна” гэж, 10.1.2-т “Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагад шүгэл үлээгчийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлнэ” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 5.6.5-д “Авлига, албан тушаалын гэмт хэргийн мэдээлэл хүлээн авах, нууцыг хадгалах тогтолцоог бэхжүүлж, энэ төрлийн гэмт хэргийг илчилсэн, мэдээлсэн хүнийг хамгаалах эрх зүйн үндсийг бүрдүүлж, авлигаас урьдчилан сэргийлэх төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагаа, олон нийтийн хяналтыг сайжруулна” гэж тусгасан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.2.1.3-т “авлига, ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх тогтолцоог хялбаршуулах, энэ төрлийн гэмт хэргийн эсрэг шүгэл үлээгчийг хамгаалах, дэмжих хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ” гэж заасан.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох

үндсэн чиглэл"-ийн 45-д Монгол Улсын Засгийн газраас Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг санаачлан боловсруулахаар тусгасан.

1.2.Практик шаардлага

Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг нийтэд ил болгосны улмаас тодорхой хувь хүн, бүлэг этгээд, аж ахуйн нэгж, албан тушаалтан болон төрийн байгууллагын зүгээс дарамт шахалтад өртөх, эрх чөлөөгөө хязгаарлуулах, хувь хүний эрх нь зөрчигдөх, хүчирхийлэлд өртөх, улмаар үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжгүй болох тохиолдол дэлхий нийтэд түгээмэл ажиглагддаг.

Монгол Улсад 2002, 2016, 2023 онуудад Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг батлан мөрдүүлж байгаа боловч шүгэл үлээгч буюу мэдээлэгчийн эрх, аюулгүй байдлыг хамгаалах цогц эрх зүйн зохицуулалт бүрэн бүрдээгүй байна. Тухайлбал, Транспэрэнси Интернэшнл байгууллагаас иргэдийн дунд явуулсан судалгаагаар авлигатай тэмцэх хамгийн үр дүнтэй арга нь "мэдээлэх" болон "хахууль өгөхгүй байх" гэж хариулсан хэдий ч мэдээлээгүй шалтгааныг тодруулахад оролцогчдын дийлэнх нь "үр дагавраас айдаг" гэж хариулсан нь мэдээлэгчийг хамгаалах эрх зүйн баталгаа хангалтгүй байгааг илтгэж байна.¹

Нийтийн ашиг сонирхлын төлөө аливаа хууль бус үйлдлийн талаар мэдээлэл өгсөн иргэдэд амь нас, эрүүл мэндэд заналхийлэх, нэр төр, алдар хүндэд халдах, сэтгэл санааны дарамт үзүүлэх, цахим орчинд доромжлох, мэдээлэл авах боломжийг хязгаарлах, байгууллагын зүгээс үл ойшоох, ялгаварлах, ажлаас халах, цалин хөлс, нийгмийн баталгааг бууруулах, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг боогдуулах зэрэг олон хэлбэрийн дарамт, өшөө авалтын шинжтэй үйлдэл тулгарч байна. Сүүлийн жилүүдэд нийтийн ашиг сонирхлын төлөө мэдээлэл өгсөн этгээдийг цахим орчинд доромжлох, сүрдүүлэх, нэр төрийг нь гутаах зэрэг үзэгдэл нэмэгдэх болсон нь шүгэл үлээгчийг хамгаалах тусгай эрх зүйн зохицуулалт шаардлагатайг харуулж байна.

Монгол Улсад шүгэл үлээгчийн эрхийг хамгаалах талаарх эрх зүйн ойлголт, нэгдсэн статистик мэдээллийн тогтолцоо бүрэн бүрдээгүй байна. Тухайлбал, нийтийн ашиг сонирхлыг зөрчсөн үйлдлийг илчилснээр улсад учрах байсан хохирлоос урьдчилан сэргийлсэн тохиолдлыг бүртгэх, үнэлэх систем бий болоогүй бөгөөд зарим тохиолдолд авлигын шинжтэй асуудлыг шалгах асуудлыг илүү мэдээлэл өгсөн этгээдийг эхэлж тогтоох оролдлого гарч байгаа нь мэдээлэгчийн аюулгүй байдлыг хангах баталгааг сулруулах эрсдэлийг бий болгож байна.

Хэдийгээр зарим хууль тогтоомжид мэдээлэх үүрэг, мэдээлэгчийг урамшуулах зохицуулалт бий боловч мэдээлэгчийг хамгаалах механизм бүрэн бүрдээгүй байна. Тухайлбал, Агаарын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.10-т иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын явуулж байгаа үйл ажиллагаа нь агаар бохирдуулж, улмаар хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх түвшинд хүрсэн бол холбогдох байгууллагад шаардлага тавих, гомдол мэдүүлэх, мэдэгдэх үүргийг хуульчилсан. Мөн Амьтны тухай хуулийн 38 дугаар зүйлд зөрчил илрүүлсэн, мэдээлэл өгсөн иргэнийг урамшуулах зохицуулалтыг тусгаж, мэдээлэл нь батлагдсан тохиолдолд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн дүнгийн 15 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн шагналыг сум, дүүргийн Засаг дарга олгохоор заасан. Гэвч эдгээр зохицуулалт нь зөрчил үйлдэгдсэний дараа илрүүлсэн тохиолдолд олгогдохоор хязгаарлагдаж, мэдээлэл өгсний улмаас тухайн этгээдэд учирч болзошгүй дарамт,

¹ Transparency international (2017), People and corruption: Asia Pacific-Global corruption barometer.

өшөө авалт, хохирлоос хамгаалах асуудлыг зохицуулаагүй тул мэдээлэгчийг бодитоор дэмжсэн, хамгаалсан эрх зүйн баталгаа болж чадахгүй байна.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын 2024 оны Монгол Улсын авлигын эсрэг шинэчлэлийн тав дахь шатны хяналтын тайланд Монгол Улсад шүгэл үлээгчийг хамгаалах хууль эрх зүйн болон институцийн тогтолцоо бүрдээгүйг онцолж,² хуулийн төсөл батлагдаагүй хэвээр байгааг дурдсан.

Түүнчлэн, Транспэрэнси Интернэшнл байгууллагаас гаргадаг Авлигын төсөөллийн индексийн үзүүлэлтээр Монгол Улс 2023 онд 33 оноо авч 180 улсаас 121 дүгээр байрт, 2024 онд 33 оноо авч 114 дүгээр байрт, 2025 онд 31 оноо авч 182 улсаас 124 дүгээр байрт эрэмбэлэгдэн нь авлигаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх механизм хангалтгүй байгааг харуулж байна.

Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтэс нь 2025 онд 1766 өргөдөл, гомдол хүлээн авч, 2259 үйлдэлтэй, 1369 холбогдогчтой, 1911 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан нь өмнөх онтой харьцуулбал 2.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.³ Иргэд, байгууллагаас ирүүлж буй гомдол, мэдээллийн тоо нэмэгдэж байгаа боловч мэдээлэгчийг хамгаалах эрх зүйн болон институцийн механизм хангалтгүй байгаа нь мэдээлэхээс болгоомжлох нөхцөлийг бүрдүүлж, улмаар хууль бус үйлдлийг илрүүлэх боломжийг хязгаарлаж байна.

Нийтийн ашиг сонирхолд ноцтой хохирол учруулж болзошгүй аливаа хууль бус үйлдлийг илрүүлэхэд мэдээлэгчийн оролцоо чухал бөгөөд мэдээлэл өгсөн этгээдийг хамгаалах эрх зүйн баталгаа хангалтгүй тохиолдолд зөрчил, гэмт хэрэг илрэх боломж буурдаг. Иймд шүгэл үлээгчийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх нь шударга ёсны хэрэгжилтийг хангах, төр, иргэний итгэлцлийг бэхжүүлэхэд зайлшгүй шаардлагатай.

Олон улсын сайн туршлагад шүгэл үлээгчийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэхдээ хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах, хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх бие даасан, хараат бус, хангалттай эрх мэдэл, нөөц бүхий байгууллага ажиллах, уг байгууллага нь өш хонзон, ялгаварлан гадуурхалтын талаарх гомдлыг хүлээн авах, шалгах, шийдвэрлэх, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх боломжтой байх шаардлагатайг онцолдог. Мөн шүгэл үлээгчээс өш хонзон авах, өгсөн мэдээлэлтэй нь холбогдуулан аливаа байдлаар хохирол учруулах, ялгаварлан гадуурхахыг хориглох, түүний нэр хүнд, хувийн мэдээллийг хамгаалах, зөрчил гаргасан этгээдэд хариуцлага хүлээлгэх эрх зүйн механизмыг бүрдүүлэх нь хууль хэрэгжилтийг хангах, урьдчилан сэргийлэхэд үр дүнтэй болохыг зөвлөдөг.

Зохион байгуулалттай гэмт хэрэг, өндөр түвшний авлигын хэргийн хувьд шүгэл үлээгч болон түүний гэр бүлийн гишүүдийн амь нас, аюулгүй байдалд бодит эрсдэл учрах боломжтой тул шаардлагатай тохиолдолд хувийн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх боломжийг хууль тогтоомжид тусгах шаардлагатай. Түүнчлэн, шүгэл үлээгчид олгох нөхөн олговор нь шүгэл үлээсний улмаас учирсан хохирлыг нөхөн сэргээхэд, харин шагнал нь хууль бус үйлдлийг мэдээлэхийг дэмжихэд чиглэдэг бөгөөд эдгээрийг улс орнууд өөрийн онцлогт нийцүүлэн зохистой байдлаар зохицуулах нь зүйтэйг зөвлөсөн байна⁴.

²OECD 2024, Baseline report of fifth round of monitoring of anti-corruption reforms in Mongolia, The Istanbul Anti-corruption Action Plan, Istanbul Report-2024.pdf, Сүүлд үзсэн: 2026.02.03.

³ Авлигатай тэмцэх газрын 2025 оны үйл ажиллагааны тайлан, URL: https://iaac.mn/files/editor/source/iaac_report_2025.pdf.

⁴ Transparency International, a best practice guide for whistleblowing legislation, https://images.transparencycdn.org/images/2018_GuideForWhistleblowingLegislation_EN.pdf, Сүүлд үзсэн: 2026.02.03.

Иймд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нийтийн ашиг сонирхлыг зөрчсөн, эсхүл зөрчихөөр завдсан үйлдлийг мэдээлсэн, илчилсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад үндэслэлгүй татах, дарамт шахалт үзүүлэх, өш хонзон авах аливаа эрсдэлээс хамгаалах, тэднийг гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх эрх зүйн цогц зохицуулалтыг бүрдүүлэх зорилгоор уг хуулийн төслийг боловсруулна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийн зорилт нь нийтийн ашиг сонирхолд хохирол учруулсан, эсхүл учруулж болзошгүй нөхцөл байдлын талаар мэдээлсэн шүгэл үлээгчийг хамгаалах, дэмжих, шүгэл үлээгчийн нууцлал, аюулгүй байдлыг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, үйлчлэх хүрээ, нэр томъёоны тодорхойлолт, шүгэл үлээгчийг дэмжих, хамгаалах үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тогтооно.

Хоёрдугаар бүлэгт шүгэл үлээж мэдээлэл гаргах процессыг нарийвчлан зохицуулна. Тухайлбал, шүгэл үлээх мэдээлэлд тавигдах шаардлага, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, шилжүүлэх, хяналт шалгалт явуулах, холбогдох байгууллагад хүргүүлэх ажиллагааг тодорхой тусгана.

Гуравдугаар бүлэгт шүгэл үлээгч байгууллагын дотоод нэгжид мэдээлэл гаргах, төрийн нууцтай холбоотой асуудлаар тусгай сувгаар шүгэл үлээх боломжийг хангасан зохицуулалтыг тусгана.

Дөрөвдүгээр бүлэгт шүгэл үлээгч, түүний хамаарал бүхий этгээдийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой зохицуулалтыг тусгана.

Тавдугаар бүлэгт шүгэл үлээгчийн нийгмийн баталгааг хангахтай холбоотой харилцааг зохицуулж, шүгэл үлээсэн мэдээлэлтэй нь холбогдуулан шүгэл үлээгчид өш хонзонгийн шинжтэй аливаа заналхийлэл, дарамт үзүүлэхийг хориглохоор тусгана. Тодруулбал, албан тушаал бууруулах, албан тушаал дэвшүүлэхийг хязгаарлах, сахилгын шийтгэл оногдуулах, ажлаас халах, мэргэжлийн нэр хүнд, давуу байдал, нийгмийн баталгаа, хангамж, ашиг сонирхолд нь сөргөөр нөлөөлөх, бусад хэлбэрээр хохирол учруулах, хохирол учруулж болзошгүй үйлдлийг хориглохоор зохицуулна.

Зургаадугаар бүлэгт шүгэл үлээгчид мөнгөн урамшуулал олгох, мэдээлэл гаргасны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

Долоодугаар бүлэгт хамгаалалтын арга хэмжээ авах болон мөнгөн урамшуулал олгоход шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлж, хориглох зүйл, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох хугацааг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал

Хуулийн төсөл батлагдсанаар нийтийн ашиг сонирхлыг зөрчсөн үйлдлийн талаар аюулгүй байдлын баталгаатайгаар мэдээлэх эрх зүйн орчин бүрдэж, мэдээлэл өгөх, гомдол гаргах, хамгаалалтад авах үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй үзүүлэх нөхцөл бүрдэнэ. Үүний үр дүнд төрийн байгууллагад ирүүлэх мэдээлэл, гомдол, өргөдлийн тоо тодорхой хэмжээгээр нэмэгдэж, холбогдох байгууллагын хяналт шалгалт, шалган шийдвэрлэх ажиллагааны ачаалал өсөх боломжтой боловч зөрчил, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг эрт шатанд илрүүлэх, таслан зогсоох,

улмаар төр, орон нутгийн төсөв, төрийн өмч, нийтийн ашиг сонирхолд учирч болзошгүй хохирлоос урьдчилан сэргийлэх бодит үр нөлөө бий болно.

Мөн иргэд хууль бус үйлдлийг мэдээлэхдээ өш хонзон, дарамт шахалтаас болгоомжлох байдал буурч, байгууллагын дотоод хяналт сайжрах, төрийн үйлчилгээний чанар, үр нөлөөнд тавих олон нийтийн хяналт нэмэгдэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдэнэ. Ингэснээр төрийн байгууллагын үйл ажиллагаанд итгэх олон нийтийн итгэл бэхжих, хууль дээдлэх ёсны хэрэгжилтэд эерэг нөлөө үзүүлнэ.

Түүнчлэн, уг хууль нь авлига, ашиг сонирхлын зөрчил, нийтийн ашиг сонирхолд халдсан зөрчил, гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлж, авлигын эсрэг бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэх, Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд ач холбогдолтой. Үүний үр дүнд авлигатай тэмцэх үйл ажиллагааны үр нөлөө дээшилж, олон улсын үнэлгээ, индексийн үзүүлэлтэд эерэг өөрчлөлт гарах суурь нөхцөл бүрдэнэ.

Хуулийг хэрэгжүүлэх хүрээнд мэдээлэл хүлээн авах нэгдсэн суваг, бүртгэл, мэдээллийн санг бий болгох, холбогдох байгууллагын албан хаагчдыг сургах, арга зүйн заавар, дотоод журмыг батлах, олон нийтэд мэдээлэх, соён гэгээрүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээнд нийцсэн байх бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай зэрэг хуулийн төслийг боловсруулна.

---o0o---

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 5.6.5-д “Авлига, албан тушаалын гэмт хэргийн мэдээлэл хүлээн авах, нууцыг хадгалах тогтолцоог бэхжүүлж, энэ төрлийн гэмт хэргийг илчилсэн, мэдээлсэн хүнийг хамгаалах эрх зүйн үндсийг бүрдүүлж, авлигаас урьдчилан сэргийлэх төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагаа, олон нийтийн хяналтыг сайжруулна” гэж заасан.

Түүнчлэн, Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 4.1.3-т “Компанийн ёс зүйн дүрэм, журамд дотоод шүгэл үлээгчийг дэмжих, хамгаалах, урамшуулах зохицуулалтыг тусгах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлийг үл тэвчих, шүгэл үлээх соёлыг төлөвшүүлнэ” гэж, 5.1.8-д “Хулгайлагдсан хөрөнгийг илрүүлэх, цахим орчинд шинжилгээ хийх, санхүүгийн мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулах, гэрч, хохирогч, шүгэл үлээгч, мэдээлэгчийг хамгаалах болон аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий нэгжийг байгуулна” гэж, 6.4.3-т “Шүгэл үлээгчийг хамгаалах эрх зүйн орчныг бий болгох замаар шүгэл үлээх соёлыг төлөвшүүлнэ” гэж, 9.5.2-т “Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар олон нийтэд сурталчилна” гэж, 10.1.2-т “Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагад шүгэл үлээгчийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлнэ” гэж тус тус заасан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.2.1.3-т “авлига, ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх тогтолцоог хялбаршуулах, энэ төрлийн гэмт хэргийн эсрэг шүгэл үлээгчийг хамгаалах, дэмжих хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ” гэж заасан.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 45-д Монгол Улсын Засгийн газар Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг санаачлан боловсруулахаар тусгасан.

Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг нийтэд ил болгосныхоо төлөө тодорхой хувь хүн, бүлэг этгээд, аж ахуйн нэгж, албан тушаалтан, засаг захиргааны зүгээс ямарваа дарамт шахалтад өртөх, эрх чөлөөгөө хязгаарлуулах, хувь хүний эрх нь зөрчигдөх, хүчирхийлэлд өртөх улмаар үйл ажиллагаагаа хэвийн явуулж чадахгүйд хүрэх тохиолдол дэлхий нийтийн хэмжээнд байсаар байна.

Монгол Улсын хувьд 2002, 2016, 2023 онуудад Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг баталж мөрдүүлсэн хэдий ч шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийн эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна.

Нийтийн ашиг сонирхлын төлөө ажилласныхаа төлөө амь нас, бие махбодод нь халдахаар заналхийлэх, нэр төр, алдар хүндэд халдах, сэтгэл санааны дарамт

үзүүлэх, цахим орчинд доромжлох, мэдээлэл авах боломжийг хязгаарлах, мэдээлэл өгөхөөс татгалзах, үйл ажиллагааг нь үгүйсгэх, үл ойшоох, төвөгшөөх, төрийн байгууллагын зүгээс хүнд суртал гаргах, ялгаварлах, шударга бус хандах, цалин, нийгмийн халамжийг хязгаарлах, ажлаас халах, ажлын байрны дарамт үзүүлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлах зэрэг хүндрэл бэрхшээл тулгарч байна.

Монгол Улсад шүгэл үлээгчийн эрхийг хамгаалах тухай эрх зүйн ойлголт хангалттай бүрдээгүй, түүний дотор албан тушаалтантай холбоотой болон нийтийн ашиг сонирхлыг зөрчсөн, зөрчихөөр завдсан үйлдэлд шүгэл үлээгчийн эрхийг хамгаалсан, улсад учрах байсан хохирлоос урьдчилан сэргийлсэн, хамгаалсан гэх мэт статистик мэдээг хөтөлдөггүй байна. Харин албан тушаалтантай холбоотой “авлигын асуудлыг шалгахаасаа илүү авлигын мэдээллийг хэн өгч байгааг шалгах” тохиолдол байна.

Одоогоор нийтийн ашиг сонирхлын төлөө, аливаа төрлийн хохирол учруулж болзошгүй, эсхүл учруулсан зөрчлийн талаар мэдээлэх эрхийг баталгаажуулсан хэд хэдэн хууль тогтоомж үйлчилж байна. Тухайлбал, Агаарын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.10-т “Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь “иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын явуулж байгаа үйл ажиллагаа нь агаар бохирдуулж, улмаар хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх түвшинд хүрсэн бол холбогдох байгууллагад шаардлага тавих, гомдол мэдүүлэх, мэдэгдэх” үүрэгтэй тухай заасан.

Амьтны тухай хуулийн 38 дугаар зүйлд “Зөрчил илрүүлсэн, мэдээлэл өгсөн иргэнийг урамшуулах” талаар зохицуулсан бол тус зүйлийн 38.1-д “Амьтны тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийг илрүүлсэн, илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн буюу түүний тухай мэдээлэл өгсөн иргэнд уг мэдээлэл нь батлагдсан тохиолдолд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн хэмжээний 15 хувиар тооцож мөнгөн шагналыг сум, дүүргийн Засаг дарга олгоно” гэж заасан. Ийнхүү урамшуулал, мөнгөн шагналын талаар зохицуулсан хэдий ч урамшууллыг олгохдоо зөрчил үйлдэгдсэний дараа илрүүлсэн тохиолдолд сум, дүүргийн Засаг дарга мөнгөн шагналыг олгох тухай зохицуулсан байна.

Мөн мэдээлэл хүргэсэн хүнд хор хохирол учрах бол хэрхэн хамгаалах талаар зохицуулаагүй байгаа нь энэ талаарх мэдээлэгчийг дэмжсэн зохицуулалт гэж үзэхэд хангалтгүй юм.

2023 онд Транспэрэнси Интернэшнл байгууллагаас гаргадаг Авлигын төсөөллийн индекс (АТИ)-ийн дүнгээр Монгол Улс 33 оноо авч 180 улс орноос 121 дүгээр байрт, 2024 онд 33 оноо авч 114 дүгээр байрт, 2025 онд 31 оноо авч 182 улсаас 124 дүгээр байрт эрэмбэлэгдэн 10 байр ухарсан үзүүлэлттэй байна.

Үүнээс харахад, авлигын индекс буурч, хэлбэлзэж байгаа нь ардчилсан тогтолцоо бэхжээгүй, гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг улс төрийн намуудын төлөвшил муу, авлигын эсрэг хэрэгжүүлж буй арга хэмжээ нь хангалтгүй байгаагийн илрэл болж байна.

Ийнхүү дээр дурдсан хууль зүйн үндэслэл, практик хэрэгцээ, шаардлагыг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор, “Авилгалын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц”-ийн шаардлагад нийцүүлж Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлж, түүнд нийцүүлж хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд дараах асуудлыг тусгасан. Үүнд:

Нэгдүгээр бүлэг.Нийтлэг үндэслэл

Хуулийн төсөл нь нийтийн ашиг сонирхолд хохирол учруулсан, эсхүл учруулж болзошгүй нөхцөл байдлын талаар мэдээлсэн шүгэл үлээгчийг хамгаалах, дэмжих, шүгэл үлээгчийн нууцлал, аюулгүй байдлыг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулна.

Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, үйлчлэх хүрээ, нэр томьёоны тодорхойлолт, шүгэл үлээгчийг дэмжих, хамгаалах үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тодорхойллоо.

Хоёрдугаар бүлэг.Шүгэл үлээх

Дэлхийн улс орнуудад шүгэл үлээгчийн хамгаалалтыг “шүгэл үлээгчид хариу арга хэмжээ авсан албан тушаалтанд хариуцлага тооцох, буруутай үйл ажиллагаанд оролцохоос нь татгалзуулах, зарим тохиолдолд шүгэл үлээгч болон түүний гэр бүлийн гишүүдийг холбогдох байгууллага биечлэн хамгаалах, түүний хувийн мэдээллийг хамгаалах” байдлаар хэрэгжүүлдэг байна. Тодруулбал, шүгэл үлээгчийн зөвшөөрөлгүйгээр түүний хэн болох, хэн болохыг тодорхойлох боломжтой аливаа мэдээллийг шууд болон шууд бусаар мэдээлэл хүлээн авах эрх бүхий байгууллагаас ил болгохгүй байх, нэрээ нууцлан шүгэл үлээх боломжийг олгодог байна.

Иймд хуулийн төслийн 6 дугаар зүйлд авлига, ашиг сонирхлын зөрчил, гэмт хэрэг, эсхүл нийтийн ашиг сонирхлыг хохироосон, хохироож болзошгүй нөхцөл байдлыг шалгуулах талаарх мэдээллээ монгол хэл, өөрийн эх хэл, эсхүл сайн мэдэх хэл дээр амаар, эсхүл бичгээр гаргах боломжит хувилбарыг тусгаж, шүгэл үлээгчийн хувийн мэдээллийг нууцлах, мэдээллийг нууцалсан тохиолдолд холбоо барих арга, хэрэгслийг тодорхойлж, төлөөлөх эрх бүхий этгээдээр дамжуулан шүгэл үлээх процессыг нарийвчлан тусгасан. Тодруулбал, эрх бүхий байгууллага шүгэл үлээгчийн гаргасан мэдээллийг үнэлж, зөрчил, гэмт хэрэг шалгах, эсхүл хяналт шалгалт явуулах эрх бүхий байгууллагад харьяаллын дагуу шилжүүлэхээр зохицуулсан.

Хуулийн төслийн 9 дүгээр зүйлд шүгэл үлээсэн мэдээллийг хүлээн авах, бүртгэх, шилжүүлэх, хяналт тавих, санал, зөвлөмж гаргах эрх бүхий байгууллагыг нэгдсэн нэг тогтолцоотой байхаар тодорхойлж, эрх зүйн байдлыг хуульчилсан.

Гуравдугаар бүлэг.Мэдээлэх суваг

Шүгэл үлээгч байгууллагын дотоод нэгжид мэдээлэл гаргах, төрийн нууцтай холбоотой асуудлаар тусгай сувгаар шүгэл үлээх боломжийг хангасан зохицуулалтыг тусгалаа.

Дөрөвдүгээр бүлэг.Шүгэл үлээгчийн аюулгүй байдлыг хангах

Олон улсад шүгэл үлээгчийг шүгэл үлээснийхээ төлөө бие махбод, сэтгэл санаа, эд хөрөнгөөрөө хохирох эрсдэл өндөртэй байдаг тул шүгэл үлээгчийг хамгаалах зохицуулалтыг нэн чухал гэж үздэг бөгөөд дэлхийн 59 улс шүгэл үлээгчийг хамгаалах чиглэлээр эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна. Мөн OECD-ийн тайланд дурдсанаар, шүгэл үлээгчийг хамгаалах нь олон нийтийн эрх ашгийг

хамгаалах эцсийн хамгаалалтын шугам¹ гэж онцолсны дагуу шүгэл үлээгч эрхээ хэрэгжүүлэх баталгааг нарийвчлан зохицууллаа.

Тавдугаар бүлэг.Шүгэл үлээх баталгаа

Хуулийн төсөлд шүгэл үлээгчид заналхийлэл, дарамт үзүүлэх, түүний албан тушаал, цалин урамшуулал, зэрэг дэв, цол, түүний нэмэгдлийг нь бууруулах, албан тушаал дэвшүүлэхийг хязгаарлах, сахилгын шийтгэл оногдуулах, ажлаас халах, мэргэжлийн нэр хүнд, давуу байдал, нийгмийн баталгаа, хангамж, ашиг сонирхлыг алдагдуулах зэргээр хохирол учруулах, хохирол учруулж болзошгүй үйлдлийг хориглох зохицуулалтыг тусгасан.

Зургаадугаар бүлэг.Шүгэл үлээгчид нөхөн төлбөр, мөнгөн урамшуулал олгох

Шүгэл үлээгчийг хамгаалах тогтолцоотой улс орнуудын эрх зүйн зохицуулалт нь дараах 2 үндсэн санааг агуулдаг. Нэгдүгээрт, идэвх санаачилга гарган байгууллага доторх зүй бус үйлдлийн талаарх мэдээллийг илчлэхийг дэмжих болон боломжийг нэмэгдүүлэх зэргээр байгууллагын соёлыг өөрчлөх, хоёрдугаарт, ажилтнууд эрсдэлээс айхгүйгээр зүй бус үйлдлийг илчлэхэд зориулсан үе шаттай хамгаалалт болон урамшууллыг бий болгох зэрэг юм. Тодруулбал, улс орнууд буцаан авч чадсан хөрөнгийн тодорхой хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг урамшуулал болгож, АНУ-д 10-30%, Бүгд найрамдах Солонгос улсад хоёр тэрбум вон хүртэл 4-20%, Канад улсад 5-15% урамшууллыг шүгэл үлээгчдэд олгож байна.

Иймд олон улсын сайн туршлагыг харгалзан хуулийн төсөлд шүгэл үлээсэн мэдээллийг үндэслэн хуульд заасны дагуу зохих торгох ял оногдуулсны дүнд төлөх ёстой байсан төлбөрийг төлүүлсэн, хөрөнгө, орлогыг хураасан шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон тохиолдолд шүгэл үлээгчийн өргөдлийг үндэслэн урамшуулал олгох зохицуулалтыг тусгаж, урамшууллын нийт үнийн дүн нэг сая төгрөгөөс таван тэрбум төгрөг байхаар тусгалаа.

Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийг төрөөс урамшуулах, хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллагаас түргэн, шуурхай үйлчилгээ авах боломж бүрдүүлэх, төрийн үйлчилгээний чанар, үр нөлөөг хянах хүний эрхийг хангах, урамшуулан хамгаалах нэгдсэн тогтолцоо нь хуулийн хүрээнд үйлчилснээр төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч төрийн үйл ажиллагаанд итгэх нийгмийн итгэл дээшлэх юм.

Долоодугаар бүлэг.Бусад зүйл

Уг бүлэгт хамгаалалтын арга хэмжээ авах болон мөнгөн урамшуулал олгоход шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлж, хориглох зүйл, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох хугацааг тусгалаа.

Ийнхүү хуулийн төсөл батлагдсанаар иргэдэд тусгай чиг үүрэг бүхий төрийн байгууллагаас түргэн, шуурхай үйлчилгээ авах боломж бүрдэж, төрийн үйлчилгээний чанар, үр нөлөөг хянах хүний эрхийг хангах, эрх тэгш нөхцөл байдлыг хангах, урамшуулах, хамгаалах нэгдсэн тогтолцоотой болно. Ингэснээр төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч иргэдийн эрх зөрчигдөхөөс сэргийлэх, төрийн үйл ажиллагаанд итгэх нийгмийн итгэл дээшилнэ. Монгол Улс нэгдэн орсон олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэн, авлигаас ангижирсан улс болох

¹ National whistleblower center, “Whistleblower Laws Around the World”, 2016.

зорилтдоо хүрж, мөн олон улс дахь авлигын индексийн үзүүлэлтэд сайнаар нөлөөлнө гэж үзсэн болно.

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн боловсруулсан бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай зэрэг хуулийн төслийг боловсрууллаа.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуулийн төслийн талаар

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 58/4 дүгээр тогтоолоор баталсан “Авилгалын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц”-д Монгол Улс 2005 онд нэгдэн орж, соёрхон баталсан. Тус конвенцын 33 дугаар зүйлд “Оролцогч улс бүр энэхүү конвенцын дагуу тогтоосон гэмт хэргийн талаарх аливаа баримт нотолгоог сайн санааны үүднээс, үндэслэлтэйгээр эрх бүхий байгууллагад мэдээлж буй аливаа этгээдийг аливаа шударга бус хандлагаас хамгаалах зохих арга хэмжээг дотоодын эрх зүйн тогтолцоонд нэвтрүүлэх асуудлыг авч үзнэ” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 4.1.3-т “Компанийн ёс зүйн дүрэм, журамд дотоод шүгэл үлээгчийг дэмжих, хамгаалах, урамшуулах зохицуулалтыг тусгах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлийг үл тэвчих, шүгэл үлээх соёлыг төлөвшүүлнэ” гэж, 5.1.8-д “Хулгайлагдсан хөрөнгийг илрүүлэх, цахим орчинд шинжилгээ хийх, санхүүгийн мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулах, гэрч, хохирогч, шүгэл үлээгч, мэдээлэгчийг хамгаалах болон аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий нэгжийг байгуулна” гэж, 6.4.3-т “Шүгэл үлээгчийг хамгаалах эрх зүйн орчныг бий болгох замаар шүгэл үлээх соёлыг төлөвшүүлнэ” гэж, 9.5.2-т “Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар олон нийтэд сурталчилна” гэж, 10.1.2-т “Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагад шүгэл үлээгчийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлнэ” гэж тус тус заасан.

Түүнчлэн, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 5.6.5-д “Авлига, албан тушаалын гэмт хэргийн мэдээлэл хүлээн авах, нууцыг хадгалах тогтолцоог бэхжүүлж, энэ төрлийн гэмт хэргийг илчилсэн, мэдээлсэн хүнийг хамгаалах эрх зүйн үндсийг бүрдүүлж, авлигаас урьдчилан сэргийлэх төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагаа, олон нийтийн хяналтыг сайжруулна” гэж тусгасан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.2.1.3-т “авлига, ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх тогтолцоог хялбаршуулах, энэ төрлийн гэмт хэргийн эсрэг шүгэл үлээгчийг хамгаалах, дэмжих хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ” гэж заасан.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 45-д Монгол Улсын Засгийн газар Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулахаар тусгасан.

Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг нийтэд ил болгосныхоо төлөө тодорхой хувь хүн, бүлэг этгээд, аж ахуйн нэгж, албан тушаалтан, засаг захиргааны зүгээс ямарваа дарамт шахалтад өртөх, эрх чөлөөгөө хязгаарлуулах, хувь хүний эрх нь зөрчигдөх, хүчирхийлэлд өртөх улмаар үйл ажиллагаагаа хэвийн явуулж чадахгүйд хүрэх тохиолдол дэлхий нийтийн хэмжээнд байсаар байна.

Монгол Улсын хувьд 2002, 2016, 2023 онуудад Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг баталж мөрдүүлсэн хэдий ч шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийн эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна. Тодруулбал, Транспэрэнси интернэшнл байгууллагаас иргэдийн дунд авлигын талаар судалгаа зохион байгуулж “авлигын эсрэг иргэд тэмцэх хамгийн үр дүнтэй алхам юу вэ?” гэсэн асуултад тэдний ихэнх хувь нь “мэдээлэх”, мөн “хахууль өгөхгүй байх” гэж хариулсан байна. Улмаар уг судалгаагаар яагаад “мэдээлэх” буюу шүгэл үлээх алхмыг хийгээгүй шалтгааныг тодруулахад “үр дагавраас айдаг” гэж хариулсан байна.

Нийтийн ашиг сонирхлын төлөө ажилласныхаа төлөө амь нас, бие махбодод нь халдахаар заналхийлэх, нэр төр, алдар хүндэд халдах, сэтгэл санааны дарамт үзүүлэх, цахим орчинд доромжлох, мэдээлэл авах боломжийг хязгаарлах, мэдээлэл өгөхөөс татгалзах, үйл ажиллагааг нь үгүйсгэх, үл ойшоох, төвөгшөөх, төрийн байгууллагын зүгээс хүнд суртал гаргах, ялгаварлах, шударга бус хандах, цалин, нийгмийн халамжийг хязгаарлах, ажлаас халах, ажлын байрны дарамт үзүүлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлах зэрэг хүндрэл бэрхшээл тулгарч байна. Хүний эрх, нийгмийн шударга ёсны төлөө дуугарсан хүмүүсийн дуу хоолойг хаахыг оролдох, цахим орчинд үг хэлээр дайрч, доромжлох, сүрдүүлэх, нэр төрийг гутаах, хууль шүүхийн байгууллагад дуудаж дарамтлах, сүрдүүлэх байдал сүүлийн жилүүдэд манай улсад ихээр гарах болсон.

Монгол Улсад шүгэл үлээгчийн эрхийг хамгаалах тухай эрх зүйн ойлголт хангалттай бүрдээгүй, түүний дотор албан тушаалтантай холбоотой болон нийтийн ашиг сонирхлыг зөрчсөн, зөрчихөөр завдсан үйлдэлд шүгэл үлээгчийн эрхийг хамгаалсан, улсад учрах байсан хохирлоос урьдчилан сэргийлсэн, хамгаалсан гэх мэт статистик мэдээг хөтөлдөггүй байна. Харин албан тушаалтантай холбоотой “авлигын асуудлыг шалгахаасаа илүү авлигын мэдээллийг хэн өгч байгааг шалгах” тохиолдол байна.

Одоогоор нийтийн ашиг сонирхлын төлөө, аливаа төрлийн хохирол учруулж болзошгүй, эсхүл учруулсан зөрчлийн талаар мэдээлэх эрхийг баталгаажуулсан хэд хэдэн хууль тогтоомж үйлчилж байна. Тухайлбал, Агаарын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.10-т “Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь “иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын явуулж байгаа үйл ажиллагаа нь агаар бохирдуулж, улмаар хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх түвшинд хүрсэн бол холбогдох байгууллагад шаардлага тавих, гомдол мэдүүлэх, мэдэгдэх” үүрэгтэй тухай заасан.

Амьтны тухай хуулийн 38 дугаар зүйлд “Зөрчил илрүүлсэн, мэдээлэл өгсөн иргэнийг урамшуулах” талаар зохицуулсан бол тус зүйлийн 38.1-д “Амьтны тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийг илрүүлсэн, илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн буюу түүний тухай мэдээлэл өгсөн иргэнд уг мэдээлэл нь батлагдсан тохиолдолд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн хэмжээний 15 хувиар тооцож мөнгөн шагналыг сум, дүүргийн Засаг дарга олгоно” гэж заасан. Ийнхүү урамшуулал, мөнгөн шагналын талаар зохицуулсан хэдий ч урамшууллыг олгохдоо зөрчил үйлдэгдсэний дараа илрүүлсэн тохиолдолд сум, дүүргийн Засаг дарга мөнгөн шагналыг олгох тухай зохицуулсан байна.

Мөн мэдээлэл хүргэсэн хүнд хор хохирол учрах бол хэрхэн хамгаалах талаар зохицуулаагүй байгаа нь энэ талаарх мэдээлэгчийг дэмжсэн зохицуулалт гэж үзэхэд хангалтгүй юм.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага нь 2024 онд Монгол улсын авлигын эсрэг шинэчлэлийн тав дахь шатны хяналтын тайлан дахь шүгэл үлээгчийн эрх зүйн байдлыг үнэлсэн. Уг үнэлгээгээр Монгол Улсад шүгэл үлээгчийг хамгаалах хууль эрх зүйн болон институцийн тогтолцоо одоогоор байхгүй байгааг дурдсан байна.

Мөн 2023 онд Транспэрэнси Интернэшнл байгууллагаас гаргадаг Авлигын төсөөллийн индекс (АТИ)-ийн дүнгээр Монгол Улс 33 оноо авч 180 улс орноос 121 дүгээр байрт, 2024 онд 33 оноо авч 114 дүгээр байрт, 2025 онд 31 оноо авч 182 улсаас 124 дүгээр байрт эрэмбэлэгдэн 10 байр ухарсан үзүүлэлттэй байна.

Үүнээс харахад, авлигын индекс буурч, байнга хэлбэлзэж байгаа нь ардчилсан тогтолцоо бэхжээгүй, гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг улс төрийн намуудын төлөвшил муу, авлигын эсрэг хэрэгжүүлж буй арга хэмжээ нь хангалтгүй байгаагийн илрэл болж байна.

Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтэс нь 2025 онд 1766 өргөдөл, гомдол хүлээн авч, 2259 үйлдэлтэй, 1369 холбогдогчтой, 1911 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсныг 2024 онтой харьцуулбал 2.5 хувиар өссөн байна.¹ Хэдийгээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлж буй гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл өссөн, мөрдөн шалгах ажлын ачаалал ихэссэн байгаа ч Нийтийн ашиг сонирхлын эсрэг албан тушаалтан, иргэдийн хууль бус үйлдлийг мэдээлсэн нөхцөлд төрөөс урамшуулах, хамгаалах механизм хангалтгүй үйлчилж байгаа нь албан тушаалтан, иргэдийн хууль бус үйлдэл арга нь улам бүр нарийсан ард иргэд хохирсоор байна.

Гэмт хэргийг зөвхөн авлига, хээл хахуулийн шинжээр нь тодорхойлохоос илүүтэй бусад төрлийн нийгэмд аюултай, хор уршигтай, нийтийн эрх ашгийг хөндсөн, зөрчсөн тохиолдол бүрийг хууль сахиулах байгууллага, шүүх шалган тогтоох зайлшгүй шаардлага бий. Өөрөөр хэлбэл, төрийн алба хааж буй төрийн улс төрийн, төрийн тусгай, төрийн захиргааны, төрийн үйлчилгээний албан тушаалтантай холбогдох шалтгаан нөхцөлийг судлан нийтийн эрх ашгийг хөндсөн, зөрчсөн, зөрчихөөр завдаж буй тохиолдол буйг нотлох (Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.6 дугаар зүйлд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа хүнийг гэрч гэнэ.” гэж заасан), шүгэл үлээгчийг урамшуулан, хамгаалснаар төр иргэний хоорондын харилцааны хэлбэр сайжрах, шударга ёсны зарчим алдагдахгүй байх давуу талтай.

“Transparency International” олон улсын байгууллагаас шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуулийн төслийн талаарх гарын авлагад дараах зөвлөмжийг тусгасан байна. Үүнд:

- Шүгэл үлээхтэй холбоотой хууль тогтоомжийг хянах, хэрэгжилтийг нь хангах үүрэгтэй хараат бус агентлаг байх ёстой. Агентлагууд нь хараат бус, үр дүнтэй ажиллахуйц хангалттай эрх мэдэл, нөөц бололцоотой байх шаардлагатай. Шүгэл үлээгчдийг үр дүнтэй хамгаалахын тулд уг агентлаг нь дараах чиг үүргийг хэрэгжүүлэх чадвартай байх ёстой. Үүнд: Шударга бус хандлага болон шүгэл үлээгчийн мэдээллийг зохисгүйгээр шалгасан тохиолдолд гомдол хүлээн авах, мөрдөн шалгах, шийдвэрлэх; Шүгэл үлээгчдэд зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх зэрэг хамгаалалтыг авах шаардлагатай.

¹Авлигатай тэмцэх газрын 2025 оны үйл ажиллагааны тайлан, URL: https://iaac.mn/files/editor/source/iaac_report_2025.pdf.

-Transparency International байгууллагын 6-р зарчмаар улс орнууд өш хонзон авах, хохироох, ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг хориглох ёстой гэж заасан байдаг. Хориглох ёстой үйлдэл, эс үйлдэхүйн хэлбэрүүдийг нарийн жагсааж бичихээс зайлсхийх хэрэгтэй. Үр дүнтэй хамгаалалтад шүгэл үлээгчийн нэр хүнд болон хувийн мэдээллийг хамгаалах асуудал мөн багтах ёстой. Өш хонзонгийн үйлдэл гаргасан этгээдүүдэд хориг арга хэмжээ (торгууль, шийтгэл) оногдуулах заалттай байх нь хууль хэрэгжилтийг хангахад үр дүнтэй төдийгүй, ирээдүйд ийм үйлдэл гаргахыг сэрэмжлүүлэх нөлөөтэй.

-Зарим нөхцөл байдалд шүгэл үлээгчид өш хонзонгийн улмаас өөрийнх нь болон гэр бүлийнх нь амь нас, аюулгүй байдалд аюул учрах эрсдэлтэй болдог. Ийм хувийн хамгаалалт шаардлагатай нөхцөл байдал нь зохион байгуулалттай гэмт хэрэг, өндөр түвшний авлигын хэрэг зэрэгт, мөн бусад нөхцөлд ч үүсэж болдог. Хувийн хамгаалалт нь зөвхөн шүгэл үлээгчид төдийгүй нөлөөлөлд өртсөн гэр бүлийн гишүүдэд ч хамрах ёстой.

-Шүгэл үлээгчид олгох шагналыг нөхөн олговроос, ялангуяа санхүүгийн нөхөн төлбөрөөс ялгаж ойлгох хэрэгтэй. Нөхөн олговор нь шүгэл үлээсний улмаас шударга бус хандлагад өртсөн хүний нөхцөл байдлыг сэргээх, өөрөөр хэлбэл хэрвээ шүгэл үлээгээгүй бол байх байсан байдалд нь буцаан хүргэх зорилготой байдаг. Шагнал нь мөн шүгэл үлээгчийн нөхцөл байдлыг сайжруулахад тусалдаг ч үндсэн зорилго нь хүмүүсийг шүгэл үлээхэд урамшуулах юм. Улс орнууд хууль тогтоомждоо шүгэл үлээгчийг урамшуулахдаа өөрийн улсын онцлогт тохируулж зохистой байдлаар тогтоох шаардлагатай талаар болон холбогдох бусад асуудлуудыг мөн тусгасан байна.

Ийнхүү дээр дурдсан хууль зүйн үндэслэл, практик хэрэгцээ, шаардлагыг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор, “Авилгалын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц”-ийн шаардлагад нийцүүлж Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлж, түүнд нийцүүлж хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төслийг 7 бүлэг, 26 зүйлтэйгээр боловсруулсан бөгөөд хуулийн төслийг бүлэг тус бүрээр багцлан агуулгыг танилцуулья. Үүнд:

Нэгдүгээр бүлэг.Нийтлэг үндэслэл

Хуулийн төсөл нь нийтийн ашиг сонирхолд хохирол учруулсан, эсхүл учруулж болзошгүй нөхцөл байдлын талаар мэдээлсэн шүгэл үлээгчийг хамгаалах, дэмжих, шүгэл үлээгчийн нууцлал, аюулгүй байдлыг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулна.

Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, үйлчлэх хүрээ, нэр томъёоны тодорхойлолт, шүгэл үлээгчийг дэмжих, хамгаалах үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тодорхойллоо.

Хоёрдугаар бүлэг.Шүгэл үлээх

Дэлхийн улс орнуудад шүгэл үлээгчийн хамгаалалтыг “шүгэл үлээгчид хариу арга хэмжээ авсан албан тушаалтанд хариуцлага тооцох, буруутай үйл ажиллагаанд оролцохоос нь татгалзуулах, зарим тохиолдолд шүгэл үлээгч болон түүний гэр бүлийн гишүүдийг холбогдох байгууллага биечлэн хамгаалах, түүний хувийн мэдээллийг хамгаалах” байдлаар хэрэгжүүлдэг байна. Тодруулбал, шүгэл үлээгчийн зөвшөөрөлгүйгээр түүний хэн болох, хэн болохыг тодорхойлох

боломжтой аливаа мэдээллийг шууд болон шууд бусаар мэдээлэл хүлээн авах эрх бүхий байгууллагаас ил болгохгүй байх, нэрээ нууцлан шүгэл үлээх боломжийг олгодог байна.

Иймд хуулийн төслийн 6 дугаар зүйлд авлига, ашиг сонирхлын зөрчил, гэмт хэрэг, эсхүл нийтийн ашиг сонирхлыг хохироосон, хохироож болзошгүй нөхцөл байдлыг шалгуулах талаарх мэдээллээ монгол хэл, өөрийн эх хэл, эсхүл сайн мэдэх хэл дээр амаар, эсхүл бичгээр гаргах боломжит хувилбарыг тусгаж, шүгэл үлээгчийн хувийн мэдээллийг нууцлах, мэдээллийг нууцалсан тохиолдолд холбоо барих арга, хэрэгслийг тодорхойлж, төлөөлөх эрх бүхий этгээдээр дамжуулан шүгэл үлээх процессыг нарийвчлан тусгасан. Тодруулбал, эрх бүхий байгууллага шүгэл үлээгчийн гаргасан мэдээллийг үнэлж, зөрчил, гэмт хэрэг шалгах, эсхүл хяналт шалгалт явуулах эрх бүхий байгууллагад харьяаллын дагуу шилжүүлэхээр зохицуулсан.

Хуулийн төслийн 9 дүгээр зүйлд шүгэл үлээсэн мэдээллийг хүлээн авах, бүртгэх, шилжүүлэх, хяналт тавих, санал, зөвлөмж гаргах эрх бүхий байгууллагыг нэгдсэн нэг тогтолцоотой байхаар тодорхойлж, эрх зүйн байдлыг хуульчилсан.

Гуравдугаар бүлэг.Мэдээлэх суваг

Шүгэл үлээгч байгууллагын дотоод нэгжид мэдээлэл гаргах, төрийн нууцтай холбоотой асуудлаар тусгай сувгаар шүгэл үлээх боломжийг хангасан зохицуулалтыг тусгалаа.

Дөрөвдүгээр бүлэг.Шүгэл үлээгчийн аюулгүй байдлыг хангах

Олон улсад шүгэл үлээгчийг шүгэл үлээснийхээ төлөө бие махбод, сэтгэл санаа, эд хөрөнгөөрөө хохирох эрсдэл өндөртэй байдаг тул шүгэл үлээгчийг хамгаалах зохицуулалтыг нэн чухал гэж үздэг бөгөөд дэлхийн 59 улс шүгэл үлээгчийг хамгаалах чиглэлээр эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна. Мөн OECD-ийн тайланд дурдсанаар, шүгэл үлээгчийг хамгаалах нь олон нийтийн эрх ашгийг хамгаалах эцсийн хамгаалалтын шугам² гэж онцолсны дагуу шүгэл үлээгч эрхээ хэрэгжүүлэх баталгааг нарийвчлан зохицууллаа.

Тавдугаар бүлэг.Шүгэл үлээх баталгаа

Хуулийн төсөлд шүгэл үлээгчид заналхийлэл, дарамт үзүүлэх, түүний албан тушаал, цалин урамшуулал, зэрэг дэв, цол, түүний нэмэгдлийг нь бууруулах, албан тушаал дэвшүүлэхийг хязгаарлах, сахилгын шийтгэл оногдуулах, ажлаас халах, мэргэжлийн нэр хүнд, давуу байдал, нийгмийн баталгаа, хангамж, ашиг сонирхлыг алдагдуулах зэргээр хохирол учруулах, хохирол учруулж болзошгүй үйлдлийг хориглох зохицуулалтыг тусгасан.

Зургаадугаар бүлэг.Шүгэл үлээгчид нөхөн төлбөр, мөнгөн урамшуулал олгох

Шүгэл үлээгчийг хамгаалах тогтолцоотой улс орнуудын эрх зүйн зохицуулалт нь дараах 2 үндсэн санааг агуулдаг. Нэгдүгээрт, идэвх санаачилга гарган байгууллага доторх зүй бус үйлдлийн талаарх мэдээллийг илчлэхийг дэмжих болон боломжийг нэмэгдүүлэх зэргээр байгууллагын соёлыг өөрчлөх, хоёрдугаарт, ажилтнууд эрсдэлээс айхгүйгээр зүй бус үйлдлийг илчлэхэд зориулсан үе шаттай

² National whistleblower center, “Whistleblower Laws Around the World”, 2016.

хамгаалалт болон урамшууллыг бий болгох зэрэг юм. Тодруулбал, улс орнууд буцаан авч чадсан хөрөнгийн тодорхой хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг урамшуулал болгож, АНУ-д 10-30%, Бүгд найрамдах Солонгос улсад хоёр тэрбум вон хүртэл 4-20%, Канад улсад 5-15% урамшууллыг шүгэл үлээгчдэд олгож байна.

Иймд олон улсын сайн туршлагыг харгалзан хуулийн төсөлд шүгэл үлээсэн мэдээллийг үндэслэн хуульд заасны дагуу зохих торгох ял оногдуулсны дүнд төлөх ёстой байсан төлбөрийг төлүүлсэн, хөрөнгө, орлогыг хураасан шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон тохиолдолд шүгэл үлээгчийн өргөдлийг үндэслэн урамшуулал олгох зохицуулалтыг тусгаж, урамшууллын нийт үнийн дүн нэг сая төгрөгөөс таван тэрбум төгрөг байхаар тусгалаа.

Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийг төрөөс урамшуулах, хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллагаас түргэн, шуурхай үйлчилгээ авах боломж бүрдүүлэх, төрийн үйлчилгээний чанар, үр нөлөөг хянах хүний эрхийг хангах, урамшуулан хамгаалах нэгдсэн тогтолцоо нь хуулийн хүрээнд үйлчилснээр төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч төрийн үйл ажиллагаанд итгэх нийгмийн итгэл дээшлэх юм.

Долоодугаар бүлэг.Бусад зүйл

Уг бүлэгт хамгаалалтын арга хэмжээ авах болон мөнгөн урамшуулал олгоход шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлж, хориглох зүйл, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох хугацааг тусгалаа.

Ийнхүү хуулийн төсөл батлагдсанаар иргэдэд тусгай чиг үүрэг бүхий төрийн байгууллагаас түргэн, шуурхай үйлчилгээ авах боломж бүрдэж, төрийн үйлчилгээний чанар, үр нөлөөг хянах хүний эрхийг хангах, эрх тэгш нөхцөл байдлыг хангах, урамшуулах, хамгаалах нэгдсэн тогтолцоотой болно. Ингэснээр төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч иргэдийн эрх зөрчигдөхөөс сэргийлэх, төрийн үйл ажиллагаанд итгэх нийгмийн итгэл дээшилнэ.

Түүнчлэн, нийгэмд үүсээд байгаа авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх, шударга ёсыг бэхжүүлэхэд чухал алхам болно. Монгол Улс нэгдэн орсон олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэн, авлигаас ангижирсан улс болох зорилтдоо хүрж, мөн олон улс дахь авлигын индексийн үзүүлэлтэд сайнаар нөлөөлнө гэж үзсэн болно.

Хуулийн төсөл батлагдсанаар улсын төсвөөс нэмэлт санхүүжилт шаардлагагүй болно.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээнд нийцсэн бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай зэрэг хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төслийг танилцуулах олон нийтийн хэлэлцүүлгийг 2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яамны хурлын танхимд зохион байгуулсан болно.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ШҮГЭЛ ҮЛЭЭГЧИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь нийтийн ашиг сонирхолд хохирол учруулсан, эсхүл учруулж болзошгүй нөхцөл байдлын талаар мэдээлсэн шүгэл үлээгчийг хамгаалах, дэмжих, шүгэл үлээгчийн нууцлал, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хууль тогтоомж

2.1.Шүгэл үлээгчийг хамгаалах хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Авлигын эсрэг хууль², Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль³, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль⁴, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль⁵, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Энэ хууль нь нийтийн ашиг сонирхолд хохирол учруулсан, эсхүл учруулж болзошгүй нөхцөл байдлын талаар мэдээлсэн шүгэл үлээгчийг аливаа дарамт шахалт, өс хонзон, ялгаварлан гадуурхалт болон эрх зүйн байдлыг нь дордуулах бусад үйлдлээс хамгаалах, шүгэл үлээгчийг дэмжих, түүний нууцлал, аюулгүй байдлыг нь хангахтай холбогдсон харилцааг зохицуулна.

3.2.Шүгэл үлээгч нь мэдээлэл гаргах үед тухайн мэдээлэл нийтийн ашиг сонирхолд хохирол учруулсан, эсхүл учруулж болзошгүй гэж үзэх хангалттай үндэслэлтэй байсан бол шалгалтын үр дүнгээс үл хамааран энэ хуульд заасан шууд хамгаалалт үйлчилнэ.

¹ Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

² Авлигын эсрэг хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2006 оны 35 дугаарт нийтлэгдсэн.

³ Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2019 оны 42 дугаарт нийтлэгдсэн.

⁴ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

⁵ Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2013 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

3.3. Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийн талаар шүгэл үлээх тохиолдолд тухайн мэдээллийг энэ хуульд заасан тусгай сувгаар мэдээлнэ. Тусгай сувгаар мэдээлсэн шүгэл үлээгчид энэ хуульд заасан хамгаалалт нэгэн адил үйлчилнэ.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“шүгэл үлээх” гэж шүгэл үлээгч ажил, хөдөлмөр эрхлэх, албаны чиг үүргээ хэрэгжүүлэх, мэргэжлийн болон аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх хүрээнд олж мэдсэн, өөрт нь ил болсон нийтийн ашиг сонирхлыг хохироосон, эсхүл хохироож болзошгүй нөхцөл байдлын талаар мэдээлэл, баримт сэлт гаргаж өгөхийг;

4.1.2.“нийтийн ашиг сонирхлыг хохироосон, эсхүл хохироож болзошгүй нөхцөл байдал” гэж дараах харилцаанд хамаарах хууль тогтоомж зөрчсөн, эсхүл зөрчих эрсдэлтэй нийтийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх үйлдэл, эс үйлдэхүйг:

4.1.2.а.авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчил;

4.1.2.б.төрийн болон орон нутгийн өмч, төсөв, татвар, хураамж;

4.1.2.в.Эрүүгийн хуулийн Арван есдүгээр, Хорьдугаар, Хорин дөрөвдүгээр, Хорин есдүгээр бүлэгт заасан гэмт хэргийн шинжийг агуулсан.

4.1.3.“шүгэл үлээгч” гэж энэ хуулийн 4.1.1-д заасан мэдээллийг гаргасан хүн, хуулийн этгээдийг;

4.1.4.“хамаарал бүхий этгээд” гэж шүгэл үлээгчийн гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, болон шүгэл үлээсэнтэй холбоотойгоор сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй бусад этгээдийг;

4.1.5.“нэргүй мэдээлэл” гэж мэдээлэл гаргасан этгээдийн хэн болохыг мэдээлэл хүлээн авагч тогтоох боломжгүй мэдээллийг;

4.1.6.“нууцалсан мэдээлэл” гэж шүгэл үлээгчийн хувийн мэдээлэл, түүнийг таних боломжтой аливаа мэдээллийг задруулахгүй байх нөхцөлтэйгөөр гаргасан мэдээллийг.

5 дугаар зүйл.Шүгэл үлээгчийг хамгаалах, дэмжих үйл ажиллагаанд баримтлах зарчим

5.1.Шүгэл үлээгчийг хамгаалах, дэмжих үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

5.1.1.хүний эрх, эрх чөлөөг дээдлэх;

5.1.2.нууцлал, аюулгүй байдлыг хангах;

5.1.3.мэдээлэх сувгийн хүртээмж, найдвартай байдлыг хангах;

5.1.4.ялгаварлан гадуурхахгүй байх, өс хонзон авахыг хориглох;

5.1.5.шударга, хараат бус байдлыг хангах;

5.1.6. шуурхай, үр нөлөөтэй ажиллагааг хангах.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ШҮГЭЛ ҮЛЭЭХ

6 дугаар зүйл. Мэдээлэл хүлээн авах

6.1. Шүгэл үлээгч нь нийтийн ашиг сонирхлыг хохироосон, эсхүл хохироож болзошгүй нөхцөл байдлын талаарх мэдээллийг амаар, бичгээр, эсхүл цахим хэлбэрээр гаргаж болно.

6.2. Шүгэл үлээгч мэдээллээ монгол хэл, өөрийн эх хэл, эсхүл мэддэг хэлээр гаргаж болно.

6.3. Энэ хуулийн 6.1-д заасан мэдээлэлд дараах асуудлыг тусгасан байна:

6.3.1. нийтийн ашиг сонирхлыг хохироосон, эсхүл хохироож болзошгүй нөхцөл байдалд холбогдох этгээдийн овог, нэр, албан тушаал болон тухайн этгээдийг тодорхойлох боломжтой бусад мэдээлэл;

6.3.2. нийтийн ашиг сонирхлыг хохироосон, эсхүл хохироож болзошгүй нөхцөл байдлын талаарх мэдээлэл, хуулийн дагуу олж авсан ач холбогдол бүхий, аливаа баримт сэлт;

6.3.3. шүгэл үлээгчээс шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.

6.4. Шүгэл үлээгч нь төлөөлөгчөөр дамжуулан, нууцалсан болон нэргүй мэдээлэл гаргаж болно. Төлөөлөгчөөр дамжуулан мэдээлэл гаргасан тохиолдолд төлөөлөгчөөс мэдээллийн эх сурвалжийг задруулахыг төлөөлөгчөөс шаардахыг хориглоно. Төлөөлөгчид энэ хуульд заасан хамгаалалт шүгэл үлээгчийн нэгэн адил үйлчилнэ.

6.5. Амаар гаргасан мэдээллийг хүлээн авсан эрх бүхий албан тушаалтан тэмдэглэл үйлдэж, шүгэл үлээгчид танилцуулан баталгаажуулна. Шүгэл үлээгч гарын үсэг зурахаас татгалзсан нь мэдээллийг хүлээн авахаас татгалзах үндэслэл болохгүй.

6.6. Шүгэл үлээгч нууцалсан мэдээлэл гаргасан тохиолдолд түүнтэй холбоо барих арга, хэрэгслийг энэ хуулийн 8.1, 13.2, 14.3-т заасан эрх бүхий албан тушаалтан хариуцна.

6.7. Энэ хуулийн 6.6-д заасан тохиолдолд шүгэл үлээгчийн хувийн мэдээллийг шалгалт явуулах албан тушаалтанд задруулахыг хориглоно. Ийм мэдээллийг шүгэл үлээгчийг дэмжих нэгж тусгаарлан хадгална.

6.8. Мэдээлэл хүлээн авах эрх бүхий албан тушаалтан шаардлагатай бол шүгэл үлээгчээс гаргасан мэдээлэлтэй холбогдуулан нэмэлт мэдээлэл, тайлбар гаргуулан авч болно.

6.9. Шүгэл үлээгчийг дэмжих нэгж мэдээллийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор хүлээн авсан тухай мэдэгдэж, 30 хоногийн дотор авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар шүгэл үлээгчид мэдээлнэ.

7 дугаар зүйл.Мэдээлэл хүлээн авахаас татгалзах

7.1.Дараах тохиолдолд мэдээллийг хүлээн авахгүй:

7.1.1.өмнө нь шалгагдаж, эрх бүхий байгууллага эцэслэн шийдвэрлэсэн асуудлаар шинэ нөхцөл байдал, баримтгүйгээр давтан мэдээлэл гаргасан;

7.1.2.цахим орчин, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд ил болсон мэдээллээс өөр шинэ баримт агуулаагүй;

7.1.3.мэдээлэл болон түүнд дурдсан нөхцөл байдал нь энэ хуульд заасан нийтийн ашиг сонирхолд хамаарахгүй.

7.2.Мэдээллийг хүлээн авахаас татгалзсан тохиолдолд энэ талаар мэдээлэл гаргагчид 7 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

8 дугаар зүйл.Нэргүй мэдээлэл гаргах

8.1.Шүгэл үлээгч нь нэргүй мэдээлэл гаргаж болно.

8.2. Нэргүй мэдээлэл нь нийтийн ашиг сонирхлыг хохироосон, эсхүл хохироож болзошгүй нөхцөл байдлын талаар үндэслэл бүхий баримт, мэдээллийг агуулсан бол уг мэдээллийг хүлээн авахаас татгалзахыг хориглоно.

8.3.Нэргүй мэдээлэл гаргасан шүгэл үлээгчийн хэн болохыг тогтоох зорилгоор мэдээлэл цуглуулах, мөрдөн мөшгөхийг хориглоно.

9 дүгээр зүйл.Мэдээлэл хүлээн авах, бүртгэх, шилжүүлэх эрх бүхий этгээд

9.1.Шүгэл үлээсэн мэдээллийг хүлээн авах, бүртгэх, шилжүүлэх, хамгаалалтыг зохион байгуулах чиг үүрэг бүхий нэгж /цаашид “Шүгэл үлээгчийг дэмжих нэгж” гэх/ Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлын албанд ажиллана.

9.2.Шүгэл үлээгчийг дэмжих нэгж дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

9.2.1.мэдээллийг хүлээн авах, бүртгэх;

9.2.2.мэдээллийг шалгах эрх бүхий байгууллага, албан тушаалтан /цаашид “эрх бүхий байгууллага, албан тушаалтан” гэх/-д шилжүүлэх;

9.2.3.шилжүүлсэн мэдээллийн шалгалт, шийдвэрлэлтийн явцын талаар мэдээлэл авч, шүгэл үлээгчид мэдэгдэх;

9.2.4.хамгаалалтын арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

9.2.5.мэдээллийн сан бүрдүүлж, нууцлал, аюулгүй байдлыг хангах;

9.2.6.энэ хуулийн хэрэгжилт болон шүгэл үлээгчийн хамгаалах, дэмжих ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, шүгэл үлээгчийг хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар санал, зөвлөмж гаргах, эрх бүхий байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд хүргүүлэх;

9.2.7.шүгэл үлээгчид урамшуулал, нөхөн төлбөр олгох үндэслэлийг хянаж шийдвэрлүүлэх;

9.2.8.шүгэл үлээгчийг хамгаалах хууль тогтоомжийг сурталчлан таниулах, сургалт зохион байгуулах;

9.2.9.шүгэл үлээгчид хууль зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах;

9.2.10.шүгэл үлээгч болон мэдээлэл гаргахаар төлөвлөж буй этгээдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх;

9.2.11. Эрх бүхий байгууллага, албан тушаалтан хуульд заасан журмын дагуу шалгах, шийдвэрлэх ажиллагааг явуулж байгаа эсэхэд хяналт тавих, мөн шүгэл үлээгчийн мэдээллийг хууль тогтоомжид заасан журмын дагуу шалгаагүй, үл хайхарсан, мэдээллийн нууцлалыг алдагдуулсан, шүгэл үлээгчид аюул, заналхийлэл учруулсан болон хууль тогтоомжид харшилсан бусад үйлдэл, эс үйлдэхүй илэрсэн тохиолдолд энэ талаар дээд шатны байгууллагад нь, шаардлагатай бол хуульд заасан журмын дагуу олон нийтэд мэдээлэх;

9.2.12.энэ хуулийн 18.1-д заасан шүгэл үлээгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх үйлдэл, эс үйлдэхүйн талаар хяналт, шалгалт явуулах, зөрчлийг таслан зогсоох, арилгуулах талаар зөвлөмж, санал, дүгнэлт гаргах;

9.2.13.шүгэл үлээгчийг хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар жил бүр нэгдсэн тайлан гаргаж, нийтэд мэдээлэх;

9.2.14.энэ хуулийн 13, 14 дүгээр зүйлд заасан мэдээлэх сувгийг хариуцсан ажилтан, албан тушаалтанд заавар, зөвлөгөө өгөх;

9.2.15.хуульд заасан бусад.

9.3. Шүгэл үлээгчийг таних боломжтой аливаа мэдээллийг түүний бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр задруулахыг хориглоно. Шаардлагатай тохиолдолд мэдээллийг шилжүүлэхдээ шүгэл үлээгчийг тодорхойлох боломжтой мэдээллийг нууцална.

10 дугаар зүйл.Шүгэл үлээгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулсан, эсхүл учруулж болзошгүй нөхцөл байдлын талаар шалгалт хийх

10.1. Шүгэл үлээгчийг дэмжих нэгж нь шүгэл үлээгчийн гаргасан мэдээлэлтэй холбогдуулан түүний эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулсан, эсхүл учруулж болзошгүй нөхцөл байдлын талаар шүгэл үлээгчийн гомдлыг үндэслэн шалгалт явуулж болно.

10.2.Энэ хуулийн 10.1-д заасан шалгалт нь дараах асуудлыг тогтоох зорилготой байна:

10.2.1.тухайн үйлдэл, эс үйлдэхүй нь шүгэл үлээгчээс мэдээлэл гаргасантай холбоотой эсэх;

10.2.2.өс хонзон авах шинжтэй эсэх;

10.2.3.шүгэл үлээгчийн эрх зүйн байдлыг дордуулсан эсэх;

10.2.4.шүгэл үлээгчийн аюулгүй байдалд эрсдэл үүссэн эсэх;

10.2.5.энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан мэдээлэх суваг бий болгосон эсэх;

10.2.6.шүгэл үлээгчийн гаргасан мэдээллийн дагуу зохих арга хэмжээг авсан эсэх, шүгэл үлээгч болон мэдээллийн нууцлалыг хангах шаардлагатай арга хэмжээг авсан эсэх;

10.2.7.хуульд заасан бусад.

10.3.Шалгалтыг хийх талаар Шүгэл үлээгчийг дэмжих нэгж дараах эрх эдэлнэ:

10.3.1.ажил олгогч, холбогдох байгууллага, албан тушаалтнаас тайлбар, мэдээлэл, баримт бичиг шаардах;

10.3.2.ажил олгогч, холбогдох байгууллагад очиж нөхцөл байдалтай танилцах;

10.3.3.ажил олгогч, холбогдох байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн шийдвэр, захиргааны акттай танилцах;

10.3.4.холбогдох албан тушаалтнаас тайлбар, мэдээлэл авах;

10.3.5.шаардлагатай бол мэргэжлийн байгууллага, шинжээчээр дүгнэлт гаргуулах.

10.4.Шалгалтыг гомдол хүлээн авснаас хойш 30 хоногийн хугацаанд явуулна. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг нэг удаа 30 хоногоор сунгаж болно.

10.5. Шалгалтын явцад шүгэл үлээгчид ноцтой эрсдэл үүссэн гэж үзвэл шүгэл үлээгчийг дэмжих нэгж холбогдох байгууллага, албан тушаалтанд хуульд заасан журмын дагуу зөрчил, эрсдэлийг таслан зогсоох арга хэмжээ авах тухай шаардлага хүргүүлж болно.

10.6.Ажил олгогч, холбогдох байгууллага энэ хуулийн 10.5-д заасан шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

10.7.Шалгалтын хүрээнд Шүгэл үлээгчийг дэмжих нэгж зөрчлийг таслан зогсоох, шүгэл үлээгчийн зөрчигдсөн эрхийг сэргээх, түүнд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар зөвлөмж, дүгнэлт гаргана.

10.8.Ажил олгогч, холбогдох байгууллага зөвлөмж, дүгнэлтийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор бичгээр хариу ирүүлэх үүрэгтэй. Хэрэв биелүүлэхээс татгалзсан бол шүгэл үлээгчийг дэмжих нэгж, эсхүл шүгэл үлээгч дээд шатны байгууллагад хандах, эсхүл шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

10.9.Шүгэл үлээгчийг дэмжих нэгжийн шаардлага, зөвлөмжийг биелүүлээгүй тохиолдолд холбогдох албан тушаалтан, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хуульд заасан хариуцлага хүлээлгэх талаар эрх бүхий байгууллагад санал гаргах үндэслэл болно.

11 дүгээр зүйл.Мэдээллийг шалгах

11.1.Эрх бүхий байгууллага нь мэдээллийг хүлээн авсан тухайгаа Шүгэл үлээгчийг дэмжих нэгжид мэдэгдэж, шалгалтын явц, шийдвэрлэлтийн талаар холбогдох мэдээллийг шүгэл үлээгчид, эсхүл шүгэл үлээгчийг дэмжих нэгжид 14 хоногийн дотор хүргүүлнэ.

11.2. Шүгэл үлээгчийн гаргасан мэдээллийг шалгахтай холбогдсон харилцааг холбогдох хууль тогтоомжид заасан журмаар зохицуулна. Шүгэл үлээгчийг дэмжих нэгж нь шалгалтын агуулга, явц, эцсийн шийдвэрт нөлөөлөх, шалгалтын ажиллагааг хэрхэн явуулах талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд заавар, чиглэл өгөх зэргээр шийдвэр гаргах ажиллагаанд нөлөөлөхийг хориглоно.

11.3.Энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсэг, 8 дугаар зүйлд заасан тохиолдолд эрх бүхий байгууллага шүгэл үлээгчийн хувийн мэдээлэл, түүнийг таних боломжтой аливаа мэдээллийг задруулах, таних боломж бүрдүүлэх үйлдэл хийхийг хориглоно.

11.4. Шалгалт явуулахад зайлшгүй шаардлагатай бөгөөд өөр аргаар нийтийн ашиг сонирхлыг хохироосон, эсхүл хохироож болзошгүй нөхцөл байдлыг нотлох боломжгүй тохиолдолд энэ хуулийн 6.6-д заасан шүгэл үлээгчийн хувийн мэдээллийг ил болгох асуудлыг шүгэл үлээгчийг дэмжих нэгжид хүргүүлж шийдвэрлүүлнэ. Энэ тохиолдолд шүгэл үлээгчид урьдчилан мэдэгдэж, түүний зөвшөөрлийг авна.

11.5.Эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь шүгэл үлээгчийн хэн болохыг тогтоох зорилгоор түүнийг дуудан илрүүлэх, тайлбар авах, дарамт шахалт үзүүлэх, мэдээллээ татан авахыг шаардахыг хориглоно.

12 дугаар зүйл.Олон нийтэд хандах

12.1.Шүгэл үлээгч дараах тохиолдолд өөрийн гаргасан мэдээлэлтэй холбогдох асуудлаар хэвлэл мэдээллийн байгууллага, олон нийтэд мэдээлж болно.

12.1.1.шүгэл үлээгчийн гаргасан мэдээллийг шалгаж, хуульд заасан хугацаанд хариу мэдэгдээгүй;

12.1.2.нотлох баримт устах, гэмт хэрэг, зөрчил үргэлжлэх, түүнийг нуун дарагдуулах бодит эрсдэл үүссэн;

12.1.3.гаргасан мэдээлэлд дурдсан гэмт хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтан өөрөө уг хэрэгт холбогдсон гэх үндэслэлтэй;

12.1.4.шүгэл үлээгчийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, нийтийн аюулгүй байдалд ноцтой хохирол, хор уршиг учирч болзошгүй;

12.1.5.мэдээллийг нэн даруй олон нийтэд хүргэх нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зайлшгүй шаардлагатай бусад үндэслэл.

12.2.Шүгэл үлээгчийг олон нийтэд мэдээлэл гаргасан нь энэ хуульд заасан хамгаалалт, дэмжлэг, баталгаанд хамрагдахад саад болохгүй.

12.3.Шүгэл үлээгчийн гаргасан мэдээллийг нийтэлсэн хэвлэл мэдээллийн байгууллага, ажилтнаас уг мэдээлэлтэй нь холбогдуулан гэрчээр мэдүүлэг авах,

мэдээллийн эх сурвалжаа илчлэхийг шаардах, шүгэл үлээгчийн хувийн мэдээллийг гаргуулан авахыг хориглоно.

12.4.Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийг энэ зүйлийн дагуу олон нийтэд мэдээлэхийг хориглоно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ МЭДЭЭЛЭХ СУВАГ

13 дугаар зүйл.Дотоод мэдээлэх суваг

13.1.Тавь ба түүнээс дээш ажилтантай төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн өмчийн оролцоотой, түүнчлэн хувийн хэвшлийн хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагад /цаашид “байгууллага” гэх/ нь шүгэл үлээгчийн мэдээллийг хүлээн авах дотоод сувгийг байгуулж, тогтмол ажиллагааг хангана.

13.2.Дотоод мэдээлэх суваг нь дараах шаардлагыг хангасан байна:

13.2.1.шүгэл үлээгчийн нэр, хувийн мэдээллийг нууцлах, шүгэл үлээгч нэргүй мэдээлэл, нууцалсан мэдээлэл гаргах боломж, нөхцөлийг хангасан техникийн болон зохион байгуулалтын бүтэцтэй байх;

13.2.2.бичгээр, амаар, цахим хэлбэрээр мэдээлэл гаргах боломжтой байх;

13.2.3.мэдээллийг хүлээн авах, бүртгэх, хадгалах журамтай байх;

13.2.4.мэдээллийг хүлээн авах, урьдчилан шалгах асуудлыг хариуцсан ажилтан, эсхүл нэгжтэй байх.

13.3.Шүгэл үлээгч дотоод мэдээлэх суваг ашиглан мэдээлэл гаргасан тохиолдолд байгууллага дараах үүрэгтэй:

13.3.1.шүгэл үлээгчийг аливаа дарамт шахалт, хүчирхийллээс хамгаалах;

13.3.2.мэдээллийг нууцлах;

13.3.3.ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд түүний эрх зүйн байдлыг дордуулахгүй байх;

13.3.4.шаардлагатай бол ажлын байр, ажлын нөхцөлийг түр өөрчлөх зэрэг хамгаалалтын арга хэмжээ авах;

13.4.Шүгэл үлээгч дотоод мэдээлэх суваг ашиглан мэдээлэл гаргасан тохиолдолд тухайн байгууллага шүгэл үлээгчийг хамгаалах, дэмжих арга хэмжээг хөдөлмөрийн дотоод журам болон дотоод хяналтын журамд тусган хэрэгжүүлнэ.

13.5.Дотоод мэдээлэх сувгийг хариуцсан ажилтан, нэгж нь тухайн мэдээлэлд холбогдох албан тушаалтнаас хараат бус байна.

13.6.Дотоод мэдээлэх сувгаар ирсэн мэдээллийг тухайн байгууллагын удирдлага, ажилтанд шүгэл үлээгчийг таних боломжтой хэлбэрээр дамжуулахыг хориглоно.

13.7.Шүгэл үлээгч нь дотоод мэдээлэх сувгийг ашиглах эсэхийг өөрөө сонгоно. Шүгэл үлээгчийг дотоод мэдээлэх сувгийг ашиглаагүй үндэслэлээр Шүгэл үлээгчийг дэмжих нэгж, эрх бүхий бусад байгууллага мэдээллийг хүлээн авахаас татгалзахыг хориглоно.

13.8.Энэ хуулийн 13.1-д зааснаас бусад хуулийн этгээд, байгууллага нь шүгэл үлээгчийн мэдээллийг хүлээн авах дотоод сувгийг байгуулж болно. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1-д заасан мэдээлэх үүрэгтэй этгээд дотоод мэдээлэх сувгийг заавал байгуулж, ажиллуулна.

13.9.Энэ хуулийн 13.2.4-т заасан ажилтан, эсхүл нэгж шүгэл үлээгчийн мэдээллийг хүлээн авч долоо хоногийн дотор мэдээлэл хүлээн авсан тухай мэдэгдэх бөгөөд 30 хоногийн дотор авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдэгдэнэ.

13.10.Дотоод мэдээлэх сувгаар ирүүлсэн мэдээлэл нь гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй гэх үндэслэлтэй бол энэ хуулийн 13.2.4-т заасан ажилтан, эсхүл нэгж уг мэдээллийг эрх бүхий байгууллагад нэн даруй шилжүүлж, шалгуулах үүрэгтэй.

13.11.Шүгэл үлээгч хүсэлт гаргасан тохиолдолд мэдээллийг эрх бүхий байгууллагад шилжүүлэхдээ шүгэл үлээгчийг таних боломжтой мэдээллийг нууцална.

13.12.Байгууллага, дотоод мэдээлэх суваг болон мэдээлэл гаргах журмын талаарх мэдээллийг нийтэд ил байлгана.

14 дүгээр зүйл.Төрийн болон албаны нууцтай холбоотой мэдээлэл гаргах

14.1.Төрийн болон албаны нууцтай танилцах эрх бүхий албан хаагч нь албан үүргээ гүйцэтгэх явцад нийтийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлж болзошгүй нөхцөл байдлыг илрүүлсэн бол энэ хуулийн 14.3-т заасан тусгай сувгаар мэдээлэл гаргаж болно.

14.2.Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллээр шүгэл үлээхэд тагнуулын төв байгууллагад мэдээллийг гаргана.

14.3.Энэ хуулийн 14.2-т заасан байгууллага, албан тушаалтан төрийн болон албаны нууцтай холбоотой мэдээллийг хүлээн авах, урьдчилан шалгах тусгай хамгаалалттай сувагтай байна.

14.4.Энэ зүйлд заасны дагуу мэдээлэл гаргасан этгээдийг төрийн болон албаны нууц задруулсан гэж үзэхгүй.

14.5.Энэ зүйлд заасан тусгай хамгаалалтай сувгаар шүгэл үлээгчийн мэдээллийг хүлээн авах, урьдчилан шалгах ажиллагаанд энэ хуулийн 13.9, 13.10-т заасан зохицуулалт нэгэн адил үйлчилнэ.

14.6.Шүгэл үлээгчийн зөвшөөрөлгүйгээр түүний талаарх мэдээллийг мөрдөн шалгах байгууллагаас бусад этгээдэд задруулахыг хориглоно.

ШҮГЭЛ ҮЛЭЭГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

15 дугаар зүйл.Хамгаалалтын арга хэмжээ авах

15.1.Шүгэл үлээгч болон түүний хамаарал бүхий этгээдийн амь нас, эрүүл мэндэд халдсан, эсхүл халдах эрсдэл үүссэн тохиолдолд тэдгээрийг хамгаалах арга хэмжээ авна.

15.2.Шүгэл үлээгчийг дэмжих нэгж нь шүгэл үлээгчийн хүсэлтэд үндэслэн шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хамгаалалтын арга хэмжээ авах тухай саналыг эрх бүхий байгууллага, нэгжид нэн даруй хүргүүлнэ.

15.3. Хамгаалалтын арга хэмжээ авах эрх бүхий байгууллага нь энэ хуулийн 15.2-т заасан саналыг хүлээн авмагц Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 6.1 дүгээр зүйлд заасны дагуу хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

15.4. Шүгэл үлээгч нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн болон зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрч, хохирогчоор оролцож байгаа бөгөөд түүнийг хамгаалалтад авах шаардлагатай бол Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 13.1, 13.2 дугаар зүйлд заасны дагуу хамгаалалтад авна.

15.5. Шүгэл үлээгч нь түүний мэдээллийн дагуу эрүүгийн болон зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлсэн эсэх, эсхүл уг ажиллагаанд оролцож байгаа эсэхээс үл хамааран хамгаалалтын арга хэмжээнд хамрагдах эрхтэй.

16 дугаар зүйл.Хамгаалалтын арга хэмжээ авахаас татгалзах

16.1. Шүгэл үлээгчийг дэмжих нэгж дараах тохиолдолд хамгаалалтын арга хэмжээ авах тухай саналыг эрх бүхий байгууллагад гаргахаас татгалзаж болно:

16.1.1.хамгаалалтын арга хэмжээ авах хүсэлтийг шүгэл үлээгч, эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд гаргаагүй;

16.1.2. шүгэл үлээгч өөрөө хамгаалалтаас татгалзах тухай бичгээр хүсэлт гаргасан;

16.2.Хамгаалалтын арга хэмжээ авах тухай санал гаргахаас татгалзсан шийдвэрийг бичгээр гаргаж, шүгэл үлээгчид даруй мэдэгдэнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ ШҮГЭЛ ҮЛЭЭХ БАТАЛГАА

17 дугаар зүйл.Шүгэл үлээх эрхээ хэрэгжүүлэх

17.1.Шүгэл үлээсэнтэй нь холбогдуулан шүгэл үлээгч болон түүний хамаарал бүхий этгээдийн эсрэг өс хонзон авах, ялгаварлан гадуурхах, дарамт шахалт үзүүлэх, түүнчлэн хууль ёсны эрх, ашиг сонирхолд нь хохирол учруулахыг хориглоно.

17.2.Шүгэл үлээгчид шүгэл үлээсэн, шүгэл үлээхээр оролдсон мөчөөс хамгаалуулах тухай хүсэлт гаргасан эсэхээс үл хамааран энэ хуулийн 17.1-д заасан хамгаалалт үүснэ.

17.3.Шүгэл үлээгч нь хууль зүйн болон сэтгэл зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө авах хүсэлт гаргаж болно.

17.4.Шүгэл үлээгч хууль зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөө авсан, холбогдсон, мэдээлэл өгсөнтэй холбоотой баримт, түүнчлэн түүнийг таних боломжтой аливаа мэдээллийг түүний зөвшөөрөлгүйгээр задруулахыг хориглоно.

17.5. Шүгэл үлээгч нь мэдээлэл өгсний төлөө хариуцлага хүлээхгүй бөгөөд тухайн мэдээлэл нотлогдоогүй нь түүнийг хамгаалалтад хамруулахаас татгалзах үндэслэл болохгүй.

18 дугаар зүйл.Шүгэл үлээгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулах, хохирол учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдэхүйг хориглох

18.1.Шүгэл үлээгч болон түүний хамаарал бүхий этгээдэд шүгэл үлээсэнтэй нь холбогдуулан тэдгээрийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулах, эсхүл хохирол учруулж болзошгүй дараах үйлдэл, эс үйлдэхүйг хориглоно:

18.1.1.заналхийлэх, айлган сүрдүүлэх, дарамт шахалт үзүүлэх, сэтгэл зүйн дарамтад оруулах, нэр төр, алдар хүндэд нь халдах, гутаах;

18.1.2.албан тушаалыг нь бууруулах, албан тушаал дэвшүүлэхийг хязгаарлах, сахилгын шийтгэл ногдуулах, ажлаас халах, чөлөөлөх, ажлаас чөлөөлөгдөхийг шаардах;

18.1.3.ажлын үүрэг, ажлын байрыг өөрчлөх, ажил гүйцэтгэх боломжийг хязгаарлах, цалин, урамшуулал, зэрэг дэв, цол, түүний нэмэгдэл, үнэлгээ, ажлын цагийг зориудаар бууруулах, мэргэжлийн үйл ажиллагааг нь хязгаарлах, хөдөлмөрийн нөхцөлийг нь зориудаар дордуулах;

18.1.4.мэргэшил дээшлүүлэх, чадавхжуулах сургалтад хамрагдах, хөгжих боломжоос хасах;

18.1.5.албан тушаалын байр суурь, бизнесийн харилцаа, мэргэжлийн нэр хүнд, давуу байдал, нийгмийн баталгаа, хангамж, ашиг сонирхлыг алдагдуулах;

18.1.6.өөрийнх нь зөвшөөрөлгүй албан үүргийн хуваарилалтыг өөрчлөх, шилжүүлэх;

18.1.7.цалин хөлсийг үндэслэлгүйгээр бууруулах, ажлын үр дүнг үнэлэх болон шагнал, урамшуулал олгоход ялгаварлан гадуурхах;

18.1.8.хууль бусаар аудит, хяналт шалгалт хийх, хяналт шалгалтын үр дүнг задруулах, зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, цуцлах, хүчингүй болгох;

18.1.9.бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх гэрээг цуцлах, бизнесийн үйл ажиллагаанд нь сөргөөр нөлөөлөх захиргааны болон эдийн засгийн бусад арга хэмжээ авах;

18.1.10.бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх болон хөлсөөр ажиллах гэрээг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, үндэслэлгүйгээр сунгахаас татгалзах;

18.1.11.шүгэл үлээгчийн ажлын байр, аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой хохирол учруулсан, хохирол учруулж болзошгүй бусад үйлдэл, эс үйлдэхүй.

18.2.Шүгэл үлээгч энэ хуулийн 18.1-д заасан нөхцөл үүссэн гэж үзвэл Шүгэл үлээгчийг дэмжих нэгжид гомдол гаргаж болно.

18.3. Энэ хуулийн 18.1-д заасан үйлдэл, эс үйлдэхүйг хэрэгжүүлсэн байгууллага нь өөрийн гаргасан шийдвэрийн үндэслэлийг нотлох үүрэгтэй. Шийдвэрийн үндэслэлээ нотлоогүй тохиолдолд тухайн байгууллага шүгэл үлээгчийн эрх зүйн байдлыг дордуулсан үйлдлийг нэн даруй зогсоон, учруулсан хохирлыг нөхөн төлж, энэ тухай мэдээллийг Шүгэл үлээгчийг дэмжих нэгж болон холбогдох бусад эрх бүхий байгууллагад хүргүүлэх үүрэгтэй.

18.4. Шүгэл үлээгч шүгэл үлээснээс хойш хоёр жилийн хугацаанд түүний эрх зүйн байдалд сөргөөр нөлөөлсөн аливаа үйлдэл, эс үйлдэхүйг шүгэл үлээсэнтэй нь холбоотой гэж үзэх үндэслэлтэй бөгөөд тухайн үйлдэл, эс үйлдэхүй нь шүгэл үлээсэнтэй холбоогүй болохыг шийдвэр гаргасан этгээд өөрөө нотлох үүрэгтэй.

18.5.Өмнө нь тухайн байгууллагад ажиллаж байсан этгээдийг шүгэл үлээсэнтэй нь холбогдуулан ажилд авах, гэрээ байгуулах, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх, зөвшөөрөл авах боломжийг хязгаарлах, мэргэжлийн тодорхойлолт, санал, мэдээлэл өгөхөөс үндэслэлгүй татгалзах, хар жагсаалтад оруулах, эсхүл бусад байдлаар нэр хүнд, ажил мэргэжлийн боломжид нь сөргөөр нөлөөлөхийг хориглоно.

18.6.Шүгэл үлээгчтэй байгуулсан нууцын гэрээ, эсхүл бусад гэрээний заалт нь энэ хуульд заасан шүгэл үлээх эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

19 дүгээр зүйл.Шүгэл үлээгчид хариуцлага хүлээлгэхгүй байх

19.1. Шүгэл үлээгч нь мэдээлэл гаргах үедээ тухайн мэдээлэл нь нийтийн ашиг сонирхлыг хохироосон, эсхүл хохироож болзошгүй нөхцөл байдалд хамаарах бөгөөд үнэн зөв гэж итгэх хангалттай үндэслэлтэй байсан бол уг мэдээлэлтэй нь холбогдуулан түүнд иргэний, захиргааны болон сахилгын хариуцлага хүлээлгэхийг хориглоно.

19.2. Төрийн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэх явцдаа нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээсэн тохиолдолд түүнд хууль тогтоомжоор тогтоосон холбогдох хязгаарлалт хамаарахгүй.

19.3. Энэ хуулийн 19.1-д зааснаас бусад этгээдээс гаргасан нийтийн ашиг сонирхлыг хохироосон, эсхүл хохироож болзошгүй нөхцөл байдлын талаарх мэдээлэл нь байгууллагын, албаны, арилжааны, мэргэжлийн болон хувь хүний нууцын мэдээллийг агуулсан нь тухайн этгээдийг хууль тогтоомж, хамтын гэрээ, хөдөлмөрийн гэрээ, нууцын гэрээ болон хөдөлмөрийн дотоод журамд заасан нууц хадгалах үүргээ зөрчсөн гэж үзэх үндэслэл болохгүй.

19.4.Шүгэл үлээгчийн гаргасан мэдээлэл нь нийтийн ашиг сонирхлыг хохироосон, эсхүл хохироож болзошгүй нөхцөл байдалд хамаарахгүй болох нь тогтоогдсон нь шүгэл үлээгчийг мэдээлэл гаргасантай нь холбогдуулан Эрүүгийн хууль⁶, Зөрчлийн тухай хууль⁷ болон бусад хуульд заасан хариуцлагад татах үндэслэл болохгүй.

19.5.Мэдээллийг хууль бусаар олж авсан, эсхүл санаатайгаар худал мэдээлэл тараасан нь тогтоогдсон тохиолдолд энэ зүйл хамаарахгүй.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ ШҮГЭЛ ҮЛЭЭГЧИД НӨХӨН ТӨЛБӨР, УРАМШУУЛАЛ ОЛГОХ

20 дугаар зүйл.Шүгэл үлээгчид нөхөн төлбөр олгох

20.1.Шүгэл үлээгч болон түүний хамаарал бүхий этгээд нь шүгэл үлээсэнтэй нь холбогдуулан тэдгээрийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлсөн аливаа үйлдэл, эс үйлдэхүйн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй.

20.2.Шүгэл үлээгч болон түүний хамаарал бүхий этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол, хор уршиг учруулсан этгээд нь зөрчигдсөн эрхийг гэм хор учруулахаас өмнөх байдалд сэргээх үүрэгтэй. Зөрчигдсөн эрхийг сэргээх боломжгүй бол учирсан гэм хорыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлнө.

20.3.Дараах хохирлыг нөхөн төлбөрт хамааруулна:

20.3.1.алдсан цалин хөлс, орлого, урамшуулал;

20.3.2.ажлаас халагдсан, албан тушаал буурсан, гэрээ цуцлагдсанаас үүссэн орлогын алдагдал;

20.3.3.хууль зүйн туслалцаа, хамгаалалтын арга хэмжээтэй холбоотой зардал;

20.3.4.нэр төр, алдар хүнд, мэргэжлийн үйл ажиллагаанд учирсан хохирол;

20.3.5.сэтгэл санааны хохирол.

20.4.Шүгэл үлээгч болон түүний хамаарал бүхий этгээд гэмт хэргийн хохирогч болсон тохиолдолд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн⁸ 10 дугаар зүйлд заасан нөхөн төлбөр авах эрхтэй.

21 дүгээр зүйл.Шүгэл үлээгчид олгох урамшуулал

21.1.Шүгэл үлээгчийн мэдээллийг үндэслэн дараах үр дүн гарсан тохиолдолд шүгэл үлээгч мөнгөн урамшуулал авах эрхтэй:

⁶ Эрүүгийн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

⁷ Зөрчлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

⁸ Засгийн газрын тусгай сангийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2019 оны 48 дугаарт нийтлэгдсэн.

21.1.1.Авлигын эсрэг хуулийн 33.2-т заасны дагуу Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийн олсон эд хөрөнгө, орлогыг хураасан;

21.1.2.гэмт хэрэг, зөрчилд торгох ял, шийтгэл оногдуулсан, алданги, нөхөн төлбөр гаргуулсан;

21.1.3.гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийн хөрөнгө, орлогыг хураасан;

21.1.4.нийтийн ашиг сонирхолд хохирол учрахаас урьдчилсан сэргийлсэн.

21.2.Энэ хуулийн 21.1.4-т заасан урьдчилан сэргийлсэн хохирлын хэмжээг санхүү, эдийн засгийн шинжилгээний дүгнэлт, аудитын шалгалт, эсхүл шүүхийн шинжилгээний байгууллагын дүгнэлт зэрэгт үндэслэн тогтооно.

21.3.Мөнгөн урамшууллыг шүгэл үлээгчийн мэдээлэл нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, хяналт шалгалт, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бодитой хувь нэмэр оруулсан болох нь тогтоогдсон тохиолдолд олгоно.

21.4.Мөнгөн урамшууллыг энэ хуулийн 21.1-д заасны дагуу хураасан эд хөрөнгө, орлого, ногдуулсан торгох ял, шийтгэл, гаргуулсан алданги, нөхөн төлбөр, урьдчилан сэргийлсэн хохирлын дүнгийн дараах хувь, хэмжээгээр тооцон олгоно:

21.4.1.тавин сая хүртэл төгрөгийн 15 хувийг;

21.4.2.тавин саяас хоёр зуун тавин сая хүртэл төгрөгийн 7.5 сая төгрөг дээр 50 сая төгрөгөөс давсан дүнгийн 12 хувийг;

21.4.3.хоёр зуун тавин саяас нэг тэрбум хүртэл төгрөгийн 31.5 сая төгрөг дээр 250 сая төгрөгөөс давсан дүнгийн 10 хувийг;

21.4.4.нэг тэрбумаас хоёр тэрбум хүртэл төгрөгийн 106.5 сая төгрөг дээр 1 тэрбум төгрөгөөс давсан дүнгийн 6 хувийг;

21.4.5.хоёр тэрбум, түүнээс дээш төгрөгийн 166.5 сая төгрөг дээр 2 тэрбум төгрөгөөс давсан дүнгийн 4 хувийг.

21.5.Мөнгөн урамшууллын хэмжээ нь 1 сая төгрөгөөс 5 тэрбум төгрөг хүртэл байна.

21.6.Нэг асуудлаар хэд хэдэн шүгэл үлээгч мэдээлэл гаргасан бол тэдгээрийн оруулсан хувь нэмрийг харгалзан мөнгөн урамшууллыг хуваарилна.

21.7.Илт худал мэдээлэл гаргасан, эсхүл гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд хамтран оролцсон нь тогтоогдсон бол мөнгөн урамшуулал олгохгүй.

21.8.Шүгэл үлээгч энэ хуульд заасны дагуу ирүүлсэн мэдээлэлтэй холбоотойгоор бусад хууль тогтоомжийн дагуу мөнгөн урамшуулал авсан бол уг дүнг энэ хуульд заасан мөнгөн урамшууллын хэмжээнээс хасаж тооцно.

22 дугаар зүйл.Мөнгөн урамшууллыг олгох

22.1.Нийтийн ашиг сонирхлыг хохироосон, эсхүл хохироож болзошгүй нөхцөл байдлыг шалгаж, шийдвэрлэсэн эрх бүхий байгууллага, албан тушаалтан, Шүгэл

үлээгчийг дэмжих нэгж энэ хуулийн 21.1-д заасан шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 14 хоногийн дотор шүгэл үлээгчид мэдэгдэнэ.

22.2.Шүгэл үлээгч мэдэгдэл хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор урамшуулал авах хүсэлтээ Шүгэл үлээгчийг дэмжих нэгжид гаргана.

22.3.Шүгэл үлээгчийг дэмжих нэгж хүсэлтийг хянаж, дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

22.3.1.мөнгөн урамшууллыг бүрэн эсхүл хэсэгчлэн олгох;

22.3.2.мөнгөн урамшуулал олгохоос татгалзах.

22.4.Шүгэл үлээгчийг дэмжих нэгж нь мөнгөн урамшууллыг хүсэлт гаргагчид хэсэгчлэн олгох тухай шийдвэр гаргасан тохиолдолд үлдэгдэл төлбөрийг дараагийн жилд бүрэн барагдуулах талаар танилцуулгад тусгана.

22.5.Энэ хуулийн 22.3.1-д заасан шийдвэр гаргаснаас хойш ажлын 5 өдрийн дотор Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлын албаны даргад танилцуулна.

22.6.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлын албаны дарга саналыг хүлээн авснаас хойш ажлын 7 өдрийн дотор Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасны дагуу мөнгөн урамшуулал олгох шийдвэр гаргана.

22.7.Мөнгөн урамшууллын зөвлөл энэ хуулийн 21.4-т заасан аргачлалд нийцүүлэн мөнгөн урамшууллын хэмжээг тогтоох бөгөөд дараах нөхцөлийг харгалзан үзнэ:

22.7.1.мэдээллийн ач холбогдол;

22.7.2.шалгалт, мөрдөн ажиллагаанд үзүүлсэн дэмжлэг;

22.7.3.мэдээлэлгүйгээр зөрчил илрэх боломж байсан эсэх;

22.7.4.шүгэл үлээгчид учирсан эрсдэл.

22.8.Энэ хуульд заасны дагуу шүгэл үлээгчид мөнгөн урамшуулал олгоогүй тохиолдолд шүгэл үлээгч энэ талаар эрх бүхий байгууллага, эсхүл шүүхэд гомдол гаргаж болно.

ДОЛООДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

23 дугаар зүйл.Санхүүжилт

23.1.Шүгэл үлээгчид олгох мөнгөн урамшууллыг шүгэл үлээгчийн мэдээллийг үндэслэн хураан авсан, нөхөн төлүүлсэн, эсхүл торгууль, алданги, төлбөр хэлбэрээр улсын орлого болгосон хөрөнгөөс санхүүжүүлнэ.

23.2.Шүгэл үлээгчид олгох урамшуулал, нөхөн төлбөрийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан Шүгэл үлээгчийг дэмжих сангаас олгоно.

23.3.Эрүүгийн хуулийн Арван наймдугаар бүлэг /Эдийн засгийн гэмт хэрэг/, Хорьдугаар бүлэг /Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг/, Хорин хоёрдугаар бүлэг /Авлигын гэмт хэрэг/, Хорин дөрөвдүгээр бүлэг /Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг/-т заасан гэмт хэрэг үйлдэж олсон

хөрөнгө, орлого болон эдгээр гэмт хэрэгт шүүхээс ногдуулсан торгох ялыг биелүүлж, төсөвт тушаасан мөнгөн хөрөнгийн 20 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг энэ хуульд заасны дагуу шүгэл үлээгчийг дэмжих үйл ажиллагаанд зориулан Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21⁴ дүгээр зүйлд заасан Шүгэл үлээгчийг дэмжих санд тухай бүр төвлөрүүлж, санхүүжүүлнэ.

23.4.Тухайн жилийн төсвөөс мөнгөн урамшууллыг олгох боломжгүй тохиолдолд дараагийн жилийн төсөвт тусгайлан тусгаж, санхүүжүүлнэ.

23.5.Шүгэл үлээгчид учруулсан аюул заналхийлэл, өс хонзонгийн үйлдэл тогтоогдсон бол хамгаалалтын арга хэмжээний зардлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ. Энэ хэсэгт заасан зардлыг нөхөн төлүүлэх нэхэмжлэлийг Шүгэл үлээгчийг дэмжих нэгж гаргана.

24 дүгээр зүйл.Хориглох зүйл

24.1.Шүгэл үлээгчид мэдээллээсээ татгалзах, мэдээллээ буцаан авах, өөрчлөх, эсхүл тодруулахгүй байхыг шаардах, ятгах, дарамтлах, аливаа хэлбэрээр нөлөөлөхийг хориглоно.

24.2.Шүгэл үлээгч өөрт болон өөрийн хамаарал бүхий этгээдэд ашиг хонжоо, давуу байдал олж авах зорилгоор шүгэл үлээж, хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараахыг хориглоно.

25 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

25.1. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

25.2. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй бол холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

26 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

26.1.Энэ хуулийг 2026 оны .. дугаар сарын ... өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалт:

“4.1.5. “шүгэл үлээгч” гэж Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуулийн 4.1.3-т заасныг;”

2/21 дүгээр зүйлийн 21.2.5 дахь заалт:

“21.2.5. шүгэл үлээгч, түүний хамаарал бүхий этгээдийг хамгаалах асуудлаар Шүгэл үлээгчийг дэмжих нэгжийн бичгээр гаргасан саналыг үндэслэн мөрдөгч.”

2 дугаар зүйл. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.2, 5.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“5.1. Энэ хуулийн зохицуулалтад гэрч, хохирогч, хүний эрх хамгаалагч, шүгэл үлээгч хамаарна.

5.2. Шаардлагатай гэж үзвэл гэрч, хохирогч, хүний эрх хамгаалагч, шүгэл үлээгчийн хамаарал бүхий этгээдийг энэ хуулийн зохицуулалтад хамааруулж болно.

5.3. Энэ хуулийн 5.2-т заасан гэрч, хохирогч, хүний эрх хамгаалагч, шүгэл үлээгчийн хамаарал бүхий этгээд гэж тэдгээрийн эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, төрсөн, дагавар болон үрчилж авсан хүүхэд, төрсөн ах, эгч, дүү, ач хүү, зээ охин, зээ хүү, зээ охиныг ойлгоно.”

3 дугаар зүйл. Энэ хуулийг Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 5.21 дүгээр зүйл нэмсүгэй:

“5.21 дүгээр зүйл.Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хууль зөрчих:

1.Хуульд заасныг зөрчиж шүгэл үлээгчийн албан тушаалыг нь үндэслэлгүйгээр бууруулах, дэвшихийг хязгаарлах, сахилгын шийтгэл оногдуулах, ажлаас халах, чөлөөлөгдөхийг шаардсан, эсхүл шүгэл үлээгчийн албан үүргийн хуваарилалтыг өөрчлөх, шилжүүлэх, цалин, урамшуулал, зэрэг дэв, цол, түүний нэмэгдлийг зориудаар бууруулах, мэргэжлийн үйл ажиллагааг нь хязгаарлах, хөдөлмөрийн нөхцөлийг нь зориудаар дордуулах, эсхүл ажлын үр дүнг үнэлэх, шагнал, урамшуулал олгоход ялгаварлан гадуурхсан бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Шүгэл үлээгчийн ажилд хууль бусаар хяналт шалгалт хийх, хяналт шалгалтын үр дүнг ил болгох, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, цуцлах, хүчингүй болгосон, эсхүл шүгэл үлээгчийн бараа, ажил, үйлчилгээний гэрээг цуцлах, түүний үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх захиргааны болон эдийн засгийн бусад арга хэмжээ авсан бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Шүгэл үлээгчийн зөвшөөрөлгүйгээр түүний нууцалсан мэдээллийг задруулсан, бусдад дамжуулсан, ашигласан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар

хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.8 дахь заалтын “5.16, 5.18, 5.19” гэсний дараа “, 5.21” гэж, мөн зүйлийн 6.30 дахь заалтын “Зөрчлийн тухай хуулийн” гэсний дараа “5.21 дүгээр зүйл,” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар

хот

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

1/16.3 дугаар зүйлийн 4.7 дахь заалт:

“4.7.шүгэл үлээгчийн өгсөн мэдээлэлтэй нь холбогдуулан хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан.”

2/29.5 дугаар зүйлийн 1.4 дэх заалт:

“1.4.шүгэл үлээсэн мэдээлэлтэй холбогдуулан хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнаас мэдээллийн эх сурвалжаа илчлэхийг шаардах, шүгэл үлээгчийн өөрийнх нь зөвшөөрөлгүй хувийн мэдээллийг гаргуулан авах.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ...дугаар
сарын ..-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах зүйл, заалт нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 5.3.29 дэх заалт:

“5.3.29.Шүгэл үлээгчийг дэмжих сан.”

2/21⁴ дүгээр зүйл:

“21⁴ дүгээр зүйл.Шүгэл үлээгчийг дэмжих сан

21⁴.1.Шүгэл үлээгчийг дэмжих сангийн хөрөнгө нь энэ хуулийн 6.1.1, 6.1.2-т зааснаас гадна дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

21⁴.1.1.Эрүүгийн хуулийн Арван наймдугаар бүлэг /Эдийн засгийн гэмт хэрэг/, Хорьдугаар бүлэг /Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг/, Хорин хоёрдугаар бүлэг /Авлигын гэмт хэрэг/, Хорин дөрөвдүгээр бүлэг /Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг/-т заасан гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлд заасны дагуу хураан авч төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгө;

21⁴.1.2.энэ зүйлийн 21⁴.1.1-д заасан гэмт хэрэгт шүүхээс ногдуулсан торгох ялыг биелүүлж, төсөвт тушаасан мөнгөн хөрөнгийн 20 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө.

21⁴.2.Шүгэл үлээгчийг дэмжих сангийн хөрөнгөөр дараах үйл ажиллагааг санхүүжүүлнэ:

21⁴.2.1.шүгэл үлээгчид хамгаалалтын арга хэмжээ авах;

21⁴.2.2.шүгэл үлээгчид мөнгөн урамшуулал олгох;

21⁴.2.3.Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуульд заасан Шүгэл үлээгчийг дэмжих нэгжийн үндсэн үйл ажиллагаатай холбогдсон зардлыг санхүүжүүлэх.

21⁴.3.Энэ хуулийн 21⁴.2-т заасан үйл ажиллагаанд санхүүжилт олгох асуудлыг Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

21⁴.4.Сан нь Удирдах зөвлөлтэй байх бөгөөд уг Удирдах зөвлөл нь Удирдах зөвлөлийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

21⁴.5.Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний тоо нийт 5 байх ба Удирдах зөвлөлийн дарга, гишүүнээс бүрдэнэ. Гишүүдийн бүрэлдэхүүнд төрийн байгууллагын болон олон нийтийн төлөөллийг тэнцүү тоогоор оролцуулсан байна.

21⁴.6.Эрүүгийн хуулийн Арван наймдугаар бүлэг /Эдийн засгийн гэмт хэрэг/, Хорьдугаар бүлэг /Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг/, Хорин хоёрдугаар бүлэг /Авлигын гэмт хэрэг/, Хорин дөрөвдүгээр бүлэг /Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг/-т заасан гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого болон эдгээр гэмт хэрэгт шүүхээс ногдуулсан торгох ялыг биелүүлж, төсөвт тушаасан мөнгөн хөрөнгийн 20 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг Шүгэл үлээгчийг дэмжих санд тухай бүр төвлөрүүлнэ.

21⁴.7.Шүгэл үлээгчийг дэмжих сангийн хөрөнгийг энэ хуулийн 21⁴.2-т заасан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна.

21⁴.8.Шүгэл үлээгчийг дэмжих сангийн дүрэм, Удирдах зөвлөл, түүний ажиллах журам болон уг сангийн хөрөнгийг төвлөрүүлэх, бүрдүүлэх, зарцуулахтай холбогдсон журмыг Засгийн газар батална.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

**ШҮГЭЛ ҮЛЭЭГЧИЙН ЭРХ
ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ
АНХДАГЧ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ,
ШААРДЛАГЫГ
УРЬДЧИЛАН ТАНДАН
СУДЛАХ**

СУДАЛГААНЫ ТАЙЛАН



Судалгааг захиалагч:

Хууль зүй, дотоод хэргийн яам

Судалгааг хянасан:

Б.Өлзийсайхан

Захирал, Хууль зүйн доктор, профессор

Судалгааг удирдсан:

М.Түвшинжаргал

Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
Хууль зүйн доктор (Ph.D)

Судалгааг гүйцэтгэсэн:

Э.Анударь

Эрдэм шинжилгээний ахлах ажилтан

М.Ганди

Эрдэм шинжилгээний ажилтан

Г.Болор-Эрдэнэ

Эрдэм шинжилгээний ажилтан

Б.Отгонзаяа

Дадлагажигч (МУИС- ХЗС V түвшний оюутан)

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

АТГ	Авлигатай тэмцэх газар
АТИ	Авлигын төсөөллийн индекс
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БОХтХ	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
БОХТЗИБЗТБМӨИМУОЖ	Байгаль орчны хууль тогтоомжийн зөрчлийг илрүүлсэн буюу зөрчлийн талаар бодит мэдээлэл өгсөн иргэнд мөнгөн урамшуулал олгох журам
БОУАӨЯ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
ЕХ	Европын Холбоо
ЗХДЗШШ	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх
ЗХАШШ	Захиргааны хэргийн анхан шатны шүүх
МУИХСтХ	Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль
МУИХ	Монгол Улсын Их Хурал
МЭГ	Монополын эсрэг газар
ОХУ	Оросын Холбооны Улс
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
ТББ	Төрийн бус байгууллага
УИХ	Улсын Их Хурал
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХХЗХ	Харилцаа холбооны зохицуулах хороо
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
ҮЦХ	Үндсэн хуулийн цэц
UNDP	United Nations Development Programme
OECD	Organization for Economic Co-operation and Development

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.Мэдээлэгч болон шүгэл үлээгч гэх нэр томъёоны ялгаа.....	9
Хүснэгт 2. 2017-2023 онд авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн нөхцөл байдал	18
Хүснэгт 3.Иргэд, байгууллагаас төлбөртэй мэдээлэл авахад баримтлах үнэлгээний жишиг	22
Хүснэгт 4.Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн талаар зөрчлийн шийдвэрлэлт 2023 оны байдлаар.....	27
Хүснэгт 5. Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үеэр цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл	33
Хүснэгт 6. Асуудлыг зохицуулж болох хувилбаруудын эерэг болон сөрөг тал	41

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.Зарим улс орнуудад Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуулийг баталсан он, цагийн дараалал	11
Зураг 2.Тагнуулын ерөнхий газраас мэдээлэл авах тухай мэдэгдэл.....	19
Зураг 3.ЦЕГ-аас гэмт хэргийн талаарх мэдээллийг төлбөртэй авах ТАЛААР ЗАР БАЙРШУУЛСАН БАЙДАЛ	21
Зураг 4. УИХ, орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үеэр иргэдээс гаргасан гомдол, маргааны тоо	34
Зураг 5. УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн үеэр иргэдээс гаргасан гомдол, маргааны тоо	34
Зураг 6. Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үеэр иргэдээс гаргасан гомдол, маргааны тоо.....	35
Зураг 7. БНСУ-ын Авлигатай тэмцэх болон иргэний зөрчигдсөн эрхийг хамгаалах комиссын бүтэц, зохион байгуулалт	63

АГУУЛГА

I. УДИРТГАЛ.....	6
II. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ	8
2.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал.....	8
2.1.1. Нэр томьёоны асуудал	8
2.1.2. Шүгэл үлээгчийг хамгаалах тогтолцоо.....	11
2.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд.....	15
2.3. Асуудал үүссэн шалтгаан, нөхцөл	16
2.3.1. Авлигын эсрэг хуулийн гэмт хэргийн талаар мэдээлэл гаргахтай холбоотой зохицуулалтын хэрэгжилт	16
2.3.2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төлбөртэй мэдээлэл авахтай холбоотой зохицуулалтын хэрэгжилт	18
2.3.3. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн төлбөртэй мэдээлэл авахтай холбоотой зохицуулалтын хэрэгжилт	22
2.3.4. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн төлбөртэй мэдээлэл авахтай холбоотой зохицуулалтын хэрэгжилт	23
2.3.5. Амьтны тухай хуулийн төлбөртэй мэдээлэл авахтай холбоотой зохицуулалтын хэрэгжилт.....	26
2.3.6. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн төлбөртэй мэдээлэл авахтай холбоотой зохицуулалтын хэрэгжилт	30
2.3.7. Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн төлбөртэй мэдээлэл авахтай холбоотой зохицуулалтын хэрэгжилт	33
2.3.8. Өрсөлдөөний тухай хуулийн төлбөртэй мэдээлэл авахтай холбоотой зохицуулалтын хэрэгжилт	36
III. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ	37
IV. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ	40
V. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ	43
5.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө	43
5.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө	43
5.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө	43
5.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө	43
5.5. Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэж байгаа эсэх.....	44
VI. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ	44
6.1. Америкийн Нэгдсэн Улс	44
6.2. Бүгд Найрамдах Хятад Ард Улс.....	47
6.3. Оросын Холбооны Улс.....	51
6.4. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	53
6.5. Япон Улс	57
6.6. Сингапур Улс	60
6.7. Бүгд Найрамдах Солонгос Улс.....	62
VII. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	75
НОМ ЗҮЙ	77
ХАВСРАЛТ	82

I. УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2.7 дахь дэд заалтад Засгийн газар нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр заасан. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (2019)-ийн 35 дугаар зүйлд гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээллийг иргэдээс төлбөртэй авах талаар зохицуулсан бөгөөд шаардлагатай тохиолдолд мэдээлэгчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг гэмт хэрэг, зөрчлийн хэрэг бүртгэл, мөрдөн шалгах эрх бүхий байгууллага, албан тушаалтан авах үүргийг хуульчилжээ.

Манай улсад мэдээлэгчийн эрх зүйн байдлыг тодорхойлсон, хамгаалах арга хэмжээг тогтоосон хууль тогтоомж одоогоор байхгүй бөгөөд мэдээллийг төлбөртэй авах талаар зохицуулалт л салбарын хууль тогтоомжид¹ тусгагдсан байна. Ийнхүү мэдээлэл өгөх хүнийг хамгаалаагүй, хаана, хэнд хандаж хэрхэн мэдээлэл гаргах нь тодорхойгүй хэдий ч Эрүүгийн хуулийн 39 дугаар зүйлийн 39.1, 39.3 дахь хэсэгт гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж байгааг болон үйлдсэнийг мэдсээр байж зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлээгүй этгээдийг **үл мэдээлэгч** хэмээн тодорхойлсон бөгөөд тухайн үл мэдээлэгчийг гэмт хэрэгт хамаарагсад болгон хуульчилжээ.

Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 1.6.45-т зааснаар Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай анхдагч хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Авлигатай тэмцэх газартай хамтран боловсруулж, 2025 онд багтаан Улсын Их Хуралд өргөн барих хуваарьтай байна.

Тус чиглэл: “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.1.3-т “Авлигатай тэмцэх 5Ш ажиллагааг үргэлжлүүлж, авлига, ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх тогтолцоог хялбаршуулах, энэ төрлийн гэмт хэргийн эсрэг шүгэл үлээгчийг хамгаалах, дэмжих хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ” гэж заасныг, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын 2024 оны 46 дугаар тогтоолын хавсралтаар баталсан төлөвлөгөөний 6.4.3-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг шүүмжилсэн, мэдээлсэн, илчилсэн тохиолдолд яллах, эрүүгийн хариуцлагад татах, дарамтлахаас мэдээлэгчийг хамгаалах, шүгэл үлээгчдийг аливаа өш хонзон, гэмт хэргийн хохирогч болохоос хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох.” хэмээн тусгажээ.

Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулан өргөн барих талаар тусгасан байжээ. Энэ хүрээнд 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр төслийг УИХ-д өргөн барьсан боловч 2022 оны 10 дугаар сарын 20-ны чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд шийдэлд хүрэхгүйгээр төслийг хууль санаачлагчид буцаажээ.

Тухайн төслийг боловсруулах чиглэлд төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг шүүмжилсэн, мэдээлсэн, илчилсэн тохиолдолд

¹ Авлигын эсрэг хууль (2009)-ийн 9 дүгээр зүйл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017)-ийн 30.5 дугаар зүйл, Цагдаагийн албаны тухай хууль (2017)-ийн 39 дүгээр зүйл, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (2019)-ийн 34, 35 дугаар зүйл, Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995)-ийн 54 дүгээр зүйл, Амьтны тухай хууль (2012)-ийн 38 дугаар зүйл, Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн худалдааг зохицуулах тухай хууль (2002)-ийн 14 дүгээр зүйл, Соёлын өвийг хамгаалах тухай хууль (2014)-ийн 40 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль (2019)-ийн 81 дүгээр зүйл, Өрсөлдөөний тухай хууль (2010)-ийн 11 дүгээр зүйл.

яллах, эрүүгийн хариуцлагад татах, дарамтлахаас мэдээлэгчийг хамгаалах, шүгэл үлээгчдийг аливаа өш хонзон, гэмт хэргийн хохирогч болохоос хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох талаар заасан байжээ. Харин 2021 оны Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай анхдагч хуулийн төсөлд мэдээлэгч гэх ойлголтыг шүгэл үлээгчээс ялгаатай зохицуулаагүй байх бөгөөд тус төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтад “шүгэл үлээх гэж нийтийн ашиг сонирхлыг хохироосон, хохироож болзошгүй нөхцөл байдал, үйлдлийн талаар эрх бүхий байгууллагад мэдээлэл өгөх, өргөдөл, гомдол гаргах, тайлбар өгөх /цаашид “мэдээлэл өгөх” гэх/-ийг”² ойлгоно хэмээн оруулсан байна.

Өөрөөр хэлбэл, “шүгэл үлээгч=мэдээлэгч” гэх байдлаар тус хоёр ялгаатай ойлголтыг нэг болгон зохицуулах гэж оролдсон нь харагдаж байна. Ингэхдээ шүгэл үлээгч нь заавал тухайн байгууллагын ажилтан байх шаардлагыг тавиагүй бөгөөд шүгэл үлээгчийг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд зааснаар хамгаалах арга хэмжээ авахаар зохицуулжээ.

Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулахад өгсөн чиглэлийг харьцуулаад харвал, өмнө нь ганц авлигын талаар бус төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын аливаа гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлсэн мэдээлэгч, шүгэл үлээгчийг хамгаалахтай холбоотой зохицуулалтыг бий болгохоор заасан байсан бол сүүлд батлагдсан чиглэл дээр авлигын гэмт хэргийн эсрэг шүгэл үлээсэн этгээдийг хамгаалах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар нэмж тусгасан байна.

Ийнхүү мэдээлэгчийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх, шүгэл үлээгчийг гэмт хэргийн хохирогч болохоос сэргийлэх, авлигын гэмт хэргийн талаар шүгэл үлээсэн этгээдийг тухайлан анхаарах чиглэлийг Засгийн газарт чиглэл болгожээ.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого тэргүүтэй бодлогын баримт бичгүүдэд авлигагүй нийгмийг цогцлоон бүрдүүлэх, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох, тогтолцоог бэхжүүлэх, гэмт хэрэг үйлдсэн нийтийн албан тушаалтныг нийтийн албанаас чөлөөлөх, эгүүлэн татах эрх зүйн орчныг бүрдүүлж, авлигатай тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай нийтлэг байдлаар заасан. Үүнтэй холбоотойгоор Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн А/41 тоот тушаалаар Авлигын эсрэг багц хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулан байгуулан ажиллаж байна.

Иймд тус судалгааны ажлын хүрээнд авлигын гэмт хэргийн талаар шүгэл үлээсэн этгээдийг хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулах Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай анхдагч хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлах³ юм. Ингэхдээ Монгол Улсад дан ганц шүгэл үлээгчийг бус мэдээлэгчийг хамгаалах эрх зүйн орчныг сайжруулах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, тэр дундаа авлигын хэргийн талаар мэдээлсэн, шүгэл үлээсэн этгээдийг хамгаалахтай холбоотой гадны зарим улс орны туршлагыг судалсны үндсэн дээр зөвлөмж боловсруулахыг зорилоо.

² Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хууль (2021)-ийн төсөл. <https://lawforum.parliament.mn/project/237/>

³ 2019 он, 2021 он, 2025 оны 4 дүгээр сард тус тус Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай анхдагч хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан бөгөөд судалгааны тайланг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Авлигын багц хуулийн төслийг боловсруулах ажлын хүрээнд энэ удаагийн судалгааны ажилаар авлигын эсрэг шүгэл үлээсэн этгээдийг хамгаалах асуудлыг гүнзгийрүүлсэн судалж, авлигын хэрэгт шүгэл үлээсэн этгээдийг зохицуулсан хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг тандан судаллаа.

II. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

2.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал

2.1.1. Нэр томьёоны асуудал

Блайкийн хууль зүйн тайлбар толь бичигт (Black's Law Dictionary) мэдээлэгч (informer) гэдэг нь бусдын үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлдэг этгээдийг хэлнэ⁴ хэмээн тодорхойлсон. Тус толь бичигт шүгэл үлээгчийн тодорхойлолт байхгүй бөгөөд нийтийн ашиг сонирхол, аюулгүй байдлын эсрэг үйлдлийн тухай мэдээлэл тараахыг улс төрийн нэр томьёонд шүгэл үлээх гэдэг байна.⁵

Шүгэл үлээгч гэдэг нэр томьёог 1972 онд Америкийн иргэний эрхийн төлөө тэмцэгчдийн нэг Ralf Nader “нууц мэдээлэгч”, “матаач” зэрэг сөрөг утгатай нэршлээс ялгаатай гэсэн санаагаар анх тайлбарлаж, эрх мэдэлтэн, улс төрийн өндөр албан тушаалтан, төрийн байгууллагын эсрэг хүчтэй дугарч, асуудалд нийгмийн анхаарлыг чиглүүлж байгаа хүнийг шүгэл үлээгч гэх утгаар хэрэглэж эхэлсэн байна.⁶

Орчин үед АНУ-д уг нэр томьёог арай өөр утгаар ойлгож, хэрэглэж байна. Тухайлбал, АНУ-ын Шүгэл үлээгчийн үндэсний төвөөс тодорхойлсноор шүгэл үлээгч (whistleblower) гэдэг нь нийтийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, авлига өгөх, авах, эсхүл олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдалд заналхийлж болзошгүй үйлдлийг илрүүлж, холбогдох эрх бүхий этгээдэд мэдээлэл хүргэдэг этгээдийг хэлнэ. Ерөнхийдөө шүгэл үлээгч нь тухайн зөрчил гарч буй байгууллагын дотоод ажилтан байх нь түгээмэл боловч, ажилтан байхыг шаарддаггүй⁷ хэмээжээ.

Харин Корнеллийн хууль зүйн их сургуулийн эрдэмтдийн тодорхойлсноор мэдээлэгч (informant) гэдэг нь тагнуулын байгууллагад нууц харилцааны хүрээнд мэдээлэл өгч, уг этгээдийн хувийн мэдээллийг олон нийтэд илчлэгдэхээс хамгаалах этгээдийг⁸ ойлгох юм. Шүгэл үлээгч гэдэг нь нийтийн, эсхүл хувийн хэвшлийн байгууллагын ажил олгогчийнхоо хууль зөрчсөн, буруутай үйл ажиллагаа, эсхүл олон нийтэд хохирол учруулахуйц зөрчлийн талаар мэдээлэл гаргасан ажилтныг⁹ хэлнэ хэмээн тус тус тодорхойлсон байна.

Европын холбооны улс орнуудад шүгэл үлээгч нь тухайн байгууллагын ажилтныг, мэдээлэгч нь тухайн салбар, байгууллагын талаар мэдээлэлтэй хүмүүсийг (industry insiders)¹⁰ ойлгоно гэжээ. Дэлгэрүүлбэл, шүгэл үлээгч гэдэг нь төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын ажилтан, эсхүл албан үүргийн хүрээнд уг байгууллагатай

⁴ Black's Law Dictionary 919 (4th ed. 2015).

⁵ Пүрэвдожийн Батбаатар, *Гэрч, хохирогчийн аюулгүй байдлын онол, практикийн асуудал*, (Улаанбаатар: УБ ДХИС-ийн хэвлэх үйлдвэр, 2021), 118 дахь тал.

⁶ *Мөн тэнд*.

⁷ National whistleblower center, “What is a Whistleblower?”, <https://www.whistleblowers.org/what-is-a-whistleblower/>.

⁸ United States Code, art. 3126, <https://www.law.cornell.edu/uscode/text/50/3126>.

⁹ Cornell Law School, Wex definitions, “whistleblower”, (Last reviewed in July of 2024), <https://www.law.cornell.edu/wex/whistleblower>.

¹⁰ European Union, “Whistleblowers and Informants”, https://competition-policy.ec.europa.eu/index/whistleblower_en.

харилцаж байгаа хүн нийтийн ашиг сонирхолд аюул заналхийлэл учруулж болохуйц үйлдлийн талаар мэдэж холбогдох байгууллагад мэдэгдсэн этгээд юм.¹¹

Васерманы хуульд¹² шүгэл үлээгч гэдгийг гэмт хэрэг, зөрчил, нийтийн ашиг сонирхолд аюул занал учруулж болзошгүй үйлдэл, Франц улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг, эсхүл Европын холбооны хууль тогтоомжийг зөрчсөн үйлдлийг нуун дарагдуулах оролдлоготой холбоотойгоор өөртөө шууд болон шууд бус байдлаар хөрөнгө, санхүүгийн давуу талыг бий болгох сэдэлгүй, төлбөргүйгээр, шударгаар мэдээлэл гаргасан этгээд¹³ хэмээн тодорхойлжээ.

Ийнхүү шүгэл үлээгчийг улс орнууд нэгдсэн байдлаар тодорхойлоогүй хэдий ч мэдээлэгчээс явцуу утгатай ойлголт болох нь нийтлэг харагдаж байна. Тус хоёр нэр томъёоны ялгааг АНУ-д хэрхэн тайлбарладаг тухай доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт 1. Мэдээлэгч болон шүгэл үлээгч гэх нэр томъёоны ялгаа¹⁴

Шалгуур	Мэдээлэгч (informant)	Шүгэл үлээгч (whistleblower)
Хамрах хүрээ (audience)	Мэдээлэгчийг холбооны хууль сахиулах байгууллага, цагдаа эсхүл прокурорт мэдээлэл өгсөн тохиолдолд хамгаална.	Байгууллагын дотоод нэгжид мэдээлэл гаргаснаар нь хамгаална. Мөн хуульд мэдээлэл хүлээн авах байгууллагыг (external agency) тусгасан. Шүгэл үлээгч мэдээллээ шүүх, Конгресс, Ерөнхий хянан шалгагч (Inspectors General), хууль сахиулах байгууллага, эсхүл бусад хуулиар томилогдсон этгээдэд гаргасан бол хамгаалагдах юм. Шүгэл үлээгч нь мэдээллийг доор дурдсан нөхцөлөөс бусад тохиолдолд шууд олон нийтэд илчлэх боломжтой: • тухайн мэдээлэл нууцын ангилалд хамаарах бол; • тухайн мэдээллийг олон нийтэд тараахыг хуульд шууд хориглосон.
Сэдэл (motives)	Мэдээлэгч нь эдийн засгийн давуу байдал, өс хонзон, шударга ёсыг тогтоох хүсэл, цагаачлалын тусгай хүсэлт, цагдаа, прокурорын дарамт шахалт, эсхүл илүү сайн нөхцөлтэй хорих анги руу шилжүүлэх зэрэг нөхцөлийг холбогдох байгууллагаас	Шүгэл үлээгч нь нийтийн ашиг сонирхол, өс хонзон, эдийг засгийн давуу байдал, шударга ёсны төлөө мэдээлэл гаргасан байж болно. Харин хуулийн хамгаалалтад орох шалгуур нь тухайн мэдээлэл үндэслэлтэй, эсхүл үнэн гэж итгэж үнэмших үндэслэл тухайн үед байсан байх явдал юм.

¹¹ Directive (EU) 2019/1937 of the European Parliament and of the Council of 23 October 2019 on the protection of persons who report breaches of Union law, <https://eur-lex.europa.eu/eli/dir/2019/1937/oj/eng>.

¹² Уг хуулиар Directive (EU) 2019/1937 буюу “Хууль зөрчсөн үйлдлийг илчилсэн хүний хамгаалалт” гэсэн Европын холбооны зохицуулалтыг Франц улсад нэвтрүүлсэн бөгөөд байгууллага доторх илт хууль бус үйлдлийг илчилсэн мэдээлэгч буюу “lanceur d’alerte”-г хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулдаг байна. Тус хууль нь 2022 оны 3 дугаар сарын 21-ны өдөр батлагдсан бөгөөд хууль санаачлагчдын нэрээр Waserman хэмээн нэрлэсэн.

¹³ Transparency International France, “Mediator, Facebook, Luxembourg Leaks, or Swiss Leaks in tax matters... many are the “affairs” revealed by whistleblowers. The term is as widespread as whistleblowers are useful to society”, <https://transparency-france.org/convaincre/lanceurs-dalerte/>.

¹⁴ “Exploring the blurred line between whistleblowers and informants”, (2023.08.01), <https://www.corporatecrime.co.uk/post/whistleblowers-vs-informants>.

	амласны хариуд мэдээлэл гаргаж болдог.	
Мөнгөн урамшуулал (financial incentives)	Мэдээлэгч нь Холбооны мэдээлэгчийн урамшууллын хөтөлбөрийн дагуу гэрээ байгуулан цалин авдаг.	Шүгэл үлээгч нь маш бага санхүүгийн урамшуулал авдаг.
Элсүүлэх боломж (recruitment)	Мэдээлэгчийг хууль сахиулах байгууллага тэдний мэдлэгт үндэслэн ажилд авч, түүнчлэн зарим гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаанд туслалцаа үзүүлэн оролцуулж болдог.	Шүгэл үлээгчийг мэдээлэл өгсөн гэх үндэслэлээр хууль сахиулах байгууллага ажилд авдаггүй. Гэсэн хэдий ч холбооны мөрдөн шалгах байгууллагуудтай хамтран ажиллах ёстой бөгөөд шүүхэд мэдүүлэг өгөх шүгэл үлээгчийг хамгаалдаг.
Харилцаа холбоотой байх хугацаа (length of relationship)	Мэдээлэгч нь хууль сахиулах байгууллагад нэг удаагийн, эсхүл байнгын давтамжтай мэдээлэл өгөх боломжтой. Өөрөөр хэлбэл, хууль сахиулах байгууллагуудтай удаан хугацаанд харилцаж болно.	Шүгэл үлээгч нь хууль сахиулах байгууллагад нэг удаагийн эсхүл байнгын давтамжтай мэдээлэл өгөх боломжтой боловч ихэнх тохиолдолд шинэ зөрчил илрээгүй, эсхүл шинэ нотлох баримт байхгүй бол хэргийг хаасны дараа харилцаа дуусдаг.
Хамгаалалт (protection)	Мэдээлэгчийн хувийн мэдээлэл нууцлагдах боловч мэдээллийн нотлох баримт болох чадварыг хангах үүднээс түүний хэн болохыг ил болгож болдог. Түүнийг бие махбодын аюул заналхийллээс хамгаалахын тулд гэрчийг хамгаалах хөтөлбөрийг хэрэгжүүлсэн бөгөөд, түүний аюулгүй байдлыг хууль сахиулах байгууллага хариуцдаг. Түүнчлэн мэдээлэгч мэдээллийг олж авахын тулд хийсэн үйлдэлд иргэн болон эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй боловч, хэтэрсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх боломжтой байдаг.	Шүгэл үлээгчийн хувийн мэдээллийг нууцалж, түүний албан үүрэгт өөрчлөлт оруулах байдлаар хариу арга хэмжээ авахаас урьдчилан сэргийлдэг. Шүүхийн үйл ажиллагаанд талуудын тэнцвэртэй байдлыг хадгалахын тулд түүний нэрийг илчилж болдог. Түүнийг хамгаалах асуудлыг мэдээлэл хүлээн авсан байгууллага хариуцах боломжгүй тул хууль сахиулах байгууллага хариуцдаг. Шүгэл үлээгчийг иргэний болон эрүүгийн хариуцлагаас чөлөөлдөггүй.

Дээрхээс харвал, АНУ-д шүгэл үлээгч нь байгууллагын ажилтан, эсхүл ажил хэргийн хүрээнд хамааралтай хүн байх бөгөөд дотроосоо шүгэл үлээж байгаа гэдэг утгаар нь тухайн хүнийг ажлаас нь халах, албан тушаал бууруулах, дарамтлах зэргээс хамгаалах шаардлагатай болдог байна. Харин мэдээлэгч нь өөртөө давуу байдал бий болгох, эсхүл нийтийн ашиг сонирхлын төлөө мэдээлэл өгч байгаа этгээд бөгөөд шүгэл үлээгчтэй харьцуулахад хэн нэгний шууд хамааралтайгаар ажил, албан тушаал нь өөрчлөгдөхгүй учраас хамгаалалтад авах хэрэгцээ ч шүгэл үлээгчтэй харьцуулахад бага байна.

Монгол Улсын хувьд мэдээлэгч гэх нэр томъёог хууль тогтоомжид хэрэглэж байгаа ч тодорхойлж, хамгаалалтад авах талаар нарийвчилсан зохицуулалт байхгүй


байна. Харин шүгэл үлээгч гэх ойлголтыг албан бусаар хэрэглэж байгаа бөгөөд нэгдсэн утгаар ойлгож, хэрэглэж байгаа практик бас байхгүй юм.

2.1.2. Шүгэл үлээгчийг хамгаалах тогтолцоо

Шүгэл үлээгч нь мэдээлэгчтэй харьцуулахад шүгэл үлээснийхээ төлөө бие махбод, сэтгэл санаа, эд хөрөнгөөрөө хохирох эрсдэл өндөртэй байдаг учраас шүгэл үлээгчийг хамгаалах зохицуулалтыг чухал гэж үздэг. Тухайлбал, 2016 оны OECD-ийн тайланд дурдсанаар, шүгэл үлээгчийг хамгаалах нь олон нийтийн эрх ашгийг хамгаалах эцсийн хамгаалалтын шугам¹⁵ юм хэмээжээ.

2024 оны байдлаар 59 улс орон шүгэл үлээгчийг хамгаалах тухай эрх зүйн зохицуулалтай байна.¹⁶ Доорх зургаар зарим улс орнуудын Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуулиа баталсан он, цагийн дарааллыг харууллаа. Хамгийн эхэнд АНУ 1989 онд Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуультай болж байсан бол Хорват улс 2019 онд тус хуулиа шинэчлэн баталжээ.

Зураг 1. Зарим улс орнуудад Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуулийг баталсан он, цагийн дараалал¹⁷



Шүгэл үлээгчийг хамгаалах хуультай улс орнуудад хуулийн хамрах хүрээ нь ялгаатай байна. Тухайлбал, Энэтхэг, Румын зэрэг улсын Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хууль нь зөвхөн төрийн албан хаагчийг хамгаалдаг байхад Япон, БНСУ зэрэг улс нь нийтийн болон хувийн эрх зүйн салбар дахь ажилтныг хамгаалдаг байна.

¹⁵ National whistleblower center, “Whistleblower Laws Around the World” <https://www.whistleblowers.org/whistleblower-laws-around-the-world/>.

¹⁶ National whistleblower center, “Major International Whistleblower Laws”, <https://www.whistleblowers.org/major-international-whistleblower-laws/#:~:text=At%20least%2059%20countries%20around,laws%20vary%20widely%20between%20countries>.

¹⁷ OECD, Fair Market Conditions for Competitiveness in the Adriatic Region, Whistleblower Protection to Fight Corruption, Policy briefing note, p.5-10.

Улс орнуудын нийтийн болон хувийн эрх зүйн салбар дахь шүгэл үлээгчид тавигдах шаардлага мөн харилцан адилгүй, ялгаатай байна. Зарим улсад зөвхөн нийтийн албан хаагч нь шүгэл үлээгч болох боломжтой бол Португал, Норвеги, АНУ зэрэг улсад өмнө нь нийтийн албанд ажиллаж байсан этгээд, ажилд орохоор горилогч этгээд, гэрээт ажилтан, ханган нийлүүлэгч зэрэг өргөн хүрээний хүмүүс нийтийн албаны шүгэл үлээгчийн шалгуурыг хангах боломжтой байдаг.¹⁸

Шүгэл үлээгчийн хамгаалалт ч олон төрөл байдаг. Үүнд, шүгэл үлээгчид хариу арга хэмжээ авсан албан тушаалтанд хариуцлага тооцох, буруутай үйл ажиллагаанд оролцохоос нь татгалзуулах, зарим тохиолдолд шүгэл үлээгч болон түүний гэр бүлийн гишүүдийг холбогдох байгууллага биечлэн хамгаалах зэрэг багтана. 2014 онд OECD-оос явуулсан судалгааны тайлангаас үзэхэд, АНУ, Канад, Япон, Австрали, БНСУ, Нидерланд, Шинэ Зеланд, Их Британи зэрэг улсад шүгэл үлээгчийг хамгийн өргөн хүрээнд хамгаалдаг болохыг тогтоожээ.¹⁹

Шүгэл үлээгчийн хамгаалалтын суурь нь түүний хувийн мэдээллийг хамгаалах бөгөөд үүнийг дараах байдлаар хэрэгжүүлдэг байна:

- шүгэл үлээгчийг хувийн мэдээллийг нууцлах (preserving confidentiality);
- нэрээ нууцлан шүгэл үлээх боломжийг олгох (allowing anonymous reporting) хамаарна.

Шүгэл үлээгчийн хувийн мэдээллийг нууцлах гэдэг нь шүгэл үлээгчийн зөвшөөрөлгүйгээр түүний хэн болох, хэн болохыг тодорхойлох боломжтой аливаа мэдээллийг шууд болон шууд бусаар мэдээлэл хүлээн авах эрх бүхий байгууллагаас ил болгохгүй байхыг хэлнэ.²⁰ Харин нэрээ нууцлан шүгэл үлээх боломжийг олгох гэдэг нь байгууллагаас нэрээ нууцалсан мэдээллийг хүлээн авч, хянан шалгах, цаашлаад нэрээ нууцалсан этгээдийг хамгаалах тухай асуудал юм.²¹

Ихэнх улс орнууд шүгэл үлээгчийн мэдээллийг нууцлах зохицуулалтыг хуульдаа тусгадаг бөгөөд Словак, Австрали зэрэг улсад нэргүйгээр мэдээлэл гаргах боломжийг олгосон байна. 2015 оны BluePrint байгууллагаас зохион байгуулсан “Breaking the Silence” илтгэлд Их-хорь (G20)-ийн²² улс орнуудын мэдээллийн хамгаалалтыг үнэлсэн. Тодруулбал, Энэтхэг, Канад, Австрали улс дахь нийтийн албан хаагчийн мэдээллийн нууцлал болон АНУ, БНСУ дахь нийтийн болон хувийн хэвшлийн ажилтны мэдээллийн нууцлал сайн буюу хувийн мэдээллийг чандлан хамгаалж байгааг онцолжээ.²³

Мөн дэлхийн улс орнууд шүгэл үлээгчийг хамгаалах зохицуулалтаа сайжруулж шинэ түвшинд гаргахад анхаарах, мэдээлэл гаргах тусгай байгууллага, алба нэгжгүй, шүлэг үлээгчийн хувийн мэдээллийг нууцлах зохицуулалт дутмаг, мэдээллийг шалгах, хүлээн авах тусгайлсан хяналтын механизм дутмаг байгаагаас үүдэн шүгэл үлээх тогтолцоо бодит амьдралд хангалттай хэрэгжихгүй²⁴ байгаа талаар дурдаж байжээ.

¹⁸ National whistleblower center “Whistleblower Laws Around the World”, <https://www.whistleblowers.org/whistleblower-laws-around-the-world/>.

¹⁹ National whistleblower center, “Whistleblower Laws Around the World” <https://www.whistleblowers.org/whistleblower-laws-around-the-world/>.

²⁰ Transparency International, “Internal whistleblowing systems”, (2022), https://files.transparencycdn.org/images/2022_Internal-Whistleblowing-Systems_English.pdf.

²¹ Ibid.

²² G20-ийн 19 улс (Аргентин, Австрали, Бразил, Канад, БНХАУ, Франц, ХБНГУ Энэтхэг, Индонез, Итали, Япон, БНСУ, Мексик, ОХУ, Саудын араб, Турк, Их Британи, АНУ), Европын холбоо, Африкийн холбоо (the African Union.)

²³ National whistleblower center, “Whistleblower Laws Around the World”, <https://www.whistleblowers.org/whistleblower-laws-around-the-world/>.

²⁴ Ibid.

2018 онд BluePrint-ээс гаргасан тайланд, Европын холбооны орнуудын шүгэл үлээгчийн хууль тогтоомжийг үнэлсэн бөгөөд “Европын холбооны ихэнх улсын хууль тогтоомж хангалтгүй түвшинд байгаа бөгөөд шүгэл үлээгчийг хамгаалах, дэмжих тусгай чиг үүрэгтэй байгууллага байхгүй нь хуулиар шүгэл үлээгчийг хамгаалж чадахгүйд хүрнэ” гэсэн шүүмжлэлийг өгсөн байна.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 2019 оны тайланд, дэлхийн олон улс оронд шүгэл үлээгчийг хамгаалах тухай хууль батлагдаж, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа нь ахиц дэвшил боловч хэрэгжилтийн явцад хуулийн хийдэл, зөрчил гарсаар байгааг анхаарах нь зүйтэй²⁵ хэмээжээ.

Ийнхүү улс орон болгоны шүгэл үлээгчийг хамгаалах тогтолцоо ялгаатай байна. Шүгэл үлээгчийг хамгийн өргөн хүрээнд хамгаалдаг гэх Их Британид уг хуулиар мэдээлэгчийг хамгаалсан байна. 1998 онд Нийтийн ашиг сонирхлыг төлөөлсөн мэдээллийг ил болгох тухай (Public Interest Disclosure Act) хуулийг батлан гаргажээ. Энэ хуульд гэмт хэрэг үйлдсэн тухай, аливаа этгээд хуулиар оногдуулсан албан үүргээ биелүүлээгүй тухай, шүүн таслах ажиллагааны алдааны талаар, хүмүүсийн эрүүл мэндэд учирч буй хор аюулын талаар, байгаль орчинд учрах хор аюулын тухай мэдээллийг нуун дарагдуулсан тухай мэдээлсэн тохиолдолд хамгаалахаар заажээ. Төр нь хувийн ямар нэгэн ашиг сонирхолгүй, зөвхөн нийтийн эрх ашгийг тэргүүнд тавьсан тухай мэдээллийг үнэн зөв гэж итгэж мэдээлсэн этгээдийг хамгаалахаар заасан байна. Хувийн ямар нэгэн ашиг сонирхолгүйгээр мэдээлэл задалсан ажилтанд учирсан хохирлыг нөхөн төлөх боломжийг мөн хуульчилжээ.²⁶

Дээрхээс харвал, шүгэл үлээгчийн тухай хуульд мэдээлэгчийг өргөн хүрээнд хамгаалах боломжтой бөгөөд тухайн улсын онцлогоос хамаараад шүгэл үлээгчийг ямар хүрээнд ойлгох нь ялгаатай байна. Харин мэдээлэл гаргах суваг, байгууллага тодорхой байх, түүнийг нь хүлээж авч хянадаг тогтолцоо зайлшгүй байх шаардлага улс орнуудын өмнө тавьж буй нийтлэг шалгуур болжээ.

OECD-ийн шүгэл үлээгчийг хамгаалах бодлогын зөвлөмжүүдийг үндэслэн Атриатын бүсийн орнуудад авлигын эсрэг үйл ажиллагааг сайжруулах, шүгэл үлээгчийг хамгаалах тогтолцоог бэхжүүлж буй 5 үйл ажиллагааг²⁷ авч үзье.

(i) Ухамсрыг дээшлүүлэх (raise awareness)

Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын ажилтнууд буруутай үйлдэл илрүүлсэн тохиолдолд хаана, хэрхэн, хэнд мэдээлэхийг, эсхүл тэдгээр нь шүгэл үлээгчийг хамгаалах хуулиар хамгаалагдсан эсэхээ мэдэхгүй байх нь түгээмэл байдаг. Иймд ажилтан гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлэхийн ач холбогдол, түүний эрх, үүргийн талаар таниулах нь чухал юм. OECD-ийн 1998 оны “Төрийн албаны ёс зүйг сайжруулах зөвлөмж”-ийн 4 дэх зарчимд “төрийн албан хаагч буруу үйлдэл илчилсэн тохиолдолд ямар хамгаалалт авах боломжтойгоо мэддэг байх ёстой” гэж заасан.

Ажилтны боловсрол, ухамсрыг дээшлүүлэх ажлын хүрээнд хяналтын байгууллагаас жил бүр тайлан гаргах; хүлээн авсан хэргийг шийдвэрлэсэн үр дүн, шүгэл үлээгчийн нөхөн төлбөр, авлигын хэргийг илрүүлснээр олсон хөрөнгө, хэргийг

²⁵ National Whistleblower center, “Whistleblower Laws Around the World” <https://www.whistleblowers.org/whistleblower-laws-around-the-world/>.

²⁶ Пүрэвдожийн Батбаатар, *Гэрч, хохирогчийн аюулгүй байдлын онол, практикийн асуудал*, (Улаанбаатар: УБ ДХИС-ийн хэвлэх үйлдвэр, 2021), 119 дэх тал.

²⁷ OECD, Fair Market Conditions for Competitiveness in the Adriatic Region, Whistleblower Protection to Fight Corruption, Policy briefing note, p.5-10.

шийдвэрлэх дундаж хугацааг мэдээлэх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж болно (OECD, 2016).

Хорват улсын жишээ: Хэвлэл мэдээллийн тусламжтайгаар шүгэл үлээгчийг “баатар” болгон дүрсэлж, олон нийтийн хандлагыг өөрчилж чадсан. НҮБ-ын судалгаагаар “Хорватын иргэдийн талаас илүү хувь нь авлигыг мэдээлсэн хүнийг хожим харамсана, үр дүн гарахгүй” гэж итгэдэг байсан ч сэтгүүлчид шүгэл үлээгчид найдаж эхэлжээ. Үр дүнд нь хоёр иргэн тутмын нэг нь авлигын талаар мэдээлнэ гэдэг болсон талаар Transparency International мэдээлсэн. Үүнээс харвал, төр, иргэний нийгмийн хамтын ажиллагаа шүгэл үлээгчийг дэмжих, мэдээлэл өгөхийг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй байна.

(ii) Мэдээлэл өгөх байгууллага, суваг тодорхой байх (provide clear reporting channels)

Шүгэл үлээх суваг тодорхой, хүртээмжтэй байгаагүй нөхцөлд хүмүүс итгэлгүй болж мэдээлэхээс зайлсхийдэг байна. OECD-ийн 2021 оны Авлигын эсрэг зөвлөмж нь улс орнуудыг авлигын талаар мэдээлэхэд амар болгохыг (утас, цахим шуудан гэх мэт аргаар) уриалжээ.

Зарим улсад шүгэл үлээхэд зориулсан тусгай дугаарын утас, цахим платформ байдаг. Гэвч иргэний нийгэмд мэдээлсэн тохиолдолд бус хууль сахиулах байгууллагад өгсөн мэдээллийг үндэслэж, хууль тогтоомжийн дагуу хяналт тавих боломжтой юм. Тухайлбал, Эстони улсад авлигын эсрэг цахим хуудас болон утсаар мэдээлэл өгөх боломжтой байдаг бол **Унгар улсын** Үндэсний Цагдаагийн газраас “Phone Witness” гэх нэртэй нэрээ нууцалсан үүрэн холбооны шугам ажиллуулдаг байна.

(iii) Бодитой дэмжлэг үзүүлэх (provide practical guidance)

Шүгэл үлээгч буруу үйлдлийг мэдээлэхдээ ихээхэн хэмжээний эрсдэл хүлээж байдаг тул түүнд мэдээлэл, зөвлөгөө өгч, итгэлцэл бий болгох нь чухал юм. Холбогдох байгууллага мэдээлэл өгсөн иргэдтэй байнгын холбоотой байж, хэргийн явцыг мэдээлдэг байх нь тэдний итгэлийг нэмэгдүүлнэ.

Хорват улсын жишээ: 2021-2030 оны Авлигын эсрэг стратегид хэвлэл мэдээллийн байгууллага, төрийн албан хаагч, олон нийтийн байгууллага, сэтгүүлчдэд зориулсан сургалт, кампанит ажил хийхээр тусгасан.

Серби улсын жишээ: Pištaljka гэх нэртэй ТББ нь хэвлэл мэдээллийн байгууллага, шүүгч, прокурорт шүгэл үлээгчийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар сургалт ордог байна.

(iv) Мөнгөн урамшуулал олгох (provide financial rewards)

Шүгэл үлээх нь тухайн хүний ажлын байр, нэр хүнд, орлогын хувьд эрсдэл дагуулах нь бий. Иймд зарим улсад түүний амьдрах зардал, хууль зүйн зардлыг нь нөхөх мөнгөн урамшуулал олгох тогтолцоог нэвтрүүлсэн.

Серби улсын жишээ: 2014 оны Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуулиар мэдээлэл өгөхийг хязгаарлах үйлдлийг хориглосон бөгөөд ажил олгогч мэдээлэл хүлээн авах эрх бүхий хүнийг томилох үүрэгтэй байна.

Босни ба Херцеговина улсын жишээ: 2017 оны хууль нь төр, хувийн хэвшлийн салбарт шүгэл үлээсэн болон түүнтэй хамааралтай этгээдийг хамгаалдаг ч санхүүгийн тусламж, үнэгүй хууль зүйн туслалцаа авах эрхийг хангаагүй байна.

Унгар улсын жишээ: Картелийн үйл ажиллагааны талаар цаг тухайд нь нотлох баримт өгсөн шүгэл үлээгчид торгуулийн 1%-тай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал (хамгийн дээд хэмжээ нь ойролцоогоор 180,000 ам.доллар) олгодог байна.

(v) Хувийн мэдээллийг хамгаалах болон нийтийн ашиг сонирхлыг хамгаалах хоорондын тэнцвэрийг хуулиар тогтоох (ensure data protection legislation does not impede reporting)

Шүгэл үлээгчийг нууц задруулсан, гүтгэсэн гэх байдлаар Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэгт яллах нь дуугүй болгох арга хэрэгсэл болдог. Тиймээс хууль тогтоомжоор хувийн мэдээллийг хамгаалах болон нийтийн ашиг сонирхлыг хамгаалах хоорондын зохистой тэнцвэрийг хангах ёстой байна.

Хорват улсын жишээ: Хорватын Омбудсменын газар шүгэл үлээгчийн өгсөн мэдээллийг хамгаалж шүүхэд оролцох, парламентад жил бүр илтгэл тавих үүрэгтэй байна. 2021 онд Хорват улс ЕХ-ны 2019/1937 тоот Шүгэл үлээгчийг хамгаалах тухай удирдамжтай нийцүүлэн шинээр хуулийн төслийг баталсан бөгөөд 2022 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

Түүнчлэн “Transparency International” олон улсын байгууллагын энэ асуудлаар олон жил ажиллаж, туршлагажсан мэргэжилтнүүд шүгэл үлээгчийг хамгаалах тухай хууль тогтоомжийг боловсруулахдаа харгалзах зөвлөмжийг өгсөн байна. Үүнд:

- 1) Төрийн хамгаалалтын хүрээнд зөвхөн төрийн албан хаагч төдийгүй хувийн хэвшил, төрийн бус байгууллагыг хамруулах;
- 2) Шүгэл үлээгчийг өс хонзонгоос хамгаалах;
- 3) Шүгэл үлээгчид зүй ёсны урамшуулал, шан хүртээх тэдэнд учирсан хохирол, алдагдлыг нөхөн төлөх;
- 4) Шүгэл үлээгчийн мэдээллийг ил болгох шуурхай журмыг аль болох нарийвчлан тогтоох;
- 5) Андуурсан этгээдийг шийтгэхгүй байх;
- 6) Шүгэл үлээгчтэй харилцах ажлыг дагнан эрхэлсэн хараат бус байгууллага байгуулах зэрэг юм.²⁸

2.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд

Мэдээлэгч, шүгэл үлээгчийг хамгаалахтай холбоотой хууль, эрх зүйн орчин байхгүйгээс үүдэн эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдийг дараах байдлаар тодорхойллоо.

Эрх ашиг нь хөндөгдөж буй этгээд		Нөлөөлж буй хэлбэр
1.	Нийгмийн бүлэг	Нийтийн ашиг сонирхлын төлөө үг хэлсэн, үйл ажиллагаа явуулсан болон бүхий л хэлбэрээр тэмцсэний төлөө нийгмийн бүлгийн хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөх бодит эрсдэл байсаар байна.
2.	Иргэн /18 насанд хүрсэн/	Иргэний үндсэн эрх зөрчигдсөн, зөрчигдөх эрсдэл үүссэн, нийтийн ашиг сонирхлын төлөө хууль бус үйлдлийн үр дагаврыг багасгах, гэмт хэргийн талаар мэдсэн, гэмт хэргээс урьдчилан

²⁸ Пүрэвдожийн Батбаатар, *Гэрч, хохирогчийн аюулгүй байдлын онол, практикийн асуудал*, (Улаанбаатар: УБ ДХИС-ийн хэвлэх үйлдвэр, 2021), 120 дахь тал.

		сэргийлэх зорилгоор мэдээлэл өгсний төлөө төрөөс шаардлагатай урамшуулал, хамгаалалтыг хийх явдал төдийлөн хангалттай бус байна.
3.	Ажилтан, төрийн албан хаагч	Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад ажиллаж буй ажилтан дотроосоо шүгэл үлээх асуудлыг огт зохицуулаагүй нь тухайн байгууллагын хууль бус үйлдлийг илчлэх нөхцөл боломж, итгэлцэл байхгүй болгож байна. Шүгэл үлээгчийг албан тушаал буруулах, ажлаас халах, бусад хэлбэрээр дарамтлах эрсдэл байсаар байгаа төдийгүй байгууллагын дотор болон гадна мэдээллийг хүлээн авч, хянах, шүгэл үлээгчийг хамгаалах чиг үүрэгтэй нэгж байхгүй байна.
4.	Төр	Нийтийн албан тушаалтны үйлдсэн албан тушаалын гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах, хариуцлага тооцоход шүгэл үлээгч, мэдээлэгчийн тусламж, үр нөлөө их юм. Ийнхүү шүгэл үлээсэн, эсхүл мэдээлсэн этгээдийг хамтран ажиллахад сэдэлжүүлсэн мэдээ, мэдээлэл олгох ажиллагаа байхгүй нь төрийн шударга, хууль ёсны үйл ажиллагаанд шууд бусаар нөлөөлж байна.

Дээрхээс харвал, шүгэл үлээх тогтолцоонд оролцогч талууд нь төр, иргэн, бүх хэвшлийн байгууллага байх боломжтой байдаг тул тэдгээрийн бүгдийнх нь эрх, ашиг шууд болон шууд бусаар хөндөгдөж байна.

2.3. Асуудал үүссэн шалтгаан, нөхцөл

Монгол Улсын хууль тогтоомжид гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлэл төлбөртэй авах талаар Авлигын тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Цагдаагийн албаны тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Амьтны тухай, Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай, Соёлын өвийг хамгаалах тухай, Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай болон Өрсөлдөөний тухай хуульд тус тус зохицуулсан.

Мэдээлэгч, шүгэл үлээгчийг хамгаалах хууль, эрх зүйн орчныг сайжруулах боломжийг эрэлхийлэхийн тулд одоо хэрэгжиж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийх учиртай билээ. Иймд одоо практикт байгаа нөхцөл байдлыг тодруулах зорилгоор хэд хэдэн хуулийн зүйл, заалтыг судалж үзье.

2.3.1. Авлигын эсрэг хуулийн гэмт хэргийн талаар мэдээлэл гаргахтай холбоотой зохицуулалтын хэрэгжилт

9 дүгээр зүйл.Өргөдөл, гомдол гаргах, мэдээлэл өгөх

9.1.Иргэн, хуулийн этгээд авлигын асуудлаар Авлигатай тэмцэх газарт өргөдөл, гомдол гаргаж, мэдээлэл өгч болно.

9.2.Авлигатай тэмцэх газар нь өргөдөл, гомдол, мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Авлигатай тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасны дагуу иргэн, хуулийн этгээд авлигын асуудлаар Авлигатай тэмцэх газарт өргөдөл, гомдол гаргаж, мэдээлэл өгч болно. Ингэхдээ 110 тусгай дугаарт, ДАН системээр нэвтрэх, цахим хаягаар (contact@iaac.mn) болон онлайнаар эсвэл биеэр очиж гомдол мэдээлэл өгөх боломжтой байна.

Гомдол мэдээлэхдээ “Гомдол, мэдээллийн маягт”-ыг бөглөх шаардлагатай ба үүнд овог нэр, оршин суугаа хаяг, цахим хаяг, утасны дугаар, гомдол мэдээллийн утгыг бичиж, нотлох баримтыг хавсаргах шаардлагатай байна. Мэдээлэл өгч байгаа хүн ямар гэмт хэрэгтэй холбоотой (Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1-22.13 дахь хэм хэмжээ) мэдээлэл өгч болох талаар нарийн заасан байхаас гадна тухайн иргэн нэрээ нууцлах боломжийг олгожээ.

2024 онд АТГ нь байгууллагын өргөдөл, гомдол, мэдээллийн менежментийн байдалд дүн шинжилгээ хийж, боловсронгуй болгох арга хэмжээний хүрээнд орон тоо, зохион байгуулалтыг өөрчлөх, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (UNDP)-ийн “Авлигыг мэдээлэх механизмыг боловсронгуй болгох нь” төсөлтэй хамтран ажиллах зэргээр удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлжээ. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Авлигыг мэдээлэх механизмыг боловсронгуй болгох нь” төслийн хүрээнд байгууллагын өргөдөл, гомдлын “Smart office” системд хөгжүүлэлт, интеграци хийж, all/call программыг үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна. Энэхүү программыг нэвтрүүлснээр 110 тусгай дугаарын утсаар өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах ажиллагаанд дэвшил гарч, чанаргүй дуудлагын тоо цөөрч, хийдэл болон зохиомол ачаалал буурсан эерэг үр дүн гарч байна гэж дүгнэжээ.

Авлигатай тэмцэх газарт ирүүлж буй гомдол, мэдээлэл жил ирэх тусам нэмэгдэж байгаа ба 2020-2023 оны хугацаанд авлигын гэмт хэргийн талаар нийт 6,484 гомдол, мэдээлэл хүлээн авсан бөгөөд үүнээс 5,247 гомдол, мэдээлэл нь гэмт хэргийн шинжтэй байжээ.

График 1. Авлигын гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл (2020-2023)





График 2. Авлигын гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл (2020-2023)



Тухайлбал, 2023 онд 1670 авлигын гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллээс 701 тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэж, хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн, 870 тохиолдолд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан, 44 хэргийг харьяаллын дагуу шилжүүлсэн, 55 тохиолдол ажиллагаанд байгаа үзүүлэлттэй байна.

Мөн тухайн өргөдөл, мэдээллийг төлбөртэй авдаг талаар дээрх хуульд тусгаагүй байгааг дурдах нь зүйтэй. Авлигатай тэмцэх газар нь авлигын эсрэг гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг дээрх тусгай дугаар, цахим хаягаар үнэ төлбөргүй хүлээн авч байгаа талаар Авлигатай тэмцэх газрын ажилтан Б болон Авлигатай тэмцэх газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дурджээ.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2017-2023 онд авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн нөхцөл байдлыг дараах байдлаар тоймлон олон нийтэд танилцуулсан байна.

Хүснэгт 2. 2017-2023 онд авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн нөхцөл байдал

Иргэд		Авлигатай тэмцэх газар		Прокурорын байгууллага (Нийслэлийн прокурорын газар)		Шүүх (Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх)
Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл	Хэрэг үүсгэсэн	Мөрдөн шалгагдсан хэрэг	Шилжүүлсэн хэрэг	Хяналт тавьсан	Шилжүүлсэн хэрэг	Шийдвэрлэсэн
7641	-	8860 өмнөх онуудын үлдэгдлийн хамт	1578	7229	1005	739

АТГ-аас дээрх хугацаанд 8860 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 1578 хэрэг буюу 17.8 хувийг нь яллах дүгнэлт үйлдүүлэхээр прокурорын байгууллагад шилжүүлсэн байх ба прокурорын байгууллага нийт хяналт тавьсан хэргийн 13.9 хувийг буюу 1005 хэргийг шүүхэд шилжүүлсэн байна. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх нийт хүлээн авсан 1005 хэргийн 73.5 хувийг буюу 739 хэргийг шийдвэрлэжээ.

2023 онд АТГ шалгасан нийт хэргийн 325 буюу 17.7 хувийг шүүхэд шилжүүлэх саналтай, 544 буюу 29.6 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хаах, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай, 57 буюу 3.1 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлж, 132 хэргийг нэгтгэн шалгаж, 12 хэргийг түдгэлзүүлж, 767 эрүүгийн хэргийн үлдэгдэлтэй байгаагаас хэрэг бүртгэлтийн 690 хэрэг, мөрдөн байцаалтын 77 хэрэг байна. Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн шийдвэрлэлт 57.6 хувьтай, өмнөх оны мөн үеэс 5.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Шүүхээр 192 хэрэг шийдвэрлэгдсэн байна²⁹.

2.3.2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төлбөртэй мэдээлэл авахтай холбоотой зохицуулалтын хэрэгжилт

30.5 дугаар зүйл. Гэмт хэргийн талаархи мэдээллийг төлбөртэй авах

1. Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага дараахь мэдээллийг төлбөртэй авахаар нийтэд зарлаж болно:

²⁹ Авлигатай тэмцэх газар, “2023 оны үйл ажиллагааны тайлан”, 2024, 57 дахь тал, <https://iaac.mn/54/coopitem>.

- 1.1.гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж байгаа, завдсан, эсхүл үйлдсэн тухай;
 - 1.2.эрэн сурвалжлагдаж байгаа хүн, эд зүйл, тээврийн хэрэгсэл, баримт бичгийн тухай.
- 2.Мэдээллийг төлбөртэй авах тухай зарлаагүй боловч хүн, хуулийн этгээдээс хүсэлт гаргасан тохиолдолд мэдээллийг төлбөртэй авах эсэхийг мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагын дарга шийдвэрлэнэ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлд зааснаар мөрдөн шалгах ажиллагааг Тагнуулын байгууллага, Цагдаагийн байгууллага, Авлигатай тэмцэх газар тус явуулна. Иймд тус 3 байгууллагын гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж байгаа, завдсан, эсхүл үйлдсэн тухай болон эрэн сурвалжлагдаж байгаа хүн, эд зүйл, тээврийн хэрэгсэл, баримт бичгийн тухай мэдээллийг төлбөртэй авах талаар нийтэд мэдээлсэн байдлыг шалгаж үзлээ.

(i) Тагнуулын ерөнхий газар

Тагнуулын ерөнхий байгууллага нь иргэд, хуулийн этгээдээс төлбөртэй мэдээлэл авах тухай, түүнд урамшуулал олгох тухай мэдээллийг олон нийтэд нээлттэй тавьсан байна. (Зураг 1) Үүний дагуу иргэд Танилт нэвтрэлтийн систем (ДАН систем, <https://sso.gov.mn/>)-д хандан гэмт хэрэгтэй холбоотой мэдээллийг мэдэгдэх боломжтой байна.

Зураг 2. Тагнуулын ерөнхий газраас мэдээлэл авах тухай мэдэгдэл



**ТАГНУУЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР**

Танилцуулга Хууль эрх зүй Мэдээлэл Төрийн болон албаны нууц

Мэдээлэл авах

Төрийн болон албаны нууцыг хамгаалахад туслалцаа үзүүлсэн иргэн, хуулийн этгээдийг урамшуулах тухай танилцуулга

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т төрийн болон албаны нууц задарсан, үрэгдсэн байж болзошгүй тухай мэдсэн, түүнчлэн гээгдсэн, алдагдсан нууц тээгчийг олсон аливаа албан тушаалтан, иргэн энэ талаар тагнуулын байгууллагад нэн даруй мэдэгдэх үүрэгтэй гэж заасан.

Та төрийн болон албаны нууцыг хадгалалт, хамгаалалтын талаар үнэн зөв, бодитой, цаг мэдээлэл өгснөөр Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт зохих хувь нэмэр оруулж байгаа явдал бөгөөд "Журам батлах тухай" Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон албаны нууцыг хамгаалахад туслалцаа үзүүлсэн иргэн, хуулийн этгээдийг урамшуулах журам"-д заасны дагуу мөнгөн болон бусад хэлбэрийн урамшуулал авах боломжтой юм.

Тагнуулын байгууллага нь таны өгсөн мэдээллийн нууцлалыг чанд хадгалж, таны аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах болно.

Таны өгсөн мэдээлэл нь үнэн зөв, бодитой байх шаардлагатай бөгөөд санаатайгаар худал мэдээлэл өгсөн, төөрөгдүүлсэн бол Зөрчлийн тухай хуулийн 15.13 дугаар зүйлд заасны дагуу шийтгэл оногдуулахыг АНХААРНА УУ

Эх сурвалж: <https://www.gia.gov.mn/mn/menu/402>

Тагнуулын ерөнхий газар нь Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Тагнуулын байгууллагын тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд улс орны үндэсний аюулгүй байдлыг тагнуулын аргаар хангах үндсэн чиг үүрэгтэй төрийн тусгай байгууллага юм. Тус чиг үүргийнхээ хүрээнд үйл ажиллагаа нь нийтэд ил байдаггүй тул гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж байгаа, завдсан, эсхүл үйлдсэн тухай болон эрэн сурвалжлагдаж байгаа хүн, эд зүйл, тээврийн хэрэгсэл, баримт бичгийн тухай мэдээллийг төлбөртэй авсан байдлыг илрүүлэх боломжгүй байна.

(ii) Цагдаагийн байгууллага

2020-2024 оны хугацаанд Цагдаагийн байгууллагаас тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр Хууль


зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын 2017 оны А/297, 360 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Иргэд, байгууллагаас төлбөртэй мэдээлэл авахад баримтлах үнэлгээний жишиг”, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны Гэмт хэргийн тухай мэдээллийг төлбөртэй авах /код 210/ журам”-ын дагуу иргэд, олон нийтэд телевиз, цахим сайтууд, тараах материал, зурагт самбар зэргийг бэлтгэн нийт нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсүүдээс 2853 удаа мэдээлэл түгээж ажилласан байна.

Мөн 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрөөс “Цагдаагийн ерөнхий газраас эрэн сурвалжилж байна” пэйж хуудсыг нээн ажиллуулж, өнөөдрийн байдлаар оршин суугаа газраасаа сураггүй алга болсон (Бага насны хүүхэд), оргодол 373 зарлан мэдээлсэн байна. Уг зарлан мэдээллийн үр дүнд 102 иргэнийг олж тогтоосон бөгөөд тухай бүрт “ач холбогдолтой мэдээллийг төлбөртэй авна” гэсэн агуулгыг оруулж ажилласан. Тус пэйж нь өнөөдрийн байдлаар нийт 25,390 дагач, 13,500 лайк, сарын хугацаанд тогтмол 3,400,000 иргэнд мэдээлэл түгээж байна.

Түүнчлэн 2020 оны мэдээгээр “Хулгайн гэмт хэргийг таслан зогсоох зорилгоор цагдаагийн байгууллага төлбөртэй мэдээлэл авдаг болсон” талаар ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Б.Чулуунтамир мэдээлжээ. Тодруулбал, Монгол улсад жилд дунджаар 40 мянга орчим гэмт хэрэг бүртгэгддэгээс 80 хувь орчим нь өмчийн эсрэг гэмт хэрэг байдаг ба үүнээс урьдчилан сэргийлэх 2 төрлийн үйл ажиллагааны нэг нь иргэдээс мэдээлэл худалдаж авах болсон байна. Иргэд аль ч аймгийн Цагдаагийн газарт очоод “Энэ гэмт хэргийн талаар, ийм мэдээлэл надад байна. Би үүнийг зарна” гэсэн тохиолдолд худалдаж авах үүрэг нь тухайн аймгийн цагдаагийн газрын удирдлагад байгаа гэжээ.

Эрүүгийн хууль (2015)-ийн 17.1 дүгээр зүйлд заасан “Хулгайлах” гэмт хэргийн сүүлийн 8 жилийн (2017-2024) статистик тоон баримтыг харвал 2018-2021 он хүртэл тогтмол буурсан, 2021-2024 оны хооронд бага зэргийн хэлбэлзэлтэй байгаа ч ерөнхийдөө буурч буй чиг хандлагыг илтгэж байна.

График 3.Хулгайлах гэмт хэргийн статистик үзүүлэлт (2017-2024 он)



Эх сурвалж: ЦЕГ-ын 2017-2024 онд бүртгэгдсэн гэмт хэргийн тайлангаас,
<https://police.gov.mn/as/article/3?page=5&size=20>

Түүнчлэн Цагдаагийн байгууллагаас эрэн сурвалжилж байгаа, сураггүй алга болсон, зөрчил үйлдсэн иргэний мэдээллийг төлбөртэй авах тухай дараах зарыг өөрийн цахим хуудаст тогтмол байршуулж байна.

Зураг 3. ЦЕГ-аас гэмт хэргийн талаарх мэдээллийг төлбөртэй авах талаар зар байршуулсан байдал

ЭРЭН СУРВАЛЖИЛЖ БАЙНА

СУРАГГҮЙ АЛГА БОЛСОН

ЗӨРЧИЛ ҮЙЛДСЭН ХҮН



Эцэг /Эх/: Ахжархын

Нэр: Айхын

Нас: 12

Хүйс: Эр

Мэдээлэл өгөх: Баян-Өлгий аймгийн ЦГ

Утас: 94442902



Эцэг /Эх/: Ахжархын

Нэр: Ислам

Нас: 13

Хүйс: Эр

Мэдээлэл өгөх: Баян-Өлгий аймгийн ЦГ

Утас: 94442902



Эцэг /Эх/: Амандых

Нэр: Мейрамбек

Нас: 13

Хүйс: Эр

Мэдээлэл өгөх: Баян-Өлгий аймгийн ЦГ

Утас: 94442902



Эцэг /Эх/: Чулуунбаатар

Нэр: Чулуунсугар

Нас: 30

Хүйс: Эм

Мэдээлэл өгөх: Хан-Уул дүүргийн цагдаагийн газрын 2-р хэлтэс

Утас: 94945425



Эцэг /Эх/: Монхор

Нэр: Сурдалай

Нас: 56

Хүйс: Эр

Мэдээлэл өгөх: Говьсүмбэр аймгийн ЦХ

Утас: 98641102



Эцэг /Эх/: Готов

Нэр: Отгонцэцэг

Нас: 49

Хүйс: Эм

Мэдээлэл өгөх: Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн газрын 3-р хэлтэс

Утас: 94945419



Эцэг /Эх/: Нина

Нэр: Одхүү

Нас: 47

Хүйс: Эр

Мэдээлэл өгөх: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар

Утас: 266344



Эцэг /Эх/: Өлзий

Нэр: Улаанаа

Нас: 41

Хүйс: Эм

Мэдээлэл өгөх: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар

Утас: 266344



Эцэг /Эх/: Дуламдорж

Нэр: Мөнхтогтох

Нас: 24



Эцэг /Эх/: Батсүх

Нэр: Маналжав

Нас: 57

Хүйс: Эм



Эцэг /Эх/: Цэрэндулам

Нэр: Рэнцэнбат

Нас: 77



Эцэг /Эх/: Дэнсмаа

Нэр: Агаарнаран

Нас: 14

Хүйс: Эр



Эцэг /Эх/: Дэнсмаа

Нэр: Агаарнаран

Нас: 14

Хүйс: Эр

Танд энэ хүний талаар өгөх мэдээлэл байгаа бол доор байрлах **МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ УТСАНД** холбогдож цагдаагийн байгууллагатай хамтран ажиллахыг хүсье.

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛИАС

35 дугаар зүйл. Гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээллийг иргэдээс төлбөртэй авах

35.1. Гэмт хэрэг, зөрчил үйлдэхээр бэлтгэж байгаа болон үйлдсэн тухай мэдээллийг гэмт хэрэг, зөрчлийг хянан шалгах эрх бүхий байгууллага иргэдээс төлбөртэй авч болно.

35.2. Гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээллийг төлбөртэй авах ажиллагаанд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.2 дугаар зүйл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.5 дугаар зүйлийг баримтална.

35.3. Гэмт хэрэг, зөрчлийн хэрэг бүртгэл, мөрдөн шалгах эрх бүхий байгууллага, албан тушаалтан мэдээллийн нууцыг чанд хадгалж, шаардлагатай бол мэдээлэгчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авах үүрэгтэй.

мэдээлэл өгөх: 94945409

Эх сурвалж: ЦЕГ-ын албан ёсны цахим хуудас, <https://police.gov.mn/suspect>

Түүнчлэн дээрх төлбөртэй авах талаарх мэдээллийг зарлаагүй боловч хүн, хуулийн этгээдээс мэдээллийг төлбөртэй өгөх талаар сүүлийн 5 жилийн хугацаанд нийт 246 хүсэлт ирснээс 240 хүсэлтийг шийдвэрлэсэн байна.

(iii) Авлигатай тэмцэх газар

Тус судалгааны ажлын 2.3.1 дэх хэсгээс дэлгэрүүлэн харна уу.

2.3.3. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн төлбөртэй мэдээлэл авахтай холбоотой зохицуулалтын хэрэгжилт

39 дүгээр зүйл. Мэдээллийг төлбөртэй авах

39.1.Цагдаагийн байгууллага дараахь мэдээллийг төлбөртэй авахаар нийтэд зарлаж болно:

39.1.1.гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж байгаа, завдсан, эсхүл үйлдсэн тухай;

39.1.2.эрэн сурвалжлагдаж байгаа хүн, эд зүйл, тээврийн хэрэгсэл, баримт бичгийн тухай.

39.2.Мэдээллийг төлбөртэй авах тухай зарлаагүй боловч хувь хүн, хуулийн этгээдээс хүсэлт тавьсан тохиолдолд мэдээллийг төлбөртэй авах эсэхийг тухайн цагдаагийн байгууллагын дарга шийдвэрлэнэ.

39.3.Мэдээллийн төлбөрийн үнэлгээний жишгийг дотоод хэргийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

39.4.Шаардлагатай бол мэдээлэгчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авна.

Цагдаагийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсгийг үндэслэн 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын хамтран Дугаар А-297,360 тушаалыг баталсан байна. Тус тушаалын хавсралтаар “Иргэд, байгууллагаас төлбөртэй мэдээлэл авахад баримтлах үнэлгээний жишиг”-ийг дараах байдлаар тогтоосон байна.

Хүснэгт 3.Иргэд, байгууллагаас төлбөртэй мэдээлэл авахад баримтлах үнэлгээний жишиг

№	Үнэлгээний жишгийн шалгуур	Мөнгөн дүн /төгрөгөөр/
1	Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж байгаа, завдсан, эсхүл үйлдсэн тухай мэдээлэл	50,000-2,000,000 төгрөг хүртэл
2	Арван хоёр жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан илрээгүй хүнд гэмт хэргийн тухай мэдээлэл	5,000,000 төгрөг хүртэл
3	Үндэстэн дамнасан зохион байгуулалттай, террор үйлдэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, хүн худалдаалах гэмт хэргийн тухай мэдээлэл	5,000,000 төгрөг хүртэл
4	Эрэн сурвалжлагдаж буй түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйл, бусад эд зүйлсийн тухай мэдээлэл	2,000,000 төгрөг хүртэл

Эх сурвалж: Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын хамтарсан А-297,360 дугаар тушаалын хавсралт, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=208193>

Түүнчлэн Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөх албанаас Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.5 дугаар зүйл (Гэмт хэргийн талаарх мэдээллийг төлбөртэй авах), Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 39 дүгээр зүйл (Мэдээллийг төлбөртэй авах)-ийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд иргэдээс төлбөртэй мэдээлэл авахад шаардагдах 30.000.000 (Гучин сая) төгрөгийг шийдвэрлүүлэхээр Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдөр албан бичиг хүргүүлж ажилласан байгааг дурдах нь зүйтэй.

Цагдаагийн байгууллагаас 2019 онд эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр 144 аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлж, 134 гэрч, хохирогчийг; 2020 онд 104 хамгаалалтын арга хэмжээ авч 4 шүүгч, 3 прокурор, 6 гэрч, 82 хохирогч, 6 хамаарал бүхий этгээд нийт 101 хүнийг; 2021 оны эхний хагас жилд эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр Урьдчилан сануулах 82, Тодорхой үйлдлийг хязгаарлах 4, Биечилсэн хамгаалалт 4, Мэдээллийн нууцлалыг хангах 1, Аюулгүй газарт түр

байрлуулах 1, нийт 96 хамгаалалтын арга хэмжээ хэрэгжиж, гэрч, 7, хохирогч 88, прокурор 1, хамаарал бүхий иргэн 5, нийт 101 хүнийг аюулгүй байдлыг хангасан байна.

2.3.4. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн төлбөртэй мэдээлэл авахтай холбоотой зохицуулалтын хэрэгжилт

54 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах эдийн засгийн хөшүүрэг

1. Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд үзүүлэх хортой аюултай нөлөөллийг багасгах дэвшилт арга, хоргүй, аюулгүй, бохирдолгүй, хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг төрөөс урамшуулна.

2. Экологийн боловсрол, хүмүүжил олгох, байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх ажилд төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журмыг Засгийн газар тогтооно.

4. Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгсөн, түүнчлэн зөрчлийг илрүүлсэн, илрүүлэхэд бодитой тусалцаа үзүүлсэн иргэнд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн орлогын дүнгийн 15 хувьтай тэнцэх мөнгөн урамшууллыг сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос олгоно.

5. Хууль бусаар бэлтгэж хураалгасан байгалийн баялгийн борлуулалтын орлогын 15 хувийг тухайн зөрчлийг илрүүлсэн улсын байцаагч, байгаль хамгаалагчид тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос олгоно.

6. Энэ зүйлийн 4, 5, 8, 9 дахь хэсэгт заасан урамшуулал олгох журмыг Сангийн болон Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд батална.

7. Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан мэдээлэгчийг холбогдох хууль тогтоомжийн дагуу нууцална.

8. Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгсөн иргэн, нөхөрлөл, төрийн бус байгууллагад 150000 төгрөгийн мөнгөн урамшууллыг сум, дүүргийн Засаг дарга ажлын 10 өдөрт багтаан байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос олгоно.

10. Хууль бусаар бэлтгэж хураалгасан байгалийн баялгийг борлуулсны орлого болон гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд ашиглаж хураалгасан зэвсэг, тээврийн хэрэгсэл, унаа хөсөг, техник, тоног төхөөрөмжийг борлуулсны орлогыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан Байгаль орчин, уур амьсгалын санд оруулна.

11. Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийг мөрдөхөд шаардлагатай үнэлгээ, шинжилгээ, шинжээчийн болон лабораторийн зардлыг эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр Байгаль орчин, уур амьсгалын сангаас санхүүжүүлнэ.

Байгаль орчныг хамгаалах эдийн засгийн хөшүүргийг зохицуулсан 54 дүгээр зүйлээр байгальд ээлтэй үйл ажиллагааг дэмжих, хууль бус үйлдлийг мэдээлэх, илрүүлэхэд иргэд, байгууллагуудыг идэвхтэй оролцуулах байна. Тус зүйлд байгаль орчныг хамгаалж, нөхөн сэргээх, хоргүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийг төрөөс урамшуулах зохицуулалттай бөгөөд эдгээр урамшууллыг олгох журмыг Засгийн газар тогтоохоор хуульчилжээ.

Мөн байгаль орчны хууль тогтоомжийг зөрчсөн үйлдлийг мэдээлсэн, илрүүлсэн иргэн, нөхөрлөл, төрийн бус байгууллагад торгууль, нөхөн төлбөрийн орлогын 15 хувь буюу тодорхой хувийг мөнгөн урамшуулал болгон олгох болон 150,000 төгрөгийн урамшуулал өгөхөөр зохицуулсан. Хууль бусаар бэлтгэсэн байгалийн баялаг, зөрчил гаргахад ашигласан тээврийн хэрэгсэл, зэвсгийг хураан авч борлуулсан орлогын 70 хүртэлх хувийг зөрчлийг илрүүлсэн албан хаагч, нөхөрлөл, ТББ-д урамшуулал болгон олгох юм.

Эдгээр урамшууллыг Байгаль орчин, уур амьсгалын сан болон орон нутгийн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос санхүүжүүлэх бөгөөд урамшууллын хэмжээг Сангийн сайд болон байгаль орчны асуудал эрхэлсэн сайд нар хамтран баталсан 2006 оны 342/366 дугаар хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралтаар “Байгаль орчны хууль тогтоомжийн зөрчлийг илрүүлсэн буюу зөрчлийн талаар бодит мэдээлэл өгсөн иргэнд мөнгөн урамшуулал олгох журам”, 2 дугаар хавсралтаар “Хууль бусаар бэлтгэж хураалгасан байгалийн баялгийн борлуулалтын орлогоос байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчийг урамшуулах журам”-ийн дагуу зохицуулна.

Байгаль орчны хууль тогтоомжийн зөрчлийг илрүүлсэн буюу зөрчлийн талаар бодит мэдээлэл өгсөн иргэнд мөнгөн урамшуулал олгохдоо дараах шалгуурыг тодорхойлжээ. Үүнд:

- Аливаа зөрчлийг илрүүлсэн буюу ноцтой зөрчлийн талаар цаг үеэ олсон бодитой үнэн зөв, тодорхой мэдээлэл ирүүлсэн иргэнд мөнгөн урамшуулал олгоно.
- Мэдээлэлд дурдсан зөрчил нь хөдөлшгүй баримтаар нотлогдож эцэслэн шийдвэрлэгдсэн тохиолдолд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн орлого нь зохих дансанд төлөгдсөний дараа уг торгууль, нөхөн төлбөрийн орлогын дүнгийн 15 хувиар тооцож мөнгөн урамшууллыг мэдээлэгчид олгоно.
- Мөнгөн урамшуулал нь байгаль орчны хяналтын орон тооны бүх шатны байцаагч, байгаль хамгаалагчдад хамаарахгүй. Байгаль орчны ноцтой зөрчлийг илрүүлсэн, эсвэл зөрчлийн талаар мэдээлэл өгсөн, зөрчлийг илрүүлэхэд бодит туслалцаа үзүүлсэн иргэн нь мэдээллийнхээ хариуг авсны дараа мөнгөн урамшуулал авах тухай хүсэлтээ нутаг дэвсгэрийн харьяалсан тухайн шатны Засаг даргад хандаж өргөдөл бичнэ.
- Өргөдлийг хүлээн авсан байгууллагын удирдлага нь уг мэдээллийн мөрөөр шалгалт хийсэн байгаль орчны хяналтын улсын байцаагчаас албан ёсны тодорхойлолт гаргуулсны үндсэн дээр торгууль, нөхөн төлбөрийн орлогын 15 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох талаар шийдвэр гаргана.
- Мэдээллийн дагуу хяналт шалгалт хийх явцад тухайн мэдээлэлд дурдагдаагүй бусад зөрчил илэрсэн тохиолдолд уг зөрчлийг үйлдсэн этгээдэд ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн орлогоос мэдээлэгчид урамшуулал олгохгүй.
- Мэдээлэгчид мөнгөн урамшуулал олгох тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг үндэслэн тухайн байгууллагын санхүү урамшууллыг эзэнд нь саадгүй олгох ажлыг хариуцан гүйцэтгэнэ.

БОХтХ-ийн 54 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгсөн, түүнчлэн зөрчлийг илрүүлсэн, илрүүлэхэд бодитой туслалцаа үзүүлсэн иргэнд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн орлогын дүнгийн 15 хувьтай тэнцэх мөнгөн урамшууллыг сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос олгоно”, мөн хуулийн болон 54.9-д “Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгсөн иргэн, нөхөрлөл, төрийн бус байгууллагад 150,000 төгрөгийн мөнгөн урамшууллыг сум,

дүүргийн Засаг дарга ажлын 10 өдөрт багтаан байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос олгоно” гэж заасан.

Үүнээс харахад, БОХТХ-д байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд иргэн, нөхөрлөл, төрийн бус байгууллага мэдээлэхэд 150,000 төгрөгийн урамшуулал болон зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн орлогын дүнгийн 15 хувьтай тэнцэх мөнгөн урамшууллыг олгох хуулийн зохицуулалт хоорондын давхардал бий болсон байна. Өөрөөр хэлбэл иргэн, нөхөрлөл, төрийн бус байгууллага байгаль орчны тухай хуулийн зөрчлийг мэдээлэлсэн тохиолдолд тус хуулийн зохицуулалт дахь урамшууллын хэмжээ нь ойлгомжгүй байна.

Түүнчлэн БОХТЗИБЗТБМӨИМУОЖ-ийн 22 дугаар зүйлд “Мэдээлэгчийг урамшуулахад шаардагдах торгууль, нөхөн төлбөрийн орлогын 15 хувийг зөрчил гаргагчид ногдуулж төв орон нутгийн төсвийн орлого /төрийн сан/-ын дансанд оруулсан торгууль, нөхөн төлбөрийн орлогоос гаргана” гэж заасан.

БОХТХ-ийн 54 дүгээр зүйлийн 4 болон 9 дэх хэсэгт хууль зөрчсөн тохиолдолд мэдээлэхэд урамшууллыг “байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос” олгоно гэж заасан бол БОХТЗИБЗТБМӨИМУОЖ-ийн 22-д “төв орон нутгийн төсвийн орлого /төрийн сан/-ын дансанд оруулсан торгууль, нөхөн төлбөрийн орлогоос гаргана” гэж урамшуулал олгох байгууллагыг хууль болон журамд ялгаатай байдлаар тодорхойлсон байна. Үүний талаар БОУАӨЯ-ны Салбарын хяналтын газраас дараах ярилцлагад дурдахдаа:

Шигтгээ 1. “Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээлэл өгсөн иргэнийг урамшуулах журам”-ыг боловсронгуй болгох талаар ярилцлагын хэсгээс

Сангийн сайд, Байгаль орчны сайдын 2006 оны 342/366 дугаар хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралтаар “Байгаль орчны хууль тогтоомжийн зөрчлийг илрүүлсэн буюу зөрчлийн талаар бодит мэдээлэл өгсөн иргэнд мөнгөн урамшуулал олгох журам”, 2 дугаар хавсралтаар “Хууль бусаар бэлтгэж хураалгасан байгалийн баялгийн борлуулалтын орлогоос байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчийг урамшуулах журам” тус тус батлагдсан боловч **урамшуулал олгохоор хуульчилсан санхүүжилтийн эх үүсвэр, хууль эрх зүйн зохицуулалт зөрүүтэйгээс журмын хэрэгжилт хангагдахгүй байна.**”

Дээрхээс үзвэл, БОХТХ-ийг зөрчсөн талаарх мэдээллийг иргэн, хуулийн төрийн бус байгууллагаас эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн тохиолдолд олгох урамшууллын хэмжээ, нөхцөл, журмыг тус хуульд тодорхой заагаагүй нь эрх зүйн зохицуулалтын тодорхой бус байдлыг бий болгож байна. Мөн БОХТХ болон “Байгаль орчны хяналт, түүний зөрчлийн илрүүлэлт, бүртгэл, мэдээллийн үнэлгээ, мэдээлэл өгсөн этгээдийг урамшуулах журам”-д урамшуулал олгох эрх бүхий байгууллагыг өөр өөрөөр тодорхойлсон нь давхардал, зөрүү үүсгэж, урамшууллын тогтолцооны хэрэгжилтэд хүндрэл учруулж байна. Үүний үр дүнд БОХТХ-ийн иргэдийн идэвхтэй оролцоог дэмжих, байгаль орчны зөрчлийг илрүүлэхэд олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэх гэсэн зорилго бүрэн хэрэгжихгүй байгаа нь ажиглагдаж байна. Иймээс урамшуулал олгох хэмжээ, байгууллага, журмыг нэг мөр, харилцан уялдаатайгаар сайжруулах шаардлагатай байна.

Байгаль орчны салбарт хийж гүйцэтгэсэн сүүлийн 2 жилийн хяналт шалгалтын дүнгээс үзэхэд, иргэдийн өргөдөл, гомдлын мөрөөр хийсэн хяналт шалгалтын тоо өссөн, байгалийн нөөц баялагт учруулсан хохирлын хэмжээ, зөрчил гаргагчдын тоо нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Иймд тус яамнаас иргэд, олон нийтийн байгалиа хамгаалах журамт үүргийг идэвхжүүлэх, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор гомдол, мэдээлэл хүлээж авах

117 тусгай дугаар ажиллуулж, иргэдийн гомдол, хүсэлтийн дагуу хяналт шалгалтыг шуурхай зохион байгуулах, үнэн бодит мэдээлэл өгсөн иргэдийг урамшуулах эрх зүйн зохицуулалтыг боловсруулахад анхаарч ажиллаж байна.³⁰

Ийнхүү БОУАӨЯ-ны Салбарын хяналтын газар энэ оноос Байгалийн орчны зөрчлийн мэдээллийг хүлээн авах 117 тусгай дугаар ажиллуулж эхэлжээ. Ой, байгалийн ургамал, амьтан, газрын хэвлий, ус, рашаан ашиглалт, хаягдал ус, хог хаягдал, химийн бодис зэрэг байгаль орчинд шууд буюу шууд бусаар хохирол учруулж болзошгүй нөхцөл байдал үүссэн талаарх иргэд, олон нийтийн мэдээллийг хүлээн авч байна.

Шигтгээ 2. Байгаль орчны газрын байгаль орчны хяналтын улсын байцаагчийн ярилцлагын хэсгээс

“Байгаль орчны зөрчил мэдээллийг хүлээн авах 117 тусгай дугаарт улсын хэмжээнд зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч, зөрчил аль орон нутагт үйлдэгдсэнээс хамааран тэр орон нутаг руу мэдээллийг шилжүүлэн шийдвэрлэгддэг.”

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны дэргэдэх 117 тусгай дугаарт 2025 оны байдлаар нийт 12 дуудлага мэдээлэл ирүүлсэн байна. Тухайлбал, Сэлэнгэ аймгийн Баянгол сум, Нарангийн голын ай савд сав газрын урсац, голын голдирлыг өөрчлөн алт ухаж байгаа асуудлаар хэд хэдэн дуудлага мэдээлэл 117 дугаарт ирсэн байна.³¹

Мөн Сэлэнгэ аймгийн Мандал, Түнхэл сумын иргэд, аж ахуйн нэгжээс ойгоос мод бэлтгэх журмыг цуцалсантай холбогдуулан мод бэлтгэх үйл ажиллагаа зогссон ба хууль эрх зүйн зохицуулалтыг яаралтай шийдвэрлэх, Төв аймаг Баянчандмань сумын Эрдэнэ 3 дугаар баг, Жимбэгэрийн аманд ой модтой газар олгосон, ойг хашаалсан гэх гомдол, мэдээллийг бүртгэгдэж, холбогдох чиглэлээр ирүүлсэн гомдол мэдээллийг шалган шийдвэрлэхээр ажиллаж байгаа³² талаар мэдээлсэн байна.

Дүгнэвэл, БОХТХ-ийн зөрчсөнтэй холбоотой мэдээллийг хүргүүлсэн иргэн, хуулийн этгээд, төрийн бус байгууллагад урамшуулал олгохоор хуульчилсан санхүүжилтийн эх үүсвэр болон хууль болон журмын зөрүүтэй байдлаас тус хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Мөн уг мэдээллийг хүлээн авах 117 тусгай дугаарт бүртгэгдсэн мэдээллийн тохиолдол цөөн байх бөгөөд тэдгээр иргэдийг урамшуулсан эсэх тоон мэдээ байхгүй байна.

2.3.5. Амьтны тухай хуулийн төлбөртэй мэдээлэл авахтай холбоотой зохицуулалтын хэрэгжилт

Амьтны тухай хууль

38 дугаар зүйл. Зөрчил илрүүлсэн, мэдээлэл өгсөн иргэнийг урамшуулах

38.1. Амьтны тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийг илрүүлсэн, илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн буюу түүний тухай мэдээлэл өгсөн иргэнд уг мэдээлэл нь батлагдсан тохиолдолд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн хэмжээний 15 хувиар тооцож мөнгөн шагналыг сум, дүүргийн Засаг дарга олгоно.

³⁰ “Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээлэл өгсөн иргэнийг урамшуулах журам”-ыг боловсронгуй болгоно, Монголын Үндэсний олон нийтийн цахим хуудас, 2025.02.20, <https://www.mnb.mn/i/324355>, (Сүүлд үзсэн: 2025.10.15).

³¹ “Байгаль орчны зөрчил мэдээлэлд урамшуулал олгоно”, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, 2025.03.12, <https://www.gov.mn/mn/news/all/7d0761be-9977-4d4c-91f9-96744f6341d6>, (Сүүлд үзсэн: 2025.10.15).

³² Мөн тэнд.

Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль

14 дүгээр зүйл. Зөрчил илрүүлсэн, мэдээлэл өгсөн иргэнийг урамшуулах

14.1.Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийг илрүүлсэн буюу түүний тухай мэдээлэл өгсөн иргэнд уг мэдээлэл нь батлагдсан тохиолдолд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн хэмжээний 20 хүртэл хувиар тооцож мөнгөн шагналыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

Амьтны тухай хуулийн 38 дугаар зүйл болон Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуулийн 14 дүгээр зүйл нь иргэдийг байгаль хамгааллын зөрчил илрүүлэх, мэдээлэх үйл ажиллагаанд оролцуулахыг дэмжих зорилготой байна. Амьтны тухай хуульд зөрчил илрүүлсэн иргэнд ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн 15 хувиар урамшуулал олгохоор, сум, дүүргийн Засаг дарга хариуцахаар заасан бол Ховордсон амьтан, ургамлын тухай хуульд энэ хэмжээ 20 хүртэл хувь байж болох бөгөөд шагналыг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно гэжээ. Эдгээр хуулийн урамшууллын заалт нь иргэдийн оролцоог нэмэгдүүлж, хууль сахиулах, байгаль орчныг хамгаалах үйлсэд чухал ач холбогдолтой юм.

Байгаль хамгаалах чиглэлийн хууль тогтоож, ялангуяа Амьтны тухай хууль хэрхэн хэрэгжиж байгаад хяналт тавих нь өөрийн өвөрмөц онцлогтой байдаг. Учир нь энэ хуулийн хэрэгжилт хэрхэн хангагдаж байгаа байдал, үйлдэгдэж буй зөрчил нь бусдын нүдэн дээр тэр бүр ил үйлдэгдээд байдаггүй, далд байдаг учраас хяналт шалгалтыг төлөвлөгөөтэйгөөр тогтмол эсхүл цаг хугацааны хувьд гэнэтийн буюу төлөвлөгөөт бус гэсэн хэлбэрээр явуулдаг. Иймд хөдөө орон нутагт амьтныг агнах, барихыг хориглосон цаг хугацаа, зөрчил ихээр үйлдэгдэж болзошгүй газар оронд шалгалтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан хяналт шалгалтын арга хэлбэрээр, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан зөрчлийг эрх бүхий албан тушаалтан өөрийн хяналт шалгалтаар илрүүлэх, гомдол мэдээллийн дагуу зөрчил шалгадаг.³³

Хүснэгт 4.Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн талаар зөрчлийн шийдвэрлэлт 2023 оны байдлаар

Зөрчлийн тухай хуулийн бүлэг, зүйл, заалт	Нийт зөрчил	Газар дээр нь хялбаршуулсан журмаар шийтгэл оногдуулсан	Бүртгэж, хялбаршуулсан журмаар шийтгэл оногдуулсан	Зөрчлийн хэрэг бүртгэлийн хэрэг нээсэн
7.1 дүгээр зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль зөрчих	267	0	221	46
7.2 дугаар зүйл. Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль зөрчих	17	0	9	8

³³ Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF), “Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх: Хууль бусаар ан агнах гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэхэд анхаарах асуудлууд”, Сургалтын гарын авлага, (Хууль сахиулах байгууллагуудын албан хаагч нарын албан хэрэгцээнд зориулав), 185 дахь тал, https://wwfasia.awsassets.panda.org/downloads/20p10_wwf_hand_book_negdsen_.pdf.

7.3 дугаар зүйл. Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль зөрчил	1	0	0	1
7.4 дүгээр зүйл. Агаарын тухай хууль зөрчих	10	0	5	5
7.5 дугаар зүйл. Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль зөрчих	0	0	0	0
7.6 дугаар зүйл. Амьтны тухай хууль зөрчих	556	0	453	103
7.7 дугаар зүйл. Байгалийн ургамлын тухай хууль зөрчих	34	0	28	6
7.8 дугаар зүйл. Ургамал хамгааллын тухай хууль зөрчих	5	0	5	0
7.9 дүгээр зүйл. Ойн тухай хууль зөрчих	354	0	180	174
7.10 дугаар зүйл. Газрын хэвлийн тухай хууль зөрчих	223	0	192	31
7.11 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хууль зөрчих	114	0	61	53
7.12 дугаар зүйл. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль зөрчих	115	0	56	59
7.13 дугаар зүйл. Газрын тосны тухай хууль зөрчих	3	0	1	2
7.14 дүгээр зүйл. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль зөрчих	22	0	20	2
7.15 дугаар зүйл. Усны тухай хууль зөрчих	254	8	183	63
7.16 дугаар зүйл. Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль зөрчих	2	0	0	2
7.17 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутагт хориглосон үйл ажиллагаа явуулах	178	0	162	16
7.18 дүгээр зүйл. Генетик нөөцийн тухай хууль зөрчих	0	0	0	0
7.19 дүгээр зүйл. Гэрийн тэжээвэр амьтны тухай хууль зөрчих	0	0	0	0
Байгаль орчин, амьтан, ургамлыг хамгаалах журмын эсрэг зөрчил нийт	2142	8	1574	560

2023 оны байдлаар, Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлд Амьтны тухай хууль зөрчих зөрчлийг бүртгэж, хялбаршуулсан журмаар шийтгэл оногдуулсан 453, зөрчлийн хэрэг бүртгэлийн хэрэг нээсэн 103 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

Амьтны тухай хуулийн 38 дугаар зүйлд “Зөрчил илрүүлсэн, мэдээлэл өгсөн иргэнийг урамшуулах” талаар зохицуулсан бол тус зүйлийн 38.1 дэх хэсэгт “Амьтны тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийг илрүүлсэн, илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн буюу түүний тухай мэдээлэл өгсөн иргэнд уг мэдээлэл нь батлагдсан тохиолдолд зөрчил

гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн хэмжээний 15 хувиар тооцож мөнгөн шагналыг сум, дүүргийн Засаг дарга олгоно” гэж зохицуулсан.

Ийнхүү урамшуулал, мөнгөн шагналын талаар зохицуулсан хэдий ч Зөрчлийн тухай хуулиар 150 нэгж буюу 150,000 төгрөгөөр иргэнийг торгож, түүнийхээ 15 хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг олгохдоо батлагдсан тохиолдолд сум, дүүргийн Засаг дарга мөнгөн шагналыг олгох тухай зохицуулсан байна. Үүнтэй холбоотойгоор мэдээлэл өгсөн этгээдэд урамшуулал олгосон тухай олон нийтэд ил болсон тоо баримт, шийдвэр байхгүй байна. Харин 117 тусгай дугаарт 2025 оны байдлаар 12 мэдээлэл ирсэн болохыг холбогдох албан тушаалтнаас мэдээлсэн.

Байгаль орчинд үзүүлэх хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах зэрэг ирээдүйн ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалахад хувь нэмрээ оруулж зөрчил гаргасан иргэн, ААН-ийг илрүүлэн, энэ талаараа гомдол, мэдүүлэг гарган мэдэгдсэн ч мэдээлэгчийг урамшуулах, дэмжих, хамгаалах, цаашид учруулсан хохирлын хэмжээг тооцох, нөхөн төлүүлэх, төрөөс авах арга хэмжээний талаарх зохицуулалт, уялдаа холбоо хангалтгүй байна.³⁴

Амьтны тухай хуулийн 38 дугаар зүйл болон Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуулийн 14 дүгээр зүйлд тус тус зөрчил илрүүлсэн, мэдээлэл өгсөн иргэнийг урамшуулах эрх зүйн зохицуулалтыг тусгасан нь байгаль орчны тухай хууль тогтоомжийн зөрчлийг илрүүлэх, мэдээлэхэд иргэдийн идэвхийг нэмэгдүүлэх, хууль бус үйлдлийг илрүүлэхэд тусалсан иргэнийг урамшуулах зорилготой боловч бодит байдалд хэрэгжилт сул болох нь харагдаж байна.

Амьтны тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт “зөрчил илрүүлсэн, мэдээлэл өгсөн иргэнд мэдээлэл нь батлагдсан тохиолдолд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн хэмжээний 15 хувиар тооцож мөнгөн шагналыг сум, дүүргийн Засаг дарга олгоно” гэж заасан бол Ховордсон амьтан, ургамлын тухай хуулийн 14.1-д ижил агуулгатайгаар, гэхдээ “20 хүртэл хувиар” тооцож урамшууллыг “байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” олгоно гэж тусгасан байна. Ийнхүү тус хоёр хуулийн зорилго нь ижил боловч урамшуулал олгох эрх бүхий байгууллага, урамшууллын хэмжээ, олгох механизм харилцан адилгүй байгаа нь хууль хоорондын уялдаа дутмаг байгааг илэрхийлэх бөгөөд хэрэгжилтийн шатанд тодорхой хүндрэл үүсгэхээр байна.

Нэгдүгээрт, урамшуулал олгох байгууллагын ялгаа нь хэрэгжилтийн тодорхой бус байдлыг бий болгож байна. Амьтны тухай хуульд сум, дүүргийн Засаг дарга урамшуулал олгохоор заасан бол, Ховордсон амьтан, ургамлын тухай хуульд төв байгууллага буюу Байгаль орчин, аялал жуулчлалын яам хариуцахаар заасан. Энэ нь мэдээлэл хүлээн авах, шалгах, баталгаажуулах, шагнал олгох шат дамжлагын уялдаа, хариуцлагыг тодорхой бус болгож, зарим тохиолдолд хэрэгжилт гацах шалтгаан болдог. Тухайлбал, орон нутгийн түвшинд илрүүлсэн зөрчилд ямар байгууллага урамшуулал олгох вэ гэсэн асуудал тодорхойгүй хэвээр байна.

Хоёрдугаарт, эдгээр хуулийн хэрэгжилтэд нарийвчилсан журам, хэрэгжилтийн механизмын дутагдал байгаа нь урамшууллын бодит хэрэгжилтэд хамгийн том саад болж байна. Хуулиар урамшуулал олгох хэмжээ, эрх бүхий этгээдийг заасан боловч, уг

³⁴ Хууль зүйн үндэсний хүрээлэн, *Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан*, (Улаанбаатар: 2025), 17 дахь тал.

заалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай “урамшуулал олгох журам”, “бүртгэл, хяналтын систем”, “санхүүжилтийн эх үүсвэр”-ийг нарийвчилсан байдлаар батлаагүй байна. Үүний улмаас мэдээлэл өгсөн иргэнд урамшуулал олгох процесс тодорхойгүй, санхүүгийн хувьд бүрэн хэрэгжих боломжгүй байдал үүсэхээр байна.

Гуравдугаарт, мэдээлэл баталгаажуулах буюу “мэдээлэл нь үнэн зөв, зөрчил тогтоогдсон тохиолдолд” гэж заасан хэсэг нь практикт хэрэгжихэд төвөгтэй байдаг. Зөрчлийг илрүүлэхэд орон нутгийн хяналтын байгууллагууд, байгаль хамгаалагч, цагдаагийн байгууллагын оролцоо шаардлагатай бөгөөд мэдээлэл баталгаажих хүртэл хугацаа урт, зарим тохиолдолд нотлох баримт хангалтгүй байдаг. Иймээс мэдээлэл батлагдсан ч, урамшуулал олгох хүртэл хугацаа удааширч, иргэдийн идэвх буурах хандлага бий болох эрсдэлтэй юм.

Дөрөвдүгээрт, эдгээр зохицуулалтын хэрэгжилтэд төсвийн болон хариуцлагын асуудал давхар тулгардаг. Сум, дүүргийн Засаг дарга болон төв байгууллага нь урамшуулал олгоход шаардагдах хөрөнгийг тухайн үеийн төсвийн төлөвлөгөөнд тусгахгүй байх, эсвэл урамшууллын санг бүрдүүлээгүй байх боломжтой.

Тавдугаарт, мэдээлэгчийн эрх зүйн хамгаалалт, нууцлал, хариуцлагын асуудал хуульд тодорхой тусгагдаагүй байна. Хуульд мэдээлэгчийг хамгаалах, урамшуулах тухай заалт байгаа ч, түүний нэр нууцлах, хамгаалалтад авах, эсвэл худал мэдээлэл өгсөн тохиолдолд хариуцлага тооцох асуудал нарийн тодорхойгүй байна. Энэ нь мэдээлэгчийн итгэл, идэвхийг бууруулж, хууль хэрэгжих үр дүнд сөргөөр нөлөөлж байна.

Иймд дээрх хоёр хуулийн урамшууллын зохицуулалт нь иргэдийн оролцоог дэмжих, хууль бус агнуур, худалдаа, байгаль орчны зөрчлийг илрүүлэхэд чухал ач холбогдолтой боловч, хэрэгжилтийн түвшинд эрх зүйн тодорхой бус байдал, санхүүгийн дэмжлэгийн дутагдал, байгууллагуудын уялдаа, журам, механизмын сул тал зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан бодитоор хэрэгжихгүй байна. Цаашид эдгээр хуулийн заалтыг бодитоор хэрэгжүүлэхийн тулд урамшуулал олгох нарийвчилсан журмыг батлах, урамшууллын санхүүжилтийн тогтолцоог бий болгох, мэдээлэгчийн эрх зүйн баталгааг бэхжүүлэх, хяналт-шинжилгээний ил тод байдлыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Ингэснээр хуульд заасан урамшууллын зохицуулалт амьдралд хэрэгжиж, иргэдийн идэвхтэй оролцоо нэмэгдэн байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилт бодит үр дүнтэй болох боломж бүрдэх юм.

2.3.6. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн төлбөртэй мэдээлэл авахтай холбоотой зохицуулалтын хэрэгжилт

40 дүгээр зүйл. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах

40.1. Соёлын өвийг сурвалжлан олсон, нээлт хийсэн, соёлын өвийн сан хөмрөгийг баяжуулах, авран хамгаалах, түүнийг олон нийтэд сурталчлан таниулах, сэргээн уламжлуулах, сэргээн засварлахад идэвх санаачилгатай ажилласан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг төрөөс урамшуулна.

40.2. Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, захиргааны зөрчлийг илрүүлэхэд хувь нэмэр оруулсан иргэнийг төрөөс алдаршуулж, урамшуулна.

40.3. Энэ хуульд заасан шаардлагыг зөрчсөн этгээдийг илрүүлсэн, соёлын өвийг хуулбарласан, бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулсан тухай мэдээлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, улсын байцаагч, гэрээт харуулд борлуулалтын орлогын 15 хувийг аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга олгоно.

2014 оны Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 40 дүгээр зүйлд зааснаар дараах тохиолдолд иргэн, аж ахуй нэгж, байгууллагыг урамшуулахаар байна:

- соёлын өвийг сурвалжлан олсон, нээлт хийсэн, соёлын өвийн сан хөмрөгийг баяжуулах, авран хамгаалах, түүнийг олон нийтэд сурталчлан таниулах, сэргээн уламжлуулах, сэргээн засварлахад идэвх санаачилгатай ажилласан;
- соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, захиргааны зөрчлийг илрүүлэхэд хувь нэмэр оруулсан;
- хуульд заасан шаардлагыг зөрчсөн этгээдийг илрүүлсэн, соёлын өвийг хуулбарласан, бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулсан тухай мэдээлсэн.

Мөн тус хуулийн 40 дүгээр зүйлийн 40.5 дахь хэсэгт соёлын биет бус өвийг үндэсний болон дэлхийн хэмжээнд сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагчийг жил бүр тодруулж, мөнгөн шагнал олгох бөгөөд мөнгөн шагнал олгох журмыг Засгийн газар батлахаар зохицуулжээ.

Үүний дагуу 2017 онд Соёлын өвийг хамгаалахад идэвх санаачилгатай оролцсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам батлагдсан. Тус журамд зааснаар дараах тохиолдолд урамшууллыг олгохоор зохицуулжээ. Үүнд:

- соёлын өвийг сурвалжлан олсон, нээлт хийсэн, соёлын өвийн сан хөмрөгийг баяжуулсан, авран хамгаалсан, олон нийтэд сурталчлан таниулсан, сэргээн уламжлуулсан, сэргээн засварласан ажилд 3-аас доошгүй удаа сайн дураараа идэвх санаачилгатай оролцсон;
- соёлын өвийг гадаад улсад алдаршуулах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх үйлсэд бодитой хувь нэмэр оруулсан;
- соёлын биет өвийг байгалийн аюулт үзэгдэл, осол, аюулаас авран хамгаалахад идэвх зүтгэлтэй оролцсон;
- соёлын биет өвийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоосон, эсхүл гэмт хэрэг зөрчлийг илрүүлэхэд хувь нэмэр оруулсан нь хуулийн байгууллагын тодорхойлолтоор тогтоогдсон;
- соёлын биет өвийн өмчлөх эрхээ төрд үнэ төлбөргүй шилжүүлсэн;
- эвдэрч гэмтэх, устах аюул учирсан палеонтологи, археологийн олдворыг эрх бүхий этгээдэд мэдэгдсэн, хамгаалах арга хэмжээг хууль тогтоомжид заасан журмын дагуу авсан;
- соёлын өвийг хамгаалах ажилд шинжлэх ухааны туршилтаар батлагдсан шинэ технологи нэвтрүүлсэн;
- монгол угсаатны түүхэнд холбогдох түүх, соёлын дурсгалт зүйлийг гадаад улсаас эргүүлэн авчирсан, эсхүл энэ ажилд чухал хувь нэмэр оруулсан нь 3-аас доошгүй төрийн болон төрийн бус байгууллагын тодорхойлолтоор нотлогдсон.

Ийнхүү урамшуулал олгох тохиолдлыг хууль болон журамд давхардуулан зохицуулсан нь асуудал үүсгэхээр байна. Журам буюу захиргааны хэм хэмжээний акт нь нэгдүгээрт, Үндсэн хууль болон зарим хуулиудад тусгагдсан “гагцхүү хуулиар...” гэсэн зохицуулалтын хүрээнд, хоёрдугаарт хэм хэмжээний актын зохицуулалтын хүрээ буюу эрх шилжүүлж буй хуулиар олгогдсон хүрээ, хязгаарын хувьд тусгайлан эрх олгож буй хуулийн агуулга, зорилго, хүрээнд байх ёстой.³⁵ Гэтэл ийнхүү хуулийн агуулгаас давсан журмын зохицуулалт байгаа нь асуудал үүсгэж байна. Түүнчлэн тухайн зохицуулалттай холбоотойгоор дараах асуудал тулгамдаж байна.

³⁵ Даржаагийн Баттулга, “Хэм хэмжээний актаар зохицуулах харилцааны хүрээ, хязгаар болон хяналтын зарим асуудлыг боловсронгуй болгох нь”, 2016, 8 дахь тал, <https://legaldata.mn/b/338>.

(i) *Мэдээлэл, бүртгэл, статистикийн дутагдал ба нэгдмэл сангуй байдал*

Соёл, урлагийн салбарын статистикийн мэдээлэл цуглуулах, боловсруулах үйл явц, аргачлал, маягтууд Монгол Улсад сүүлийн жилүүдэд шинэчлэгдэж байгаа ч мэдээллийн тогтмол, хэвшмэл систем бүрэн хөгжөөгүй байна³⁶. Соёлын өвийн үндэсний төвийн 2021 оны тайланд:

- Улсын хэмжээнд 9,754 дурсгалт газар, 336,449 ширхэг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл бүртгэгдэн хадгалагдаж байна.
- Соёлын биет бус өвлөн уламжлагчдын бүртгэлд 10,849 хүн (2021 онд) байна³⁷.

(ii) *Урамшуулах тогтолцооны тогтмол бус байдал, санхүүжилтийн хязгаар*

Соёлын биет бус өвийн шилдэг өвлөн уламжлагчийг жил бүр мөнгөн шагналаар шагнадаг уламжлалтай байдаг талаар мэдээлэл бий. Жишээ нь, 2021 онд Соёлын сайдын тушаалаар хамгийн шилдэг өвлөн уламжлагчийг “30 сая төгрөг”-өөр шагнахаар шийдвэрлэсэн байна³⁸. Гэхдээ эдгээр шагнал, урамшууллыг жил бүр тогтмол өгдөг эсэх, шагналын хэмжээг бодлого, төсөвт хэрхэн уялдуулдаг зэрэг нарийвчилсан мэдээлэл олон нийтэд нээлттэй биш байна. Энэ нь урамшуулах механизм тогтмол, ил тод биш болохыг харуулж байна.

Дүгнэвэл, Монгол Улсад соёлын өвийг хамгаалах, хадгалах, түгээн дэлгэрүүлэх асуудал нь үндэсний оюуны өвийг хамгаалах үндсэн чиглэл бөгөөд энэ хүрээнд иргэн, байгууллагыг урамшуулах тогтолцоог хуульчилсан байна. 2014 онд батлагдсан Соёлын өвийг хамгаалах тухай хууль нь соёлын өвийг илрүүлэх, авран хамгаалах, түгээн дэлгэрүүлэхэд идэвхтэй оролцсон иргэн, байгууллагыг урамшуулах эрх зүйн үндсийг бүрдүүлжээ. Тус хуулийн 40 дүгээр зүйлд соёлын өвийг сурвалжлан олсон, нээлт хийсэн, соёлын өвийн эсрэг гэмт хэрэг илрүүлэхэд хувь нэмэр оруулсан, хууль зөрчигчийг мэдээлсэн зэрэг тохиолдолд урамшуулал олгохоор тусгасан нь иргэдийн оролцоог дэмжих зорилготой байна.

Гэвч энэхүү зохицуулалтыг хэрэгжүүлэх зорилгоор 2017 онд батлагдсан Соёлын өвийг хамгаалахад идэвх санаачилгатай оролцсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам нь хуулийнхаа цар хүрээнээс давсан бөгөөд хууль болон журмын хоорондын давхардал, уялдаагүй байдал бий болсон байна.

Тухайн журмын агуулга нь холбогдох хуулийнхаа 40 дүгээр зүйлийн зорилго, цар хүрээг давж, зарим тохиолдолд шинээр эрх зүйн үндэслэл бий болгосон буюу “соёлын биет өвийг хамгаалах ажилд шинжлэх ухааны шинэ технологи нэвтрүүлсэн”, “гадаад улсаас соёлын дурсгал эргүүлэн авчирсан” гэх зэрэг нөхцөлүүдийг нэмснээр хуулиар олгогдоогүй урамшуулах үндэслэлийг журмаар бий болгожээ. Энэ нь эрх зүйн хэм хэмжээний актын шатлалын зарчим (хууль журмаас дээгүүр байх)-д нийцэхгүй байна.

³⁶ Үндэсний статистикийн хороо, “Соёл, урлагийн салбарын танилцуулга-2019”, 2020.

³⁷ Соёлын яам, “Соёлын өвийн үндэсний төвийн 2021 оны гүйцэтгэлийн тайлан”, <https://ncch.gov.mn/Files/Report/%D0%A1%D3%A8%D2%AE%D0%A2-%D0%93.%D1%82%D0%B0%D0%B9%D0%BB%D0%B0%D0%BD-2021-%D0%BE%D0%BD.pdf?utm>.

³⁸ “Соёлын биет бус өвийн 2024 оны шилдэг өвлөн уламжлагчид шагнал гардууллаа”, 2025.05 сар, <https://eagle.mn/r/90HdFQAqeW3>, (Сүүлд үзсэн: 2025.10.15).

2.3.7. Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн төлбөртэй мэдээлэл авахтай холбоотой зохицуулалтын хэрэгжилт

81.7. Сонгогчид хууль бусаар мөнгө, эд зүйл тараасан болох нь тогтоогдсон бол мэдээлэл гаргасан иргэн тараасан бэлэн мөнгө болон эд барааны үнийн дүнг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг гэм буруутай этгээдээс гаргуулахаар шаардах эрхтэй.

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.7 дахь хэсэгт сонгогчид хууль бусаар мөнгө, эд зүйл тараасан болох нь тогтоогдсон бол мэдээлэл гаргасан иргэн тараасан бэлэн мөнгө болон эд барааны үнийн дүнг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг гэм буруутай этгээдээс гаргуулахаар зохицуулсан. Үүнтэй холбоотой практик нөхцөл байдлыг Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн хүрээнд авч үзье.

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үеэр нийт цагдаагийн байгууллагад 786 гомдол, мэдээлэл бүртгэгдсэн байна. Үүнээс гэмт хэргийн шинжтэй 315, зөрчлийн шинжтэй 471 гомдол, мэдээллийг хүлээн авсан бөгөөд 608 гомдол, мэдээллийг шийдвэрлэж дууссан байна. Одоо ажиллагаанд 178 гомдол, мэдээлэл шалгагдаж байна. Нийт гэмт хэргийн шинжтэй 315 гомдол, мэдээллийг ангилж харвал:

Хүснэгт 5. Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үеэр цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл

№	Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг	Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн тоо
1	10.1 дүгээр зүйлд заасан Хүнийг алах гэмт хэргийн шинжтэй	9
2	11.6 дугаар зүйлд заасан Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах гэмт хэргийн шинжтэй	5
3	13.5, 13.12, 13.14 дүгээр зүйлд заасан Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэргийн шинжтэй	29
4	14.5 дугаар зүйлд заасан Иргэн сонгуулийн эрхээ эдлэх, сонгуулийн хорооны ажилд саад хийх гэмт хэргийн шинжтэй	53
5	14.6 дугаар зүйлд заасан Сонгууль, ард нийтийн санал асуулгад илүү санал өгөх гэмт хэргийн шинжтэй	3
6	14.7 дугаар зүйлд заасан Сонгууль, ард нийтийн санал асуулгад хууль бусаар нөлөөлөх, санал хураалтын дүнг буруу гаргах гэмт хэргийн шинжтэй	3
7	14.8 дугаар зүйлд заасан Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах гэмт хэргийн шинжтэй	209
8	14.9 дүгээр зүйлд заасан Сонгуулийг хууль бусаар явуулах хуйвалдаан зохион байгуулах гэмт хэргийн шинжтэй	2
9	23.2 дугаар зүйлд заасан Хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах гэмт хэргийн шинжтэй	1
10	23.7 дугаар зүйлд заасан Нийтийн албан тушаалтныг заналхийлэх гэмт хэргийн шинжтэй	1

Мөн тухайн үед сонгуулийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн талаар нөхцөл байдлыг Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссоос судалсан ба Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох хууль, хүний эрхийн олон улсын гэрээ конвенцоор баталгаажсан сонгох, сонгогдох эрх зөрчигдсөн талаар УИХ болон Аймаг, нийслэл, сум,


дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үеэр иргэдээс нийт 2,649 гомдол, мэдээллийг төрийн холбогдох байгууллагад гаргасны 1,428 нь УИХ-ын сонгуультай, 1,221 нь орон нутгийн Хурлын сонгуультай холбоотой байна.

Зураг 4. УИХ, орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үеэр иргэдээс гаргасан гомдол, маргааны тоо

№	Нэрс	Монгол Улсын Их Хурлын сонгуультай холбоотой			Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны ээлжит сонгуультай холбоотой		
		Нийт	Үүнээс		Нийт	Үүнээс	
			Шилжүүлсэн	Шийдвэрлэсэн		Шилжүүлсэн	Шийдвэрлэсэн
1	ХЭҮК	3	2	1	2		2
2	СЕХ	85	56	29	35	8	27
3	ЗХДЗШШ	16	11	5			
4	ЗХАШШ	10	8	2			
5	ТЕГ	17	12	5	4	4	
6	ХХЗХ	31	24	7			
7	МЭГ				3	3	
8	УБЕГ	3	3				
9	ЦЕГ	1263	44	88	1177	24	54
	Нийт	1428	160	137	1221	39	83

Эх сурвалж: ХЭҮК, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл, УБ, 2024.

Зураг 5. УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн үеэр иргэдээс гаргасан гомдол, маргааны тоо




Эх сурвалж: ХЭҮК, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл, УБ, 2024.

ЦЕГ УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн үед 1,263 гомдол, мэдээлэл хүлээн авсны 756 нь нийслэлээс, 507 орон нутгаас ирүүлсэн байна. Эдгээрээс гэмт хэргийн шинжтэй 474 гомдол хүлээн авснаас 412 буюу 86 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 29 буюу 6 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 33 буюу 7 хувийг харьяаллын дагуу холбогдох байгууллагад нь шилжүүлсэн байна. Зөрчлийн шинжтэй 789 гомдол, мэдээлэл бүртгэгдсэнээс 663 буюу 84 хувийг нь хүлээн авахаас татгалзсан, 56 буюу 8 хувьд нь зөрчлийн хэрэг нээсэн, 11 буюу 2 хувийг нь холбогдох байгууллагад

харьяаллын дагуу шилжүүлж, 59 буюу 8 хувийг нь хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн байна.

Зураг 6. Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үеэр иргэдээс гаргасан гомдол, маргааны тоо



Эх сурвалж: ХЭҮК, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл, УБ, 2024.

Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуультай холбоотой гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 1,177 гомдол, мэдээлэл бүртгэгдсэн. Үүнээс гэмт хэргийн хэргийн шинжтэй 411 гомдол хүлээн авснаас 375 буюу 91 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 23 буюу 5 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 13 буюу 3 хувийг харьяаллын дагуу шилжүүлсэн байна. Зөрчлийн шинжтэй 766 гомдол, мэдээлэл бүртгэгдсэнээс 701 буюу 91 хувийг нь хүлээн авахаас татгалзаж, 32 буюу 4 хувьд нь зөрчлийн хэрэг нээж, 9 буюу 1 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, хялбаршуулсан журмаар 24 буюу 3 хувийг нь шийдвэрлэсэн байна.

Ийнхүү УИХ болон орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуультай холбоотой 2,649 гомдол, мэдээлэл бүртгэгдсэний 2,440 гомдол, мэдээллийг цагдаагийн байгууллага шалгаснаас 2,151 буюу 88 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 66 буюу 3 хувийг харьяалах байгууллагад шилжүүлж, 83 буюу 4 хувийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэжээ.

Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн агуулгаас харахад 40 хувь нь сонгуулийн үеэр нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэх, ийм агуулга бүхий хэвлэмэл материалыг нийтэд тараах эсвэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчинд тараасан, зөвшөөрснөөс бусад хугацаанд сонгуулийн сурталчилгаа хийсэн, сонгуулийн хорооны ажилд саад хийх, сонгуулийн байранд танхайрсан, хэрүүл маргаан үүсгэсэн, ухуулагчийн эрх чөлөөнд халдсан, мөнгө, эд зүйл тараасан байна. Харин зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 30 хувь сонгуулийн сурталчилгааны хугацаа эхлээгүй болон дууссан үед цахим орчинд сурталчилгаа явуулсан, 20 хувь сонгогчдын саналыг татах зорилгоор мөнгө эд бараа өгөх гэрээ, хэлцэл хийх, амлалт өгсөн, сонгуулийн сурталчилгааны зурагт самбар болон

сурталчилгааны материалыг санаатайгаар устгаж, бохирдуулсан, цоолох, эвдсэн гэх зүйчлэлтэй байна.³⁹

Дээрхээс харвал, Монгол Улсын Их Хурлын сонгуультай холбоотой гомдол, мэдээллийг ихэнх тохиолдолд хэрэг бүртгэлийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн болох нь тогтоогдож байна. Мөн Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.7 дахь хэсэгт сонгогчид хууль бусаар мөнгө, эд зүйл тараасан болох нь тогтоогдсон тохиолдолд мэдээлэлсэн этгээдийг урамшуулсан тухай тоо баримт байхгүй байна. Өөрөөр хэлбэл, мэдээлэгчийг урамшуулахтай холбоотой зохицуулалт нь практикт хэрэгжиж байгаа эсэхийг үнэлэх боломжгүй байна.

2.3.8. Өрсөлдөөний тухай хуулийн төлбөртэй мэдээлэл авахтай холбоотой зохицуулалтын хэрэгжилт

11.4.Энэ хуулийн 11.1, 11.2-т заасан гэрээ, хэлцэл (картель) байгуулсан, шийдвэр гаргасан этгээдийн талаархи бодит мэдээллийг холбогдох нотлох баримтын хамт Монополын эсрэг газарт ирүүлсэн этгээдэд тухайн зөрчилд ногдуулсан торгуулийн мөнгөн дүнгийн таван хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар батална.

Өрсөлдөөний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг болон 11.2 дахь хэсэгт зааснаар дараах гэрээ, хэлцэл байгуулахыг хориглодог:

- бараа бүтээгдэхүүний үнийг хэлцэн тогтоох;
- зах зээлийг нутаг дэвсгэр, үйлдвэрлэл, үйлчилгээ, борлуулалт, барааны нэр, төрөл, худалдан авагчаар хуваарилах;
- бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлт, борлуулалт, ачилт болон тээвэрлэлт, зах зээлд нэвтрэн орох боломж, хөрөнгө оруулалт, техник, технологийн шинэчлэлийг хязгаарлах;
- уралдаант шалгаруулалт, дуудлага худалдаа болон төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа, түүний нэг багц, хэсэгт харилцан хамаарал бүхий этгээдтэй хамт оролцох, эсхүл бусад оролцогчтой өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн гэрээ, хэлцэл байгуулах, эсхүл үнэ, бусад нөхцөл, шалгуурыг урьдчилан тохиролцох.

Түүнчлэн аж ахуй эрхлэгчдийн хооронд байгуулсан дараах гэрээ, хэлцэл (картель) нь нийтийн ашиг сонирхолд харшлах, эсхүл өрсөлдөөнийг хязгаарлах нөхцөлийг бүрдүүлэхээр бол хориглоно:

- эдийн засгийн болон технологийн үндэслэлгүйгээр аж ахуйн харилцаа тогтоохоос татгалзах;
- барааг гуравдагч этгээдэд худалдах, худалдан авахыг хязгаарлах;
- өрсөлдөөнд чухал ач холбогдол бүхий хэлцэл, тохиролцооноос хамсан татгалзах;
- аж ахуйг ашигтай эрхлэх зорилгоор аль нэг байгууллагад гишүүнээр элсэхэд нь өрсөлдөгчид саад учруулах.

Өрсөлдөөний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэгт тухайн гэрээ, хэлцэл (картель) байгуулсан, шийдвэр гаргасан этгээдийн талаархи бодит мэдээллийг холбогдох нотлох баримтын хамт Монополын эсрэг газарт ирүүлсэн этгээдэд тухайн

³⁹ Хүний Эрхийн Үндэсний Комисс, *Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл*, (Улаанбаатар: 2024), 86-96 дахь тал.

зөрчилд ногдуулсан торгуулийн мөнгөн дүнгийн таван хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар батална.

Үүний дагуу Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 119 дүгээр тогтоолын хавсралтаар “Өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн гэрээ, хэлцэл (картель) байгуулсан, шийдвэр гаргасан этгээдийн талаар мэдээлэл ирүүлэгчид мөнгөн урамшуулал олгох журам” батлагджээ. Тус журам болон Өрсөлдөөний тухай хуулийн холбогдох зохицуулалтын хэрэгжилт нь дараах нөхцөл байдалтай байна.

Нэгдүгээрт, Өрсөлдөөний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэгт зааснаар мэдээлэгчид мөнгөн урамшуулал олгосон тохиолдол одоогийн байдлаар тогтоогдоогүй байна⁴⁰. Өөрөөр хэлбэл, Монгол Улсад “Өрсөлдөөний тухай хуулийн 11.4”-ийн дагуу мэдээлэгчдэд мөнгөн урамшуулал бодитоор олгосон тухай ил тод, баримт нотолгоотой жишээ одоогоор нийтэд мэдээлэгдээгүй байна. Энэ нь хууль хэрэгжих боломжгүй гэсэн үг биш, харин мэдээлэгчийн хамгаалалт, нууцлалын түвшин өндөр, шалгуур хэт нарийн, мөн ил тод байдлын бодлого сул байгаатай холбоотой гэж үзэх үндэстэй юм. Ирээдүйд өрсөлдөөний хууль тогтоомжийн хэрэгжилт, ил тод байдал, мэдээлэгчийн эрх зүйн баталгааг сайжруулснаар энэхүү заалт бодит амьдралд илүү өргөн хүрээнд хэрэгжих боломжтой.

Хоёрдугаарт, урамшуулал олгох үндэслэл “торгууль ногдуулж, торгууль төлөгдсөний дараа” гэж журамд заасан тул процесс урт, төвөгтэй байдгаас гадна мэдээлэгчийн мэдээлэл анхдагч, баталгаатай байх ёстой гэх хатуу шаардлага (журмын 3.2-т заасан) тавигдсан нь урамшууллыг хүртэх боломжийг хязгаарлаж байна.

III. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Судалгааны ажлын өмнөх бүлэгт мэдээлэгч болон шүгэл үлээгчийн ялгаа, шүгэл үлээх тогтолцооны ач холбогдол, улс орнуудын шүгэл үлээгчийг хамгаалах тогтолцооны онцлог, ялгаа, Монгол Улс дахь мэдээлэгчийг урамшуулахтай холбоотой зохицуулалтын хэрэгжилтийг авч үзлээ. Энэ хүрээнд шүгэл үлээгч, мэдээлэгчийн эрх зүйн байдлын тодорхой болгох; гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлэл өгөх, байгууллагын дотроос шүгэл үлээх асуудлыг ялгамжтай зохицуулах; мэдээллийг хүлээн авах суваг, хянан шалгах байгууллагыг бий болгох, шүгэл үлээгч, мэдээлэгчийг хамгаалах арга хэмжээг хуульчлах зэрэг асуудлыг шийдвэрлэх шаардлагатай болох нь харагдаж байна.

Ингэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас гаргасан бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийцсэн шийдэл буюу асуудлыг шийдвэрлэх зорилгыг тодорхойлох нь чухал юм. Түүнчлэн энэхүү судалгааны удиртгал хэсэгт дурдсанчлан, авлигын хэрэгтэй холбоотойгоор мэдээллийг холбогдох байгууллагад хүргүүлсэн этгээдийг шүгэл үлээгч хэмээн тодорхойлж, Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслөөр гагцхүү шүгэл үлээгч гэх нэрлэсэн авлигын хэргийн мэдээлэгчийг хамгаалах нь дээр дурдсан асуудалд шийдэл болж чадах эсэхэд дүн шинжилгээ хийх шаардлагатай. Иймд тулгамдаж байгаа асуудал болгонд шийдэл болохуйц зорилгыг дэс дараатай тодорхойлохыг оролдлоо. Үүнд:

- (i) *Мэдээлэгчийг яллах, эрүүгийн хариуцлагад татах, дарамтлахаас хамгаалах*

⁴⁰ Монополийн эсрэг газрын цахим хуудас, <https://www.gov.mn/mn/organization/AMA>.

Нэгдсэн Үндэстний байгууллагын Ерөнхий Ассамблейн 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 58/4 тоот тогтоолоор баталсан Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцид Монгол Улс 2005 онд нэгдэн орсон. Уг конвенцийн **“Мэдээлэгч этгээдийг хамгаалах”** гэх 33 дугаар зүйлд “Оролцогч улс бүр энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргийн талаархи аливаа баримт нотолгоог сайн санааны үүднээс, үндэслэлтэйгээр эрх бүхий байгууллагад мэдээлж буй аливаа этгээдийг аливаа шударга бус хандлагаас хамгаалахаар заах талаархи зохих арга хэмжээг өөрийн дотоодын эрх зүйн тогтолцоонд нэвтрүүлэн оруулах асуудлыг авч үзнэ.” гэжээ.

2019 оны Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 35 дугаар зүйлд гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээллийг иргэдээс төлбөртэй авах талаар зохицуулсан бөгөөд шаардлагатай тохиолдолд мэдээлэгчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг гэмт хэрэг, зөрчлийн хэрэг бүртгэл, мөрдөн шалгах эрх бүхий байгууллага, албан тушаалтан авах үүргийг хуульчилсан. Үүнээс харвал, авлигын гэмт хэрэг талаар мэдээлэл өгсөн этгээдийг хамгаалах үүргийг Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн бол хууль тогтоомжид дан ганц авлигын бус бусад төрлийн гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлсэн хүнийг хамгаалах зохицуулалт орсон байна.

Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 1.6.45-т “...төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг шүүмжилсэн, мэдээлсэн, илчилсэн тохиолдолд яллах, эрүүгийн хариуцлагад татах, дарамтлахаас мэдээлэгчийг хамгаалах...” гэж Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийг боловсруулахдаа анхаарах чиглэлийг УИХ-аас өгсөн байна.

Хууль зүйн доктор, судлаач П.Батбаатар өөрийн бүтээлдээ шүгэл үлээгчийг цагдаагийн байгууллагад гэмт хэргийн тухай мэдээлэгчээс ялгах шаардлагатай талаар дурдсан байдаг. Гэмт хэргийн талаар мэдээлэгч нь гэмт хэргийг хамтран үйлдэгч эсхүл хуулийн байгууллагатай хамтран ажиллах этгээдээр тогтоосон зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн гишүүн, нууц ажилтан ч байх боломжтой байна.

Олон улсын төвшинд мэдээлэгчийг шүгэл үлээгчтэй харьцуулахад бага эрсдэл хүлээж, гэмт хэргийн талаар мэдээлдэг гэж үздэг байна. Энэ утгаараа зарим улсад мэдээлэгчийг тухайлан хамгаалах талаар заагаагүй байх тохиолдол ч бий. Гэвч Монгол Улсын хувьд Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд мэдээлэгчийг шаардлагатай тохиолдолд хамгаалах үүргийг хуульчилсан тул түүнийг хамгаалалтгүйгээр орхих боломжгүй юм.

Манай улсын салбарын хэд хэдэн хууль тогтоомжид гэмт хэрэг, зөрчил болон хууль бус үйлдлийн талаар мэдээлэл өгсөн этгээдэд урамшуулал олгох, мэдээллийг төлбөртэй авах талаар заасан хэдий ч хэрэгжилт нь хангалтгүй, журам нь холбогдох хуультайгаа зөрчилдсөн, уялдаагүй байдал илэрсэн билээ. Мэдээлэгчийг урамшуулах нөхцөл нь янз бүр, урамшууллын хэмжээ ялгамжтай, мэдээлэгчийг хамгаалах эрх зүйн баталгаа байхгүй нөхцөлд мэдээлэл гаргахад төвөгтэй байдал бий болж байна. Түүнчлэн мэдээллийг хүлээн авах, хянан шалгах байгууллага тодорхойгүй, мэдээлэл өгөх боломжтой талаар мэдээ, мэдээллийг олон нийтэд нээлттэй тавих, хууль тогтоомжийг сурталчлан таниулах ажил хомс байгаагаас үүдэн дээрх зохицуулалтын хэрэгжилт сул байх нөхцөл бүрдэж байгааг онцлох нь зүйтэй.

Иймд хуулиар мэдээлэгчийг хамгаалах үндэслэлийг төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн байгууллагын үйл ажиллагааг шүүмжилсэн, мэдээлсэн, илчилсэн тохиолдолд, тэр тусмаа авлигын гэмт хэргийн талаар мэдээлсэн тохиолдолд аливаа хэлбэрээр дарамтлах, яллах, эрүүгийн хариуцлагад татахаас хамгаалах шаардлагатай байна. Ийнхүү хуульд тусгахдаа мэдээлэгчийг хамгаалах шаардлагатай тохиолдлыг

шүгэл үлээгчийг хамгаалах нөхцөлөөс ялгамжтай байдлаар тогтоохыг зорих нь ач холбогдолтой юм.

(ii) Шүгэл үлээгчийг аливаа өш хонзон, гэмт хэргийн хохирогч болохоос хамгаалах

Шүгэл үлээгч гэдэг байгууллага доторх хууль бус ажиллагааг илчилж байгаа ажилтныг ойлгодог талаар судалгааны өмнөх хэсэгт дурдсан билээ. Дэлхийн улс орнууд шүгэл үлээгч гэдэгт нэг бол нийтийн албан тушаалтан эсхүл төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын албан хаагч байхаар зохицуулсан байдаг бөгөөд үүнийг тухайн улсын бодлого, хууль тогтоомжийн онцлогтой уялдуулан тайлбарлах боломжтой. Харин манай улсын хувьд шүгэл үлээгчийн талаар нэгдсэн нэг ойлголтод хүрээгүй тул төрийн бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны хөтөлбөр зэргийг үндэслэн хувилбар дэвшүүлье.

Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 06 сарын 30-ны өдөр баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2023-2030”-ийн Зорилт 4.1.3-т “Компанийн ёс зүйн дүрэм, журамд дотоод шүгэл үлээгчийг дэмжих, хамгаалах, урамшуулах зохицуулалтыг тусгах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлийг үл тэвчих, шүгэл үлээх соёлыг төлөвшүүлнэ” гэж, Зорилт 5.1.8-д “Хулгайлагдсан хөрөнгийг илрүүлэх, цахим орчинд шинжилгээ хийх, санхүүгийн мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулах, гэрч, хохирогч, шүгэл үлээгч, мэдээлэгчийг хамгаалах болон аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий нэгжийг байгуулна” гэж, Зорилт 6.4.3-т “Шүгэл үлээгчийг хамгаалах эрх зүйн орчныг бий болгох замаар шүгэл үлээх соёлыг төлөвшүүлнэ” гэж, Зорилт 9.5.2-т “Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар олон нийтэд сурталчилна” гэж, Зорилт 10.1.2-т “Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагад шүгэл үлээгчийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлнэ” гэж тус тус заасан.

Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.1.3-т “Авлигатай тэмцэх 5Ш ажиллагааг үргэлжлүүлж, авлига, ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх тогтолцоог хялбаршуулах, энэ төрлийн гэмт хэргийн эсрэг шүгэл үлээгчийг хамгаалах, дэмжих хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ” гэж заасан байна. Ийнхүү манай улсын хувьд шүгэл үлээгчийг байгууллагын дотроос авлигын хэрэг дээр шүгэл үлээх этгээд хэмээн тодорхойлж болох нэг хувилбар байна.

Энэ тохиолдолд шүгэл үлээгч нь нийтийн албанд ажиллаж байгаа этгээдийг ойлгох бөгөөд Авлигын эсрэг хуулийн 4.1-д заасан албан тушаалтны үйлдсэн гэмт хэргийн талаар үндэслэл бүхий мэдээллийг Авлигатай тэмцэх газар хүргүүлэх боломжтой юм. Нийтийн албан хаагчийг аливаа дарамт, гэмт хэрэгт яллахаас хамгаалах шаардлагатай бөгөөд энэ хүрээнд хуулийн төслийг боловсруулахад гаднаас мэдээлэл гаргасан этгээдийг мэдээлэгч гэх ойлголтын хүрээнд авч үзэх боломжтой.

Нөгөө нэг хувилбар нь шүгэл үлээгч гэдгийг илүү өргөн хүрээнд нийтийн албан хаагч болон хувийн хэвшлийн компани, холбоо, сан зэргийн ажилтан гэж үзэх нөхцөл юм. Энэ тохиолдолд авлигын хэрэгт холбогдох боломжтой албан тушаалтанд авлига өгсөн хувийн байгууллага, албан тушаалтны талаар мэдээлэлтэй байгаа ажилтан ч шүгэл үлээх боломж бүрдэнэ. Мөн дээрээс нь төрийн бус байгууллагад давуу байдал бий болгосон гэх нийтийн албан тушаалтны талаар мэдээлэлтэй төрийн бус байгууллагын гишүүн ч шүгэл үлээх давуу талтай юм.

Өөрөөр хэлбэл, авлигын гэмт хэргийн нэг талд хэдийгээр нийтийн албан тушаалтан гарцаагүй байдаг хэдий ч нөгөө тал нь хэн ч байх боломжтой. Тэдгээр

байгууллагын дотроос шүгэл үлээх боломжийг нээж өгснөөр тухайн төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд илүү нэмэртэй байхыг үгүйсгэхгүй. Мөн авлигын гэмт хэргээр л мэдээллийн цар хүрээг хязгаарлах нь шүгэл үлээх гэдэг ойлголтын цаад мөн чанарыг хязгаарлах эрсдэлтэй гэж харж байна.

Тодруулбал, шүгэл үлээнэ гэдэг дан ганц авлигын гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор л гарч ирсэн ойлголт биш бөгөөд нийтийн ашиг сонирхлын төлөө гэх өргөн агуулгатай зорилго оршиж байдаг. Ийнхүү нийтийн албанд ажиллаж этгээд, хувийн хэвшлийн ажилтан аль аль нь нийтийн ашиг сонирхлын төлөө хууль бус үйлдлийг хүлцэн тэвчихгүйгээр тэмцэх эрхтэй байх нь зүйтэй. Энэ эрхээ эдлэхийн тулд бүгд ялгаагүй хуулиар хамгаалагдаж, дарамтад орох, ажлаас халагдах зэргээс айхгүйгээр илчлэх зоригтой болох шаардлагатай юм.

Иймд Монгол Улсад мэдээлэгч, шүгэл үлээгчийг хамгаалахын тулд мэдээлэгчийг шүгэл үлээгчээс тусад нь тодорхойлох, хамгаалах нөхцөлийг ялгамжтай тогтоох шаардлагатай байна. Ингэхдээ шүгэл үлээгч гэдгийг нийтийн албанд ажиллаж байгаа албан хаагч гэж явцуу тодорхойлох, эсхүл бүх салбарт ажиллаж буй ажилтан гэх өргөн утгаар тодорхойлох боломжтой юм. Гэвч түүнийг өргөн хүрээнд тодорхойлох нь авлигын гэмт хэрэг, бусад гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэхэд илүү нэмэртэй болохыг онцлох нь зүйтэй.

(iii) Монгол Улсын хууль тогтоомж дахь мэдээлэгчийг урамшуулах зохицуулалтыг сайжруулах, уялдуулах

Авлигын тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Цагдаагийн албаны тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Амьтны тухай, Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай, Соёлын өвийг хамгаалах тухай, Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай болон Өрсөлдөөний тухай хуульд мэдээлэгчээс төлбөртэй мэдээлэл авах талаар зохицуулсан бөгөөд эдгээр хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийсэн билээ.

Эдгээр хуулиудыг дагалдан гарсан журмууд холбогдох хуультайгаа нийцэхгүй байгаа асуудал тулгамдаж байна. Түүнчлэн мэдээлэгчийн эрх зүйн байдал, түүнийг хэн, хэрхэн, яаж хамгаалах талаар зохицуулалт байхгүй нь практикт бүрэн хэрэгжих боломжийг хязгаарлаж байгаа юм. Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслөөр шүгэл үлээгч, мэдээлэгчийг зохицуулахдаа салбарын хуульд байгаа урамшууллын зохицуулалтыг нэгтгэх, эсхүл нэгтгэхгүйгээр уялдуулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

IV. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Мэдээлэгчийг яллах, эрүүгийн хариуцлага хүлээлгэх, дарамтлахаас хамгаалах, шүгэл үлээгчийг аливаа өш хонзон, гэмт хэргийн хохирогч болохоос хамгаалах, Монгол Улсын хууль тогтоомж дахь мэдээлэгчийг урамшуулах зохицуулалтыг сайжруулах, уялдуулах зорилгод хүрэхийн тулд ямар арга хэмжээ авах хувилбарыг доор хүснэгтээр харууллаа. Ингэхдээ хувилбаруудын эерэг болон сөрөг талыг харьцуулж, дүн шинжилгээ хийсэн болно.

Хүснэгт 6. Асуудлыг зохицуулж болох хувилбаруудын эерэг болон сөрөг тал

Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1. Тэг хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах	Гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлэл төлбөртэй авдаг өнөөгийн нөхцөл байдалд өөрчлөлт гарахгүй. Өдгөө тулгамдаж буй асуудлууд хэвээр үргэлжилнэ.	Нэмэлт зардал гарахгүй бөгөөд одоогийн зохицуулалтын уялдаагүй байдлаас үүдэн мэдээлэгчийг ялгамжтай мөнгөн дүнгээр урамшуулах эрсдэлтэй байна.	Үр дүн гарахгүй
2. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Хэдий хууль тогтоомж төгс байж болох нь түүний хэрэгжилт сул байх нэг хүчин зүйл нь иргэдийн мэдээ, мэдээлэлгүй байдал байдаг. Ялангуяа шүгэл үлээгч, мэдээлэгчийг идэвхжүүлэх нь олон нийтийн болон иргэдийн оролцооноос шууд хамааралтай учраас эрх зүйн орчин бүрдүүлсний үндсэн дээр тэр талаар сургалт, мэдээлэл орох, олон нийтэд энэхүү шинэлэг тогтолцоог сурталчлан таниулах нь асуудлыг шийдвэрлэхэд чухал байна. Дангаараа бол шийдэл болоход учир дутагдалтай байна.	Зардал тодорхой хэмжээгээр шаардагдах хэдий ч тулгамдаж буй асуудлуудыг бүрэн шийдэх боломжгүй байдалд хүрнэ.	Хүссэн үр дүнд хүрэхгүй
3. Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлэл өгч байгаа иргэнийг урамшуулах тогтолцоог санхүүжүүлснээр эерэг үр дүн гарч болох ч тэдгээрийг хамгаалах механизм байхгүй нь эргээд хэрэгжилт сул байх нөхцөлийг бүрдүүлнэ.	Төрөөс тодорхой хэмжээний зардал гарах хэдий ч үр өгөөж хязгаарлагдмал байна.	Тодорхой үр дүнд хүрэх боломжтой
4. Төрөөс санхүүгийн интервенц хийх	Асуудал нь авлигын болон бусад төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, түүний эсрэг шүгэл үлээх, мэдээлэл гаргахтай холбоотой тул	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнд хүрэх боломжгүй

		энэ хувилбарыг хэрэгжүүлэх боломжгүй болно.		
5.	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Асуудал нь авлигын болон бусад төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, түүний эсрэг шүгэл үлээх, мэдээлэл гаргахтай холбоотой тул энэ хувилбарыг хэрэгжүүлэх боломжгүй болно.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнд хүрэх боломжгүй
6.	Захиргааны шийдвэр гаргах	Захиргааны шийдвэр гаргах буюу захиргааны хэм хэмжээний акт буюу журам, дүрмээр авлигын болон бусад гэмт хэргийн эсрэг шүгэл үлээсэн, мэдээлэл гаргасан этгээдийг мэдээллийг хянан шалгах, тэдгээрийг хамгаалах боломжгүй юм. Түүнчлэн захиргааны хэм хэмжээний акт нь хуульд заасан үндэслэлээр гардаг тул хууль нь байхгүй нөхцөлд энэ аргыг хэрэглэх боломжгүй байна.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй
7.	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Асуудлыг шийдвэрлэх боломжтой бөгөөд ийнхүү эрх зүйн орчныг боловсронгуй болгохдоо өнөөгийн эрх зүйн зохицуулалт хоорондын уялдаа холбоог сайжруулах, Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай анхдагч хуулийн төслийг боловсруулж, мэдээлэгч болон шүгэл үлээгчийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна.	Мэдээлэгч, шүгэл үлээгчийг хамгаалах байгууллага, мэдээллийг хянан шалгах нэгж, байгууллага, тэдгээрийг урамшуулах зэргээр зардал гарах хэдий ч нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээх, гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлэл гаргаснаар одоогийн нөхцөл байдлыг сайжруулах боломжтой болно.	Тодорхой үр дүнд хүрэх боломжтой

Дээрхээс харвал, дээр дурдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд шүгэл үлээгч, мэдээлэгчтэй холбоотой харилцааг зохицуулсан эрх зүйн орчин бүрдүүлэх шаардлагатай байна. Тухайн хуулийн төслийг боловсруулахдаа өөрийн орны онцлогт

тохирсон эрх зүйн зохицуулалтыг бий болгох нь чухал бөгөөд үүний дараа олон нийтэд сурталчлах, таниулах зэргээр хэд хэдэн шаттай арга хэмжээг цогцоор нь авснаар л практикт ямар үр дүн гарахыг үнэлэх боломжтой болно.

V. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

5.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл нь гэмт хэрэг, зөрчлийн улмаас зөрчигдөх иргэний эрхийг мэдээлэгчийн тусламжтай хамгаалах, нийтийн ашиг сонирхлыг шүгэл үлээгчийн тусламжтайгаар хамгаалах боломжийг бүрдүүлэх боломжтой. Гагцхүү энэхүү хүний эрхэд үзүүлэх үр нөлөөний цар хүрээ нь хуулийн төслийн цар хүрээнээс шууд хамааралтай байх буюу гагцхүү авлигын гэмт хэргийн талаар мэдээлэл өгсөн хүнийг шүгэл үлээгч гэж тодорхойлбол хүний эрхэд үзүүлэх үр нөлөө нь хумигдах юм.

Монгол Улсын иргэний үндсэн эрхийг шүгэл үлээгч, мэдээлэгч нь шууд хамгаалах субъект биш хэдий ч тэдний эрхийг зөрчигдөж байгаа үйлдлийн талаар холбогдох байгууллагад мэдэгдэж, ирээдүйд дахин зөрчигдөх эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд хувь нэмэр оруулахаар байна. Нөгөө талаараа иргэн, ажилтны оролцоотойгоор хууль бус үйлдэлтэй тэмцэх нь ардчиллын үндсэн зарчмыг бэхжүүлэхэд үнэтэй хувь нэмэр болох юм.

5.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Авлига, албан тушаалын гэмт хэргийн улмаас төр, иргэнд учирч байгаа хохирол, бусад төрлийн гэмт хэргийн улмаас нийтийн ашиг сонирхол, байгаль орчин зэрэгт учирч байгаа хохирлын хэмжээ асар их. Шүгэл үлээгч, мэдээлэгчийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор тэдний эрх зүйн байдлыг хуульд тодорхой болгосноор энэхүү их хохирлын хэмжээг багасгах боломж бүрдэнэ.

Түүнчлэн мэдээлэгч, шүгэл үлээгчийг урамшуулах, тэднийг хамгаалах үйл ажиллагаанд тодорхой хэмжээний зардал гарах нь ойлгомжтой. Харин түүнийхээ хариуд эдийн засагт үзүүлэх үр нөлөө нь зардлаасаа илүү байх нь мөн тодорхой юм. Иймд эдийн засагт тодорхой хэмжээний эерэг үр дүн урт хугацаандаа авчрахаар байна.

5.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл нь нийгэмд хамгийн их үр нөлөө үзүүлэх юм. Тодруулбал, нийтийн эрх ашиг зөрчигдөж байгаа үйлдлийг мэдээлэх, илчлэх нь түүнийг таслан зогсооход нэмэртэй бөгөөд нийгмийн сайн сайхны төлөө шүгэл үлээсэн этгээд нийгмийн төлөө гэсэн сэтгэлээр л тухайн үйлдлийг хийдэг. Иймд тухайн этгээдийг аливаа дарамт, хүчирхийлэл, шударга бус байдлаас хамгаалах нь шүгэл үлээх ажилтан, албан хаагчдын тоог нэмэгдүүлж, нийгэмд эерэг үр дүн бий болгох юм.

5.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Хуулийн төслөөр ганц авлигын гэмт хэргийн эсрэг шүгэл этгээдийг зохицуулсан тохиолдолд байгаль орчинд ямар нэг нөлөө үзүүлэхгүй. Харин байгаль орчны хууль тогтоомжид төлбөртэй мэдээлэл авахтай холбоотой зохицуулалтыг сайжруулж, байгаль

орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлэл гаргаж байгаа этгээдийг хамгаалах тогтолцоог хуулийн төслөөр бүрдүүлсэн тохиолдолд байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд хувь нэмэр оруулах болно.

5.5. Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэж байгаа эсэх

НҮБ-ын Авлигын эсрэг конвенцид зааснаар Монгол Улс авлигын гэмт хэргийн эсрэг мэдээлэл гаргасан этгээдийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх үүрэгтэй байна. Тус үүргээ биелүүлэх нэг боломж нь Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулиар мэдээлэгчийг хамгаалах явдал юм.

VI. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Судалгааны ажлын энэхүү бүлэгт гадны хэд хэдэн улс орны шүгэл үлээгч, мэдээлэгчийг зохицуулсан туршлагыг судлах бөгөөд авлигын гэмт хэргийн талаар мэдээлэл гаргасан, шүгэл үлээсэн этгээдийг хэрхэн хамгаалдаг талаар тодруулахыг зорилоо. Харьцуулсан судалгааны хүрээнд хамгийн эхэнд Шүгэл үлээгчийн тухай хуультай болж байсан АНУ, манай улсын хоёр хөрш болох БНХАУ, ОХУ, эх газрын эрх зүйн бүлийн орны төлөөлөл болох ХБНГУ, өөрийн орны онцлогт тохируулан нутагшуулсан Сингапур, Япон, БНСУ-ыг сонгон судлах болно.

6.1. Америкийн Нэгдсэн Улс

1978 оны “Төрийн албаны шинэчлэлийн тухай хууль” (Civil Service Reform Act)-д тусгагдсан шүгэл үлээгчтэй холбоотой зохицуулалт нь холбооны албан хаагчдыг хамгаалах анхны хууль зүйн үндэс болсон гэж үздэг. Холбооны засгийн газар болон ихэнх муж улсууд шүгэл үлээх үйлдлийг хууль ёсны гэж үздэггүй байсан бөгөөд тухайн үед шүгэл үлээгчийг хамгаалах баталгаа нь АНУ-ын Үндсэн хуулийн Нэгдүгээр нэмэлт өөрчлөлтийн (First Amendment) хүрээнд эргэлзээтэй байдлаар хэрэглэгдэж байсан юм. Харин 20 жилийн дараа, олон муж, улсын хууль тогтоомжид шүгэл үлээгчийг хамгаалах заалтууд тусгагдаж, эрх зүйн зохицуулалтын хүрээ өргөжсөн байдаг. Эдгээр хууль тогтоомжийн ихэнх нь тодорхой салбарт чиглэсэн зохицуулалттай бөгөөд үүнд дараах асуудлууд орно:

- эрүүл мэндийн үйлчилгээний байгууллага дахь зөрчил;
- хүүхэд болон өндөр настны эсрэг хүчирхийлэл;
- асрамж болон үрчлэлттэй холбоотой гэр бүлийн орчин дахь зөрчил;
- авто тээврийн хэрэгсэлд утааны хяналт;
- ажилтны нөхөн олговор;
- олон нийтийн үйлчилгээний байгууллага (public utilities) гэх мэт⁴¹.

Ийнхүү эрх зүйн хөгжил нь шүгэл үлээгчийг хамгаалахыг хууль ёсны хүрээнд хүлээн зөвшөөрч, АНУ нь 1989 онд Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хууль (Whistleblower Protection Act, WPA)-ийг баталсан.

АНУ нь авлигын гэмт хэрэгт шүгэл үлээх асуудлыг дээр дурдсан хууль болон Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуулийн нэмэлт (Whistleblower Protection Enhancement

⁴¹ Robert G. Vaughn, “State whistleblower statutes and the future of whistleblower protection”, (Published by: American Bar Association), Administrative Law Review, Vol. 51, No. 2 (Spring 1999), pp. 581-625, <http://www.jstor.org/stable/40709997>.

Act of 2012), Худал нэхэмжлэл гаргахыг хориглох тухай хууль (False Claims Act, FCA), Сарбэнс-Окслигийн хууль (Sarbanes–Oxley Act SOX, 2002), “Додд-Франк санхүүгийн шинэчлэл, хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль (Dodd-Frank Act, 2010), “Гадаад авлигын эсрэг, төлбөр ба үйл ажиллагааны дүрмийн тухай хууль (Foreign Corrupt Practices Act, FCPA, 1977) болон муж тус бүрийн өөрсдийнхөө хуулиудаар тус тус зохицуулж байна.

Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хууль 1989 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан бөгөөд нийтийн албанд ажиллаж буй албан хаагчид авлига, залилан болон бусад хууль бус үйлдлийн талаар шүгэл үлээж мэдээлэл гаргасан тохиолдолд тэднийг хамгаалах зорилготой юм. Уг хуулийн 2012 онд нэмэлт, өөрчлөлтөөр баяжуулж хамгаалалтын хүрээг өргөтгөсөн байдаг. Ийнхүү зөвхөн одоо ажиллаж буй нийтийн албан хаагчид бус, хуучин ажиллаж байсан болон шинээр ажилд орсон албан хаагч, ажилд орохоор өргөдлөө гаргасан иргэдийн шүгэл үлээх асуудлыг хамардаг⁴² болсон. Хуулийн хамгаалалтад орохын тулд тодорхой нөхцөлийг хангадаг байна. Үүнд:

- тухайн ажилтныг хамгаалах талаар хуульд заасан байх;
- задруулахыг хуулиар зөвшөөрсөн мэдээллийг илчилсэн байх;
- мэдээллийг илчилсэнтэй холбоотойгоор тухайн этгээдийн албан тушаалын байдлыг дордуулсан⁴³ байх зэрэг нөхцөлүүд хамаарна.

Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуулиар хамгаалахаар заасан этгээдэд нь албан тушаалтны хууль тогтоомж зөрчсөн, эсхүл буруу менежмент, хөрөнгийг их хэмжээгээр үрсэн, эрх мэдлээ урвуулан ашигласан, эсхүл нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдалд ноцтой аюул учруулж байна гэх үндэслэлтэй гэж үзвэл шүгэл үлээнэ. Шүгэл үлээгчийн удирдах албан тушаалтан нь эрх зүйн үндэслэлгүйгээр шүгэл үлээгчид дараах арга хэмжээг авахыг хориглодог. Үүнд:

- албан тушаалд томилох;
- албан тушаал дээшлүүлэх;
- өөр албан тушаалд шилжүүлэх;
- сахилгын шийтгэл хүлээлгэх;
- цалин, хөлс нэмэх;
- шагнал болон сургалтад суулгах тухай шийдвэр;
- сэтгэцийн шинжилгээ хийлгэх тухай шийдвэр гаргах;
- байгууллагын аливаа мэдээллийг задруулахгүй байх шийдвэр гаргах;
- тэтгэмж олгох;
- албан үүргээс үндэслэлгүйгээр чөлөөлөх;
- албан үүргээс нь түдгэлзүүлэх;
- хөдөлмөрийн нөхцөлд нь мэдэгдэхүйц өөрчлөлт оруулах болон бусад арга хэмжээ авах зэрэг үйлдлүүд хамаарна⁴⁴.

Дээрх арга хэмжээг авсан бол шүгэл үлээгч Тусгай зөвлөхийн алба (Office of Special Counsel, OSC)-нд ханддаг. Уг байгууллага нь албан тушаалтны хориглосон арга хэмжээ авсан тухай гомдлыг хүлээн авч, хянан шалгадаг гол байгууллага билээ. Шүгэл

⁴² Georgios Kontogeorgis, “Whistleblowers and their role in the Fight against corruption. Problems in protecting Whistleblowers and Suggestions for improvement”, *International Multilingual Journal of Science and Technology*, Vol. 10 Issue 2, (February 2025), <https://www.imjst.org/wp-content/uploads/2025/03/IMJSTP29121138.pdf>.

⁴³ Balser, Jimmy, “The Whistleblower Protection Act (WPA): A Legal Overview”, (Publication Date: 12/30/2024), <https://www.congress.gov/crs-product/R48318>.

⁴⁴ Balser, Jimmy, “The Whistleblower Protection Act (WPA): A Legal Overview”, (Publication Date: 12/30/2024), <https://www.congress.gov/crs-product/R48318>.

үлээгч гомдлоо “OSC Complaint Form OSC-11” нэртэй маягт⁴⁵-ыг цахимаар бөглөж, эсхүл маягтыг татан авч бөлгөн шуудангаар илгээх хэлбэрээс сонгон гаргадаг. Тусгай зөвлөхийн алба гомдлыг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хүлээн авснаа шүгэл үлээгчид бичгээр мэдэгдэх үүрэгтэй⁴⁶. Тийнхүү гомдлыг 240 хоногийн дотор судлан, мөрдөн шалгах ажиллагааг явуулна. Хэрэв дахин хугацаа сунгах шаардлагатай гэж үзвэл, шүгэл үлээгчийн зөвшөөрлийн үндсэн дээр хугацааг сунгана⁴⁷.

Хяналт шалгалтын үр дүнд албан тушаалтан хориглосон арга хэмжээ авсан тухай нотлох баримт олдсон тохиолдолд шалгалтын тайланг Мерит тогтолцоог хамгаалах зөвлөл (Merit Systems Protection Board, MSPB or the Board)-д илгээнэ. Тухайн хориглосон арга хэмжээ авсан албан тушаалтан уг зөрчлөө засахгүй бол Тусгай зөвлөхийн алба засуулах арга хэмжээг албадан авхуулахаар Мерит тогтолцоог хамгаалах зөвлөлд хүсэлт гаргадаг. Хүсэлтийг биелүүлээгүй тохиолдолд тухайн хориглосон арга хэмжээг авсан удирдах албан тушаалтанд сахилгын шийтгэл⁴⁸ ногдуулдаг байна. Засуулах арга хэмжээ гэдэг нь тухайн ажилтныг байсан ажилд нь эргүүлэн томилох, боломжгүй бол төсөөтэй ажилд томилох, эмнэлгийн болон өмгөөлөгчөөс туслалцаа авсан бол зардлыг нь нөхөн төлөх, урьдчилан таамаглаж болохуйц хохирлыг нөхөн төлөх зэрэг багтана⁴⁹.

Харин Тусгай зөвлөхийн алба нь ажилтанд хориглосон арга хэмжээ авсан үйлдлийг илрүүлж чадаагүй, хяналт шалгалтын үр дүнг ажилтанд 240 хоногийн хугацаанд нь мэдээлээгүй гэж үзвэл ажилтан Мерит тогтолцоог хамгаалах зөвлөлд давж заалдах гомдол гаргах эрхтэй. Түүнчлэн Мерит тогтолцоог хамгаалах зөвлөлийн шийдвэрийг гомдол гаргасан ажилтан үндэслэлгүй гэж үзвэл Холбооны дээд шүүхэд гомдол гаргах⁵⁰ боломжтой байна.

Үүнээс харахад, Шүгэл үлээгчийг хамгаалах хуулийн дагуу зөвхөн гүйцэтгэх эрх мэдлийн харьяа байгууллагын алба хаагч шүгэл үлээх боломжтой бөгөөд шүгэл үлээгчийн гомдолдоо дурдсан этгээд нь мөн гүйцэтгэх эрх мэдлийн харьяа байгууллагын албан хаагч байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, хувь хүн, энгийн иргэн Тусгай зөвлөхийн албанд албан тушаалтны хууль бус үйлдлийн талаар гомдол гарган шийдвэрлүүлэх эрхгүй байна.

Хувийн эрх зүйн салбан дахь ажилтан, хуулийн этгээдийн дотоод авлигын талаар шүгэл үлээх асуудлыг зохицуулахад, Худал нэхэмжлэл гаргахыг хориглох тухай хууль⁵¹ (False Claims Act, FCA), Сарбэнс-Окслигийн хууль (Sarbanes-Oxley Act SOX, 2002), Додд-Франк санхүүгийн шинэчлэл, хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль⁵² (Dodd-Frank Act, 2010) зэрэг эрх зүйн хэм хэмжээнүүд голлох байр суурийг эзэлдэг. Додд-Франк санхүүгийн шинэчлэл, хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль нь шүгэл үлээгчийн

⁴⁵ U.S. Office of Special Counsel, “Prohibited Personnel Practices Overview”, <https://osc.gov/Services/Pages/PPP.aspx>.

⁴⁶ United States Code, art. 1214, <https://www.law.cornell.edu/uscode/text/5/1214>.

⁴⁷ *Ibid*.

⁴⁸ Албан тушаалаас нь огцруулах, зэрэглэл бууруулах, таван жилээс илүүгүй хугацаагаар албан тушаалаас нь огцруулах зэрэг хамаарна.

⁴⁹ Balser, Jimmy, “The Whistleblower Protection Act (WPA): A Legal Overview”, (Publication Date: 12/30/2024), <https://www.congress.gov/crs-product/R48318>.

⁵⁰ *Ibid*.

⁵¹ Засгийн газартай хийсэн гэрээ, санхүүжилттэй холбоотой авлигын үйлдлийг илчилсэн шүгэл үлээгчийг хамгаалсан хууль юм.

⁵² Санхүүгийн зах зээлийн зохицуулалтын хүрээнд авлига, луйврын илчилсэн шүгэл үлээгчийг хамгаалсан хууль юм.

тодорхойлолт, түүнд олгох урамшуулах, шүгэл үлээгчээс өшөө авах үйлдэл хийсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татах зохицуулалтыг агуулдаг⁵³.

2002 оны 7 дугаар сарын 30-ны өдөр Конгресс хөрөнгийн биржид бүртгэлгүй хуулийн этгээдэд ажиллаж буй шүгэл үлээгчийг хамгаалах, түүнд олгох давуу тал, мөн гомдлыг нууц хэлбэрээр гаргахтай холбогдох асуудлыг зохицуулах зорилготой Сарбэнс-Окслигийн хуулийг баталсан⁵⁴. Уг хуулиар хамгаалагдах этгээд нь тухайн хуулийн этгээдийн ажилтан байна. Шүгэл үлээсэн ажилтанд сахилгын арга хэмжээ авах, албан үүргээс нь чөлөөлөх зэргээр хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд нь сөрөг нөлөө үзүүлэхийг хориглодог. Хэрэв тэгсэн тохиолдолд ажилтан 90 хоногийн дотор гомдлоо бичгээр Хөдөлмөрийн яаманд (Department of Labor) гаргана. Гомдлыг хянан шийдвэрлэсний үр дүнд ажилтан:

- ажлын байрандаа эргүүлэн томилогдох;
- цалингаа нөхөн авах;
- өөрт учирсан бодит хохирлоо нөхөн төлүүлэх;
- уучлалт гуйхыг шаардах⁵⁵ зэрэг эрхтэй.

Шүгэл үлээгчийг урамшуулахыг хэд хэдэн хууль дээр зохицуулсан байна. Жишээлбэл, Худал нэхэмжлэл гаргахыг хориглох тухай хууль (False Claims Act, FCA)-д зааснаар шүгэл үлээгч төрийн нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргаж, төрийн эсрэг залилан хийсэн этгээдээс нөхөн төлбөр авах боломжтой болгосон бол шүүхээс нөхөн төлбөрийн 15-25 хувь хүртэлх хэмжээний мөнгөөр шүгэл үлээгчийг урамшуулах, эсхүл шүгэл үлээгчийн оролцоо их байсан бол 30 хувь хүртэлх хэмжээгээр ч урамшуулах⁵⁶ боломжтой байдаг.

6.2. Бүгд Найрамдах Хятад Ард Улс

Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ) нь авлигын гэмт хэргийн талаар иргэдээс гомдол, мэдээлэл гаргаж, шалгахтай холбоотой асуудлыг БНХАУ-ын Эрүүгийн хууль (中华人民共和国刑法, 1980), БНХАУ-ын Шударга бус өрсөлдөөний эсрэг хууль (中华人民共和国反不正当竞争法, 1993), БНХАУ-ын Хяналт шалгалтын тухай хууль (中华人民共和国监察法, 2018) зэрэг хуулиудаар зохицуулдаг ба авлигын гэмт хэргийн талаар шүгэл үлээсэн этгээдийг хамгаалах бие даасан хууль байхгүй юм.

БНХАУ-ын иргэдэд төрийн албан тушаалтны буруутай үйлдлийг мэдээлэх эрхийг Үндсэн хуулиар олгож, үүний эсрэг арга хэмжээ авахаас урьдчилан сэргийлж,

⁵³ Georgios Kontogeorgis, "Whistleblowers and their role in the Fight against corruption. Problems in protecting Whistleblowers and Suggestions for improvement", *International Multilingual Journal of Science and Technology*, Vol. 10 Issue 2, (February 2025), <https://www.imjst.org/wp-content/uploads/2025/03/IMJSTP29121138.pdf>.

⁵⁴ *Ibid*.

⁵⁵ National whistleblower center, "Sarbanes-Oxley (SOX) Whistleblower FAQ", (Published on June 03, 2018), https://www.whistleblowers.org/faq/sarbanes-oxley-sox-faq/?gad_source=1&gad_campaignid=20173867156&gbraid=0AAAAAC098VLDTXx4e0_22i0t0lqvPNjO&gclid=Cj0KCQjw0Y3HBhCxAARIsAN7931VYQL420vC7ccZBM_T6IEoblhPHCHDhNYJwicpjBrpK1j_uIFScXoBkaAIIKEALw_wcB.

⁵⁶ United States Code, art. 3730, <https://www.law.cornell.edu/uscode/text/31/3730>.

мэдээлэгчийг хамгаалдаг⁵⁷ байна. БНХАУ-ын Эрүүгийн хуулийг авч үзвэл, Авлига, хахуультай холбогдох асуудлыг 8 дугаар бүлгээр зохицуулсан байдаг.

БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 382 дугаар зүйлд төрийн албан тушаалтан (state functionary), 383 дугаар зүйлд төрийн албан хаагч (state employee) авлигын гэмт хэрэг үйлдэх, 387-393 дугаар зүйлд төрийн байгууллага бусдаас авлига авсан, өгсөн үйлдлийг, 394-396 дугаар зүйлд бэлэг өгөх, авах, хөрөнгө нь хууль ёсны орлогоосоо илэрхий давсан болон байгууллагын хөрөнгийн зөрчилтэй⁵⁸ холбогдох асуудлыг тус тус зохицуулдаг.

Харин төрийн өмчийн хуулийн этгээдийн авлигатай холбогдох асуудлыг “Социалист зах зээлийн эдийн засгийн дэг журмыг алдагдуулах” гэх 3 дугаар бүлгийн Компанийн болон аж ахуйн нэгжийн удирдлагын дэг журмыг алдагдуулах гэмт хэрэг гэсэн 3 дугаар хэсэгт зохицуулжээ. Тодруулбал, 165 болон 169 дүгээр зүйлд төрийн өмчийн хуулийн этгээдийн удирдлага өөрийн албан тушаалаа урвуулан ашиглан хууль бус орлого олох, 166 дугаар зүйлд төрийн өмчийн хуулийн этгээдийн ажилтан дээрх үйлдлийг гаргавал хариуцлага хүлээх⁵⁹ тухай тус тус хуульчилсан байна.

БНХАУ-ын Хяналт шалгалтын тухай хуулиар Үндсэн хуульд нийцүүлэн улсын хяналтын тогтолцооны шинэчлэлийг гүнзгийрүүлэх, төрийн эрх мэдлийг хэрэгжүүлж буй бүх төрийн албан хаагчдын үйл ажиллагаанд хяналт тавих, улсын хяналтыг иж бүрэн хэрэгжүүлэх, **авлигын эсрэг тэмцлийг эрчимжүүлэх**, төрийн засаглалын тогтолцоо ба чадавхыг орчин үеийн түвшинд хүргэх зорилгыг хангахтай⁶⁰ холбогдох харилцааг зохицуулдаг.

Уг хуульд зааснаар Хяналтын хороо нь нийтийн албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, албаны үүргээ зөрчих болон түүнтэй холбоотой эрх мэдлээ урвуулан ашиглах болон авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах, авлигатай тэмцэх, Үндсэн хууль, бусад хуулийн нэр хүндийг хамгаалах⁶¹ буюу төрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх мэргэшсэн байгууллага юм. Хяналтын хороо нь Төв Засгийн газрын харьяа хот, муж, өөртөө засах орон нутаг, аймаг, сум, өөртөө засах хошуу, хот болон дүүрэг бүрд байдаг бөгөөд хянан шалгах чиг үүргээ хэрэгжүүлдэг⁶².

Хяналтын хорооны дээд байгууллага нь Үндэсний Хяналтын хороо байдаг⁶³ бөгөөд хараат бусаар хяналтын эрх мэдлээ хэрэгжүүлж, төрийн захиргааны болон бусад байгууллага, хувь хүний оролцоо, нөлөөнд үл автан ажиллах үүрэгтэй⁶⁴. Хяналтын хороо нь иргэдийн өргөдөл, мэдээлэл, гомдлыг хүлээн авч, холбогдох хяналт шалгалтыг хийж шийдвэрлэдэг⁶⁵. Хэрэв харьяаллын бус асуудал байвал тусгай чиг үүрэг бүхий байгууллагад нь шилжүүлнэ. БНХАУ-ын Хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу Хяналтын хороо нь дараах нийтийн албан тушаалтанд хяналт тавьдаг. Үүнд:

1. Хятадын Коммунист Намын байгууллага, Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал болон түүний Байнгын хороо, Ардын Засгийн газар, Хяналтын хороо, Ардын шүүх, Ардын прокурор, Хятадын Ардын Улс төрийн Зөвлөлдөх Зөвлөлийн

⁵⁷ Mini vandePol, Vivian Wu, “New Rules Offer Greater Protection and Incentives to Whistleblowers in China” (2016), <https://www.globalcompliancenews.com/2016/05/04/new-rules-offer-greater-protection-and-incentives-to-whistleblowers-in-china-20160504>.

⁵⁸ БНХАУ-ын Эрүүгийн хууль (1979).

⁵⁹ *Мөн тэнд* (1979).

⁶⁰ БНХАУ-ын Хяналт шалгалтын тухай хууль (2018).

⁶¹ *Мөн тэнд* (2018), 3 дугаар зүйл.

⁶² *Мөн тэнд* (2018), 7 дугаар зүйл.

⁶³ *Мөн тэнд* (2018), 7 дугаар зүйл.

⁶⁴ *Мөн тэнд* (2018), 4 дүгээр зүйл.

⁶⁵ *Мөн тэнд* (2018), 35 дугаар зүйл.

бүх шатны байгууллага, ардчилсан намын байгууллага, арилжаа, үйлдвэрлэлийн холбоод, мөн БНХАУ-ын Төрийн албан хаагчийн тухай хуульд заасан албан хаагч;

2. Хууль тогтоомжид зааснаар нийтийн хэрэг удирдах эрх бүхий байгууллагад нийтийн үйлчилгээ эрхэлж буй албан хаагч, эсхүл төрийн байгууллагаас тэдгээрийг удирдах эрх олгосон этгээд;
3. Төрийн өмчит хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан;
4. Нийтийн боловсрол, шинжлэх ухаан, соёл урлаг, эмнэлэг, эрүүл мэнд, спорт болон бусад төрийн байгууллагын удирдах албан тушаалтан;
5. Суурь түвшний олон нийтийн өөрөө удирдах байгууллагын удирдах ажилтан;
6. Хуульд заасны дагуу нийтийн чиг үүрэг гүйцэтгэж буй бусад этгээд⁶⁶ хамаарна.

Хяналтын хороо нь хууль тогтоомжийн дагуу дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг. Тухайлбал:

1. Төрийн албан хаагчдад авлигын эсрэг сургалт зохион байгуулах, тэдгээрийн хууль ёсны дагуу ажиллаж, эрх мэдлээ шударгаар хэрэгжүүлж, үйл ажиллагаандаа мэргэжлийн болон ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж байгаа эсэхэд хянан тавих, удирдан чиглүүлэх;
2. Авлига авах, хахууль өгөх, эрх мэдлээ урвуулан ашиглах, албан үүргээ биелүүлэхээс зайлсхийх, эрх мэдэл төвлөрүүлэх, ашиг хонжоо хайх, бусдад давуу байдал бий болгох, залилах, улсын өмч, хөрөнгийг үрэгдүүлэх гэмт хэрэг болон албан үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой зөрчлийг хянан шалгах;
3. Зөрчил гаргасан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу захиргааны шийтгэл оногдуулах; албан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүй удирдах албан тушаалтанд хариуцлага тооцох; албан тушаалын гэмт хэргийн шинжтэй үйлдэлд холбогдох хууль тогтоомжийн дагуу Ардын Прокурорын газарт ял шийтгэл оногдуулах санал гаргах болон прокурорын хяналт тавиулахаар шилжүүлэх; хяналтад байгаа этгээдийн харьяалагдах байгууллагад зөвлөмж хүргүүлэх⁶⁷ зэрэг болно.

Нийтийн албан тушаалтны үйлдсэн зөрчил, гэмт хэргийг шалгахдаа тухайн байгууллага, иргэдээс нөхцөл байдлыг тодруулах, нотлох баримтыг гаргуулан авах эрхтэй. Энэ хүрээнд хувь хүн, байгууллага нь үнэн зөв нотлох баримт гаргаж өгөх үүргийг хуулиар хүлээдэг. Харин Хяналтын хорооны албан хаагчид албан үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн төрийн нууц, бизнесийн болон хувь хүний нууцыг задруулахгүй, чанд хадгалах үүрэгтэй байна. Аливаа байгууллага, хувь хүн нотлох баримтыг хуурамчаар үйлдэх, нуун дарагдуулах, устгахыг хориглодог⁶⁸.

Харин хувийн эрх зүйн салбар дахь авлигын гэмт хэргийн талаарх мэдээлэх асуудлыг зохицуулж буй эрх зүйн гол эх сурвалж нь БНХАУ-ын Шударга бус өрсөлдөөний эсрэг хууль юм. Тус хуулийн зорилго нь социалист зах зээлийн эдийн засгийн эрүүл хөгжил, шударга өрсөлдөөнийг хөхиүлэн дэмжих, шударга бус өрсөлдөөнөөс урьдчилан сэргийлэх, аж ахуйн нэгж, хэрэглэгчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалахад оршино⁶⁹.

Шударга бус өрсөлдөөний эсрэг хуулиар бизнес эрхлэгч өөртөө давуу боломж, нууц мэдээлэл олж авахын тулд харилцагч байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгч

⁶⁶ Мөн тэнд (2018), 15 дугаар зүйл.

⁶⁷ Мөн тэнд (2018), 11 дүгээр зүйл.

⁶⁸ Мөн тэнд (2018), 18 дугаар зүйл.

⁶⁹ БНХАУ-ын Шударга бус өрсөлдөөний эсрэг хууль (1993), 1 дүгээр зүйл.

болон аливаа байгууллага, хувь хүнд хахууль өгөхийг хориглодог байна⁷⁰. Уг үйлдлийн талаар мэдсэн, сэжиглэсэн этгээд Хяналт, шалгалтын албанд мэдэгддэг. Ингэхдээ тус албаны мэдээлэл хүлээн авах утас, шуудан, цахим шуудангаар мэдээллээ илгээх боломжтой. Хяналт шалгалтын албанаас мэдээллийг хүлээн авч, түргэн шуурхай шалгах үүрэгтэй байна⁷¹.

Бизнес эрхлэгчээс хахууль өгсөн асуудлыг шалгахдаа аж ахуйн нэгж, хувь хүнээс тохиолдол, нөхцөл байдлын талаар мэдээллийг авах, тухайн этгээд шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх үүргийг харилцан хүлээнэ⁷². Хэрэв шалгагдаж буй этгээд хахууль авсан нь тогтоогдвол хууль бусаар олсон орлогыг хурааж, 100,000 юаниас доошгүй, 3,000,000 юаниас дээшгүй хэмжээний мөнгөн торгууль ногдуулдаг байна. Шаардлагатай тохиолдолд арилжаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээг авч болдог⁷³. Хяналт шалгалтын албаны алба хаагч нь мэдээллийн эх сурвалж, мэдээлэл гаргагчийн хувийн мэдээллийг чанд нууцлах үүргийг хүлээж, зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээдэг⁷⁴.

Дээрхээс үзвэл, БНХАУ-д нийтийн эрх зүйн салбар дахь авлигатай холбоотой асуудлыг Хяналт шалгалтын тухай хуулиар, хувийн эрх зүйн салбар дахь авлигатай холбоотой асуудлыг Шударга бус өрсөлдөөний эсрэг хуулиар тус тус зохицуулж байна. Ингэхдээ шүгэл үлээгч, мэдээлэгч гэх ойлголтыг хууль тогтоомжид тодорхойлоогүй бөгөөд аливаа албан тушаалтан авлига, хахууль авсан тухай иргэдээс өргөдөл, гомдол, мэдээллийг холбогдох байгууллагад гаргах тухай л зохицуулжээ.

Нийтийн эрх зүйн салбарын албан хаагчтай холбоотой авлигын хэргийг Хяналтын хороо, хувийн эрх зүйн салбарын арилжаа эрхлэгчийн хахууль өгөхтэй холбоотой хэргийг Хяналт шалгалтын алба хариуцан тус тус шалгадаг байна. Энэ хоёр байгууллагаас гадна, салбарын тусгай чиг үүргийн онцлогоос хамааран Сахилгын хяналтын төв комисс зэрэг байгууллага авлигын хэрэгтэй холбоотой асуудлыг хянан шийдвэрлэдэг.

БНХАУ-д өргөдөл, гомдол, мэдээлэл гаргасан этгээдийг урамшуулахтай холбоотой зохицуулалт хуульд байхгүй боловч салбарын онцлогоос шалтгаалан тухайлсан журам хэрэгжиж байна. Жишээлбэл, 2016 оны 3 дугаар сарын 30-ны өдөр Ардын дээд прокурорын газар, Сангийн яамнаас хамтран албаны эрх мэдлээ урвуулан ашигласан, авлига авсан алба хаагчийг мэдээлсэн мэдээлэгчийг хамгаалах, урамшуулах “Шинэ журам” гэх нэртэй журмыг баталсан. Уг журамд мэдээлэгчийн хувийн мэдээллийг чандлан нууцлах, тэдний ойр дотны хүмүүсийн аюулгүй байдал, өмч хөрөнгийг хамгаалах тухай арга хэмжээг тусгажээ. Мэдээллийг хүлээн авахдаа албан ёсны вэбсайтуудыг ашиглаж эхэлсэн. Мөн мэдээлэгчид 200,000-500,000 юань хүртэлх мөнгөн урамшуулал олгох боломжтой⁷⁵ болжээ. “Шинэ журам”-ыг аж ахуйн нэгжүүд мөрдөж байгаа боловч тухайн журмаар эрх зүйн хариуцлага хүлээлгэхгүй байгаа нь учир дутагдалтай байна.

⁷⁰ *Мөн тэнд* (1993), 7 дугаар зүйл.

⁷¹ *Мөн тэнд* (1993), 16 дугаар зүйл.

⁷² *Мөн тэнд* (1993), 14 дүгээр зүйл.

⁷³ *Мөн тэнд* (1993), 19 дүгээр зүйл.

⁷⁴ *Мөн тэнд* (1993), 30 дугаар зүйл.

⁷⁵ Mini vandePol, Vivian Wu, “New Rules Offer Greater Protection and Incentives to Whistleblowers in China” (2016), <https://www.globalcompliance.com/2016/05/04/new-rules-offer-greater-protection-and-incentives-to-whistleblowers-in-china-20160504>.

6.3. Оросын Холбооны Улс

Оросын Холбооны Улс нь авлигын гэмт хэргийн талаар мэдээлэх асуудлыг Авлигын эсрэг хууль (О противодействии коррупции, 2008); Эрүүгийн хууль (Уголовный кодекс Российской Федерации, 1996); Захиргааны зөрчлийн тухай хууль (Кодекс Российской Федерации об административных правонарушениях, 2001) болон салбарын тусгай дүрэм, журмуудаар тус тус зохицуулдаг бөгөөд шүгэл үлээгчийг хамгаалах тухай бие даасан хуульгүй байна.

Нийтийн албан тушаалтны үйлдсэн авлигын гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 291 дүгээр зүйлд (Дача взятки) дотоодын, гадаад улсын⁷⁶, олон улсын байгууллагын албан тушаалтны⁷⁷ үйлдсэн авлигын гэмт хэргийг; 291.1 дүгээр зүйлээр (Посредничество во взяточничестве) авлига өгөх, авахад зуучлах буюу туслах гэмт хэргийг, 291.2 дугаар зүйлд (Мелкое взяточничество) бага хэмжээний⁷⁸ авлига өгөх, авах гэмт хэргийг тус тус зохицуулжээ.

Харин хувийн эрх зүйн салбарын хувьд, 204 дүгээр зүйлд (Коммерческий подкуп) арилжааны авлигын гэмт хэргийг, 204.1 дүгээр зүйлд (Посредничество в коммерческом подкупе) арилжааны авлигыг зуучлах гэмт хэргийг, 204.2 дугаар зүйлд (Мелкий коммерческий подкуп) арилжааны үйл ажиллагаанд бага хэмжээний авлига өгөх гэмт хэргийг тус тус зохицуулсан байна.

ОХУ-ын Авлигын тухай хууль нь 2008 оны 12 дугаар сарын 22-ны өдөр батлагдсан. Энэхүү хуулиар авлигатай тэмцэх үндсэн зарчим, авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, авлигын гэмт хэргийн үр дагаврыг бууруулах эрх зүйн болон зохион байгуулалтын үндсийг тогтоосон байна⁷⁹. Уг хуульд авлига (коррупция) гэж албан тушаалаа урвуулан ашиглах, авлига өгөх, авах, эрх мэдлээ зүй бусаар ашиглах, бусад этгээдээр дамжуулан өөрийн албан тушаалыг нийгэм, төрийн хууль ёсны эрх ашгийн эсрэг ашиглан өөртөө болон гуравдагч этгээдэд мөнгө, үнэт зүйл, бусад өмч хөрөнгө, эдийн засгийн шинжтэй үйлчилгээ, бусад өмчийн эрх ашгийг авахад чиглэсэн хууль бус үйлдэл, эсхүл бусад этгээдээс уг давуу байдлыг хууль бус байдлаар авах болон тус үйлдлийг хуулийн этгээдийн нэрээр, эсхүл түүний ашиг сонирхлын төлөө үйлдэх⁸⁰ гэж тодорхойлжээ.

Аливаа этгээд Авлигын эсрэг хууль тогтоомжийг хуулийн этгээд болон хувь хүн зөрчиж болзошгүй байгааг илчлэх үүргийг хүлээдэггүй бөгөөд сайн дурын үндсэн дээр тухайн зөрчлийг ил болгодог. Зөвхөн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх тухай гэмт хэргийн шинжтэй үйлдлийн талаар сэжиг авсан тохиолдол болон алан хядлага, хүчирхийллийн гэмт хэргийн талаар холбогдох хууль сахиулах байгууллагад мэдэгдэх үүргийг хүлээдэг⁸¹.

⁷⁶ Гадаад улсын албан тушаалтан гэдэг нь гадаад улсын хууль тогтоох, гүйцэтгэх, захиргаа эсхүл шүүхийн байгууллагад сонгогдсон болон томилогдсон алтан тушаалтан, мөн гадаад улсын төрийн болон нийтийн байгууллагын нийтэд зориулагдсан ямар нэг үүрэг гүйцэтгэж байгаа аливаа этгээдийг хэлнэ.

⁷⁷ Олон улсын байгууллагын албан тушаалтан гэдэг нь олон улсын нийтийн албан хаагч эсхүл тухайн байгууллагын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах эрх олгогдсон аливаа этгээдийг хэлнэ.

⁷⁸ Бага хэмжээний авлига гэдэг нь 10,000 рубль хүртэлх хэмжээг ойлгоно.

⁷⁹ Российская федерация федеральный закон о противодействии коррупции, 25 декабря 2008 года, Авлигын эсрэг хуулийн эхний хэсэг, <https://faolex.fao.org/docs/pdf/rus202742.pdf>.

⁸⁰ Монгол Улсын Авлигын эсрэг хууль (2006), 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг.

⁸¹ Anna Fufurina, "Anti-Corruption and bribery in Russia" (20 June 2017), <https://www.krioni.com/blog/anti-corruption-and-bribery-in-russia/>.

2016 оны 7 дугаар сарын 06-ны өдөр Эрүүгийн хуульд 205.6 дугаар зүйл (Несообщение о преступлении) шинээр нэмэгдсэн. Уг зүйлээр гэмт хэргийн талаар холбогдох эрх бүхий байгууллагад мэдээлээгүй үйлдлийг гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг⁸² болсон. Гэсэн хэдий ч энэхүү мэдээлэх шаардлагатай гэмт хэрэгт авлига өгөх, авах гэмт хэрэг ороогүй байна.

Ийнхүү авлига өгөх, авах гэмт хэргийн талаар мэдээлэх үүргийг хуульчлаагүй ч авлига өгсөн этгээд нь тухайн гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагаанд идэвхтэй туслалцаа үзүүлсэн, авлига авсан этгээдийн дарамтад өртсөн, эсхүл сайн дураараа холбогдох байгууллагад мэдэгдсэн тохиолдолд эрүүгийн хариуцлагаас чөлөөлдөг⁸³ билээ.

ОХУ-ын хууль тогтоомжид мэдээлэгчийг хамгаалахтай холбоотой харилцааг Авлигын эсрэг хуулийн 9 дүгээр зүйлээр зохицуулсан. Тухайлбал, нийтийн болон орон нутгийн албан хаагч авлигын шинжтэй үйлдлийн талаар ажил олгогч буюу дээд шатны удирдах албан тушаалтан, эсхүл бусад холбогдох байгууллагад мэдэгдэх үүрэгтэй⁸⁴. Энэхүү үүргээ биелүүлээгүй бол албан үүргээс нь чөлөөлөх хүртэл арга хэмжээ авдаг⁸⁵. Харин үүргээ биелүүлсэн мэдээлэгч (информер)-ийг хууль тогтоомжид нийцүүлэн төрийн хамгаалалтад авдаг байна⁸⁶. Хэрэв тухайн мэдээлэл гаргагч нь шүүгч, хууль сахиулах байгууллагын албан тушаалтан байвал “Шүүгч, хууль сахиулах байгууллагын албан тушаалтныг төрийн хамгаалалтад авах тухай” Холбооны хуулиар хамгаална.

Иймд энэхүү хамгаалалт зөвхөн нийтийн эрх зүйн албан хаагчид л хамаардаг. Тэдгээрийг хамгаалах зохицуулалт Авлигын эсрэг хуульд байгаа боловч ямар процессын дагуу, хэрхэн хамгаалах тухай нарийвчлан зохицуулаагүй байна. Мөн хувийн эрх зүйн салбар дахь мэдээлэгчийг хамгаалах хуулийн зохицуулалт байхгүй.

Авлигын гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд тухайн этгээдэд хүлээлгэх хариуцлагын хэмжээ өндөр байна. Тухайлбал, Захиргааны зөрчлийн тухай хуульд хуулийн этгээдийн нэрийн өмнөөс хууль бусаар цалин хөлс авах зөрчил гаргасан бол дараах хариуцлагыг хүлээлгэнэ:

- *Бага хэмжээний хахууль*: хахуулийн дүнг 3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний торгууль ногдуулах ба торгуулийн хэмжээ 1,000,000 рублээс багагүй байна.
- *Их хэмжээний хахууль*: хахуулийн хэмжээ 1,000,000 рублээс давсан бол хахуулийн хэмжээг 30 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний торгууль ногдуулах бөгөөд торгуулийн хэмжээ 20,000,000 рублээс багагүй байна.
- *Онц их хэмжээний хахууль*: хахуулийн хэмжээ 20,000,000 рублээс давсан бол хахуулийн хэмжээг 100 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний торгууль ногдуулах бөгөөд торгуулийн хэмжээ 100,000,000 рублээс багагүй байна⁸⁷.

2017-2019 оны хооронд хэд хэдэн удаа Төрийн Думд “Төрийн болон хувийн хэвшилд авлигын талаар мэдээлсэн мэдээлэгчийг хамгаалах тухай” хуулийн төслийг өргөн барьсан боловч дэмжигдээгүй. ОХУ нь авлигын талаар мэдээлэл гаргасан мэдээлэгчийг хамгаалах зохицуулалт хомс байгааг үл харгалзан урамшууллаар дэмжихийг оролдсон. Дотоод хэргийн яамнаас 2018 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн 356 дугаар тушаалаар 2018 оны 8 дугаар сарын 29-ны өдрөөс эхлэн авлига, хахууль

⁸² ОХУ-ын Эрүүгийн хууль (1996), 205 дугаар зүйлийн 205.6 дахь хэсэг.

⁸³ *Мөн тэнд* (1996), 291, 291.1, 291.2 дугаар зүйлийн Тэмдэглэл хэсэг.

⁸⁴ ОХУ-ын Авлигын эсрэг хууль (2008), 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг

⁸⁵ *Мөн тэнд* (2008), 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг

⁸⁶ *Мөн тэнд* (2008), 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг

⁸⁷ Захиргааны зөрчлийн тухай хууль (2001), 19 дүгээр зүйлийн 19.28 дахь хэсэг

зэрэг гэмт хэргийн тухай мэдээлсэн хүнд мэдээллийн нотлох баримт болох боломж, чанар, баталгааг харгалзан 3,000,000 рубль хүртэлх хэмжээний урамшуулал олгохоор шийдвэрлэсэн байна⁸⁸.

Зарим нийтийн эрх зүйн байгууллага нь авлигын тухай мэдээлэл өгөх дотоод алба, нэгжийг ажиллуулдаг. Тухайлбал, Прокурорын байгууллагын харьяа Авлигын эсрэг тусгай нэгж⁸⁹ (Special Anti-Corruption Units, SACU), Дотоод хэргийн яамны харьяа Эдийн засгийн аюулгүй байдал авлигын эсрэг газар⁹⁰ (Economic Security and Anti-Corruption Department) зэрэг болно.

Хувийн эрх зүйн салбар дахь авлигын асуудлыг зохицуулахдаа, Авлигын эсрэг хуульд тус улсад үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд, байгууллага авлигаас урьдчилан сэргийлэх тусгайлсан арга хэмжээг багтаасан авлигатай тэмцэх хөтөлбөр хэрэгжүүлэх ёстой хэмээсэн. Үүний хүрээнд хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажиллах, нийт ажилтны сахин биелүүлэх журам, ажилтны ёс зүйн дүрэм батлах, ашиг сонирхлын эсрэг бодлого хэрэгжүүлэх болон бусад шаардлагатай арга хэмжээг авна⁹¹ гэжээ.

ОХУ-д шүгэл үлээх тогтолцоог нэвтрүүлэхэд тулгамдаж буй хүндрэлтэй асуудлын нэг бол иргэдийн мэдээлэл гадагш задрах эрсдэл юм. Тодруулбал, гадаад дугаар, цахим шуудангийн хаяг болон гадаад улсын серверүүд дээрх өгөгдөл хадгалах вэбсайтууд нь иргэдийн хувийн мэдээллийг цуглуулж хадгалдаг байна. Иймд цахимаар мэдээлэхэд энэхүү улсад аюулгүй байдлын асуудал үүсэж⁹² байгаа болно.

6.4. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Холбооны Бүгд Найрамдах Герман улс нь авлигын гэмт хэрэгт шүгэл үлээх асуудлыг Авлигын эсрэг хууль⁹³ (Gesetz zur Bekämpfung der Korruption, 2015); Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хууль (Hinweisgeberschutzgesetz, 2023); Эрүүгийн хууль (Strafgesetzbuch, 1871)-иудаар тус тус зохицуулдаг бөгөөд нарийвчлан зохицуулсан бие даасан хууль байхгүй байна.

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийг авч үзвэл, авлига өгөх, авах гэмт хэргийг субъектээр нь нийтийн албан тушаалтан⁹⁴ болон хувийн эрх зүйн салбар дахь ажилтны үйлдсэн гэмт хэргийг тусад нь зохицуулсан байна. Тухайлбал,

⁸⁸ Hannes Lubitzsch, "Russia", (14 Jan 2022), Global Investigation Review, <https://globalinvestigationsreview.com/guide/the-practitioners-guide-global-investigations-archived/2022/article/russia>.

⁸⁹ The Prosecutor General's Office of the Russian Federation, "Combating corruption", https://epp.genproc.gov.ru/web/eng_qprf/combating-corruption.

⁹⁰ Directorate General of Human Rights and Legal Affairs, "Evaluation Report on the Russian Federation", (2008), <https://rm.coe.int/16806c7d06>.

⁹¹ ОХУ-ын Авлигын эсрэг хууль (2008), 273 дугаар зүйлийн 273.1 дэх хэсэг

⁹² Hannes Lubitzsch, "Russia", (14 Jan 2022), Global Investigation Review, <https://globalinvestigationsreview.com/guide/the-practitioners-guide-global-investigations-archived/2022/article/russia>.

⁹³ Энэхүү хууль нь авлигын эсрэг тэмцэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авах, байгууллагуудын хариуцлагыг тодорхойлох, авлигын эсрэг сургалт, мэдээллийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зэрэг зохицуулалтыг агуулдаг.

⁹⁴ Criminal Code in the version published on 13 November 1998 (Federal Law Gazette I, p. 3322), as last amended by Article 2 of the Act of 22 November 2021 (Federal Law Gazette I, p. 4906), https://www.gesetze-im-internet.de/englisch_stgb/englisch_stgb.html, ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасны дагуу нийтийн албан тушаалтан гэдэгт: а) төрийн албан хаагч, эсхүл шүүгч; б) нийтийн албаны бусад чиг үүргийг хэрэгжүүлэгч, эсхүл в) эрх бүхий байгууллага, эсхүл өөр төрлийн байгууллагад ажиллахаар томилогдсон, эсхүл зохион

- нийтийн албан тушаалтанд авлига өгөх, авах гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 331-338 дугаар зүйл;
- хувийн эрх зүйн салбар дахь авлигын гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 299-301 дүгээр зүйлээр тус тус зохицуулдаг⁹⁵.

Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хууль (Hinweisgeberschutzgesetz) нь 2023 оны 7 дугаар сарын 02-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Уг хуулийн зорилго нь албан ажлын хүрээнд хууль зөрчсөн үйлдлийн талаар мэдээлэлтэй, мэдээллийг хуульд заасны дагуу хүлээн авах байгууллагад мэдээлсэн, эсхүл олон нийтэд ил болгосон хувь хүн буюу мэдээлэгч этгээд (reporting persons)⁹⁶, мэдээлэлд дурдагдсан этгээд болон бусад холбогдох этгээдийг хамгаалахтай холбогдох харилцааг зохицуулахад оршино⁹⁷. Шүгэл үлээгч гэж хэн болох талаар хуульд тодорхойлолт байхгүй боловч хуулийн хамрах хүрээнээс үзвэл, шүгэл үлээгч гэдэг нь ажил хэргийн хүрээнд хууль зөрчсөн үйлдлийн талаар олж мэдэж, түүний талаар шүгэл үлээсэн болон шүгэл үлээхээр оролдсон этгээдийг хэлэхээр байна. Эдгээрт:

- байгууллагын ажилтан, гэрээт ажилтан, дадлагажигч, дагалдан, туслах, үйлчилгээ үзүүлэгч, цагийн ажилтан, ажил горилогч;
- төрийн албан хаагч;
- мэдээлэлд хамаарал бүхий бусад этгээд /тухайлбал, гэрч/⁹⁸;
- шүүгч /хүндэт шүүгчээс бусад/;
- цэргийн албан хаагч⁹⁹ хамаарна.

Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуулийн дагуу шүгэл үлээгч нь дараах төрийн байгууллагад мэдээлэл өгөх боломжтой юм. Үүнд¹⁰⁰:

- Холбооны хууль зүйн төв (Bundesamt für Justiz) дахь Холбооны гадагшаа мэдээлэх газар (Federal External Reporting Office);
- Холбооны санхүүгийн зохицуулах байгууллага (Federal Financial Supervisory Authority);
- Холбооны картелийг зохицуулах газар (Bundeskartellamt) зэрэг хамаарна.

Холбооны хууль зүйн төв нь албан тушаалтны үйлдсэн зөрчлийн талаар мэдээлэх төв байгууллага юм. Харин Холбооны санхүүгийн зохицуулах байгууллага нь Хяналтын албыг байгуулах тухай хууль (Gesetz über die Bundesanstalt für Finanzdienstleistungsaufsicht) болон Үнэт цаас худалдан авах болон эзэмших тухай хууль

байгуулалтын хэлбэрээс үл хамааран нийтийн захиргааны үйл ажиллагаа эрхэлж гүйцэтгэхээр даалгасан этгээд хамаарна.

⁹⁵ Dr. Andreas Lohnei and Nicolai Behi, "Anti corruption in Germany", (2025), <https://www.globalcompliance.com/anti-corruption/handbook/anti-corruption-in-germany/>.

⁹⁶ Хуулийн гарчиг нь Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хууль бөгөөд агуулгын хувьд мэдээлэгч (informant) бус шүгэл үлээгчтэй холбоотой харилцааг зохицуулсан байна. Хуулийн англи орчуулга дээр тухайн субъектыг "reporting persons" гэсэн байгааг энэхүү судалгааны ажлын хүрээнд мэдээлэгч этгээд хэмээн монгол хэлэнд буулгаж хэрэглэлээ. Энэ нь агуулгын хувьд мэдээлэгч (informant)-ээс өөр бөгөөд шүгэл үлээгч (whistleblower) гэх нэр томъёотой ижил утгатай байна.

⁹⁷ Whistleblower Protection Act of 31 May 2023 (Federal Law Gazette 2023 I no. 140) as last amended by Article 16 of the Act of 27 December 2024 (Federal Law Gazette 2024 I, no. 438), https://www.gesetze-im-internet.de/englisch_hinschg/englisch_hinschg.html.

⁹⁸ Andre Appel, "Germany's New Whistleblower Protection Act: What Employers Need to Know" (August 28, 2023), <https://ogletree.com/insights-resources/blog-posts/germanys-new-whistleblower-protection-act-what-employers-need-to-know/>.

⁹⁹ Whistleblower Protection Act of 31 May 2023 (Federal Law Gazette 2023 I no. 140) as last amended by Article 16 of the Act of 27 December 2024 (Federal Law Gazette 2024 I, no. 438), art. 3.8, 3.9, 3.10, https://www.gesetze-im-internet.de/englisch_hinschg/englisch_hinschg.html.

¹⁰⁰ *Ibid*, art. 19-24.

(Wertpapiererwerbs- und Übernahmegesetz)-д заасан зөрчлийн дагуу хянан шалгах үүргийг хэрэгжүүлдэг¹⁰¹.

Холбооны картелийг зохицуулах газар нь Өрсөлдөөнийг хязгаарлахын эсрэг хуулийн дагуу (Gesetz gegen Wettbewerbsbeschränkungen, GWB) хуулийн этгээд давуу байдлаа урвуулан ашигласан, өрсөлдөөнийг хязгаарласан гэрээ, хэлцэл байгуулсан зэрэг үйлдлийг хариуцан шалгах¹⁰² чиг үүрэгтэй.

Түүнчлэн Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу шүгэл үлээгчээс мэдээлэл хүлээн авч буй байгууллага нь шударгаар, бие даан үйл ажиллагаагаа явуулж буй эсэхэд харилцан хяналт тавьдаг байна. Хувь хүн мэдээлэл хүлээн авч буй байгууллагын үйл ажиллагаатай холбогдох гомдол, хүсэлтийг өөр байгууллагад гаргана. Жишээлбэл, Холбооны санхүүгийн зохицуулах байгууллага болон Холбооны картелийг зохицуулах газрын мэдээлэл хүлээн авахтай холбогдох үйл ажиллагааны талаар гомдол, хүсэлт хүлээн авах байгууллага нь Холбооны хууль зүйн төв дахь Холбооны гадагшаа мэдээлэх газар байна¹⁰³.

Үүнээс гадна шүгэл үлээгч байгууллагынхаа дотоод нэгж, хэлтэст мэдэгдэж мэдээлэл гаргах боломжтой. Хуульд зааснаар 50 болон түүнээс дээш тооны ажилтныг ердийн нөхцөлд тогтмол ажиллуулдаг байгууллага шүгэл үлээх дотоод нэгжийг бий болгоно¹⁰⁴. Тухайн нэгжийг ажил олгогч, байгууллагын хэд хэдэн ажилтан, эсхүл гуравдагч этгээд хариуцан ажиллуулна. Түүнчлэн тухайн байгууллагын ажил олгогч нь ирсэн мэдээллийн дагуу зөрчлийг шалган шийдвэрлэх болон ажилтнуудыг шүгэл үлээх тогтолцооны талаар тодорхой, ойлгомжтой мэдээллээр хангах үүргийг тус тус хүлээнэ¹⁰⁵.

Шүгэл үлээгч мэдээллээ аман (утсаар) хэлбэрээр, эсхүл бичгээр (и-мэйл) гаргах бөгөөд шаардлагатай тохиолдолд цахимаар уулзалт хийх боломжтой¹⁰⁶. Шүгэл үлээгч мэдээллээ төрийн байгууллага болон байгууллагын дотоод нэгжийн алинд нь ч гаргаж болох ч эхлээд байгууллагын дотоод нэгждээ хандан шийдвэрлүүлж, тухайн шийдвэр нь зөрчлийг арилгаагүй гэж шүгэл үлээгч үзсэн тохиолдолд төрийн байгууллагад хандах нь илүү тохиромжтой¹⁰⁷ гэж үздэг байна.

Зөрчлийн талаар шууд олон нийтэд илчлэхийг зохимжгүй гэж үздэг бөгөөд холбогдох төрийн байгууллагад мэдээлэл өгсөн ч хяналт шалгалтыг хийгээгүй, үр дүнгийн талаар шүгэл үлээгчид эргэн мэдэгдээгүй, эсхүл зайлшгүй нөхцөл байдал (нотлох баримтыг устгах, нуун далдлах нөхцөл бүрдсэн, шүгэл үлээгчийн мэдээллийг хянах, шалгах эрх бүхий этгээд зөрчил үйлдэгчтэй хуйвалдсан, нөхөж баршгүй хохирол учрах эрсдэлтэй зэрэг шалтгаанаар олон нийтийн ашиг сонирхолд аюул занал учруулж болзошгүй¹⁰⁸ гэх мэт) бий болсон тохиолдолд олон нийтэд шууд илчлэхийг зөвшөөрдөг байна.

¹⁰¹ Whistleblower Protection Act of 31 May 2023 (Federal Law Gazette 2023 I no. 140) as last amended by Article 16 of the Act of 27 December 2024 (Federal Law Gazette 2024 I, no. 438), art. 21, https://www.gesetze-im-internet.de/englisch_hinschg/englisch_hinschg.html.

¹⁰² *Ibid*, art. 22.

¹⁰³ *Ibid*, art. 23.

¹⁰⁴ *Ibid*, art. 12.

¹⁰⁵ *Ibid*, art. 7.3.

¹⁰⁶ Andre Appel, "Germany's New Whistleblower Protection Act: What Employers Need to Know" (August 28, 2023), <https://ogletree.com/insights-resources/blog-posts/germanys-new-whistleblower-protection-act-what-employers-need-to-know/>.

¹⁰⁷ Whistleblower Protection Act of 31 May 2023 (Federal Law Gazette 2023 I no. 140) as last amended by Article 16 of the Act of 27 December 2024 (Federal Law Gazette 2024 I, no. 438), art. 7.1, https://www.gesetze-im-internet.de/englisch_hinschg/englisch_hinschg.html.

¹⁰⁸ *Ibid*, art. 32.

Шүгэл үлээгчийн гаргасан мэдээллийг эрх бүхий ажилтан 7 хоногийн дотор шалгаж, тухайн үйл баримт нь авлига, хахуультай холбоотой эсэхийг тогтооно. Шаардлагатай тохиолдолд нэмэлт нотлох баримт, мэдээлэл цуглуулах буюу мөрдөн шалгах ажиллагааг явуулна. Ийнхүү мэдээллийг баталгаажуулснаас хойш 3 сарын дотор холбогдох хариуг шүгэл үлээгчид мэдэгдэж, үүнд холбогдох нотлох баримтыг 3 жилийн хугацаанд хадгалах үүргийг тус тус хүлээдэг. Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуулийн хамгаалалтын хүрээний хувьд:

- мэдээлэл өгсөн хувь хүн;
- мэдээлэлд нэр дурдагдсан этгээд;
- мэдээлэлд нэр дурдагдсан бусад этгээд буюу хамаарал бүхий этгээдүүдийг хамгаалах зохицуулалттай байна¹⁰⁹.

Шүгэл үлээгчийг хамгаалахдаа түүний хувийн мэдээллийг нууцалж аливаа хэлбэрээр дарамт, шахалт ирэхээс урьдчилан сэргийлдэг. Түүнчлэн шүгэл үлээгчээс өшөө авах шинжтэй аливаа үйлдэл хийх, хийхээр завдахыг хориглоно. Хэрэв шүгэл үлээгч мэдээлэл өгснийхөө улмаас хохирч, түүнийгээ нэхэмжилсэн тохиолдолд нотлох үүргийг хариуцагч /авлигын гэмт хэргийн талаар шүгэл үлээсэн тохиолдолд авлига авсан гэх албан тушаалтан/ хүлээнэ¹¹⁰. Нотолж чадаагүй тохиолдолд хохирлыг нөхөн төлөх бөгөөд аливаа байдлаар хөдөлмөрийн эрх зүйн харилцаа үүсгэх, албан тушаал дэвшүүлэх болон бусад гэрээний харилцаа бий болгох замаар хохирол барагдуулахыг хориглодог байна¹¹¹.

Шүгэл үлээгч нь мэдээлэл өгөх, эсхүл мэдээллийг илчлэх үед тухайн мэдээллийг үнэн гэж үзэх үндэслэл байсан, эсхүл мэдээлэл нь Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуулийн зохицуулалтын хүрээнд хамаарах, эсхүл мэдээлэгч уг хүрээнд хамаарна гэж итгэх үндэслэлтэй тохиолдолд түүнийг хамгаална¹¹². Мөн шүгэл үлээгч нь гомдолд дурдсан мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулах, эсхүл олон нийтэд зарлах нь зөрчлийг илрүүлэхэд зайлшгүй шаардлагатай гэж үзсэн нь үндэслэлтэй тохиолдолд шүгэл үлээгч хариуцлага¹¹³ хүлээхгүй болно.

Шүгэл үлээгчийн мэдээлэлд дурдагдсан этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах тодорхой, зохистой арга хэмжээг авах үүргийг мэдээлэл шалгагч эрх бүхий этгээд Холбооны хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль (Federal Data Protection Act, 2017)-ийн дагуу хүлээдэг. Хуулийн хамгаалагдах хүрээнд шууд ороогүй ч шүгэл үлээгчид тусалсан этгээд буюу бусад хамгаалагдах этгээд (other protected person) гэх ойлголтыг хуулиар тодорхойлсон. Уг этгээд нь дараах нөхцөлийг хангавал хуулийн хамгаалалтын хүрээнд ордог. Үүнд:

- мэдээлэл нь үнэн байх, эсхүл шүгэл үлээгчийн өгсөн, нийтэд илчилсэн мэдээлэл үнэн гэж үзэх үндэслэл тухайн үед байсан;
- мэдээлэл нь энэхүү хуулийн зохицуулалтын хүрээнд хамаарах зөрчлийн тухай байх, эсхүл мэдээлэл нь уг хуулийн үйлчлэлийн хүрээнд хамаарна гэж үзэх үндэслэл тухайн үед шүгэл үлээгчид тусалсан этгээдэд байсан¹¹⁴.

Дээрх хоёр нөхцөлийн аль нэгийг хангаж байвал тухайн этгээдийг хамгаалах юм. Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдийг 50,000 хүртэлх

¹⁰⁹ *Ibid*, art. 8.1.

¹¹⁰ *Ibid*, art. 36.

¹¹¹ *Ibid*, art. 37.

¹¹² *Ibid*, art. 33.1.

¹¹³ *Ibid*, art. 35.2.

¹¹⁴ *Ibid*, art. 34.

евроогоор торгодог байна¹¹⁵. Мөн ХБНГУ-д шүгэл үлээгчийг урамшуулах тухай хуулийн зохицуулалт байхгүй боловч тухайн байгууллага дотоод дүрэм, журмаараа урамшууллын тогтолцоог бий болгох бүрэн боломжтой юм.

6.5. Япон Улс

Япон улс нь авлигын гэмт хэргийг Эрүүгийн хуулийн¹¹⁶ 197, 198 дугаар зүйлээр зохицуулдаг. Эрүүгийн хуульд заасан бүхий л гэмт хэрэг болон бусад хууль тогтоомжид заасан асуудлаар шүгэл үлээх харилцааг Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуулиар зохицуулж байна. Тус хуулийг 2004 онд баталж, 2006 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн. Уг хуулийн зорилго нь шүгэл үлээгчийг шүгэл үлээсэн болон түүнд холбогдох бусад үндэслэлээр ажлаас халах болон зохисгүй харьцахыг хориглох, аж ахуйн нэгж (enterprise) болон захиргааны байгууллагаас¹¹⁷ шүгэл үлээлтийн талаар авах арга хэмжээ болон бусад төстэй үйлдлийг зохицуулах, түүнчлэн иргэдийн амь нас, аж амьдрал (wellbeing), эд хөрөнгө болон бусад ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой хууль, дүрэм журмын дагуу үйл ажиллагаа явуулахыг дэмжих замаар иргэдийн амьдралыг тогтворжуулах, түүнчлэн эрүүл нийгэм болон эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулахад оршино¹¹⁸.

Уг хуулиар авлигын гэмт хэрэгт шүгэл үлээхтэй холбогдох харилцааг зохицуулдаг. Ингэхдээ аливаа хувь хүн, хуулийн этгээд бус байгууллага дотроосоо буюу уг байгууллагын ажилтан гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлэх асуудлыг зохицуулж байгааг онцлох нь зүйтэй. Шүгэл үлээгч гэж шүгэл үлээсэн ажилтныг хэлнэ¹¹⁹ хэмээн тодорхойлсон ба дараах этгээд нь шүгэл үлээх боломжтой байдаг. Үүнд¹²⁰:

- ажилтан¹²¹, байнгын ажилтан, цагийн ажилтан, илгээгдсэн ажилтан¹²²(dispatched worker), зарим тохиолдолд төрийн албан хаагч;

¹¹⁵ Andre Appel, “Germany’s New Whistleblower Protection Act: What Employers Need to Know” (August 28, 2023), <https://ogletree.com/insights-resources/blog-posts/germanys-new-whistleblower-protection-act-what-employers-need-to-know/>.

¹¹⁶ Japan, Penal Code (Act No. 45 of 1907), Last Version : Act No. 72 of 2017, art. 197,198, <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3581/en>.

¹¹⁷ Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хууль (2004)-ийн 2 дүгээр зүйлийн 2.4 дэх хэсэг “Захиргааны байгууллага” гэж Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Эзэн хааны гэр бүлийн агентлаг, (Засгийн газрын Хэрэг эрхлэх тухай хууль (1999)-ийн 49 дүгээр зүйлийн 49.1 эсхүл 49.2 дох хэсэг) Дижитал агентлаг, (Үндэсний засгийн газрын тухай хууль (1948)-ийн 3 дугаар зүйлийн 3.2 дох хэсэг) хуульд заасны дагуу байгуулагдсан, Засгийн газрын харьяанд ажилладаг байгууллагууд, эдгээр байгууллагуудын дотроо байгуулагдсан нэгжүүд, эсвэл дээр дурдсан байгууллагын хуульд заасны дагуу эрх мэдлээ бие даан хэрэгжүүлэх эрхтэй ажилтнууд болон орон нутгийн засаг захиргааны байгууллага.

¹¹⁸ Japan, Whistleblower Protection Act (Act No. 122 of 2004), Last Version : Act No. 70 of 2017, art. 1, <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3362/en>.

¹¹⁹ Japan, Whistleblower Protection Act (Act No. 122 of 2004), Last Version : Act No. 70 of 2017, art. 2.2, <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3362/en>.

¹²⁰ Ibid, art. 2.1.

¹²¹ Japan, Labor Standards Act (Act No. 49 of 1947), Last Version : Act No. 13 of 2020, art 9, Хөдөлмөр стандартын тухай хууль (1947)-ийн 9 дүгээр зүйл “ажилтан” гэж тухайн аж ахуйн нэгжид ажиллаж, ямар ч төрлийн мэргэжил, албан тушаалаас үл хамааран цалин авдаг хүнийг хэлнэ, <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/4913>.

¹²² Japan, Act on Securing the Proper Operation of Worker Dispatching Businesses and Protecting Dispatched Workers (Act No. 88 of 1985) , Last Version : Act No. 37 of 2019, art. 4, <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/4014/en> .

- тэтгэвэрт гарсан хүн;
- гэрээт байгууллагын ажилтан (worker of client enterprise);
- албан тушаалтан (officer).

Шүгэл үлээж буй этгээд нь дараах үйлдлийн талаар мэдээллэнэ. Үүнд¹²³, хүний амь нас, эрүүл мэнд, сайн сайхан байдлыг хамгаалах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, байгаль орчныг хамгаалах, шударга өрсөлдөөнийг хангах, иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө болон хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахтай холбогдсон энэ хууль болон бусад холбогдох хууль тогтоомж¹²⁴-ид заасан гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эсхүл иргэний торгууль (civil fine) ногдуулахаар заасан бусад үндэслэл болон үүнтэй холбоотойгоор гаргасан шийдвэр зэрэг болно.

Үүнээс харахад, Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуульд авлигын талаар шүгэл үлээх тухайлсан заалт ороогүй ч Эрүүгийн хууль болон бусад хууль тогтоомжийн зөрчлийг илчлэх үйлдлийг шүгэл үлээх гэж үздэг тул авлигын гэмт хэрэг нь уг хуулийн хамгаалалтад багтдаг байна. Хуульд заасны дагуу, доор дурдсан үндэслэлээр шүгэл үлээгчтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээгээ цуцлах, түүнд сөрөг нөлөө бүхий арга хэмжээ авах нь хүчингүйд тооцогдоно. Үүнд¹²⁵:

1. *Байгууллага эсхүл компанийн доторх нэгжид мэдээлэх*: Шүгэл үлээгч нь гэмт хэрэг, зөрчил гарсан эсхүл гарах гэж байгаа тухай мэдээлэл хүлээн авах этгээд эсхүл үйлчилгээг хүлээн авагч (recipient of services)-д мэдэгдсэн бол;
2. *Захиргааны байгууллагад мэдээлэх*: Шүгэл үлээгч нь гэмт хэрэг, зөрчил гарсан, эсхүл гарах гэж байгаа гэж үзэх үндэслэлтэй бол түүнд холбогдох нотлох баримт (цахим арга, соронзон арга эсхүл хүний мэдрэхүйгээр танигдах боломжгүй бусад арга)-ыг холбогдох захиргааны байгууллагад гаргасан бол¹²⁶;
3. *Гуравдагч этгээдэд мэдээлэх*: Шүгэл үлээгч нь гэмт хэрэг, зөрчил гарсан эсхүл гарах гэж байгаа гэх үндэслэлтэй бөгөөд дараах нөхцөлүүдийн аль нэгэнд

¹²³ Japan, Whistleblower Protection Act (Act No. 122 of 2004), Last Version : Act No. 70 of 2017, art. 2.3, <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3362/en>.

¹²⁴ Food Sanitation Act (Act No. 233 of 1947) , <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/5024>, Financial Instruments and Exchange Act (Act No. 25 of 1948) , <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/4633>, Act on Japanese Agricultural Standards (Act No. 175 of 1950) , <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/4484>, Air Pollution Control Act (Act No. 97 of 1968) , <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/4601>, Act on Waste Management and Public Cleaning (Act No. 137 of 1970) , https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/4529/en?utm_source=chatgpt.com, Act on the Protection of Personal Information (Act No. 57 of 2003) , <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/130/en>, Өмнөх заалтад дурдсан зүйлсээс гадна, Засгийн газрын тогтоолоор заасан, хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, байгаль орчныг хадгалах, шударга өрсөлдөөнийг хамгаалах, иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө болон бусад эрх ашгийг хамгаалахтай холбоотой хуулиуд.

¹²⁵ Japan, Whistleblower Protection Act (Act No. 122 of 2004), Last Version : Act No. 70 of 2017, art. 3, <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3362/en>.

¹²⁶ Захиргааны байгууллагад мэдээлэхийн тулд шүгэл үлээгч нь дараах мэдээллийг бүрэн гаргаж өгнө. Үүнд: шүгэл үлээгчийн нэр, хаяг, оршин суугаа газар; мэдээлэх үйл баримтын дэлгэрэнгүй; мэдээлэх үйл баримт нь гарсан эсхүл гарах гэж байгаа гэж үзэх үндэслэл; мэдээлэх үйл баримтын үндсэн дээр хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авах шаардлагатай гэж үзсэн үндэслэл зэрэг болно.

хамаарах бол тухайн үйл баримтаас гарч болох хохирол, эсхүл үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор аливаа этгээдэд илчлэх боломжтой:

- a) шүгэл үлээгч нь өмнөх 2 заалтын дагуу шүгэл үлээвэл үндэслэлгүйгээр хөдөлмөрийн гэрээг цуцлах, эсхүл бусад сөрөг нөлөө бүхий байдал бий болно гэж үзэж байвал;
- b) шүгэл үлээгч нь байгууллага эсхүл компанийн доторх нэгжид мэдээллэвэл түүнд холбогдох нотлох баримтыг нуун дарагдуулах, хуурамчаар үйлдэх, эсхүл өөрчлөх үндэслэлтэй гэж үзэж байвал;
- c) шүгэл үлээгч нь байгууллага эсхүл компанийн доторх нэгжид мэдээллэвэл шүгэл үлээсэн этгээдийг тодорхойлох боломжтой буюу мэдээллийг задруулна гэж үзэж байвал;
- d) шүгэл үлээх гэж буй этгээдэд шүгэл үлээхгүй байхыг байгууллага эсхүл компанийн доторх нэгж болон захиргааны байгууллагаас шаардсан тохиолдолд;
- e) байгууллага эсхүл компанийн доторх нэгжид мэдээллэснээс хойш 20 хоног өнгөрсөн ч шүгэл үлээсэн этгээдэд мөрдөн шалгах ажиллагаа эхэлсэн тухай мэдэгдээгүй, эсхүл шүгэл үлээсэн үйл баримтыг үндэслэлгүйгээр мөрдөн шалгаагүй тохиолдолд;
- f) шүгэл үлээсэн этгээдийн мэдээлж буй үйл баримтаас үүдэн хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол үүссэн эсхүл үүсэх эрсдэл байгаа гэж үзэж байвал.

Шүгэл үлээгчид сөрөг нөлөө үзүүлэхийг доор дурдсаны дагуу хориглодог. Үүнд¹²⁷:

1. шүгэл үлээсэн гэх үндэслэлээр албан тушаал болон цалинг бууруулах, тэтгэвэр тэтгэмж олгохоос татгалзах болон бусад байдлаар сөрөг нөлөө үзүүлэх;
2. шүгэл үлээсэн гэх үндэслэлээр илгээгдсэн ажилтныг өөр ажилтнаар солихыг тухайн ажилтныг илгээсэн аж ахуйн нэгжээс шаардах болон бусад байдлаар сөрөг нөлөө үзүүлэхийг хориглоно.

Дээрх зохицуулалтаас харахад, шүгэл үлээгчийг шүгэл үлээсэн гэх үндэслэлээр ажлаас халахыг хориглохоос гадна эдийн засгийн болон нийгмийн дарамт шахалт, түүнчлэн хохирол учруулах үйлдлийг мөн адил хориглодог.

Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуульд шүгэл үлээж буй этгээдийг хамгаалах талаар зохицуулсан байдаг. Тодруулбал, шүгэл үлээгчээс гаргасан мэдээлэлтэй холбоотой үйл ажиллагаанд оролцож байгаа эсхүл оролцож байсан хүн нь шүгэл үлээсэн этгээдийг илрүүлэх боломжтой аливаа мэдээллийг үндэслэлгүйгээр задруулахгүй байх үүргийг хүлээсэн ба үүнийг зөрчиж задруулсан бол 300,000 иенээс илүүгүй торгууль оногдуулахаар хуульчилсан байдаг.¹²⁸ Түүнчлэн Ерөнхий сайд нь аж ахуйн нэгжээс (enterprise) тайлан/илтгэх хуудас (report)-ыг шаардах эрхтэй. Уг тайланг гаргаж өгөөгүй, эсхүл хуурамч тайлан гаргасан этгээдэд 200,000 иенээс хэтрэхгүй торгууль ногдуулдаг байна¹²⁹.

¹²⁷ Japan, Whistleblower Protection Act (Act No. 122 of 2004), Last Version : Act No. 70 of 2017, art. 5, <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3362/en>.

¹²⁸ *Ibid*, art. 21.

¹²⁹ *Ibid*, art. 22.

6.6. Сингапур Улс

Сингапур улс нь авлигын гэмт хэргийн талаар шүгэл үлээх асуудлыг Авлигын эсрэг хууль (Prevention of Corruption, 1960); Эрүүгийн хууль (Penal code, 1871) болон салбарын тусгай дүрэм, журмуудаар тус тус зохицуулдаг бөгөөд шүгэл үлээгчийг хамгаалах тухай бие даасан хууль байхгүй байна.

Авлигын эсрэг хуулийн 36 дугаар зүйлд авлигын гэмт хэргийн талаар мэдээлэл өгч байгаа этгээд (informant)-ийг хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулжээ.

36 дугаар зүйл. Мэдээлэгчийг хамгаалах

(1) Энэ хуулийн хүрээнд хамаарах зөрчлийн талаарх гомдлыг дор дурдсанаас бусад тохиолдолд иргэний болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримтад тооцохгүй. Гэрч нь мэдээлэгчийн нэр, хаягийг задруулах, эсхүл түүнийг илчлэгдэхэд хүргэх аливаа баримтыг дэлгэхийг, бусад этгээд, гэрчээс тийнхүү шаардахыг хориглоно.

(2) Иргэний болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх аливаа ажиллагаанд нотлох баримтад тооцсон, эсхүл хяналт шалгалт хийх аливаа ном, баримт бичиг, цаасан эх сурвалж дээр мэдээлэгчийг нэрлэсэн, тодорхойлсон, эсхүл түүнийг илчлэхэд хүргэж болзошгүй мэдээллийг агуулсан тохиолдолд, тухайн хэргийг хянан шийдвэрлэж буй шүүх нь мэдээлэгчийг хамгаалахад шаардлагатай хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр эдгээр хэсгийг нууцлах, эсхүл баллах арга хэмжээ авна.

(3) Хэрэв энэ хуулийн хүрээнд гэмт хэргийг шүүх хянан шийдвэрлэх явцад тухайн мэдээлэгч өөрийн гомдлыг худал болохыг мэдэж байсан эсхүл эргэлзээтэй байхад мэдээлсэн гэж шүүх дүгнэсэн, эсхүл талуудын хооронд шударга ёсыг бүрэн тогтоохын тулд мэдээлэгчийг илчлэх зайлшгүй шаардлагатай гэж үзсэн тохиолдолд, шүүхээс мэдээлэгчийг илчлэх, шалгахыг зөвшөөрч болно.

Дээрхээс харвал, мэдээлэгчийг хамгаалахдаа түүний хувийн мэдээллийг нууцалж, иргэний болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримтад тооцохгүй байх зэргээр хамгаалжээ. Харин гомдлыг ямар байгууллагад гаргаж, хэрхэн хянан шийдвэрлэх талаар зохицуулаагүй байна.

Түүнчлэн мэдээлэгчийн нэр, хувийн мэдээллийг гагцхүү цаасан хэлбэртэй баримт бичиг дээр нууцалж байгаа нь цахимаар түүний мэдээллийг хамгаалах механизм сул байгааг харуулж байна. Энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах тохиолдолд мэдээлэгчийг хамгаалах боломжгүй байгааг онцлох нь зүйтэй.

Зарим байгууллага дотоод журмаараа шүгэл үлээгч (whistleblower)-ийг тодорхойлж түүнийг хамгаалах зохицуулалтыг оруулжээ. Тухайлбал, “шүгэл үлээх” гэдэг нь байгууллагын ажилтан эсхүл бусад оролцогчийн (other stakeholder) зүгээс тухайн байгууллагад болон нийтийн ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй зөрчил, буруутай үйл ажиллагааны талаар сайн санааны (good faith) үүднээс мэдээлэхийг хэлнэ. Хувь хүний шинжтэй гомдлыг шүгэл үлээх гэж үзэхгүй¹³⁰ гэжээ.

Дээрхээс харвал, шүгэл үлээгчид тухайн байгууллагын ажилтан, эсхүл бусад хамаарал бүхий этгээд хамаарна. Шүгэл үлээх гэдэг нь тухайн байгууллагын дотоод үйл ажиллагаа бөгөөд гадны хэн нэгэн этгээд байгууллагын доторх зөрчлийн талаар шүгэл үлээх боломжгүй байдаг. Харин мэдээлэгч мэдээлэл гаргахад тухайн байгууллагын ажилтан байх шаардлага тавигддаггүй бөгөөд аливаа зөрчлийн талаар олж мэдсэн хэн боловч мэдээлэх боломжтой.

¹³⁰ The Institute of Internal Auditors Singapore, Whistle-blowing policy and procedures, A Guide for Charities and Institutions of a Public Character, 2017, p.2.

Ийнхүү Сингапур улсын хувьд мэдээлэгч болон шүгэл үлээгчийн аль аль нь авлигын талаар мэдээллийг өгөх боломжтой байна. Авлигын талаар мэдээлэх нь дан ганц байгууллагын дотоод зөрчил, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг илрүүлэхээс өргөн цар хүрээтэй асуудал учраас Авлигын эсрэг хуульд шүгэл үлээгч (whistleblower) бус мэдээлэгч гэх нэр томьёог хэрэглэсэн нь оновчтой гэж үзэж байна.

Авлигатай холбогдох асуудлыг мөрдөн шалгадаг гол байгууллага нь Авлигын хэрэг мөрдөн шалгах товчоо (Corrupt Practices Investigation Bureau, CPIB) бөгөөд Ерөнхий сайдын харьяа бие даан үйл ажиллагаагаа явуулдаг. Иргэн, албан хаагч нийтийн болон хувийн салбар дахь авлигын талаар CPIB-д мэдээлэлдэг¹³¹. Түүнчлэн цагдаагийн байгууллага болон үйл ажиллагааны чиглэлээр нь дагнан банк, санхүүгийн гүйлгээ, өрсөлдөөнтэй холбоотой тохиолдлуудыг CCCS (Competition and Consumer Commission of Singapore) гэх мэт тусгай байгууллагад мэдээлэх боломжтой¹³². Бүх хувийн хэвшлийн байгууллага шүгэл үлээх тогтолцоотой байх шаардлагагүй ч санхүүгийн байгууллагын хувьд шүгэл үлээх харилцааг зохицуулсан байх нь зүйтэй¹³³ гэж үздэг.

CPIB-д мэдээлэхдээ түүний албан ёсны цахим хуудас, утас, и-мэйл, захидал, факсаар дамжуулан, эсхүл биечлэн очиж мэдээлэх хэлбэрээс сонгоно. Эрх бүхий ажилтан мэдээллийг хүлээн аваад үнэлж, шаардлагатай тохиолдолд мөрдөн шалгалтыг эхлүүлнэ. Үүний үр дүнд хэргийн нөхцөл байдлыг олж тогтоон хариуцлагыг буруутай этгээдэд хүлээлгэх, эсхүл хэргийг холбогдох хууль хяналтын байгууллагад шилжүүлдэг¹³⁴ байна. Хэрэв шүгэл үлээгч нь шударгаар (in good faith) мэдээлэл өгсөн бол үнэн эсэхээс үл хамааран хариуцлага хүлээлгэхгүй. Харин санаатайгаар худал мэдээлэл өгсөн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээх боломжтой¹³⁵ байдаг.

Мэдээлэгчийг хамгаалахдаа түүний нэр, гэрийн хаягийг нууцалж, хувийн мэдээллийг олж тогтоохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаг¹³⁶. Түүнчлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтыг шалгах бол шүүх мэдээлэгчийн биеийн байцаалтыг нотлох баримт дээрээс устгаж нууцалдаг билээ. Харин мэдээлэгч санаатайгаар худал мэдээлсэн нь шүүхээс тогтоогдвол түүний хувийн мэдээллийг илчлэх боломжтой. Мөн зарим мэдээлэгчид хувийн мэдээллээ нууцлан мэдээлэл гаргаж болох тухай тусгасан байдаг ч энэхүү тохиолдолд мэдээлэгчээс тодруулга авах боломжгүй байдалд хүрэх, мэдээллийн найдвартай байдлыг сулруулах, мөрдөн байцаалтын ажиллагаанд саад учруулах зэрэг сул талтай байдаг¹³⁷.

¹³¹ "Prevention of Corruption Act" (2025), Last Updated 16 Oct 2025, <https://www.cpiib.gov.sg/about-corruption/legislation-and-enforcement/prevention-of-corruption-act/>.

¹³² Andreas Pyrczek, "Why trust is essential for whistleblowing programs to be effective", (27 Mar 2025), https://www.ey.com/en_sg/insights/forensic-integrity-services/why-trust-is-essential-for-whistleblowing-programs-to-be-effective.

¹³³ Lakshanthi Fernando, Wei Ming Tan, Os Agarwal, "Whistleblower protection and reporting channels in Singapore", (12 Jul 2023), Last updated: 12 Jul 2023, <https://cms.law/en/int/expert-guides/whistleblower-protection-and-reporting-channels/singapore>.

¹³⁴ "E-complaint for Corrupt Conduct", (2025), <https://www.cpiib.gov.sg/e-services/e-complaint-for-corrupt-conduct/>.

¹³⁵ "E-complaint for Corrupt Conduct" (2025), <https://www.cpiib.gov.sg/e-services/e-complaint-for-corrupt-conduct/>.

¹³⁶ Prevention of Corruption, Act 1960, 2020 revised edition, art. 36, <https://sso.agc.gov.sg/Act/PCA1960>.

¹³⁷ "Laws Protecting Informers/ Whistleblowers in Singapore", (2024), Last updated on December 5, 2024, <https://singaporelegaladvice.com/law-articles/laws-protecting-informers-whistleblowers-singapore/>.

Зарим төрийн байгууллага ажилтнуудаа ялгаварлан гадуурхалт, хэлмэгдүүлэлт болон бусад сөрөг үр дагавраас эмээхгүйгээр зөрчлийн талаарх мэдээлэх нөхцөлөөр хангахын тулд бие даасан дотоод аудитын албыг ажиллуулдаг¹³⁸. Уг албанд цахим маягт бөглөх, и-мэйл, захидал илгээх зэргээр мэдээллээ гаргадаг.

Хууль тогтоомжид мэдээлэгчийг урамшуулах зохицуулалт байхгүй боловч салбарын онцлогоос хамааран зарим байгууллагууд мэдээлэгчийг урамшуулах тохиолдол бий. Тухайлбал, Картель, өрсөлдөөний эсрэг хууль зөрчсөн үйлдлийг илрүүлэхэд мэдээлсэн үйл баримт нь ихээхэн тусалсан буюу мөрдөн шалгах ажиллагаанд тус болохуйц нотлох баримтаар хангасан байвал мэдээлэгч “CCCS Reward” гэж нэрлэгдэх урамшууллыг авдаг. Урамшууллын дээд хэмжээ нь SGD 120,000 хүртэл байдаг¹³⁹. Даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдтэй холбогдох хууль бус даатгалыг илрүүлэхэд мэдээллээр хангасан этгээдийг SGD 10,000 хүртэлх хэмжээгээр урамшуулдаг билээ. Түүнчлэн аливаа этгээд татвараас зайлсхийсэнтэй холбоотой мэдээлэл, баримт бичгийг гарган өгч, тухайн хүртсэн ашгийг буцаан төлүүлэх нөхцөл байдалд хүргэсэн бол урамшуулал авах хүсэлтээ Сингапур улсын татварын ерөнхий газар (Inland Revenue Authority of Singapore, IRAS)-т гаргах эрх нээгдэнэ. Хүсэлтийг шалган үзэж, үндэслэлтэй гэж үзвэл нөхөн төлөгдсөн татварын 15 хувиар /100,000 SGD хүртэлх/ мэдээлэгчийг урамшуулдаг байна¹⁴⁰.

6.7. Бүгд Найрамдах Солонгос Улс

БНСУ-д авлигын талаар шүгэл үлээхтэй холбоотой харилцааг дараах хууль тогтоомжоор зохицуулдаг байна. Үүнд:

- Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх болон иргэний зөрчигдсөн эрхийг хамгаалах комисс байгуулах, түүний үйл ажиллагааны тухай хууль (Act on the prevention of corruption and the establishment and management of the anti-corruption and civil rights commission, 2008)
- Нийтийн эрх ашгийн төлөө шүгэл үлээгчийг хамгаалах тухай хууль (Public interest whistleblower protection act, 2011)

Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх болон иргэний зөрчигдсөн эрхийг хамгаалах комисс байгуулах, түүний үйл ажиллагааны тухай хууль нь иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, дээрхээр дамжуулж захиргааны тогтолцоог сайжруулах, авлигыг таслан зогсоох зорилгоор авлигатай тэмцэх болон иргэний зөрчигдсөн эрхийг хамгаалах комиссыг байгуулах, иргэдийн үндсэн эрх, эрх ашгийг хамгаалах, нийтийн үйлчилгээг зохистой хэрэгжүүлэх, төрийн алба болон нийгэмд шударга орчныг бүрдүүлэх зорилгын хүрээнд 8 бүлэг 91 зүйлтэйгээр хэрэгжиж байна.¹⁴¹

Дээрх хэсэгт дурдагдаж буй Авлигатай тэмцэх болон иргэний зөрчигдсөн эрхийг хамгаалах комисс буюу Anti-corruption & Civil Rights Commission нь 2008 оны 02 дугаар

¹³⁸ Ibid.


¹³⁹ “Reward/whistle-blowing Scheme”, (2025), Last updated 26 September 2025, <https://www.cccs.gov.sg/get-in-touch/for-businesses/reward---whistle-blowing-scheme>.

¹⁴⁰ “Laws Protecting Informers/ Whistleblowers in Singapore”, (2024), Last updated on December 5, 2024, <https://singaporelegaladvice.com/law-articles/laws-protecting-informers-whistleblowers-singapore/>.

¹⁴¹ Act on the Prevention of Corruption and the Establishment and Management of the Anti-corruption and Civil Rights Commission (2008), Act No. 20712, Jan. 21, 2025, art. 1, https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=69417&lang=ENG.

сарын 29-ний өдөр БНСУ-ын Омбудсман¹⁴², Авлигын эсрэг бие даасан комисс¹⁴³, Захиргааны хэргийн давж заалдах комисс¹⁴⁴ гэх гурван байгууллагыг нэгтгэн байгуулагдсан.¹⁴⁵ Комиссын гишүүдийн хувьд комиссын дарга, гурван дэд дарга, гурван байнгын гишүүн, найман байнгын бус гишүүн бүхий арван таван хүнээс бүрдэнэ.¹⁴⁶ Гурван дэд даргын хувьд доорх чиглэлээр комиссын даргад туслалцаа үзүүлж ажилладаг.

Зураг 7. БНСУ-ын Авлигатай тэмцэх болон иргэний зөрчигдсөн эрхийг хамгаалах комиссын бүтэц, зохион байгуулалт



Авлигын эсрэг хяналт, хамгаалалтын товчоо нь авлигын үйлдлийн талаар мэдээллийг хүлээн авч шийдвэрлэх, шүгэл үлээгчийг хамгаалах, урамшуулахтай холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Товчоо болгон тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн хэлтсүүдээс бүрдэнэ.

Тухайлбал, хяналт хамгаалалтын товчоонд хамаарах Авлигын хяналт, шалгалтын хэлтэс нь:¹⁴⁷

- мэдээллийн үндэслэл, зорилго, нотлох баримт байгаа эсэх зэрэг мэдээллийн дэлгэрэнгүйг шалгах;
- мэдээллийг нотлоход шаардлагатай нэмэлт баримт бичгийг шаардах;
- мэдээллийн комиссоор хэлэлцэх асуудлуудыг бэлтгэх. Тухайлбал, холбогдох байгууллагад шилжүүлэх;

¹⁴² Захиргааны байгууллага болон түүний албан тушаалтан бүрэн эрхээ урвуулан ашиглах, хэтрүүлэн хэрэглэх явдлаас үүдэн иргэний эрх, эрх чөлөөг зөрчихөөс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг зохистой хяналт, зохицуулалтад байлгах, мөн эрхийн зөрчлийг шийдвэрлэхээс гадна институцийн өөрчлөлт, сайжруулалтыг дэмжихэд чиглэсэн институцийн тогтолцоо юм.

¹⁴³ “БНСУ-ын авлигатай тэмцэх болон иргэний зөрчигдсөн эрхийг хамгаалах комисс нь тус улсын авлигын эсрэг бодлого, тогтолцоог боловсруулан хэрэгжүүлэхийн зэрэгцээ шударга ёсны соёлыг түгээн дэлгэрүүлэх, шударга ёсны боловсрол олгох замаар авлигаас урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг, авлигын эсрэг хяналтын төв байгууллага юм.”

¹⁴⁴ Захиргааны байгууллагуудын хууль бус, шударга бус шийдвэрийн улмаас иргэдийн эрх, ашиг сонирхлын зөрчлөөс нэмэлт зардалгүйгээр, шуурхай, шударга журмын дагуу чөлөөлөхөд чиглэсэн хагас шүүх ажиллагаа юм.

¹⁴⁵ ACRC, “Taking a Big Stride Forward on Transparency & Civil Rights”, p.4 https://files.acquia.undp.org/public/migration/seoul_policy_center/d322267f349e7d876cea6f448e734bd36f569cb9846f1d7a3bb207c2203965f1.pdf.

¹⁴⁶ Ibid.

¹⁴⁷ Anti-Corruption & Civil Rights Commission, <https://www.acrc.go.kr/menu.es?mid=a20103000000>.

- шилжүүлсэн хэргүүдийг хүлээн авч, дүн шинжилгээ хийж, мөрдөн байцаалтын үр дүнг мэдээлэл гаргагчид мэдэгдэх, шаардлагатай тохиолдолд дахин мөрдөн байцаалт явуулах хүсэлт гаргах чиг үүрэгтэй байна.

Хамгаалалт, урамшууллын бодлогын хэлтэс нь:

- нийтийн эрх ашгийн төлөө шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуульд заасан шүгэл үлээгчийн хамгаалах, нөхөн төлбөр олгох тогтолцоог бий болгон хэрэгжүүлэх;
- шүгэл үлээгчийг хамгаалах, нөхөн олговор олгох тогтолцооны талаар олон нийтэд сурталчлах;
- нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээх тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх, сурталчлах.

Шүгэл үлээгчийг хамгаалах хэлтэс нь:

- шүгэл үлээгчийн хамгаалах талаар зөвлөгөө, чиглэл өгөх;
- шүгэл үлээгчийг хариуцлагаас чөлөөлөх, сөрөг арга хэмжээ авахаас хамгаалах санал гаргах;
- шүгэл үлээгч болон холбоотой этгээдүүдэд хувийн хамгаалалтын арга хэмжээ авах хүсэлт гаргах;
- шүгэл үлээгчийн хувийн мэдээлэл задруулсантай холбоотой асуудлыг шалган шийдвэрлэх үүрэгтэйгээр тус тус үйл ажиллагаагаа явуулж байна.

Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх болон иргэний зөрчигдсөн эрхийг хамгаалах комисс байгуулах, түүний үйл ажиллагааны тухай хуульд авлигын үйлдлийн талаар мэдсэн хүн бүр авлигатай тэмцэх болон иргэний зөрчигдсөн эрхийг хамгаалах комисст мэдэгдэж болно.¹⁴⁸ Харин нийтийн албан тушаалтны хувьд албан үүргээ гүйцэтгэх явцдаа авлигын үйлдлийн талаар мэдсэн, эсхүл өөр нийтийн албан тушаалтан авлигын үйлдэл хийхийг албадсан, санал болгосон тохиолдолд мөрдөн байцаах байгууллага, Аудит болон хяналт шалгалтын хороо, Авлигатай тэмцэх болон иргэний зөрчигдсөн эрхийг хамгаалах комисст (цаашид “комисс” гэх) нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.¹⁴⁹ Иймд авлигын үйлдлийн талаар эрх бүхий байгууллагад мэдэгдэж байгаа этгээдийг “мэдээлэл гаргагч (reporting person)” гэж тодорхойлж байна. Авлигын үйлдэл гэдэгт¹⁵⁰:

- нийтийн албан тушаалтан өөртөө болон гуравдагч этгээдэд ашиг хонжоо хайж, өөрийн албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашигласан, хууль тогтоомжийг зөрчсөн үйлдэл;
- нийтийн эрх зүйн этгээдийн буюу public institution төсвийг зохицуулах, нийтийн эрх зүйн этгээдийн өмч хөрөнгийг худалдаж авах, удирдах, ашиглах буюу шилжүүлэх, нийтийн эрх зүйн этгээдийн талаас гэрээг байгуулж хэрэгжүүлэх үедээ хууль тогтоомж дүрэм журмыг зөрчиж нийтийн эрх зүйн этгээдийн өмч хөрөнгөд хохирол учруулах үйлдэл;
- а болон б зүйлд заасан аливаа үйлдлийг албадах, ятгах, санал болгох, өдөөн хатгах үйлдлийг ойлгоно.

¹⁴⁸ Act on the Prevention of Corruption and the Establishment and Management of the Anti-corruption and Civil Rights Commission (2008), Act No. 20712, Jan. 21, 2025, art. 55, https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=69417&lang=ENG.

¹⁴⁹ *Ibid* (2008), art. 56.

¹⁵⁰ *Ibid* (2008), art. 2(4).

Харин нийтийн албан тушаалтан гэдэгт дараах хүмүүсийн аль нэгийг ойлгоно.¹⁵¹Үүнд:

- Улсын нийтийн албан тушаалтны тухай хууль буюу State Public Officials Act болон орон нутгийн нийтийн албан тушаалтны тухай хуулийн буюу Local Public Officials Act дагуух нийтийн албан тушаалтан, бусад хуулиар мэргэшил, томилгоо, боловсрол болон сургалт, албан үүргийн гүйцэтгэл, цалин хөлс, эрх зүйн баталгааны хувьд нийтийн албан тушаалтан гэж хүлээн зөвшөөрөгдсөн этгээд;
- Төрийн үйлчилгээний байгууллагын захирал болон тус байгууллагын ажилтан;
- Төрөл бүрийн түвшний хувийн сургуулийн захирал, ажилтнууд мөн бага, дунд боловсролын тухай хууль, дээд боловсролын тухай хууль, сургуулийн өмнөх боловсролын тухай хууль болон бусад хууль, дүрмийн дагуу байгуулагдсан бүх шатны хувийн сургууль, мөн төрөөс эсхүл орон нутгийн засаг захиргаанаас санхүүгийн дэмжлэг авдаг хувийн сургуулийн тухай хуулийн дагуу байгуулагдсан сургуулийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд хамаарна. Гэхдээ энэ хэсэгт хамаарах этгээдүүд нь тус хуулийн тавдугаар бүлэгт буюу авлигын үйлдлийг мэдээлэх, хамгаалалт авахтай холбоотой зохицуулалт дээр л нийтийн албан тушаалтанд хамаарна.

Улсын нийтийн албан тушаалтны тухай хуульд нийтийн албан тушаалтныг дараах байдлаар ангилжээ.¹⁵² Нийтийн албан тушаалтныг байнгын албаны нийтийн албан тушаалтан (public officials in career service) болон түр албаны нийтийн албан тушаалтан (public officials in non-career service) гэж хоёр ангилсан байна. Байнгын албаны нийтийн албан тушаалтан гэж мэргэшил, ерөнхий ур чадварын шалгуураар томилогдсон, эрх зүйн баталгаатай бөгөөд насан туршдаа нийтийн албан тушаалд байх албан тушаалтныг хэлнэ. Байнгын албаны нийтийн албан тушаалтнуудыг мөн дараах байдлаар ангилдаг.

- *Ерөнхий албаны нийтийн албан тушаалтан*- техникийн болон судалгааны ажил, эсхүл ерөнхий захиргааны ажил эрхэлдэг нийтийн албан тушаалтан хамаарна.
- *Тусгай албаны нийтийн албан тушаалтан*- шүүгч, прокурор, гадаад харилцааны ажилтан, цагдаа, онцгой байдлын алба, боловсролын албан тушаалтан, зэвсэгт хүчний гишүүн, цэргийн албаны ажилтан, үндсэн хуулийн цэцийн илтгэгч шүүгчид, тагнуулын ерөнхий газрын ажилтан, аюулгүй байдлын ажилтан болон бусад хуульд тусгай албаны нийтийн албан тушаалтан гэж заасан этгээд.

Түр албаны нийтийн албан тушаалтан гэж тогтмол албаны ангилалд хамаарахаас бусад нийтийн албан тушаалтныг хэлнэ. Тус албан тушаалтныг дараах байдлаар ангилна.

- *Улс төрийн албаны нийтийн албан тушаалтан*
 - Сонгуулиар сонгогддог эсхүл Улсын Их Хурлын зөвшөөрлөөр томилогддог албан тушаалтан;

¹⁵¹ Ibid (2008), art. 2(3).

¹⁵² State public officials act (1949), Act No. 20627, Dec. 31, 2024, art. 2, https://elaw.klri.re.kr/kor_service/lawView.do?hseq=69197&lang=KOR.

- Бодлогын нарийн төвөгтэй шийдвэр гаргах эсхүл түүнийг дэмжих чиг үүргийг хэрэгжүүлдэг бөгөөд хууль болон Ерөнхийлөгчийн зарлигаар (Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндэсний аюулгүй байдлын газрын зохион байгуулалтын тухай зарлигт хязгаарлагдан) улс төрийн албаны албан тушаалтанд хамааруулсан этгээд;
- *Тусгай үүргийн нийтийн албан тушаалтан*
 - Хууль, дүрмээр тусгай үүрэг гүйцэтгэх эсхүл тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан нийтийн албан тушаалтан.

Тусгай үүргийн нийтийн албан тушаалтны хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл, томилгооны журам, тус албанд ажиллах дээд насны хязгаар болон бусад шаардлагатай асуудлыг Парламентын дотоод журам, Дээд шүүхийн журам, Үндсэн хуулийн цэцийн журам, Сонгуулийн ерөнхий хорооны журам, эсхүл Ерөнхийлөгчийн зарлигаар тус тус тогтооно.

Манай улсын хувьд нийтийн албан тушаалтныг Авлигын эсрэг хуулийн 4.1-т тодорхойлсноор ойлгоно гэж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.4-т заажээ. Үүнд:

1. төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан;
2. төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан болон ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч;
3. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан;
4. олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал;
5. улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан;
6. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч;
7. бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч;
8. эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтад заасан албан тушаалтан;
9. Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 4.1.7-д заасан Ирээдүйн өв сан корпорацын эрх бүхий албан тушаалтан, хяналтын зөвлөлийн гишүүн.

БНСУ-ын хувьд улсын нийтийн албан тушаалтны тухай хууль болон орон нутгийн нийтийн албан тушаалтны тухай хуульдаа нийтийн албан тушаалтны ангиллыг нарийн тусгаж өгчээ. Мөн авлигын үйлдлийг мэдээлэх, мэдээлэл гаргагч хамгаалагдахтай холбоотойгоор төрөөс эсхүл орон нутгийн засаг захиргаанаас санхүүгийн дэмжлэг авдаг сургуулийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнуудыг нийтийн албан тушаалтанд хамруулснаараа онцлогтой байна.

Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх болон иргэний зөрчигдсөн эрхийг хамгаалах комисс байгуулах, түүний үйл ажиллагааны тухай хуулийн тавдугаар бүлэгт авлигын үйлдлийг мэдээлэх болон мэдээлэл гаргагчийг хамгаалах тухай зохицуулалтыг тусгаж өгсөн. Авлигын үйлдлийн талаар мэдээлэл гаргасан тохиолдолд дараах шат дарааллын дагуу мэдээллийг хянан шалгана. Үүнд:

1. Мэдээлэл гаргагч авлигын үйлдлийн талаар комисст мэдээлэл гаргана.
2. Комисс мэдээллийн үнэн эсэхийг баталгаажуулна.

3. Комиссын хүлээн авсан мэдээллийн дагуу мөрдөн шалгах ажиллагаа эсхүл хяналт шалгалт хийх шаардлагатай гэж үзвэл уг мэдээллийг мөрдөн шалгах байгууллага эсхүл аудит болон хяналт шалгалтын хороо, холбогдох нийтийн институцийн хяналтын байгууллагад шилжүүлнэ.
4. Мөрдөн шалгах байгууллага нь тус мэдээллийг хүлээн аваад мөрдөн шалгах ажиллагаа явуулна.
5. Мөрдөн шалгах байгууллага нь мөрдөн шалгах ажиллагаа дууссанаас хойш 10 хоногийн дотор комисст үр дүнгээ мэдэгдэх.
6. Комисс тус үр дүнг мэдээлэгчид мэдэгдэнэ. Хэрвээ мөрдөн шалгах байгууллагын хийсэн мөрдөн шалгах ажиллагаа хангалтгүй гэж үзвэл комисс тодорхой үндэслэлтэйгээр мөрдөн шалгах байгууллагад дахин мөрдөн шалгах ажиллагаа явуулах хүсэлт гаргаж болно.

Мэдээлэл гаргаж буй этгээд нь мэдээлэлдээ өөрийн хувийн мэдээлэл, мэдээлэл гаргаж буй зорилго, шалтгаан, авлигын гэмт хэргийн шинжтэй үйлдлийн нотлох баримтыг тусгана.¹⁵³ Комисс мэдээллийг хүлээн авч шалгаад, бодит байдлыг тогтооход шаардлагатай материалыг мэдээлэгчээс шаардах боломжтой. Хэрэв тус мэдээлэлд аудит болон хяналт шалгалт хийх шаардлагатай гэж үзвэл Аудит болон хяналт шалгалтын хороонд, гэмт хэрэгт сэжиглэх болон бусад үндэслэлээр эрүүгийн мөрдөн шалгах ажиллагаа шаардлагатай гэж үзвэл мөрдөн шалгах байгууллагад, Аудит болон хяналт шалгалтын хороо эсвэл мөрдөн шалгах байгууллагад шилжүүлэх нь тохиромжгүй бол холбогдох нийтийн институцийн хяналтын байгууллага (the supervisory body of the relevant public institution)-д шилжүүлнэ.¹⁵⁴

Хэрэв мэдээлэл нь дараах тохиолдлын аль нэгэнд хамаарах бол хяналтын байгууллагад шилжүүлэхгүйгээр хэргийг дуусгавар болгож болно. Үүнд:¹⁵⁵

1. мэдээллийн агуулга илт худал;
2. мэдээлэл гаргагчийн хувийн мэдээлэл тодорхойгүй;
3. мэдээлэл гаргагч нь хоёроос доошгүй удаа нэмэлт тайлбар, нотлох баримт бүрдүүлэхийг хүссэн Комиссын шаардлагыг хүлээн авсан боловч тогтоосон хугацаанд ирүүлээгүй бол;
4. мэдээлэл гаргагч нь шийдвэрлэсэн мэдээллийн үр дүнгийн талаар дахин үндэслэлгүйгээр дахин мэдээлэл гаргасан бол;
5. мэдээллийн агуулга хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдсан мэдээлэлд багтаж байгаа бөгөөд тус цацагдсан мэдээллээс өөр шинэ нотлох баримт олдоогүй бол;
6. бусад хууль тогтоомжийн дагуу авлигын холбогдох үйлдэлд мөрдөн шалгах ажиллагаа, хяналт шалгалт хийсэн буюу аль хэдийн шийдвэрлэгдсэн бол;
7. Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон авлигын үйлдэлд аудит, мөрдөн шалгах эсхүл хянан шалгах ажиллагаа явуулах шаардлагагүй бусад тохиолдол.

¹⁵³ Act on the Prevention of Corruption and the Establishment and Management of the Anti-corruption and Civil Rights Commission (2008), Act No. 20712, Jan. 21, 2025, art. 58, https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=69417&lang=ENG.

¹⁵⁴ Enforcement decree of the act on the prevention of corruption and the establishment and management of the anti-corruption and civil rights commission (2002), art 57(1), https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=68552&type=sogan&key=42.

¹⁵⁵ Act on the Prevention of Corruption and the Establishment and Management of the Anti-corruption and Civil Rights Commission (2008), Act No. 20712, Jan. 21, 2025, art. 59(3), https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=69417&lang=ENG.

Комисс нь мэдээллийг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор шийдвэрлэнэ. Мэдээллийг шалгахад нэмэлт хугацаа шаардлагатай гэж үзвэл 30 хүртэл хоногоор сунгаж болно.¹⁵⁶

Авлигын үйлдлийн талаар мэдээлэл гаргасан этгээдийг хамгаалах нь аливаа этгээд авлигын үйлдлийн талаар мэдээлэл гаргах тохиолдлыг нэмэгдүүлдэг тул мэдээлэгчийг хамгаалах тогтолцоог нийгэмд сурталчлах хэрэгтэй. БНСУ-ын хувьд мэдээлэл гаргагчийг хамгаалахын тулд Комиссоос дараах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

(i) Мэдээлэл гаргагчийн нууцлалыг хамгаалах

Мэдээлэгч өөрөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд мэдээлэл гаргагчийн хувийн мэдээллийг мэдэж байгаа хэн ч гуравдагч этгээдэд задруулах, эсхүл мэдээлэл гаргагчийн хэн болохыг таамаглахуйц баримт бичгийг ил болгохыг хориглоно.¹⁵⁷ Дээрх нөхцөлийг зөрчсөн тохиолдолд Комисс хувийн мэдээллийг хэрхэн задруулсан, ил болгосон талаар хянан шалгаад мэдээлэл гаргагчийн хувийн мэдээллийг ил болгосон этгээдэд сахилгын шийтгэл оногдуулах эрх бүхий этгээдэд зохих арга хэмжээ авах тухай хүсэлт гаргаж болно.¹⁵⁸

(ii) Хувийн хамгаалалтын арга хэмжээ авах

Мэдээлэл гаргасантай холбоотойгоор мэдээлэл гаргагчид өөрт нь болон түүний хамаатан садан, хамтран амьдрагчдынх нь бие махбодод аюул учирч байгаа бол мэдээлэл гаргагч нь хамгаалалтын арга хэмжээ авахаар комисст хүсэлт гаргаж болно. Энэ тохиолдолд комисс шаардлагатай гэж үзвэл БНСУ-ын Үндэсний цагдаагийн газрын ерөнхий комиссарт, харьяалах хот эсхүл дүүргийн цагдаагийн газрын комиссарт эсхүл харьяалах цагдаагийн газрын даргад хувийн хамгаалалтын арга хэмжээ авах хүсэлт гаргана.¹⁵⁹

Дээрх хүсэлтийг гаргахдаа мэдээлэл гаргагч болон хамгаалагдах этгээдийн хувийн мэдээлэл тус хүсэлтийг гаргах болсон үндэслэлээ бичгээр гаргана. Хэрэв яаралтай хүсэлт гаргах хэрэгцээ шаардлага тулгарсан бол амаар болон утсаар хүсэлт гаргаж болох ч дараа нь заавал бичгээр хүсэлтээ гаргах ёстой.¹⁶⁰

Мэдээлэл гаргагч болон хамгаалагдах этгээдэд хувийн хамгаалалтын арга хэмжээ авах шаардлагатай байгаа нь цаг хугацааны хувьд комисс шийдвэр гаргахад хүрэлцээгүй байгаа тохиолдолд комиссын дарга БНСУ-ын үндэсний цагдаагийн газрын ерөнхий комиссарт, харьяалах хот эсхүл аймгийн цагдаагийн газрын комиссарт эсхүл харьяалах цагдаагийн газрын даргад хувийн хамгаалалтын арга хэмжээ авах хүсэлт гаргана.¹⁶¹ Тус этгээдүүд хүсэлтийг хүлээн авмагцаа хувийн хамгаалах арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлнэ.

¹⁵⁶ Act on the Prevention of Corruption and the Establishment and Management of the Anti-corruption and Civil Rights Commission (2008), Act No. 20712, Jan. 21, 2025, art. 59(8), https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=69417&lang=ENG.

¹⁵⁷ *Ibid* (2008), art. 64(1).

¹⁵⁸ *Ibid* (2008), art. 64(4).

¹⁵⁹ *Ibid* (2008), art. 64-2(1).

¹⁶⁰ *Ibid* (2008), art 70(1).

¹⁶¹ *Ibid* (2008), 70(3).

(iii) Сөрөг арга хэмжээнээс хамгаалах¹⁶²

Мэдээлэл гаргасны улмаас ажлаас халах, албан тушаалаа алдах, эсхүл өөр байдлаар хохирол амссан тохиолдолд комисс нь түүний эрхийг сэргээх арга хэмжээ авахыг холбогдох байгууллагаас шаардаж болно.

БНСУ-ын хувьд авлигын үйлдлийн талаар мэдээлэл гаргасан этгээдийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг хууль тогтоомждоо тусгаснаас гадна мэдээлэл гаргасан этгээдийг шагнаж урамшуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг мөн тусгасан байна.

Хэрэв мэдээлэл гаргаснаар улсын сангаас алдагдсан хөрөнгийг эргүүлсэн авсан, нийтийн институцийн орлого нэмэгдсэн, зардлыг бууруулахад шууд нөлөөлсөн, эсхүл эдгээртэй холбоотой эрх зүйн харилцаа тогтоогдсон бол мэдээлэл гаргагч нь урамшуулал буюу reward авахаар комисст өргөдөл гаргаж болно.¹⁶³ Комисс тус өргөдлийг хүлээж аваад шагналын зөвлөлдөх хороогоор¹⁶⁴ хэлэлцүүлсний үндсэн дээр өргөдөл гаргагчид урамшуулал олгоно. Гэхдээ дараах байдлыг харгалзан мэдээлэл гаргагчид олгох урамшууллын хэмжээг бууруулж, эсхүл огт олгохгүй байж болно.¹⁶⁵

1. Мэдээлэл, түүнийг нотлох баримтын үнэн зөв байдал;
2. Мэдээлэл гаргасан авлигын үйлдэл аль хэдийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр ил болсон эсэх;
3. Мэдээлэл гаргагч мэдээлэлтэй холбоотой хууль бус үйлдэл хийсэн эсэх;

¹⁶² "Сөрөг арга хэмжээ" гэсэн нэр томъёо нь дараахь арга хэмжээний аль нэгийг хэлнэ.

(а) Ажлаас халах, албан тушаалаас нь чөлөөлөх, ажлаас халах болон түүнтэй адил эрх зүйн байдлаа алдахтай дүйцэх бусад сөрөг арга хэмжээ;

(б) Сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас нь түдгэлзүүлэх, цалингийн хэмжээг бууруулах, албан тушаал бууруулах, албан тушаал ахихыг хязгаарлах болон бусад шударга бус арга хэмжээ авах;

(в) Албан тушаал, ажлын байрыг өөрийн хүсэл зоригийн эсрэг сольж томилох, үүрэг даалгаврыг түдгэлзүүлэх, өөр үүрэгт шилжүүлэх зэрэг хүсэл зоригийн эсрэг авсан арга хэмжээ;

(г) Гүйцэтгэлийн үнэлгээ, хамт олны үнэлгээ зэргээр ялгаварлан гадуурхах, мөн түүнтэй холбогдон цалин, урамшууллыг ялгавартайгаар олгох;

(д) Өөрийгөө хөгжүүлэх боломж (сургалт, дадлага зэрэг)-оос хасах, төсөв, хүний нөөц зэрэг нөөцийг ашиглах боломжийг хязгаарлах, аюулгүй байдлын мэдээлэл, нууц мэдээлэлтэй харьцах мэргэшлийг ашиглахыг түдгэлзүүлэх, цуцлах, хөдөлмөрийн нөхцөлд сөрөг нөлөө үзүүлэх ялгаварлан гадуурхах, арга хэмжээ;

(е) Хяналтад хамрагдах хүмүүсийн жагсаалтыг гаргах, эдгээр жагсаалт, дээрэлхэх, хүчирхийлэл, заналхийлсэн үг хэллэг, бие махбодийн болон оюун санааны хохирол учруулсан бусад үйлдлийг задруулах;

(ж) Үүргийн гүйцэтгэлд шударга бус байдлаар шалгалт, хяналт хийх, эсхүл түүний үр дүнг нийтэд дэлгэх;

(з) Зөвшөөрөл, эрх олголтыг цуцлах болон түүнтэй адил захиргааны сөрөг үр дагавар бий болгох бусад үйлдэл;

(и) Бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний гэрээг цуцлах, эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэх бусад арга хэмжээ авах;

¹⁶³ Act on the Prevention of Corruption and the Establishment and Management of the Anti-corruption and Civil Rights Commission (2008), Act No. 20712, Jan. 21, 2025, art. 68(2), https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=69417&lang=ENG.

¹⁶⁴ Мэдээлэл гаргагчид шагнал, урамшуулал, нөхөн төлбөр олгохтой холбоотой асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхийн тулд байгуулагддаг.

¹⁶⁵ Enforcement decree of the act on the prevention of corruption and the establishment and management of the anti-corruption and civil rights commission, (2002), Presidential Decree No. 34784, Jul. 30, 2024, art 77(1), https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=68552&type=sogan&key=42.

4. Авлигын үйлдлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд мэдээлэгчийн оруулсан хувь нэмрийн түвшин;
5. Мэдээлэгч нь холбогдох захиргааны байгууллагад мэдээлэл гаргах үүрэг хүлээсэн эсэх.

Мэдээлэл гаргагчид олгох урамшууллын дээд хэмжээ нь гурван тэрбум вон байх бөгөөд хэрэв урамшууллын хэмжээ мянган воноос бага байх тохиолдолд тус урамшууллыг олгохгүй. Мөн мэдээлэл нь авлигын үйлдэл мөн гэж тогтоогдсон боловч урамшууллын хэмжээ нь гурван зуун мянган воноос хэтрэхгүй бол урамшуулал олгохгүй.¹⁶⁶

Шагналын зөвлөлдөх хорооны хурлыг тус хорооны дарга¹⁶⁷ удирдан явуулах бөгөөд хуралдааны ирц урамшууллын зөвлөлдөх хорооны даргыг оролцуулан нийт гишүүдийн олонхоор бүрдэх бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэр гаргана.¹⁶⁸ Авлигын үйлдлийн талаар мэдээлэл гаргаснаар тухайн нийтийн институцийн орлого нэмэгдсэн эсхүл зардал хэмнэгдсэн, улсын сангаас алдагдсан хөрөнгийг эргүүлэн авсан гэх эрх зүйн харилцаа тогтоогдсоныг мэдсэн өдрөөс хойш гурван жилийн дотор дээрх хүсэлтийг гаргана. Уг эрх зүйн харилцаа тогтоогдсон өдрөөс хойш таван жил өнгөрсөн тохиолдолд урамшуулал авахаар хүсэлт гаргахыг хориглоно.¹⁶⁹

Харин Комисс болон нийтийн институцэд ирүүлсэн авлигын үйлдлийн тухай мэдээлэл нь нийтийн институцийн эд хөрөнгөд хохирол учруулахаас урьдчилан сэргийлсэн, ашиг олоход хүргэсэн, нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад хувь нэмэр оруулсан тохиолдолд Комисс холбогдох мэдээлэл гаргагчийг шагнал, өргөмжлөлийн тухай хуульд зааснаар шагнаж, Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон шагналаар шагнаж болно.¹⁷⁰ Тус Ерөнхийлөгчийн зарлигийн 71 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт мэдээлэл гаргагчид шагнал олгож болох үндэслэлийг дурджээ.

1. авлигын үйлдэл хийсэн этгээдэд эрүүгийн хэрэг үүсгэх, яллах дүгнэлт үйлдэхийг түдгэлзүүлэх, мөрдөн байцаалтын ажиллагааг зогсоох (сэжигтнийг хязгаарлах), сахилгын шийтгэл ногдуулах, бусад холбогдох арга хэмжээ авах зэрэг арга хэмжээ авсан бол;
2. мэдээлэл нь байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад нөлөөлсөн. Тухайлбал, хууль батлах, өөрчлөлт оруулахад хувь нэмэр оруулсан бол;
3. мэдээлэл гаргаснаар нийтийн институт аливаа эдийн засгийн алдагдалд орохоос урьдчилан сэргийлсэн бол;
4. шагналын зөвлөлдөх хороо мөнгөн шагнал олгох боломжтой гэж үзсэн тохиолдолд.

¹⁶⁶ Enforcement decree of the act on the prevention of corruption and the establishment and management of the anti-corruption and civil rights commission, (2002), Presidential Decree No. 34784, Jul. 30, 2024, art 77(1) https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=68552&type=sogan&key=42.

¹⁶⁷ Шагналын зөвлөлдөх хорооны үйл ажиллагаанд ерөнхий хяналт тавьж, шагналын зөвлөлдөх хороог төлөөлнө.

¹⁶⁸ Enforcement decree of the act on the prevention of corruption and the establishment and management of the anti-corruption and civil rights commission, (2002), Presidential Decree No. 34784, Jul. 30, 2024, art 76(1, 2) https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=68552&type=sogan&key=42.

¹⁶⁹ Act on the Prevention of Corruption and the Establishment and Management of the Anti-corruption and Civil Rights Commission (2008), Act No. 20712, Jan. 21, 2025, art. 68(2), https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=69417&lang=ENG.

¹⁷⁰ *Ibid*, art. 68(1).

Дээрх тохиолдолд олгох шагналын хэмжээ 500 сая воноос бага байна.¹⁷¹

Мэдээлэл гаргасны улмаас мэдээлэгч, түүний хамтран амьдрагч, хамаатан саданд дараах хохирол, зардлын аль нэг нь учирч түүнийг өөрөө төлсөн бол нөхөн төлбөр авах хүсэлтийг комисст гаргаж болно. Үүнд:¹¹

1. бие махбодын болон сэтгэцийн эмчилгээнд гаргасан зардал;
2. шилжүүлэх, томилолтоор ажиллуулах зэрэгтэй холбогдон гарсан зардал;
3. авлигын гэмт хэргийн талаарх мэдээллээс үүдэн бий болсон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан зардал;
4. сөрөг арга хэмжээ авсан хугацаанд алдагдсан хөдөлмөрийн хөлсний хэмжээ;
5. бусад эдийн засгийн хохирол.

Нийтийн эрх ашгийн төлөө шүгэл үлээгчийг хамгаалах тухай хууль нь нийтийн ашиг сонирхолд сөрөг нөлөө үзүүлсэн аливаа үйлдлийг мэдээлсэн хүмүүст хамгаалалт, дэмжлэг үзүүлснээр иргэдийн амьжиргааг тогтворжуулах зорилго бүхий таван бүлэг гучин нэгэн зүйлтэйгээр 2011 онд батлагдан хэрэгжиж байна. Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх болон иргэний зөрчигдсөн эрхийг хамгаалах комисс байгуулах, түүний үйл ажиллагааны тухай хууль нь зохицуулалтын хувьд нийтийн институт болон нийтийн албан тушаалтны авлигын үйлдлийн талаар мэдээлэх, түүнийг хамгаалахад чиглэсэн байна.

Харин Нийтийн эрх ашгийн төлөө шүгэл үлээгчийг хамгаалах тухай хууль нь дээрхийг илүү өргөжүүлсэн буюу хувийн компанид ажиллаж байгаа хүмүүс нийтийн ашиг сонирхлын эсрэг үйлдлийг мэдээлэх боломжтой байхаар зохицуулснаас гадна мэдээлэл гаргасан этгээдийн хамгаалалтыг илүү сайжруулсан байна. Шүгэл үлээх гэдгийг нийтийн эрх зүйн этгээдэд эсхүл хувийн компанид ажилладаг хүн тухайн байгууллагын дотоодод гарч буй авлига, зөрчил зэрэг хууль бус үйлдлийн талаар нийтийн ашиг сонирхлын төлөө мэдээлэхийг ойлгоно.¹⁷² Уг мэдээллийг гаргаж буй хүнийг нь шүгэл үлээгч (whistleblower) гэнэ.¹⁷³

БНСУ-д нийтийн ашиг сонирхлын эсрэг үйлдлийн агуулгыг өргөн хүрээгээр тодорхойлж өгсөн тул авлигын асуудал ч мөн нийтийн ашиг сонирхлын зөрчилд хамаардаг. Өөрөөр хэлбэл, мэдээлэгч болон шүгэл үлээгчийг хамгаалахтай холбоотойгоор хоёр өөр хуулийн зохицуулалт үйлчилнэ гэсэн үг юм. Тухайлбал Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх болон иргэний зөрчигдсөн эрхийг хамгаалах комисс байгуулах, түүний үйл ажиллагааны тухай хуулийн 68 дугаар зүйлийн 6 дах хэсэгт “авлигын үйлдлийн талаар мэдээлэл гаргаснаар тухайн нийтийн институтын орлого нэмэгдсэн эсхүл зардал хэмнэгдсэн, улсын сангаас алдагдсан хөрөнгийг эргүүлэн авсан гэх эрх зүйн харилцаа тогтоогдсоныг мэдсэн өдрөөс хойш гурван жилийн дотор хүсэлтийг гаргана” гэж заасан.

Харин Нийтийн эрх ашгийн төлөө шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “шүгэл үлээснээр нийтийн институтын сангаас алдагдсан хөрөнгийг эргүүлэн авсан, орлого нэмэгдсэн гэх эрх зүйн харилцаа тогтоогдсоныг мэдсэн өдрөөс хойш гурван жилийн дотор Комисст хүсэлт гаргана. Хэрвээ хүндэтгэн

¹⁷¹ Enforcement decree of the act on the prevention of corruption and the establishment and management of the anti-corruption and civil rights commission, (2002), Presidential Decree No. 34784, Jul. 30, 2024, art 71(2), https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=68552&type=sogan&key=42.

¹⁷² 공익신고자 보호에 관한 소송(안)에 대한 검토, KCI FI001357793 4e0e5b1f-301f-4fe6-b922-2abbdec80f41.pdf

¹⁷³ Public interest whistleblower protection act (2011), Act No. 20712, Jan. 21, 2025, art 2, https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=69424&lang=ENG.

үзэх шалтгаантай бол дээрх хязгаарлалт хамаарахгүй.” гэжээ. Хүндэтгэн үзэх шалтгааныг харгалзан үзэж байгаа нь шүгэл үлээгчийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн зохицуулалт болж байна. Иймд дээрхтэй адил харьцангуй байдлыг тэгшитгэхийн тулд Комисс мэдээлэгчийг хамгаалахад чиглэсэн хууль тогтоомжийг боловсронгуй болгох арга хэмжээг авч байгаа хэмээн 2024 оны тайландаа Комисс тусгасан байна.¹⁷⁴

Нийтийн ашиг сонирхлын эсрэг үйлдэл¹⁷⁵ хийсэн эсвэл хийх магадлалтай гэж үзэж байгаа аливаа этгээдийг хэн ч байсан доорхын аль нэгэнд мэдээлж болдог байна. Үүнд:¹⁷⁶

1. нийтийн ашиг сонирхлыг эсрэг үйлдэл хийсэн хүн, байгууллага, хуулийн этгээдийн төлөөлөгч эсхүл ажил олгогчид;
2. нийтийн ашиг сонирхолд хохирол учруулах үйлдэлтэй холбогдуулан удирдах, хянах, зохицуулах эсхүл шалгах бүрэн эрх бүхий төрийн захиргааны байгууллага эсхүл хяналтын байгууллагад;
3. мөрдөн шалгах байгууллагад;
4. Авлигатай тэмцэх болон иргэний зөрчигдсөн эрхийг хамгаалах комисст;
5. нийтийн ашиг сонирхолд хохирол учруулах үйлдэл гарахаас урьдчилан сэргийлэх, эсхүл үүссэн хохирол тархахаас сэргийлэх зорилгоор Ерөнхийлөгчийн зарлигаар тодорхойлсон бусад этгээдэд.

Шүгэл үлээх хэлбэрийн хувьд доор тусгасан баримт бичгийг, нийтийн ашиг сонирхлын эсрэг үйлдлийг нотлохуйц баримтын хамт бичгээр ирүүлнэ. Үүнд:¹⁷⁷

- шүгэл үлээгчийн хувийн мэдээлэл, тухайлбал түүний нэр, регистрийн дугаар, оршин суугаа газар, холбоо барих гэх мэт;
- нийтийн ашиг сонирхлын эсрэг үйлдэл нь этгээдийн мэдээлэл;
- нийтийн ашиг сонирхлыг эсрэг үйлдлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;
- шүгэл үлээх болсон зорилго болон үндэслэл.

Шүгэл үлээгчийг хамгаалахад чиглэсэн нэг онцлог зохицуулалт нь шүгэл үлээгч хувийн мэдээллийг задруулахгүйгээр өмгөөлөгчөөр дамжуулан шүгэл үлээх боломж юм. Энэ тохиолдолд дээр дурдсан бичгийн хэлбэрээр ирүүлэх шаардлагатай хувийн мэдээллийн хэсгийг өмгөөлөгчийн хувийн мэдээллээр орлуулна.¹⁷⁸ Өмгөөлөгчөөр дамжуулан шүгэл үлээх тохиолдолд мэдээлэл болон итгэмжлэл зэргийг Комисст бүрдүүлэн өгөх шаардлагатай.¹⁷⁹ Энэ нь нэг талаас шүгэл үлээгчийн хувийн мэдээлэл анхнаасаа задрахгүй байх урьдчилсан нөхцөлийг бүрдүүлж байх бөгөөд нөгөө талаас шүгэл үлээгчийн хувийн мэдээллийг нууцлахтай холбоотой Комиссын ажлын ачааллыг бууруулсан зохицуулалт байна.

Шүгэл үлээгчийг хамгаалах хамгаалалтын тухайд хэн ч шүгэл үлээгчийн болон бусад этгээдийн зөвшөөрөлгүйгээр түүний хувийн мэдээлэл, эсхүл шүгэл үлээгч гэдгийг тодорхойлох боломжтой бусад мэдээллийг нийтэд дэлгэх, хэвлэл мэдээллийн

¹⁷⁴ Anti-Corruption & Civil Rights Commission of Korea, Annual Report 2024 <https://www.acrc.go.kr/synap/skin/doc.html?fn=17562529411211.pdf&fno=%E2%98%852024%20ACRC%20Annual%20Report.pdf&rs=/synapfile/64/202510/>, p79

¹⁷⁵ Үүнд: олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчин, хэрэглэгчийн ашиг сонирхол, шударга өрсөлдөөний эсрэг зөрчлийг ойлгохоос гадна хуульд хавсаргасан актуудад шийтгүүлэх заалттай аливаа үйлдэл, ерөнхийлөгчийн зарлигаар захиргааны арга хэмжээ авахаар заагдсан аливаа үйлдлийг хамруулна.

¹⁷⁶ Public interest whistleblower protection act (2011), Act No. 20712, Jan. 21, 2025, art 6, https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=69424&lang=ENG.

¹⁷⁷ *Ibid* (2011), art 8(1).

¹⁷⁸ *Ibid* (2011), art 8-2(1).

¹⁷⁹ *Ibid* (2011), art 8-2(2).

хэрэгслээр дамжуулахыг хориглоно. Хэрэв үүнийг зөрчсөн тохиолдолд таван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл тавин сая хүртэл воноор торгоно. Мөн хэн ч шүгэл үлээхэд саад учруулах, шүгэл үлээхээ болихыг шаардах, эсхүл шүгэл үлээсэн шалтгаанаар шүгэл үлээгч болон холбогдох этгээдэд захиргааны эсхүл эдийн засгийн шинжтэй сөрөг арга хэмжээ авахыг хориглоно. Түүнийг нь зөрчсөн тохиолдолд гурван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл гучин сая хүртэл воноор торгоно. Шүгэл үлээгч нь ажил үүргийн хүрээнд нууц хадгалах үүргээс чөлөөлөгдөхөөс гадна, шүгэл үлээсэн шалтгаанаар эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн, сахилгын шийтгэл ноогдуулсан, захиргааны арга хэмжээ авсан тохиолдолд түүнээс хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх боломжтой. Мөн мэдээлэгчтэй адилаар хувийн хамгаалалтын арга хэмжээ авахаар Комисст хүсэлт гаргаж болно.¹⁸⁰

Шүгэл үлээгчийг урамшуулах тогтолцоог авч үзвэл, шүгэл үлээгчид мөнгөн шагнал болон урамшуулал, нөхөн төлбөр олгох урьдчилсан нөхцөлийн хувьд мэдээлэгчтэй адилхан байх бол олгох мөнгөн дүнгийн хэмжээ өөр байна. Тухайлбал шүгэл үлээгчид олгох урамшууллын дээд хэмжээг хуулиар тодорхойлж өгөөгүй, харин мөнгөн шагналын хувьд 500 сая вон хүртэл байна.¹⁸¹

Монгол улсын Авлигын эсрэг хуулийн 8 дугаар зүйлд авлигын тухай мэдэгдэх зохицуулалтыг тусгасан байна. Тус хуулийн 4.1-д заасан этгээд буюу нийтийн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигын талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдэгдэх үүрэгтэй. Тус мэдэгдэх үүргийг хэрэгжүүлэхэд Төрийн болон албаны нууцын тухай, байгууллагын нууцын тухай, хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар тогтоосон хязгаарлалт хамаарахгүй. Харин иргэн, хуулийн этгээд авлигын асуудлаар Авлигатай тэмцэх газарт өргөдөл, гомдол гаргаж, мэдээлэл өгч болно гэж тус заажээ.¹⁸²

Авлигын эсрэг хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан Авлигатай тэмцэх газрын тодорхойлолтоос авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулдаг гэдгийг харж болохоор байна. Өөрөөр хэлбэл, Гүйцэтгэх ажлын тухай хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар авлигын гэмт хэргийг илрүүлэхээр байх хэдий ч өргөдөл, гомдол, мэдээлэл гаргасан этгээдийг хамгаалах, эдийн засгийн дэмжлэг үзүүлэх гэх мэт БНСУ шиг нарийвчилсан хуулийн зохицуулалт байхгүй байна.

Дүгнэвэл, БНСУ-ын хувьд авлигын талаар мэдээлэл гаргах, түүнийг шийдвэрлэх, мэдээлэл гаргасан этгээдийг хамгаалах, цаашлаад дэмжлэг үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан эрх зүйн орчин бүрдсэн бөгөөд тус асуудлыг шийдвэрлэх Комисстой гэдгээрээ онцлогтой байна. 2008 оны Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх болон иргэний зөрчигдсөн эрхийг хамгаалах комисс байгуулах, түүний үйл ажиллагааны тухай хуулиар зөвхөн нийтийн институт болон нийтийн албан тушаалтантай холбоотой авлигын үйлдлийн талаар мэдээлэх, мэдээлэгчийг хамгаалах зохицуулалтыг тусгасан байна.

Харин 2011 оны Нийтийн эрх ашгийн төлөө шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуулиар шүгэл үлээгчийг тодорхойлсон бөгөөд хувийн компанид ажиллаж буй этгээд хүртэл нийтийн ашиг сонирхлын эсрэг үйлдлийн талаар шүгэл үлээх боломжтой байхаар зохицуулсан. Цаашлаад шүгэл үлээгчийг хамгаалахтай холбоотой зохицуулалтыг мэдээлэгчээс ялгамжтай байдлаар салгаж зохицуулахыг зорьсон хууль байна.

¹⁸⁰ACRC, 부패방지 정책, <https://www.acrc.go.kr/menu.es?mid=a10101040200>.

¹⁸¹ Ibid.

¹⁸² Монгол Улсын Авлигын эсрэг хууль (2006)-ийн 9 дүгээр зүйл.

Тухайлбал, шүгэл үлээгч хувийн мэдээллээ ил болохоос сэргийлэхийн тулд өмгөөлөгчөөр дамжуулан шүгэл үлээх боломжийг нээсэн байна. Гэхдээ авлигын үйлдлийн талаар мэдээлэл гаргаж байгаа хүнийг Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг иргэний эрхийн комисс байгуулах, зохион байгуулах тухай хууль болон Нийтийн эрх ашгийн төлөө шүгэл үлээгчийг хамгаалах тухай актад нэр томьёоны хувьд ялгаатай байдлаар томьёолсон ч мэдээллийг хүлээн авч шийдвэрлэх этгээд, шийдвэрлэх механизм, мэдээлэгчийг хамгаалах арга, түүнд үзүүлэх дэмжлэг, мөнгөн урамшуулалтай холбоотой нэлээдгүй төстэй зохицуулалтууд байгаа нь мэдээлэл гаргаж байгаа хүнийг төөрөгдөлд оруулах магадлалтай байна. Харин ялгаатай зохицуулалтуудын хувьд мэдээлэл гаргаж буй этгээдийн эрх зүйн байдалд хууль бүр өөр өөрөөр нөлөөлөх боломжийг бий болгож байна.

VII. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Мэдээлэгч, шүгэл үлээгч гэх хоёр ойлголтыг дэлхийн улс орнууд нэгдсэн байдлаар тодорхойлоогүй боловч шүгэл үлээгч гэдэг нь мэдээлэгчээс явцуу утгатай, улс төрийн нэр томъёо болох нь харагдаж байна. Нийтлэг тохиолдолд шүгэл үлээгч гэдэг тодорхой нэг байгууллагын (төрийн, хувийн хэвшил, эсхүл аль алинд) ажилтан хууль бус үйлдлийн талаар холбогдох байгууллагад нийтийн ашиг сонирхлын төлөө өөртөө ямар нэг давуу байдал бий болгох зорилгогүй мэдээлэл гаргаж, тухайн үйлдлийг дотроосоо илчилж буй этгээдийг хэлж байна.

Монгол Улсын хувьд мэдээлэгч гэх нэр томъёог хууль тогтоомжид хэрэглэж байх бөгөөд гэмт хэрэг, зөрчил болон хууль бус үйлдлийн талаар мэдээлэл өгсөнтэй холбогдуулан урамшуулахтай холбоотой зохицуулалт салбарын хууль тогтоомжид тусгалаа олжээ. Харин мэдээлэгчийг хамгаалах, мэдээллийг нь хүлээж авах байгууллага, хянах механизмыг зохицуулсан эрх зүйн орчин байхгүй байгаа нь учир дутагдалтай байна.

Тухайлбал, Авлигын эсрэг хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Цагдаагийн байгууллагын тухай хуульд заасан гэмт хэргийн талаарх мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс төлбөртэй авах зохицуулалт нь хууль хэрэгжиж эхэлснээс хойш тодорхой хэмжээнд мэдээлэл цуглуулах үр нөлөөг дээшлүүлж, эрэн сурвалжлагдаж буй этгээдийг олж тогтооход хувь нэмэр оруулсан нь судалгаанаас харагдаж байна.

Харин Байгаль орчны тухай, Амьтны тухай, Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай, Соёлын өвийг хамгаалах тухай, Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай, Өрсөлдөөний тухай хуульд заасан хууль бус үйлдлийн талаар мэдээлсэн иргэн, хуулийн этгээд, төрийн бус байгууллагыг урамшуулахтай холбоотой зохицуулалтын хэрэгжилт нь практикт сул байна. Энэ нь нэг бус шалгаан, нөхцөлөөс үүдэлтэй байх бөгөөд хууль болон захиргааны хэм хэмжээний актын зөрчил, уялдаагүй байдал, урамшууллын хэмжээний ялгамжтай байдал, олон нийтэд ил тод мэдээлдэггүй байдал зэрэг нөлөөлж байна.

Түүнчлэн дээр дурдсан бүх хууль тогтоомжид нийтлэг тулгамдаж байгаа асуудал нь мэдээлэгчээс ирүүлж байгаа мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, мэдээлэгчийг хамгаалах тогтолцоо, түүнийг зохицуулсан эрх зүйн орчин дутмаг байдал юм. Ийнхүү гэмт хэрэг, зөрчил, хууль бус үйлдлийн талаар мэдээлэл гаргаж буй этгээдийг хамгаалах, нийтийн болон хувийн хэвшлийн байгууллагын дотроос шүгэл үлээсэн ажилтан, албан хаагчийг хамгаалах Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл хэрэгцээ, шаардлагатай болох нь тогтоогдож байна.

Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд мэдээлэгч гэдэгт ганц хувь хүн бус зарим нөхцөлд хуулийн этгээд байх боломжтой байгааг онцолж, шүгэл үлээгч буюу ажилтан, албан хаагчаас ялгамжтай зохицуулах нь зүйтэй байна. Ингэхдээ 2021 онд боловсруулсан Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл дээр шүгэл үлээгч, мэдээлэгч гэх хоёр ялгаатай ойлголтыг зааглаагүй байсан алдааг давтахгүйгээр мэдээлэгчийг хамгаалах нөхцөл, урамшуулах хэмжээг шүгэл үлээгчтэй холбоотой зохицуулалтаас ялгаатай боловсруулахыг зөвлөж байна.

Гадаадын зарим улсын тухайлбал АНУ, ХБНГУ, БНХАУ, ОХУ, БНСУ, Сингапур, Япон Улсын авлигын хэрэг дээр шүгэл үлээхтэй холбоотой зохицуулалтыг судалж үзэхэд улс бүрт Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хууль байгаагүй боловч нийтлэг байдлаар мэдээлэгчийг хамгаалах эрх зүйн орчин бүрдсэн байна. Харин шүгэл үлээгч гэдэгт зөвхөн нийтийн албан хаагчийг хамааруулах эсхүл нийтийн болон хувийн хэвшлийн байгууллагын ажилтныг хамааруулж байгаагаараа ялгаатай байна.

Улс болгоны мэдээлэгч, шүгэл үлээгчийг хамгаалахтай холбоотой хууль тогтоомжийг судлаад үзэхэд тэдгээр хууль нь материаллаг гэхээсээ илүү процессын шинжтэй байгаа нь анхаарал татлаа. Мэдээллийг ямар зорилгоор хэн, хэнд, яаж гаргахаас эхлээд тухайн мэдээллийг хянан шалгах, шаардлагатай тохиолдолд мэдээлэгч, шүгэл үлээгчийг хэрхэн хамгаалах, урамшуулах талаар нарийвчилсан процессыг заасан байна. Монгол Улсын хувьд эдгээр улсуудын жишээнээс хэд хэдэн онцлог зохицуулалтыг нутагшуулах боломжтой болно. Үүнд:

1. ХБНГУ-д шүгэл үлээгчийн мэдээллийг хүлээн авч байгаа байгууллага нь өөрөө хууль бус үйлдэл хийж байгаа талаарх мэдээллийг өөр нэг байгууллага хянан шалгах эрхийг хуулиар олгосон байгаа зохицуулалтыг;
2. ХБНГУ-ын шүгэл үлээгчээс мэдээллийг байгууллагын дотоод нэгжид гаргаж урьдчилан шийдвэрлүүлсний үндсэн дээр харьяалах өөр шатны байгууллагад гаргаж байгаа зохицуулалтыг;
3. БНСУ-д мэдээлэгч, шүгэл үлээгчийг хоёр тусдаа хуулиар зохицуулахдаа мэдээлэл гаргах процедур, шалгуур, хамгаалах нөхцөл, урамшууллын хэмжээ ялгаатай байгаа зохицуулалтыг зайлшгүй харгалзан үзэх нь зүйтэй.

Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийг боловсруулахад шүгэл үлээгч гэдэгт дан ганц авлигын хэргийн талаар шүгэл үлээсэн нийтийн албан хаагч байх нь байж болох хувилбар хэдий ч авлигатай тэмцэхэд төдийлөн тус болох хувилбар биш болохыг онцлох нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, авлигын гэмт хэргийн нэг талд хэдийгээр нийтийн албан тушаалтан гарцаагүй байдаг хэдий ч нөгөө тал нь хэн ч байх боломжтой. Иймд хувийн эрх зүйн хуулийн этгээдийн дотроос шүгэл үлээх боломжийг нээж өгснөөр тухайн төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд илүү нэмэртэй байхыг үгүйсгэхгүй. Мөн авлигын гэмт хэргээр л мэдээллийн цар хүрээг хязгаарлах нь нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээх гэдэг ойлголтын цаад мөн чанарыг хязгаарлах эрсдэлтэй.

Нөгөөтээгүүр шүгэл үлээгч гэдгийг илүү өргөн хүрээнд нийтийн албан хаагч болон хувийн хэвшлийн компани, холбоо, сан зэргийн ажилтан гэж тодорхойлсон тохиолдолд авлигын хэрэгт холбогдох боломжтой албан тушаалтанд авлига өгсөн хувийн байгууллага, албан тушаалтны талаар мэдээлэлтэй байгаа ажилтан ч шүгэл үлээх боломж бүрдэнэ. Мөн дээрээс нь төрийн бус байгууллагад давуу байдал бий болгосон гэх нийтийн албан тушаалтны талаар мэдээлэлтэй төрийн бус байгууллагын гишүүн ч шүгэл үлээх давуу талтай юм.

Аль ч хувилбарыг сонгосон байсан мэдээлэгч буюу гэмт хэрэг, зөрчил, хууль бус үйлдлийн талаар мэдээлэл гаргаж байгаа этгээдийг шүгэл үлээгчээс ялгаж, тэдгээрийн мэдээллийг хянан шалгах, урамшуулах, шаардлагатай тохиолдолд хамгаалахтай холбоотой харилцааг хуулийн төсөлд оруулах зайлшгүй шаардлагатай байна.

Ингэснээр Монгол Улс НҮБ-ын Авлигын эсрэг конвенцид заасан мэдээлэгчийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх үүргээ биелүүлэх болно. Мөн мэдээлэгч болон шүгэл үлээгчийн тусламжтай гэмт хэрэг, зөрчилтэй бодитойгоор тэмцэх, олон нийтийн оролцоотойгоор эрүүл, аюулгүй нийгмийг бүтээх боломжтой юм. Үүнд хүрэхийн тулд Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд хууль тогтоомжийг сурталчлах, олон нийтийн байгууллагад мэдээ, мэдээлэл түгээх, сургалт орох, хянан шалгах эрх бүхий байгууллагыг сургах, чадавхжуулах зэрэг үйл ажиллагааг орхигдуулахгүйгээр үүрэгжүүлэх нь чухал юм.

НОМ ЗҮЙ

Монгол хэл дээрх эх сурвалж

Эрх зүйн эх сурвалж

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он.
2. Авлигын эсрэг хууль, 2006 он.
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 он.
4. Цагдаагийн албаны тухай хууль, 2017 он.
5. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, 2019 он.
6. Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 он.
7. Амьтны тухай хууль, 2012 он.
8. Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн худалдааг зохицуулах тухай хууль, 2002 он.
9. Соёлын өвийг хамгаалах тухай хууль, 2014 он.
10. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, 2019 он.
11. Өрсөлдөөний тухай хууль, 2010 он.

Ном, сурах бичиг

1. Пүрэвдожийн Батбаатар, Гэрч, хохирогчийн аюулгүй байдлын онол, практикийн асуудал, (Улаанбаатар: УБ ДХИС-ийн хэвлэх үйлдвэр, 2021).
2. Авлигатай тэмцэх газар, “2023 оны үйл ажиллагааны тайлан”, 2024, <https://iaac.mn/54/coopitem>.
3. Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF), “Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх: Хууль бусаар ан агнах гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэхэд анхаарах асуудлууд”, Сургалтын гарын авлага, (Хууль сахиулах байгууллагуудын албан хаагч нарын албан хэрэгцээнд зориулав), [https://wwfasia.awsassets.panda.org/downloads/20p10_wwf_hand_book_negdsen .pdf](https://wwfasia.awsassets.panda.org/downloads/20p10_wwf_hand_book_negdsen.pdf).
4. ХЗҮХ, “Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай” хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан”, УБ, 2025.

Эрдэм шинжилгээний бүтээл

1. Хүний Эрхийн Үндэсний Комисс, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл, УБ, 2024.
2. Даржаагийн Баттулга, “Хэм хэмжээний актаар зохицуулах харилцааны хүрээ, хязгаар болон хяналтын зарим асуудлыг боловсронгуй болгох нь”, 2016, <https://legaldata.mn/b/338>.
3. Хууль зүйн үндэсний хүрээлэн, Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан, УБ, 2025.

Бусад

1. Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, 2021, <https://lawforum.parliament.mn/project/237/>.

2. Алигатай тэмцэх газар, Түүхэн замнал, <https://iaac.mn/erhem-zorilgo-undsen-zarchim-tuuhen-zarchim>.
3. ЦЕГ-ын 2017-2024 онд бүртгэгдсэн гэмт хэргийн тайлангаас, <https://police.gov.mn/as/article/3?page=5&size=20>.
4. Үндэсний статистикийн хороо, соёл, урлагийн салбарын танилцуулга-2019, УБ, 2020
5. Соёлын яам, “Соёлын өвийн үндэсний төвийн 2021 оны гүйцэтгэлийн тайлан”, <https://ncch.gov.mn/Files/Report/%D0%A1%D3%A8%D2%AE%D0%A2-%D0%93.%D1%82%D0%B0%D0%B9%D0%BB%D0%B0%D0%BD-2021-%D0%BE%D0%BD.pdf?utm>.
6. Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээлэл өгсөн иргэнийг урамшуулах журам”-ыг боловсронгуй болгоно, mongolian national broadcaster, 2025.02.20, <https://www.mnb.mn/i/324355>.
7. “Байгаль орчны зөрчил мэдээлэлд урамшуулал олгоно”, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, 2025.03.12, <https://www.gov.mn/mn/news/all/7d0761be-9977-4d4c-91f9-96744f6341d6>.
8. Соёлын биет бус өвийн 2024 оны шилдэг өвлөн уламжлагчид шагнал гардууллаа, 2025.05 сар, <https://eagle.mn/r/90HdFQAgeW3>.
9. Монгол улсын тагнуулын ерөнхий газрын цахим хуудас: <https://www.gia.gov.mn/mn/menu/402>.
10. Монополын эсрэг газрын цахим хуудас, <https://www.gov.mn/mn/organization/AMA>.
11. Цагдаагийн ерөнхий газрын албан ёсны цахим хуудас, <https://police.gov.mn/suspect>.

Гадаад хэл дээрх эх сурвалж

Эрх зүйн эх сурвалж

1. Directive (EU) 2019/1937 of the European Parliament and of the Council of 23 October 2019 on the protection of persons who report breaches of Union law, <https://eur-lex.europa.eu/eli/dir/2019/1937/oj/eng>.
2. United States Code, АНУ-ын холбооны хууль тогтоомжийн албан ёсны эмхэтгэл 1926 <https://www.law.cornell.edu/uscode/text/50/3126>
3. Transparency International France, “Mediator, Facebook, Luxembourg Leaks, or Swiss Leaks in tax matters... many are the "affairs" revealed by whistleblowers. The term is as widespread as whistleblowers are useful to society”, <https://transparency-france.org/convaincre/lanceurs-dalerte/>.
4. БНХАУ-ын Эрүүгийн хууль, 1980 он, http://www.npc.gov.cn/zgrdw/npc/lfzt/rllys/2008-08/21/content_1882895.htm.
5. БНХАУ-ын Хяналт шалгалтын тухай хууль, 2018 он, https://www.moj.gov.cn/pub/sfbgw/flfggz/flfggzflty/fltysfxzxqflfg/201812/t20181225_151325.html.
6. БНХАУ-ын Шударга бус өрсөлдөөний эсрэг хууль, 1993 он, https://www.spp.gov.cn/spp/fl/202506/t20250627_699862.shtml
7. Российская федерация федеральный закон о противодействии коррупции, 25 декабря 2008 года, ОХУ-ын Авлигын эсрэг хуулийн эхний хэсэг, <https://faolex.fao.org/docs/pdf/rus202742.pdf>.
8. ОХУ-ын Эрүүгийн хууль, 1996 он.
9. ОХУ-ын Захиргааны зөрчлийн тухай хууль, 2001 он.

10. ХБНГУ-ын Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хууль, 2023 он, https://www.gesetze-im-internet.de/englisch_hinschg/englisch_hinschg.html.
11. Япон улсын Ажилтны гэрээт байгууллагын зохистой үйл ажиллагааг хангах, гэрээт ажилтныг хамгаалах тухай хууль, 1985 он.
12. Японы Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хууль, 2004 он.
13. Япон улсын Эрүүгийн хууль, 1907 он, <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3581/en>.
14. Япон улсын Хөдөлмөр стандартын тухай хууль, 1947) он, <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/4913>.
15. Сингапур улсын Авлигын эсрэг хууль, 1960 он.
16. Act on the Prevention of Corruption and the Establishment and Management of the Anti-corruption and Civil Rights Commission (2008), Act No. 20712, Jan. 21, 2025, https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=69417&lang=ENG.
17. State public officials act (1949), Act No. 20627, Dec. 31, 2024, art. 2, https://elaw.klri.re.kr/kor_service/lawView.do?hseq=69197&lang=KOR.
18. Enforcement decree of the act on the prevention of corruption and the establishment and management of the anti-corruption and civil rights commission, (2002), Presidential Decree No. 34784, Jul. 30, 2024, https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=68552&type=sogan&key=42.
19. Public interest whistleblower protection act (2011), Act No. 20712, Jan. 21, 2025, art 2, https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=69424&lang=ENG.
20. БНСУ Авлигын эсрэг хууль, 2001 он.

Ном, сурах бичиг

1. *Black's Law Dictionary* (4th ed. 2015), <https://www.latestlaws.com/wp-content/uploads/2015/04/Blacks-Law-Dictionary.pdf>.
2. The Institute of Internal Auditors Singapore, Whistle-blowing policy and procedures, A Guide for Charities and Institutions of a Public Character, 2017.

Эрдэм шинжилгээний бүтээл

1. Georgios Kontogeorgis, "Whistleblowers and their role in the Fight against corruption. Problems in protecting Whistleblowers and Suggestions for improvement", International Multilingual Journal of Science and Technology, Vol. 10 Issue 2, (February 2025), <https://www.imjst.org/wp-content/uploads/2025/03/IMJSTP29121138.pdf>.
2. Robert G. Vaughn, "State whistleblower statutes and the future of whistleblower protection", (Published by: American Bar Association), Administrative Law Review, Vol. 51, No. 2 (Spring 1999), pp. 581-625, <http://www.jstor.org/stable/40709997>.

Бусад

1. Cornell Law School, Wex definitions, <https://www.law.cornell.edu/>.
2. European Union, Whistleblowers and Informants, https://competition-policy.ec.europa.eu/index/whistleblower_en.
3. "Exploring the blurred line between whistleblowers and informants", (2023.08.01), <https://www.corporatecrime.co.uk/post/whistleblowers-vs-informants>.
4. National whistleblower center, "What is a Whistleblower?", <https://www.whistleblowers.org/what-is-a-whistleblower/>.

5. National Whistleblower center, "Whistleblower Laws Around the World" <https://www.whistleblowers.org/whistleblower-laws-around-the-world/>.
6. National whistleblower center, "Major International Whistleblower Laws", <https://www.whistleblowers.org/major-international-whistleblower-laws/#:~:text=At%20least%2059%20countries%20around,laws%20vary%20widely%20between%20countries.>
7. Transparency International, "Internal whistleblowing systems", [https://files.transparencycdn.org/images/2022 Internal-Whistleblowing-Systems English.pdf](https://files.transparencycdn.org/images/2022%20Internal-Whistleblowing-Systems%20English.pdf).
8. OECD, Fair Market Conditions for Competitiveness in the Adriatic Region, Whistleblower Protection to Fight Corruption, Policy briefing note.
9. "Reward/whistle-blowing Scheme", (2025), Last updated 26 September 2025, <https://www.cccs.gov.sg/get-in-touch/for-businesses/reward---whistle-blowing-scheme>.
10. "Laws Protecting Informers/ Whistleblowers in Singapore", (2024), Last updated on December 5, 2024, <https://singaporelegaladvice.com/law-articles/laws-protecting-informers-whistleblowers-singapore/>.
11. "Prevention of Corruption Act" (2025), Last Updated 16 Oct 2025, <https://www.cpiib.gov.sg/about-corruption/legislation-and-enforcement/prevention-of-corruption-act/>.
12. Dr.Andreas Lohne and Nicolai Behi, "Anti corruption in Germany", (2025), <https://www.globalcompliancenews.com/anti-corruption/handbook/anti-corruption-in-germany/>.
13. Balser, Jimmy , "The Whistleblower Protection Act (WPA): A Legal Overview", (Publication Date: 12/30/2024), <https://www.congress.gov/crs-product/R48318>.
14. U.S. Office of Special Counsel, "Prohibited Personnel Practices Overview", <https://osc.gov/Services/Pages/PPP.aspx>.
15. United States Code, <https://www.law.cornell.edu/uscode/text/5/1214>.
16. National whistleblower center, "Sarbanes-Oxley (SOX) Whistleblower FAQ", (Published on June 03, 2018), https://www.whistleblowers.org/fag/sarbanes-oxley-sox-fag/?gad_source=1&gad_campaignid=20173867156&gbraid=0AAAAAC098VLDTXx4e0_22i0t0lqvpN-jO&qclid=Cj0KCQjw0Y3HBhCxARIsAN7931VYQL420vC7ccZBM_T6lEoblhPHCHDhNYJwicpjBrpK1julFScXoBkaAlIKEALw_wcB.
17. "Mini vandePol, Vivian Wu, "New Rules Offer Greater Protection and Incentives to Whistleblowers in China" (2016), <https://www.globalcompliancenews.com/2016/05/04/new-rules-offer-greater-protection-and-incentives-to-whistleblowers-in-china-20160504>.
18. Anna Fufurina, "Anti-Corruption and bribery in Russia" (20 June 2017), <https://www.krioni.com/blog/anti-corruption-and-bribery-in-russia/>.
19. The Prosecutor General's Office of the Russian Federation, "Combating corruption", https://epp.genproc.gov.ru/web/eng_gprf/combating-corruption.
20. Directorate General of Human Rights and Legal Affairs, "Evaluation Report on the Russian Federation", (2008), <https://rm.coe.int/16806c7d06>.
21. Hannes Lubitzsch, "Russia", (14 Jan 2022), Global Investigation Review, <https://globalinvestigationsreview.com/guide/the-practitioners-guide-global-investigations-archived/2022/article/russia>.

22. Andre Appel, "Germany's New Whistleblower Protection Act: What Employers Need to Know" (August 28, 2023), <https://ogletree.com/insights-resources/blog-posts/germanys-new-whistleblower-protection-act-what-employers-need-to-know/>.
23. Andreas Pyrczek, "Why trust is essential for whistleblowing programs to be effective", (27 Mar 2025), https://www.ey.com/en_sg/insights/forensic-integrity-services/why-trust-is-essential-for-whistleblowing-programs-to-be-effective.
24. Lakshanthi Fernando, Wei Ming Tan, Os Agarwal, "Whistleblower protection and reporting channels in Singapore", (12 Jul 2023), Last updated: 12 Jul 2023, <https://cms.law/en/int/expert-guides/whistleblower-protection-and-reporting-channels/singapore>.
25. "E-complaint for Corrupt Conduct", (2025), <https://www.cpib.gov.sg/e-services/e-complaint-for-corrupt-conduct/>.
26. Anti-Corruption & Civil Rights Commission of Korea, "Taking a Big Stride Forward on Transparency & Civil Rights", p.4 https://files.acquia.undp.org/public/migration/seoul_policy_center/d322267f349e7d876cea6f448e734bd36f569cb9846f1d7a3bb207c2203965f1.pdf.
27. Anti-Corruption & Civil Rights Commission of Korea, <https://www.acrc.go.kr/menu.es?mid=a20103000000>.
28. Anti-Corruption & Civil Rights Commission of Korea, Annual Report 2024 <https://www.acrc.go.kr/synap/skin/doc.html?fn=17562529411211.pdf&fno=%E2%98%852024%20ACRC%20Annual%20Report.pdf&rs=/synapfile/64/202510/>.
29. 공익신고자 보호에 관한 소송(안)에 대한 검토, KCI_FI001357793_4e0e5b1f-301f-4fe6-b922-2abbdec80f41.pdf.
30. ACRC, 부패방지 정책 <https://www.acrc.go.kr/menu.es?mid=a10101040200>.

ХАВСРАЛТ

1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	тийм	үгүй	
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	тийм	үгүй	
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	тийм	үгүй	
	1.2.Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийг оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	тийм	үгүй	
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	тийм	үгүй	
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	тийм	үгүй	

	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмын талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	тийм	үгүй	
	1.3.3Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгасан эсэх	тийм	үгүй	
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	тийм	үгүй	
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	тийм	үгүй	
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	тийм	үгүй	
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	тийм	үгүй	
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	тийм	үгүй	
	3.4.Эрх агуулагчдын ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, эдгээрээр хязгаарлагдахгүй)	тийм	үгүй	
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	тийм	үгүй	
5.Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн сэх	5.1.Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	тийм	үгүй	
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	тийм	үгүй	

2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	тийм	үгүй	
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	тийм	үгүй	
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	тийм	үгүй	
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	тийм	үгүй	
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөргөдлийг бий болгох эсэх	тийм	үгүй	
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	тийм	үгүй	
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	тийм	үгүй	
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	тийм	үгүй	Хуулийн төслийг хэрэгжүүлэхэд захиргааны зардал гарна

болон захиргааны зардал	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	тийм	үгүй	
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	тийм	үгүй	
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	тийм	үгүй	
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	тийм	үгүй	
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	тийм	үгүй	Мэдээлэх, тайлан гаргах зардал гарна
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг хөндсөн зохицуулалт бий болох эсэх	тийм	үгүй	
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	тийм	үгүй	
	5.3.Оюуны өмчийн эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	тийм	үгүй	
6.Инновац болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	тийм	үгүй	
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	тийм	үгүй	

7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	тийм	үгүй	
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	тийм	үгүй	
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	тийм	үгүй	
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	тийм	үгүй	
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	тийм	үгүй	
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	тийм	үгүй	
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	тийм	үгүй	
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	тийм	үгүй	Мэдээлэгч, шүгэл үлээгчийг хамгаалах, урамшуулахтай холбоотой зардал гарна.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	тийм	үгүй	Мэдээлэгч, шүгэл үлээгчийн мэдээллийг хүлээн авч, хянан шалгах байгууллага, нэгж, албан хаагч хэрэг болно.

	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	тийм	үгүй	
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	тийм	үгүй	
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	тийм	үгүй	
	10.3.Инфляц нэмэгдэх эсэх	тийм	үгүй	
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	тийм	үгүй	

3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	тийм	үгүй	
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	тийм	үгүй	
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	тийм	үгүй	
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	тийм	үгүй	
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	тийм	үгүй	
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	тийм	үгүй	

	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	тийм	үгүй	Ажилтан байгууллагынхаа талаарх хууль бус үйлдлийн талаар шүгэл үлээх боломжтой болно.
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	тийм	үгүй	
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	тийм	үгүй	Мэдээлэгч, шүгэл үлээгчийн мэдээллийн хүлээн авах тусгай дугаар, цахим сүлжээ бий болгох боломжтой.
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	тийм	үгүй	
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	тийм	үгүй	
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	тийм	үгүй	
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	тийм	үгүй	
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	тийм	үгүй	
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	тийм	үгүй	
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	тийм	үгүй	

	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	тийм	үгүй	
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	тийм	үгүй	
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	тийм	үгүй	
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	тийм	үгүй	
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	тийм	үгүй	
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	тийм	үгүй	
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	тийм	үгүй	
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	тийм	үгүй	
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	тийм	үгүй	
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	тийм	үгүй	Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх үйл ажиллагаанд эерэг нөлөө үзүүлнэ.

	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	тийм	үгүй	
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	тийм	үгүй	
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	тийм	үгүй	
	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	тийм	үгүй	
8.Соёл	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	тийм	үгүй	
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	тийм	үгүй	Иргэдийн оролцоо нэмэгдэнэ.

4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	тийм	үгүй	
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	тийм	үгүй	
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	тийм	үгүй	
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	тийм	үгүй	
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	тийм	үгүй	
	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	тийм	үгүй	

3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	тийм	үгүй	
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	тийм	үгүй	
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	тийм	үгүй	
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	тийм	үгүй	
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	тийм	үгүй	
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	тийм	үгүй	
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	тийм	үгүй	
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	тийм	үгүй	
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	тийм	үгүй	
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	тийм	үгүй	
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	тийм	үгүй	
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	тийм	үгүй	
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	тийм	үгүй	

---oOo---